United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

ЮНЕСКО Сэтгүүл зүйн боловсролын цуврал

# СЭТГҮҮЛ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАР

## ШИНЭ ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ЗААВАР



ЮНЕСКО Сэтгүүл зүйн боловсролын цуврал

# СЭТГҮҮЛ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАР

## ШИНЭ ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ЗААВАР

Редактор:

Факсон Банда

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагаас 2015 онд хэвлүүлэв.

© UNESCO 2015
Хуулиар оюуны өмчийн эрх хамгаалагдсан

ISBN 978-92-3-000018-9

Энэхүү товхимолд хэвлэгдсэн материал нь ЮНЕСКО-гийн аливаа улс үндэстний хууль ёсны статус, хот суурингийн эрх баригч, эрх мэдэлтний эрхэнд халдах, эсвэл аливаа хил хязгаарын асуудлыг хөндөөгүй болно.

Энэхүү товхимол дахь мэдээ материалын зохиогчид нь ЮНЕСКО байгууллагад хамааралгүй болно. ЮНЕСКО тэдний өмнөөс хариуцлага хүлээхгүй.

Зургийг : ©Shutterstock/Jozsef Bagota
хуу.30: ©Shutterstock/Cienpies Design
хуу.42: ©Shutterstock/Sergey Nivens
хуу.54: ©Shutterstock/donatas1205
хуу.66: ©Shutterstock/REDAV
хуу.90: ©Shutterstock/STILLFX
хуу.104: ©Shutterstock/Elnur
хуу.128: ©Shutterstock/JIANHAO GUAN
хуу.140: ©Shutterstock/Kamira
хуу.156: ©Shutterstock/Sam DCruz хуу.
94: ©Shutterstock/Blazej Lyjak

График дизайн: UNESCO
Нүүр хуудасны дизайн: UNESCO
Үсгийн өрөлт: UNESCO
Хэвлэсэн: UNESCO

Франц улсад хэвлэв

# АГУУЛГА


**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ** **4**

**I. ӨМНӨХ ҮГ** **5**

**II. ТАНИЛЦУУЛГА** **6**

Сэтгүүл зүйн боловсролын дэлхийн академик соёл 9

ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийн хавсарга ба түүний ирээдүйн ойлголт 12

Мэргэшсэн сэтгүүл зүйн суурь боловсролыг судлах нь 17

**III. ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА БА ХӨТӨЛБӨРИЙН ТОЙМ** **20**

I-III хэсгийн ном зүй 24

**IV. ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА** **26**

Хэвлэл мэдээллийн тогтвортой байдал 28

Дата сэтгүүл зүй 39

Олон талт соёлын сэтгүүл зүй 49

Хүйн радиогийн сэтгүүл зүй 58

Глобал сэтгүүл зүй 84

Шинжлэх ухааны сэтгүүл зүй, биоэтикийн нэгдэл 97

Жендер ба сэтгүүл зүй 121

Хүмүүнлэгийн сэтгүүл зүй 135

Хүний наймааг сурвалжлах нь 151

Аюулгүй байдал ба сэтгүүл зүй 189

**V. ХАВСРАЛТ** **201**

1. Сэтгүүл зүйн боловсролын чухал эх үүсвэрүүд 202

2. Нидерландын хүний наймаа болон хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг товчоо (агентлаг)-ийн мэдээлэл 203

**VI. ЗОХИОГЧИД** **204**

Сургалтын хөтөлбөр зохиогчдын нэрсийн жагсаалт 205

Шүүмжлэгч, тоймчдын нэрсийн жагсаалт 206

ЮНЕСКО-гийн ажилчдын нэрсийн жагсаалт 208

# ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| AEJMC | Сэтгүүл зүй болон Мэдээлэл Харилцааны Боловсролын Ассоциаци |
| AJIC | Сэтгүүл зүй болон Мэдээлэл Харилцаа Холбооны Азийн Институт |
| AMI | Африкийн Хэвлэл Мэдээллийн Санаачилга |
| AMIC | Азийн Хэвлэл Мэдээлэл болон Мэдээлэл Харилцаа Холбооны Төв |
| ASEAN | Зүүн Өмнөд Азийн Улсуудын Ассоциаци |
| BNRM | Нидерландын Хүний Наймаа Болон Хүүхдийн Хүчирхийллийн Эсрэг Товчоо (Агентлаг) |
| CNPq | Бразилийн Судалгаа болон Шинжлэх Ухааны Хөгжлийн Үндэсний Зөвлөл |
| COP | Талуудын Зөвлөлгөөнүүд |
| CPJ | Сэтгүүлчдийг Хамгаалах Хороо |
| ECREA | Европын Мэдээлэл Харилцааны Судалгаа болон Боловсролын Ассоциаци |
| EJC | Европын Сэтгүүл зүйн Төв |
| ESRC | Их Британийн Эдийн Засаг болон Нийгэм Судлалын Зөвлөл |
| GMMP | Глобал Медиа Мониторингийн Төсөл |
| ILO | Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага |
| IOM | Олон Улсын Цагаачлалын Байгууллага |
| IPDC | (ЮНЕСКО) Мэдээлэл Харилцааны Хөгжлийн Олон Улсын Хөтөлбөр |
| IWMF | Олон Улсын Эмэгтэйчүүдийн Хэвлэл Мэдээллийн Сан |
| JIT | Хамтарсан Эрэн Сурвалжлах Баг |
| LGU | Орон нутгийн өөрийн санхүүжилт бүхий зөвлөл |
| MDGs | Мянганы Хөгжлийн Зорилтууд |
| MMR | Гахайн хавдар-салхин цэцэг-улаан бурхан |
| MoHE | Дээд Боловсролын Яам |
| NGO | Төрийн Бус Байгууллага |
| NWICO | Шинэ Ертөнцийн Мэдээлэл болон Мэдээлэл Харилцааны Журам |
| OSCE | Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Нийгэмлэг |
| PBL | Төсөлд тулгуурласан сургалт |
| PUS | Шинжлэх ухааны талаарх олон нийтийн ойлголт |
| SADC | Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэг |
| UNODC | НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис болон гэмт хэрэгтэй тэмцэх алба |
| WAN/IFRA | Сонин болон Хэвлэн Нийтлэгчдийн Дэлхийн Ассоциаци |
| WFSJ | Шинжлэх Ухааны Сэтгүүлчдийн Дэлхийн Холбоо |
| WJEC | Дэлхийн Сэтгүүл Зүйн Боловсролын Зөвлөл |
| WJEC-1 | Анхдагч Ертөнцийн Сэтгүүл Зүйн Боловсролын Конгресс |
| WJEC-2 | Хоёрдогч Ертөнцийн Сэтгүүл Зүйн Боловсролын Конгресс |
| WJEC-3 | Гуравдагч Ертөнцийн Сэтгүүл Зүйн Боловсролын Конгресс |

# I. ӨМНӨХ ҮГ

Энэхүү бүтээл нь сэтгүүл зүйн боловсролын талаарх ЮНЕСКО-гийн маш чухал цуврал юм. 2008 оны дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралын үед сэтгүүл зүйн боловсролын тогтолцоо, ялангуяа технологийн хувьсал хүчтэй өөрчлөгдөж байхтай зэрэгцэн хөгжингүй орнуудын хэвлэл мэдээллийн хөтөлбөр батлагдсан.

Түүнээс хойш хөгжиж байгаа орнуудын хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн байгууллагуудад сэтгүүл зүйн боловсрол, хөтөлбөрөө стратегийн хувьд хямралын бодит нөхцөл байдалд нийцүүлж дахин төлөвлөх, өөрчлөх нөхцөл байдал тулгараад байна.

Ялангуяа хөгжиж байгаа орны сэтгүүл зүйн боловсрол болон хэвлэл мэдээлэлд энэ өөрчлөлт нь илүү их нөлөөлөх боллоо. Тиймээс ЮНЕСКО-гийн хувьд эдгээр хүндрэл бэрхшээл, өөрчлөлтөд хариулт өгөх маш олон арга замыг эрэлхийлж байна.

Уг хөтөлбөр нь 2007 онд боловсруулсан Сэтгүүл зүйн боловсролын ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөртэй дахин танилцахад дөхөм болох юм. Одоогоор тус хөтөлбөр нь 60 гаруй орны 70 орчим сэтгүүл зүйн сургуулийн хүртээл болсноор тэдний сэтгүүл зүйн мэдлэг болон арга барилд шинэ өөрчлөлтийг бий болгоод байна. Нийгэм, улс төр, эдийн засаг, технологийн хурдацтай өөрчлөлтөөс хамаарч шинэ хөтөлбөрийн дагуу эдгээр байгууллага сэтгүүл зүйн арга барил, техникээ өөрчлөх шаардлагатай боллоо. Уламжлалт сэтгүүл зүйн мэдээний өрөө болон танхимийн хичээл зэрэг зөвхөн багшид тулгуурласан сургалт биш харин тогтвортой хөтөлбөр, шинжлэх ухаан, харилцаа холбоо, утга зохиол, уул уурхайн өгөгдөл, хүний наймаа, жендерийн асуудал зэрэг шинэ салбарууд энэ хөтөлбөрт багтсан байгаа. Хөтөлбөрт багтсан бүх хичээл сургалтыг стратегийн түншлэл, сэтгүүл зүйн боловсролын шинжээч болон дэлхийн хэвлэл мэдээллийн хөгжлийн байгууллагуудтай хамтран боловсруулсан болно. Зохиогчид салбарын хөтөлбөрөө ямар ч үнэ төлбөргүйгээр ЮНЕСКО-д бэлдэж өгсөн юм. Сэтгүүл зүйн боловсролын талаарх дэлхийн чиг хандлага болон нарийн судалгаанд үндэслэж энэхүү хөтөлбөрийг боловсруулсан. ЮНЕСКО-гийн хувьд зохиогч болон эрдэмтэн судлаачдад ямар нэгэн хариу төлөөсгүй болно.

Жанис Карлинс
ЮНЕСКО-гийн Мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан туслах захирал

# II ТАНИЛЦУУЛГА

Факсон Банда

ЮНЕСКО-гийн сургалтын хөтөлбөрийн товч танилцуулга нь дараах стратегийн чухал асуултад хариулах болно. Сэтгүүл зүйн боловсролыг илүү шинэчлэхийн тулд юу хийх ёстой вэ? Энэ асуулт нь Гуравдагч Ертөнцийн Сэтгүүл зүйн Боловсролын Конгрессын (WJEC-3) гишүүдэд тулгарсан асуулт юм. Энд үндсэндээ хоёр үзэл санаа бий. Нэгдүгээрт, сэтгүүл зүйн боловсролын түүхэн замналыг хүлээн зөвшөөрөх. Хоёрдугаарт, сэтгүүл зүйн өөрчлөлтийн ирээдүйн замналын талаар дахин ярилцаж тохирох юм.

Дээрх асуултууд нь нийгэм, улс төр, эдийн засгийн нарийн төвөгтэй багц асуудлуудыг хөндөж байна. 2008 оны эдийн засаг, санхүүгийн хямралын дараа ялангуяа хөгжсөн орнуудын сэтгүүл зүйд цаашид үр дүнтэй байж болох маш олон туршилт хийсэн. Сэтгүүл зүйн боловсрол ирээдүйд ч маш олон хүндрэл бэрхшээлтэй тулгарах болно. Ховард Фингергийн Европын сэтгүүл зүйн төв дээр хэлсэнчлэн "Бид өөр төрлийн заах арга зүй нэвтрүүлснээр танхимын сургалтаа сайжруулах талаар шинийг санаачлах хэрэгтэй байна. Түүнчлэн сэтгүүл зүйн боловсролыг маш энгийн амархан аргаар эзэмших талаар ч шинийг санаачлах хэрэгтэй байна" (2012). Түүний дэвшүүлсэн шинийг санаачлах гэсэн энэ санаанд Нью-Йоркийн Карнеги Корпорацийн Дэйн С. Клауссен хариулт өгсөн юм. Түүнийхээр бол АНУ-ын Сэтгүүл зүйд маш өндөр ёс суртахуунтай дүн шинжилгээ хийдэг хүмүүс, сэтгүүл зүйн арга барилтай мэргэжлийн шинжээч, эрүүл мэндийн салбарын тоймч, эдийн засгийн болон бусад нарийн төвөгтэй сэдвийн тоймч, хамгийн анхан шатны нийгэм, олон нийт, хэл, шашин, соёлын мэдлэгтэй шинжээч хэрэгтэй байна. (2012)

Сэтгүүл зүйн үүрэг роль, үйл ажиллагаа нь АНУ-аас гадна дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Жишээ нь Бергер ба Фүүт (2013)-д тэмдэглэхдээ: сэтгүүл зүйн сургалт нь зөвхөн академик эрх чөлөөний практик биш. Цаашлаад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сэтгүүл зүйн арга барил болон сэтгүүл зүйн бусад тулгуур зарчмуудыг хамт авч үзэх хэрэгтэй юм. Сэтгүүл зүйн боловсролтой холбоотой өөр нэг эрх чөлөө нь сургалтаар хангуулах явдал юм. Сэтгүүл зүйн ур чадвар эзэмшсэн хүмүүс өөр салбар луу шилжихэд амархан байдаг. Зарим тохиолдолд сэтгүүл зүйд суралцсан оюутнууд санаандгүй байдлаар өндөр түвшний мэдээлэл болон харилцаа холбооны ур чадвар эзэмшиж чөлөөт либерал урлаг судлал, эсвэл

түүнтэй холбоотой бусад мэргэжлүүдийн салбарт шилжиж чаддаг. Хэдийгээр дээр дурьдсанчилан сэтгүүл зүйн боловсролд шинэ өөрчлөлт гарч хүндрэл бэрхшээл туулж байгаа хэдий ч энэ салбар нь хөгжсөөр байна.

Бергер ба Фүүт нарын судалснаар дэлхийн сэтгүүл зүйн боловсролын өсөлт хөгжил нь хувийн салбарыг өөртөө татаж тэдний оролцоог нэмэгдүүлж байгаа хэдий ч маш олон бүс нутагт ялангуяа хөгжиж байгаа орнуудад арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон сэтгүүл зүйн сургалтууд нь чанаргүй боловсролтой оюутнуудыг бэлтгэж байна гэсэн шүүмжлэлийг дагуулж байна. 1980-аад онд Азийн орнуудын хэвлэл мэдээллийн салбарын хөгжилд тэсрэлт гарч хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд сэтгүүл зүйн боловсролын эрэлт хэрэгцээ маш их нэмэгдсэн. Харин 1990-ээд онд Ойрх Дорнод болон Африкийн улсуудад сэтгүүл зүйн боловсролын хөгжил эрс хурдассан. 2000-аад оноос сэтгүүл зүйн боловсрол их дээд сургуулийн хэмжээнд очиж дэлхийн түвшинд ойртсон юм. Одоогоор Хятад болон Энэтхэгт сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөр маш ихээр нэмэгдэж байна. Дэлхийн сэтгүүл зүйн боловсролын зөвлөл (WJEC) нь сэтгүүл зүйн боловсролыг 2007 онд эхлүүлсэн. Бергер, Фүүт нарын 2013 онд гаргасан тайланд дэлхий даяар нийт 3000 орчим сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөр бүртгэгдсэн тухай тэмдэглэжээ. Эдгээрийн дийлэнхийг нь Хойд Америк, Европ, Ази тив эзлэж байна.
Энэ өсөлт нь боловсролын зах зээлээс шууд хамаарч байгаа ажээ. Найт Сангийн судалгааны тайлангаас үзвэл:

> Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 85 хувь нь сэтгүүл зүйн боловсрол болон мэргэжлээ дээшлүүлэхэд зориулж олон зүйл сурна, маш хэрэгтэй хөтөлбөр гэж хариулсан.
>
> Техасын их сургуулийн Найт төвийн төгсөгчид голдуу, Латин Америкийн зайн сургалтыг дүүргэсэн олон улсын сэтгүүлчид нэмэлт сургалтаас илүү их зүйл сурна хэмээн найдаж байна. Тухайлбал, 10 хүний 9 нь маш их зүйл сурна, хэрэгтэй, ашигтай гэж хариулжээ.
>
> АНУ-ын сэтгүүлчдийн хувьд 75 хувь нь маш их зүйл сурна, хэрэгтэй, ашигтай гэж үзсэн. Өмнө нь 2002 онд хийсэн Мэдээний өрөөний сургалтын судалгаагаар сэтгүүлчдийн 54 хувь нь ингэж хариулж байсан юм.
>
> Харин судалгаанд оролцсон сэтгүүлчдийн дөнгөж 3 хувь нь сургалтын хөтөлбөр хэрэггүй, ашиггүй эсвэл хариулж мэдэхгүй байна гэжээ.

Судалгаанд оролцогчдын 97% нь ямар нэг байдлаар сургалт ашигтай хүртээлтэй гэж хариулсны тал хувь нь маш их хэрэгтэй, маш сайн сургалт хэрэгтэй гэж хариулсан.

(МакЛеннан ба Ньютон, 2012)

Дэлхийн сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөрийн чанарт хэт их ач холбогдол өгөх хэрэггүй. Учир нь Бергер, Фүүт нар сэтгүүл зүйн боловсролын амин чухал зорилго нь хаана ямар сургалтын төвд хэн зааснаас үл хамааран зөвхөн оюутны боловсрол биш харин сэтгүүл  зүйн өөрийнх нь хөгжил хамгийн чухал гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн боловсролын чанар нь олон нийт болон иргэдийн сэтгүүл зүйн боловсролын чанарт нөлөөлөх учиртай юм. Сэтгүүл зүйн боловсрол нь зөвхөн энэ салбарын ажилтан, ажиллагсад биш харин олон нийтийг боловсруулах үүрэгтэй. Тиймээс сэтгүүл зүйн боловсролын багш сурган хүмүүжүүлэгчид дараах саналыг хүргүүлж байна. Энэ нь сэтгүүл  зүйн салбарын хамгийн чухал зорилго болох олон нийтэд үйлчлэх, хэвлэл мэдээллийн салбарын ашиг сонирхолд нийцүүлэх, мөн мэдээ, сурвалжлагыг чанаржуулах юм.(Фергер ба Фүүт, 2013).

Энэ бүхний эцэст ЮНЕСКО-гийн 195 гишүүн орон онлайн болон бусад мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, олон ургальч байх эрх чөлөөний зохистой стандартыг гаргахад санал нэгдсэн. Хэвлэлийн эрх чөлөөний энэхүү стандартад хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааны багтаамж, чадвар ялангуяа маш хурдтай хөгжиж байгаа технологийн агууламж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тулгуурлаж байгаа шинэ сорилт бэрхшээлийн талаар тусгасан байна.
ЮНЕСКО-гоос гаргасан сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөрийн энэ загвар нь тухайн улс орны сэтгүүл зүйн чанарыг дээшлүүлэх, олон улсын түвшинд сайн туршлага бүхий хэм хэмжээг тогтоох зорилготой юм. Мөн мэргэжлийн сэтгүүл зүйн стандартыг гаргаснаар хэвлэл мэдээллийн салбараар дамжуулан ардчиллыг бэхжүүлж хөгжүүлэхийг зорьж байна. Сэтгүүл зүйн багш нар болон оюутнууд мэдээллийн байгууллагуудын түвшинд сэтгүүл зүйн бүтээгдэхүүний чанар, үр нөлөөг хамтдаа дээшлүүлэх боломжтой хэмээн ЮНЕСКО итгэдэг. Ялангуяа хөгжиж байгаа орнуудын нийгмийн хөгжил болон ардчиллын үйл явцад сайн сургалттай мэдээний редакцыхан болон шүүмжлэлт сэтгэлгээтэй сэтгүүлчид эерэг үр нөлөөг үзүүлнэ гэдэгт ЮНЕСКО итгэж байна. Чанартай сэтгүүл зүйн боловсрол нь ардчилал болон нийгмийн хөгжилд төдийгүй хэвлэлийн эрх чөлөөний баталгаа болж өгнө.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 10 гаруй мэргэшсэн хөтөлбөрийг санал болгодог. Эдгээрээс ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөр дээр нэмээд хоёр тусдаа хөтөлбөрийг оруулсан:

- 2012 оны 8-р сарын 8-нд АНУ-ын Чикаго хотод Сэтгүүл Зүй болон Олон Нийтийн Мэдээлэл Харилцааны Боловсролын Ассиоциациас зохион байгуулсан “Хөгжиж байгаа орнуудад болон шинэ тулгар ардчилсан орнуудад сэтгүүл зүй заах: ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөр” семинар;
- Есдүгээр сарын 27-нд Истанбулд Европын Харилцаа Холбооны судалгаа ба Боловсролын Ассоциацийн (ECREA)-ийн дөрөвдэх Европын Харилцаа Холбооны зөвлөлгөөнөөр хэлэлцсэн “Сэтгүүл зүйн хөгжилд зориулсан ЮНЕСКО-гийн мөрдлөг”

ЮНЕСКО-гийн Загвар хөтөлбөрийг 2007 онд Сингапурт Сэтгүүл зүйн Боловсролын Конгрессийн чуулган дээр танилцуулсан. 2012 он гэхэд олон янзын хэл соёлтой, нийгмийн харилцаагаараа ялгаатай 60 орчим улс орны 70 гаруй сэтгүүл зүйн сургууль уг хөтөлбөрийг нутагшуулж сургалтын хөтөлбөртөө оруулсан байдаг.

2007 оноос хойш ЮНЕСКО-гийн уг загвар хөтөлбөр дэлхийн сэтгүүл зүйн боловсролын салбарт хэрхэн нөлөөлж, хэрэглэгдэж байгааг үнэлж дүгнэсэн. Дээр дурьдсан Чикаго болон Истанбулын хоёр академик семинарын үнэлэлт дүгнэлт нь эдгээрийн жишээ юм. ЮНЕСКО-гийн эдгээр хоёр үнэлгээ нь сэтгүүл зүйн боловролын хөгжлийн ирээдүйн урьдчилсан дүгнэлт болж чадсан. Эдгээрийн гол бүрэлдэхүүн хэсэг нь (I) дэлхийн сэтгүүл зүйн боловсролын академик соёл, (II) хөтөлбөрийн загварын ирээдүйн хэрэгжилт, (III) ирээдүйд тулгарч болох зүйлд зориулсан шинэ хөтөлбөрийн талаар судалж хайж олох явдал юм.

## Сэтгүүл зүйн боловсролын дэлхийн академик соёл

Их, дээд сургуулийн өргөн цар хүрээтэй академик соёл нь сэтгүүл зүйн талбарт болоод бодит амьдралд нийцэж байгаа эсэх нь гол асуудал юм.  2005 оны эхээр Парисын сэтгүүл зүйн боловсролын салбарын шинжээчдийн чуулга уулзалтаар их дээд сургуулиудийн оюуны болон академик соёлыг уг хөтөлбөрт багтааж өгсөнийг олонх нь дэмжин сайшаасан. Хөтөлбөрт багтсан сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгчдийн амжилт, сэтгүүл зүй эсвэл олон нийтийн мэдээлэл харилцаа зэрэг

нь уг хөтөлбөрийн гол цөм нь юм. (Банда болон Шмиц Вайс үзээрэй, 2013).
Уг уулзалт семинар нь зарим улс орон сэтгүүл зүйн боловсролдоо өөрчлөлт шинэчлэл хийж байх үетэй давхцсан юм. Жишээ нь 2005 оны 10-р дугаар сард Бразилын Шинжлэх Ухааны Хөгжил, Судалгааны Үндэсний зөвлөл буюу улсаас санхүүждэг шинжлэх ухааны агентлаг нь Шинжлэх ухааны хөгжлийн салбартаа шинэчлэлт, өөрчлөлт хийсэн. Сония Витжиния Морейрегийн хэлснээр боловсролын салбарын шинэчлэлтийн бодлого нь сэтгүүл зүйн онол, судалгааны салбарт дэвшил гарсныг баталгаажуулж байна. Харилцаа холбооны салбар нь нийгмийн шинжлэх ухаантай бодит байдал дээр ойртон нэгдэх ажээ. Хэд хэдэн холбогдох шинжлэх ухааны профессор, судлаач, төлөөлөгчид нэлээд хугацаанд мэтгэлцсэний дүнд баримт бичигт гарын үсэг зурснаар харилцаа холбооны салбарыг зургаан дэд салбарт ангилахаар санал нэгдсэн. Үүнд:  Кибер соёл ба харилцаа холбооны технологи; Аудио, видео буюу дуу дүрс бичлэгийн; кино, радио, телевиз; байгууллагын зохион байгуулалттай харилцаа холбоо ба олон нийттэй харилцах болон зар сурталчилгаа; эвлэрүүлэн зуучлах болон харилцаа холбооны ба харилцан үйлчлэлийн зааг; харилцаа холбооны онолууд хэмээн зургаан салбар юм. Мөн сэтгүүл зүйн есөн салбарт дээрх дэд бүлгүүдийг багтаасан. Тухайлбал, Бразилчууд харилцаа холбооны салбарыг дараах байдлаар шинэчилсэн. Үүнд: мэдээлэл харилцаа, шинжлэх ухаан, цахим, бизнес, мэргэшсэн, онлайн, төрөлжсөн болон орон нутаг гэсэн есөн салбар нэмээд гурван салбарыг оруулсан. Эдгээр нь редактор, хэвлэл мэдээлэл ба сэтгүүл зүйн түүх юм. (Банда ба Вайс, 2013).

Мэдээж шинэчлэл хийхэд асуудал заавал тулгардаг. Сэтгүүл зүйн ангиудад Морейрагийн хэлснээр “сэтгүүлч-профессор” биш заавал мэргэжлийн зэрэг эсвэл дипломтой багш нар хичээл заахыг шаарддаг байсан. Энэ шалгуур нь салбарын мэргэжилтнүүдийн ихэнхийг үргэлжлүүлэн их дээд сургуульд хичээл заахад хаалт болж байв. 1980-аад онд хэвлэл мэдээллийн салбарын хэсэг залуу мэргэжилтэн мэдээний өрөөнөөс сургуулийн танхим руу шилжсэн нь сайшаалтай зүйл болсон. Тэдний ихэнх нь сэтгүүл зүй болон харилцаа холбооны судалгаа хийж байсан туршлагатай тул сэтгүүл зүйн онол, практикийг хослуулан заах чадвар, туршлагатай болж төгссөнөөр зоосны хоёр талыг нэгдүүлж чадсан.

Бразилийн сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгчид дээр дурьдсан шинэчлэлийн үр дүнд гол бэрхшээлтэй тулгарсан. Учир нь дээрх шинэчлэлээр сэтгүүл зүйн сургалт явуулахад “лаборатори” хэмээн нэрлэгддэг мэргэжлийн талбарыг дахин шинэчлэх хүрээнд сайн тоног төхөөрөмж шаардлагатай болсон.  Ингэснээр хэвлэл мэдээллийн редакци, сэтгүүл зүйн сургалтаас тусгаарлагдсан.

Өмнө нь “сэтгүүлч-профессор” загвар ашиглагддаг байв. ЮНЕСКО-гийн гаргасан загвар  хөтөлбөрөөр бол өнөөдөр хэвлэл мэдээллийн байгууллага болон академик сургалтын гүүр нь дадлагажигч оюутан. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн оюутан хэвлэл мэдээллийн байгууллага дээр очиж дадлага хийх явдал юм.

Бразилын шинэчлэлийн дагуу сэтгүүл зүйн талбарыг их сургуультай хослуулснаар түүнийг хууль ёсны болгоод зогсохгүй бусдад таашаагдах салбар болгох сайн талтай. Энэ нь 2007 онд Сингапурт болсон Сэтгүүл зүйн Боловсролын Зарчим (WJEC-1) уулзалт семинар дээр зарласантай ижил төстэй юм. Уг хурал дээр зарласан 11 зарчмаас дурьдвал:

> Бид сэтгүүл зүйн практикийг хөгжүүлэх хариуцлага хүлээх үүднээс онол, судалгаа, сургалтыг сэтгүүл зүйн боловсролын үндэс суурь гэдэгтэй санал нэгдсэн. Сэтгүүл зүйн боловсролыг олон янзаар тайлбарлаж, тодорхойлдог. Гол цөм нь сэтгүүл зүйн бүх төрлийн сургалт юм.
> Сэтгүүл зүй  нь олон нийтэд маш чухал арга замаар үйлчилдэг. Гэвч энэ нь зөвхөн олон талын мэдлэг, тусгай ур чадвартай, мэргэжлийн сэтгүүлчдээс бүрдсэн байх ёстой. Дээр дурьдсанаас гадна хариуцлагатай сэтгүүлч нар олон нийтийн өмнө зөв ёс суртахууны үүрэг хүлээсэн байна. Энэ үүрэг хариуцлагад олон нийтийн өмнө нийгмийн хөгжлийг сайжруулахад сэтгүүл зүйн үүрэг роль, оролцооны талаар дурьдсан байдаг.
> (WJEC, 2008)

Зарчмууд нь сэтгүүл зүйн боловсролын цөм, үзэл баримтлалын гүн ухаан болон ур чадварт суурилсан агуулгын тэнцвэр юм хэмээн онцолсон. Энэ нь салбар дундын боловч сэтгүүл зүйн боловсрол нь академик талбарын эрх үүрэг, мэдлэг болон онолын цогц юм. Цаашилбал “Сэтгүүл  зүй нь их дээд сургуулийн бакалаврын болон бакалаврын дараах түвшний сургалтын боломжит талбар” юм. Сэтгүүл зүйн хөтөлбөрийг бакалавр, философийн магистр, докторын зэрэг болон сертификаттай хүмүүст зориулсан. 2010 он Өмнөд Африк (WJEC-2) –т ‘Ultimate Journalism Education’ буюу “Сэтгүүл зүйн төгс боловсрол” нэрийн дор чуулсан чуулганаар “Сэтгүүл зүй нь бие даасан гурав эсвэл дөрвөн жилийн сургалтын жилтэй байхыг шаардаагүй. Сэтгүүл зүйн боловсрол нь их сургуулийн бусад төрлийн мэдлэгт тус нэмэр болдог салбар юм” хэмээн үзсэн. (Норденстренг, 2010)

Уг зарчимд сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгч нь академик болон практик түвшний давхар туршлагатай, өөрөөр хэлбэл багш нар сэтгүүлчээр ажиллаж байсан байх ёстой гэж зааж өгсөн.

Дээр дурьдсан ажиглалт судалгаа нь мөн Истанбулд болсон чуулган дээр яригдсан юм. Туркын Анадолу Их Сургуулийн профессор Доктор Инклей Кангоз нь ямар ч сэтгүүл зүйн хөтөлбөр нь улс төр болон нийгмийн асуудалд анхаарал хандуулахын зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбарын өөрчлөлтийг байнга тусгаж байх үүрэгтэй гэжээ. Түүний Испани хамтрагч Мадридын III Карлосын (Carlos III de Madrid) Их сургуулийн профессор Пилар Каррера сургууль хоорондын сэтгүүл зүйн боловсрол нь академикийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл зүйн талбарт бие даасан байх ёстой (Бранда ба Шмиц вайс, 2013) хэмээн үздэг юм.

Эдгээр санаа нь ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийн гол зарчимтай ижил төстэй буюу 'WJEC философи' гэж нэрлэгдэх болсон (Норденстрен, 2010) бол сэтгүүл зүй нь нийгмийн практик мэдлэг,  ур чадварын суурь юм.

## ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийн хавсарга ба түүний ирээдүйн ойлголт

ЮНЕСКО-гийн сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөрийг бэлтгэхэд тулгардаг нэг бэрхшээл бий. Тэр нь олон улс үндэстэн болон бүс нутгийн амьдралын онцлог, соёлын ялгаа, туршлагыг тухайн орны сэтгүүл зүйн салбарт тааруулж боловсруулах явдал юм. Өөрөөр хэлбэл, ЮНЕСКО-гийн сэтгүүл зүйн боловсролын стандартыг тухайн улс үндэстэн өөрийн соёл болоод туршлагадаа тааруулан нутагшуулж амьдрал ахуйдаа хэрэглэх явдал. Эдгээрийг дагалдаад хэвлэл мэдээллийн салбар болоод боловсролын тогтолцооны өөрчлөлт, улс үндэстнүүдийн тэгш бус амьдралын хэв маяг гэх мэт бэрхшээл дагалдан гарч ирдэг.

Истанбулд болсон чуулганаар 'universalizing' буюу сэтгүүл зүйн боловсролыг нэг стандартад оруулах байдлыг шүүмжилсэн. Үүнтэй уялдан ЮНЕСКО дата сэтгүүлзүй болон хэвлэл мэдээллийн тогтвортой байдал гэсэн хоёр шинэ хөтөлбөрийг нэмж боловсруулсан. Энэ хоёр хөтөлбөрт дээрх асуудлуудыг тусгасан байгаа.

Үүнтэй уялдан эрдэмтэн судлаачид ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийг дэлхий нийтийн сэтгүүлзүйн боловсролын нэг стандарт уу, үгүй юу гэдэг дээр санал зөрөлдсөн. Жишээ нь Истанбулд болсон ЮНЕСКО-гийн чуулган дээр Конкордия Их сургуулийн Ким Саучук "Дэлхийн нэг стандарт гэдэг нь эргэлзээтэй" талаар дурьдсан. Тэрээр үүнийгээ сэтгүүл зүйн боловсролын харилцан тогтолцоо гэж

нэрлээд “Сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөр зохиож байгаа бол тухайн орон нутгийн хүмүүст тохируулсан, тэдний амьдрал ахуй ёс заншилд тааруулсан хөтөлбөр гаргах ёстой. Учир нь тэд эмзэгээр хүлээж авна” (Банда ба Шмиц Вайс, 2013) гэсэн байдаг.

Энэ асуудлыг шийдэхийн тулд нийгмийн шинжлэх ухааны арга зүйгээс тусгаж ашиглах нь өөр өөрийн соёл иргэншилтэй хүмүүст арай ойлгомжтой болно. Бид Майкл Пүүл (2007, ху. 22)-ийн судалснаар тайлбарлая.

> Загварын хамгийн чухал шалгуур бол зогсолтгүй үргэлжлэх шинж юм. Загварт:
>
> - Эерэг шинж чанар – Хоёр төстэй шинж чанар
> - Сөрөг шинж чанар – Хоёр өөр шинж  чанар
> - Төвийг сахисан шинж чанар – эерэг ч биш, сөрөг ч биш шинж чанар
>
> Мэри Хесс, Пүүл нарын сануулснаар харьцуулалт нь хэр үр дүнтэй, удаан үргэлжлэхийг  мэдэхгүй. Тухайн загвар төгс биш байж болох юм (2007, ху. 22).

Эдгээр загвар нь хоорондоо төсгүй, өөр өөр байж болох юм. Тиймээс ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөр тухайн улс үндэстэнд  таарахгүй арай өөр байдлаар ойлгогдож магадгүй юм. Эерэг ч бай, сөрөг ч бай, төвийг сахисан ч бай агуулга нь ерөнхийдөө төстэй байх ёстой.

Хөтөлбөрийн хувьд тухайн орон нутгийн онцлогоос хамаарч бага зэргийн өөрчлөлт хийж болно. Гэхдээ зарим тохиолдолд тухайн улс үндэстэн, орон нутгийн ойлголтод хэт тааруулж тохируулах нь сөрөг үр дагавар авчирдаг. (Жишээ нь Ирак байна) (Павлик эт ал., 2012) Номхон далайн хэвлэл мэдээллийн төвийн Рахшана Аслам энэ хөтөлбөртэй танилцаад бага зэрэг санал зөрсөн байдаг (Аслам, 2012).

Учир нь Номхон далайн орнуудын хувьд сэтгүүл зүйн мэдлэг туршлага, эерэг орчны нөөц бололцоо болон хэвлэл мэдээлэлд нэвтрэх, мэдээлэл олж авах бололцоо бага байдаг. Тиймээс ЮНЕСКО-гийн сэтгүүл зүйн боловсролын чиг үүргийг шууд дагах боломжгүй байдгаас тэдний хувьд загвар хөтөлбөр нь сөрөг байдлаар ойлгогддог. Учир нь тэд барууны буюу дэлхийн сэтгүүл зүйн үзэл санааг имперaлист үзэл санааны үүднээс ойлгодог. Тухайн улс үндэстэн ЮНЕСКО-гийн хөтөлбөрийг өөрсдийн соёл иргэншил, ёс заншлын үүднээс хүлээн авдагаас болж тус загвар улс бүрт өөр өөр байдлаар буудаг. Жишээ нь: Эрик Фридмэн,  Ричард Шафер нарынхаар бол “Шинэ тулгар ардчилсан орнуудын тухайд орон нутгийн бага орлоготой сэтгүүл зүйн салбарт хэт өндөр стандарттай хөтөлбөрт хамрагдсан

хүмүүсийн ихэнх нь бизнес болон төрийн албанд хүчин зүтгэх тохиолдол байдаг” ажээ. Үнэхээр ч ижил төстэй бусад оронд ч яг ийм үзэгдэл давтагддаг тул чанартай сэтгүүл зүйн боловсрол шаардлага хангахгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, тусгайлан бэлтгэгдсэн өндөр ур чадвартай сэтгүүлчид бага орлоготой хэвлэл мэдээллийн салбарт ажиллах бус харин илүү нөхцөл бүхий бусад салбарт шилжих тохиолдол байдаг юм. Хөгжингүй орнуудад ажлын байрны нөхцөл байдал илүү сайжирч байгаа (Фридмэн ба Шафер, 2010).

Үнэн хэрэгтээ ЮНЕСКО-гоос гаргасан сэтгүүл зүйн боловсролын загвар хөтөлбөрийн төвүүд Африкын улс орнуудад маш амжилттай үйл ажиллагаа явуулж орчин үеийн сэтгүүл зүйг хөгжүүлж байна. Цаашлаад өндөр ур чадвартай сэтгүүлчдийг тухайн загвар хөтөлбөрийн тусламжтайгаар бэлтгэж болох юм (Бергер ба Матрас, 2007). Загвар хөтөлбөрийн стандарт гарснаар улс орнууд үйл ажиллагаагаа түүнд нийцүүлэхийн тулд илүү чармайх боллоо. Эдгээр өөрчлөлтийн онол тивээс тив хооронд маш олон хэвлэл мэдээллийн салбарын хөгжилд нэмэр болж байгаа юм (Сусман-Пенья, 2012).

Гэхдээ олон улс загвар хөтөлбөрийг өөрсдийн сэтгүүл зүйн боловсролын салбарт ашиглахад тохиромжтой байна гэснээр дээрх шүүмжлэлүүд няцаагдаж байна. 2011 оны байдлаар Афганистан, Хятад, Гаяна, Иран, Ямайк, Лесото, Мавритус, Мексик, Монгол, Пакистан, Руанда, Өмнөд Африк, Танзана улсын сэтгүүл зүйн сургалтын төв болон институциуд загвар хөтөлбөрийг ямар нэг байдлаар нутагшуулж сэтгүүл зүйн салбартаа ашиглаж байна. Габон, Конго, Узбекстан, Мьянмар зэрэг улс ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийг өөрсдийн сэтгүүл зүйд ашиглах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. ЮНЕСКО-гийн бүртгэлээс харахад дээр дурьдсан 60 орчим улсын 70 гаруй сэтгүүл зүйн сургалтын төв болон институциуд загвар хөтөлбөрийг өөриймшүүлэн нутагшуулж сургалтын хөтөлбөртөө ашиглаж байна. 2012 оны 05-р сарын 16-ны байдлаар ЮНЕСКО-гийн вэб сайтнаас 12,223 удаа хөтөлбөрт хандаж, Англи, Араб, Хятад, Франц, Португали, Орос, Испани, Непал хэл дээрх хичээлийг татаж авчээ (Банда болон Шмитц Вейс, 2013).
Эдгээрээс гадна маш олон улс уг загварыг сургалтынхаа хөтөлбөр болгон ашиглаж байна. Жишээ нь 2012 оны байдлаар ЮНЕСКО-гийн олон улсын харилцаа холбооны хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Лагосын их сургууль, Ибаданы их сургууль, Лагосын Политехникийн их сургуулиуд тусгай сургалт явуулж хөтөлбөртөө ашиглажээ. Нигери улсад л гэхэд 11 сэтгүүл зүйн институц, ЮНЕСКО-гийн сургалтын хөтөлбөрийг хэрэглэж байна. Үүнд Лагосын улсын их сургууль,

Авргачийн их сургууль, Нигерийн их сургууль, Шашины их сургууль зэрэг багтана. Бусад нь Сэтгүүл зүйн институци, Сэтгүүл зүйн олон улсын институци, Ахмадугийн технологийн их сургууль, Пан Африкийн их сургууль, Яаба технологийн коллеж, Ал-Хикма их сургууль (ЮНЕСКО, 2012) юм.

Эдгээр шүүмжлэл нь хөгжсөн болон хөгжиж байгаа орнуудын ёс заншил, сэтгүүл зүйн хөгжлийн зааг ялгааны талаар маш тод харуулсан. Жишээ нь: АНУ-д ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөр хэрэгжих суурь хөрс нь бүрдсэн байна. Клауссений хэлснээр:

- Загвар хөтөлбөр нь ардчиллыг бэхжүүлэх, хөгжүүлэхэд нь сэтгүүл зүйн оюутнуудад ихээхэн дэм болох юм. Жереми Кохен болон Кол Кампбелл-нарын тодорхойлсноор АНУ-ын сэтгүүлчид улс төр болон засгийн газрын талаарх мэдээлэл бэлтгэдэг байсан бол энэ хөтөлбөр гарснаар тэдэнд шинэ сэдэв, шинэ сонголт гарч ирсэн.
- Олон улсын болон хөгжлийн сэтгүүл зүйн хөтөлбөр, Бразилын Сония, Виржиния, Морейра –гийн хөтөлбөрт оруулсан сэтгүүлзүйн хөтөлбөрүүдийг оюутнууд унших шаардлагатай. Мөн ЮНЕСКО-гийн олон улсын сэтгүүл зүйн ёс суртахууны зарчмын талаар ч унших хэрэгтэй. АНУ-ын мэргэжлийн сэтгүүлчдийн ёс суртахууны код нийгэмлэгийн зүгээс сэтгүүлчийн ёс суртахууны талаарх хичээлийн номыг хэвлэж ашиглахыг зөвшөөрсөн байдаг. Энэ хэргийн баримт материал одоо хүртэл байдаг гэдгийг хэн мэдэх вэ?
- Аргентиний их сургуулийн ахлах курсийн оюутан Жорж Лойтигийн улс төр болон засгийн газрын тайлан хөтөлбөрт дурьдсанаар АНУ-ын сэтгүүл зүйн боловсролын тогтолцоо нь яг тийм тогтолцоо байж чаддаггүй. Учир нь тэнд “сонирхлын бүлэг, бусад нөөц хүчин” гол байр суурь эзэлдэг. Түүний жагсааснаар “Зэвсэгт хүчин, Үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага, хувийн компаниуд, ТББ-ууд” уг тогтолцоонд гол байр суурь эзэлсэн байна. Олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөөгүй бүлэглэлүүдийн дарамт шахалтад террористууд, партизанууд, хар тамхи мансууруулах бодис болон зэвсгийн наймаачид, жагсагчид, тэмцэгчид, идэвхтнүүдийг хамааруулсан.

  Эдгээрийн талаар сурвалжлахад хүндрэл бэрхшээлүүд нь тухайлбал, террористууд, партизанууд, хар тамхи мансууруулах бодис болон зэвсгийн наймаачдын талаар сурвалжлахад улс төрийн сонирхолын бүлэглэлээс илүү хүчирхэг байж чаддаггүй байна. Ялангуяа АНУ-д.

  (Клоссен, 2007)

Олон улсын төсөлд оролцогч улсууд болох Австрали, Бенин, Болгар, Канад, Дани, Финланд, Франц, Гана, Энэтхэг,Леван , Морокко, Катар, Сингапур, Өмнөд Африк, АНУ-ууд энэ загвар хөтөлбөрийг судалж танилцсан (Клуйссен, 2007) эрдэмтэн судлаач, шинжээчдийн хувьд сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөрийн талаар аль нэгэн улс сурч, эсвэл өөрийн хууль дүрмэндээ тохируулан ашиглаж болох санааг авсан.

Энэ олон хичээлийн явцад загвар хөтөлбөр нь тухайн улс орны хөрсөн дээр хэрхэн буух талаар үзсэн. Жишээ нь Ази тивийг авч үзье.  Азийн хэвлэл мэдээлэл болон харилцаа холбооны төв ЮНЕСКО-той хамтран загвар хөтөлбөрийг Хинду, Тайланд, Малайз, Индонез болон бусад хэл дээр мэргэжлийн төвшинд, тухайн улс үндэстний соёл иргэншилд нийцүүлэн орчуулах шаардлагатай. Хэрэв хөтөлбөрийг олон улсад хүлээн зөвшөөрүүлж тэдний мэргэжил ажил амьдралд зохицуулъя гэвэл тухайн улсын соёл иргэншилд маш сайн нийцүүлж орчуулах ёстой. Тухайн улс үндэстэн болон бүс нутгийн хэмжээнд сургалтын хөтөлбөр өөр өөрөөр хөрвүүлэгддэг. Азийн Хэвлэл Мэдээлэл ба Харилцааны Төв (AMIC) байгууллага ЮНЕСКО-гийн хөтөлбөр загварыг амжилттай нэвтрүүлж хэрэгжүүлэхийн тулд тухайн улс орон, бүс нутгийн дэд бүтэц болон бусад холбогдох асуудалд анхаарал тавьж дэмжиж ажиллаж байгаа.

Ирак улсын хувьд дайн байлдааны байдалтай байгаа учир сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгчдийг тусгайлан бэлдэх шаардлага тулгардаг. ЮНЕСКО-гийн дэмжиж байгаа стратегийн зөвлөмжид:

- Ирак болон Курдийн бүс нутгийн сэтгүүл  зүйн оюутнуудад сэтгүүл зүйн боловсрол олгохдоо сонголт хийх нөхцлөөр хангах нь чухал. Багдад сурч байгаа Ирак оюутнуудын хувьд Курдийн түүх соёлыг харин Сулайманияд сурч байгаа оютнуудын хувьд Иракийн түүхийн талаар суралцах боломжтой байх ёстой. Энэ нь хоёр үндэстний хооронд соёл, ёс заншлын ойлголтын зөрүүг арилгах онцлогтой.
- Дээд боловсролын яам нь боловсролын технологийн зайн сургалт, онлайн сургалтыг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Ингэснээр хөдөө орон нутаг, алслагдмал сууринд амьдарч байгаа бүх иргэд боловсрол эзэмших боломжтой болно. Мөн  хүмүүсийн боловсрол эзэмших нөхцөл бололцоог ч бүрдүүлэх юм.
- Дээд боловсролын яам нь мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрийг хөгжүүлснээр суралцагсад орчин үеийн дэлхийн академик боловсрол эзэмшин олон нийттэй хөл нийлүүлж, өөрсдийнхөө боловсрол, чадварыг дээшлүүлэх боломжтой болно.

Мэргэжлийн зөвлөлгөө гэвэл хэвлэл мэдээллийн институц болон тухайн салбар хоорондын ажлын уялдаа холбоо юм. Төгсгөлд нь хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд Иракийн гадаа ч, дотор ч тухайн салбарын гүн ойлголтыг оюутнуудад зочин илтгэгч эсвэл шинжээч байдлаар хүргэх хэрэгтэй. Ийм маягаар тэдний харилцааны ур чадвар,  мэдээлэл солилцох байдал, мөн туршлагыг дээшлүүлнэ. Дараагийн зөвлөгөө гэвэл дадлага хийж байгаа оюутнуудыг их сургуулийнхан дэмжих хэрэгтэй. Олон нийт болоод хувийн салбарын түншлэл нь дадлагын үйл явцыг илүү сайжруулах ёстой. Үүнд, зочин илтгэгч, ярилцлага, төсөл дээр тулгуурласан сургалтыг нэрлэж болох юм (PBL).

Нэмж хэлэхэд ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрт оруулсан Иракийн жишээг гадаадад олон улсын сэтгүүлч болохоор бэлтгэгдэж байгаа оюутнуудад зориулсан. Уг хөтөлбөр нь шинэ тулгар ардчилсан улсуудын хувьд анхдагч нь юм. Энэ нь оюутнуудад болон мэдээ цуглуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагуудад Ирак руу орж гарахад ямар хүндрэл бэрхшээл байдаг талаар туршлага болохоос гадна чанартай мэдээ бэлтгэх боломжийг олгож байгаа. Ирак оюутнууд дадлага хийвэл зөвхөн Иракаас гарч дадлага хийнэ. Ирак дотроо хийхгүй. (Павлик, 2012).

## Мэргэшсэн сэтгүүлзүйн суурь боловсролыг судлах нь

ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийн хавсралтад олны танил болсон, олонд хүндлэгдсэн профессоруудын бүтээлийн жагсаалт арвин бий. Үүний зэрэгцээ тус хөтөлбөр бусдын судлаагүй сэтгүүлзүйн судалгааны байгууллагуудын  бүтээлийн агуулгыг гаргаж өгсөн хэмээн Гордон Стюарт Адам судалгаандаа тэмдэглэсэн. Энэхүү судалгааны хөтөлбөр нь тухайн орон нутгийн нөхцөл байдал, соёлын ялгаанаас хамаарч уян хатан байдаг. Түүнчлэн заах арга зүйн аргачлалд хувь нэмэр оруулсан. (Банда болон Смитз Вейс, 2013).
ЮНЕСКО үргэлжлүүлэн дараа дараагийн хөтөлбөртөө сэтгүүл зүйн олон олон туршлагыг оруулна. Энэ хөтөлбөр нь сэтгүүл зүйн чиглэлийн ажилтнуудад маш цэгцтэй системтэй багц мэдээлэл буюу мэргэшсэн сэтгүүл зүйн бичиг үсэгт тайлагдсан байдлын судалгаа болсон. Үүнд хэвлэл мэдээллийн байгууллагын тогтвортой байдал, дата сэтгүүл зүй, олон талт соёлын сэтгүүл зүй, хүйн сэтгүүл зүй, глобал сэтгүүл зүйг дурьдаж болох юм. ЮНЕСКО энэ загвар хөтөлбөрт бодлоготой, шүүмжлэлтэй хандаж нийгэм, соёлын нөхцөл байдлыг оруулж өгсөн юм. (Норденстренг, 2010) Энэ төрлийн тусгай хөтөлбөр нь дэлхийн сэтгүүл зүйн боловсролд тулгараад байгаа асуудлуудыг хөндсөн.

Уг хөтөлбөрт сэтгүүл зүйн хамгийн эхний заалгасан, дадлагажсан, туршлагажсан, судлагдсан чухал категорийг оруулж өгсөн. Мөн сэтгүүл зүйн онолын мэдлэгийг илүү динамик дадлага туршлагатай болгоход энэ хөтөлбөр ач холбогдолтой. Сэтгүүл зүйн боловсрол бол тухайн сэтгүүлч, хувь хүн, институци дадлага туршлагатай болж цаашид өсөж дэвжин сайжрахад маш чухал хөдөлгүүр билээ. Орчин үеийн сэтгүүл зүйн заах арга нь онол, дадлагад тулгуурладаг. ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөр нь сэтгүүл зүйн салбарын ажилчид, багш нарт мэдлэгийн хүрээгээ тэлж дадлага туршлагаа сайжруулах маш сайн гарын авлага болж өгнө.

ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрт багтсан бүх мэдээ, мэдээлэл универсал болсон бөгөөд дараах товч заавраар илэрнэ.

- Хөтөлбөрт боломжтой бол бүс нутгийн өргөн хүрээг хамарсан кейс болон жишээнүүдийг хамруулах хэрэгтэй. Ингэхдээ хөгжиж буй орнуудын жишээг оруулахыг хичээнэ. Ялангуяа цахим болон нээлттэй эх сурвалжуудыг дэмжээрэй.
- Сургалтын хөтөлбөрт аль болох олон улс үндэстний эх сурвалж, материал, ном зүйг багтаах хэрэгтэй. Дахин хэлэхэд хөгжиж байгаа орнуудыг гадуурхаж эсвэл үгүйсгэж болохгүй.
- Дээр дурьдсан хоёр зөвлөгөө, гарын авлага нь нэгдүгээрт уг хөтөлбөр дэлхий нийтийг хамрах, хоёрдугаарт тухайн улс үндэстний мэдлэг туршлагаас үл хамаарч үйл ажиллагааны хүрээгээ тэлэхэд хэрэгтэй юм.
- Хөтөлбөрт хүйсийн асуудлыг маш болгоомжтой хөндөх хэрэгтэй. Мөн үг хэллэгт анхаарах ёстой.
- Хөтөлбөр энгийн, ойлгомжтой, цэгцтэй, товч, цөөн үгээр бичигдсэн байх нь зүйтэй. Ингэж гэмээнэ сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгч, хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн хүмүүсээс эхлээд бодлого тодорхойлогч, олон нийтийг хамарч хүрээгээ тэлэх болно.

Хөтөлбөр нь байнгын өөрчлөгдөж байдаг сэтгүүл зүйн боловсрол ялангуяа олонхийн сонирхол эрх ашгийг багтаасан. Дэлхийн хэмжээнд академик буюу шинжлэх ухааны сэтгүүл зүйн боловсролын тал дээр байнга эсрэг тэсрэг байр суурь гарч ирж байдаг. ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөр, түүний хэрэгжилт нь ирээдүйн сэтгүүл зүйн хөгжлийн төлөө юм. ЮНЕСКО үргэлжлүүлэн судалгаа хийж ялангуяа шинээр гарч ирж байгаа нийгмийн асуудлыг хөтөлбөртөө байнга тусгаж байх болно. Эхний асуудал гэвэл сэтгүүл зүйн эрүүл мэтгэлцээн нь цаашдаа илүү сайн чанартай сэтгүүл зүйг бий болгохын хамт түүнийг сахилга батжуулж байдаг. Загвар

хөтөлбөрийг олон орон өөрийн ёс заншил, соёл, нөхцөл байдалдаа тохируулж нутагшуулж байгаа нь энэ хөтөлбөр хэр сайн болсон бэ гэдгийн  үнэлгээ болж байна. Сэтгүүл зүйн боловсрол бий болсноор цаашид бид хараат бус, бие даасан, олон ургальч хэвлэл мэдээллийн хэрэгслийг үүсгэн төлөвшүүлэхэд том хувь нэмэр болно. Загвар хөтөлбөр улам сайжрах нь сэтгүүл зүйн салбарт шинээр гарч ирэх асуудлаас хамаарах бөгөөд цаашид түүнийг илүү сайн боловсруулах болно. Олон улсын туршлагат энэ хэсгийг ЮНЕСКО “мэдлэгийн нийгэм” гэж нэрлэдэг бөгөөд олон улсын сэтгүүлзүйг дэлхийн болон орон нутгийн агуулгыг үргэлжлүүлэн дэмжсээр байна.

# III ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА БА ХӨТӨЛБӨРИЙН ТОЙМ

Хөтөлбөрийг яаж хэрэглэх вэ? Дадлага туршлагаа үйл ажиллагаандаа нийцүүлэн сэтгэх хэрэглэгчдэд хөтөлбөрийг зориуллаа.  ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийн тусгай хөтөлбөр  нь яг тэгэх ёстой ингэх ёстой гэсэн жор, заавар биш юм. Энэ нь тухайн улс үндэстэн эсвэл институци, багш сурган хүмүүжүүлэгч, сэтгүүл зүйгээр суралцаж байгаа хүмүүст өөрсдийнхөө орчин нөхцөлд тааруулж нутагшуулж авах хэрэгсэл юм. Олон улсын нөхцөл байдал, мэдээлэл авах хүрээ хязгаарлагдмал байх болон бусад шалтгаанаас болж бүх асуудлыг хөндөж чадахгүй байж болно.

- *Сургалтын материал нь өмнө нь байсан курсийг дэмжинэ.* Зарим сэтгүүл зүйн байгууллагуудад уг хөтөлбөр дээр байгаа курс эсвэл модуль байж болох юм. Тэгвэл хөтөлбөрийг цааш нь баяжуулан хэрэглэж болно.  Унших материал хэсэгт орсон, санал болгосон унших зүйлсийн ихэнх нь уг курст байгаа.
- *Шинэ модуль нь аль ч сургалтын хөтөлбөрт ашиглагдаж болно.*  Хөтөлбөрийн аль ч хэсэг нь инноваци тул шинээр танилцуулах эсвэл урьд нь байсан хөтөлбөртэй интеграцичлагдах шалтгаанаар тухайн оюутны мэдлэг, ур чадварыг дээшлүүлж болно.
- *Сургалтын гарын авлага.* Хөтөлбөрийн унших материал гэсэн хэсгийг хараад ямар ч сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгч энэ хөтөлбөрийг өөртөө ашиглахыг хүсэж байгаа.
- *Дадлагажигч оюутны унших материал.* Тухайн дадлага хийж байгаа оюутан унших материалаа маш амархан олж болно. Учир нь ихэнх нь онлайнаар унших боломжтой.  Энэ хөтөлбөрт багтсан унших материалын жагсаалт нь өөрийгөө хөгжүүлэх, ур чадвараа дээшлүүлэх, дадлага хийхэд дөхөмтэй.

Хөтөлбөрийг ашиглах үед сурах арга зүйд суралцахаас гадна сургалтын материалын сонголт их байх болно. Хөтөлбөрийн төгсгөлд идэвхтэн бичигч, зохиогч, ишлэл, ном зүй зэрэгт багтсан хүмүүсийн нэрсийн жагсаалтад холбоо барих хаяг, е-мэйл хаяг байгаа учир хүссэн сэтгүүлч, нийтлэлчтэй уулзаж болно.

Хөтөлбөрийн товч заавар нь сэтгүүл зүйн маш олон салбарын олон төрлийн сэдвийг хамарсан. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн тогтвортой байдал
- Дата сэтгүүл зүй
- Олон талт соёлын сэтгүүл зүй
- Хүйн радиогийн сэтгүүл зүй
- Глобал сэтгүүл зүй
- Шинжлэх ухааны сэтгүүл зүй, онол практикийн био ёс зүй
- Жендер ба сэтгүүл зүй
- Хүмүүнлэгийн сэтгүүл зүй
- Хүний наймааг сурвалжлах нь
- Аюулгүй байдал ба сэтгүүл зүй

Эдгээр салбарууд нь бүх хүмүүсийн мэдлэгт тустай юм. 2008 оны дэлхийн санхүү болон эдийн засгийн хямрал нь хэвлэл мэдээллийн салбарыг дахин өөрчлөхөд хүргэсэн юм. Хэвлэл мэдээллийн салбар зардалаа бууруулахын тулд ихэнх нь онлайн сэтгүүл зүйд шилжиж эхэлсэн билээ. Энэ хямрал нь зөвхөн хөгжиж байгаа орнуудыг төдийгүй бүхий л улс орны сэтгүүл зүйн салбарыг дайрсан. Ялангуяа сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгчид хямралд тэсч үлдэхийн тулд сургалтын арга барил, загвараа өөрчлөхөд хүрсэн юм. Жишээ нь Энэтхэгийн 'Time of India' сонины борлуулалт эрс нэмэгдсэн. Харин онлайнд шилжих процесс удаашралтай байсан. Барууны орны сонин сэтгүүлийн борлуулалт эрс буурсан. (Анхны хэвлэл, 2012). Гэхдээ энэ нь шууд онлайнд шилжсэн эсвэл зардлаа бууруулснаас хамаарсан эсэх нь эргэлзээтэй. Учир нь барууны оронд гардаг "Экономист" сэтгүүлийн ашиг нэмэгдсээр байсан юм. Эндээс сэтгүүл зүйн мэдээ мэдээллийн агуулгын чанарын асуудал хөндөгдөж эхэлсэн билээ. Ялангуяа уншигч, үзэгчдэд аль хэлбэрээр ямар чанартай мэдээлэл түгээх вэ гэдэг асуудалтай тулгарсан. Эдийн засгийн хямрал буурч өсөх тийшээ хандаж эхлэхэд уншигчид бизнес хийх ирээдүйн эрсдэлийг тооцож бие даасан эдийн засгийн анализ, дүгнэлт бүхий сонин сэтгүүлийг илүү унших болсон. Тэгэхээр эндээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл тухайн цаг үедээ тааруулж өөрчлөгдөж болдог гэдгийг сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэгчид сурсан.

Дата сэтгүүл зүй хүрээгээ тэлж эрэн сурвалжлах сэтгүүл зүй илүү хөгжих үндэс болсон. Улмаар тоон баримт, чанартай мэдээ зэрэг өгөгдөл нь эрэн сурвалжлах сэтгүүл

зүйд өргөн хэрэглэгдэх болжээ. Хямралын үед тухайн нөхцөл байдлаас хамаараад онлайн сэтгүүл зүй хөгжсөн нь мэдээлэл, том баримт цуглуулах зэргээр эрэн сурвалжлах сэтгүүлчдэд илүү давуу тал олгосон. Цаашлаад эрэн сурвалжлах сэтгүүлчид уламжлалт сэтгүүл зүйг онлайн сэтгүүл зүйн мэдээ баримттай хамтад нь хэрэглэснээр тэдний ажлын үр өгөөж дээшилсэн. (Грэй, 2013).

2001 оны ЮНЕСКО-гийн Соёлын Олон Талт Байдлын Тунхаглал, 2005 оны Соёлын Олон Талт Байдлын Илэрхийллийг Хамгаалах Конвенци батлагдснаар олон улсын соёлын сэтгүүл зүй хөгжих үндэс нь тавигдсан. Тухайлбал аливаа мэдээ, мэдээлэл, өгүүлэлд олон улсын соёлын олон талт байдлыг тусгах, хоорондоо өрсөлдөх зэрэгт нь давуу тал олгосон. Мөн олон улсын сэтгүүлчдийн хувьд бусад улсуудын соёл, амьдралын хэв маяг, орчин нөхцлийг илүү мэдэж сэтгүүл зүйн мэдлэгийн хүрээгээ тэлэхэд нь нэмэр болсон юм.

Хүйн радиогийн сэтгүүл зүй хөгжсөнөөр алслагдмал байрлалтай, харилцаа холбооны хүртээмж муу, амьжиргааны түвшин доогуур иргэд болоод тэр болгон мэдээлэл авах боломжгүй бусад хэрэглэгчид, нийгэмдээ илүү их байр суурь эзэлдэг мэдээлэлд ойр хэсэгт дуу хоолойгоо хүргэх боломж олгосон. Хүйн радиогийн сэтгүүл зүй хөгжсөнөөр зөвхөн тухайн бүс нутгаар хязгаарлагдахгүй бараг бүхий л газар нутагт мэдээлэл түгээх боломжтой болж байна.

Ялангуяа хөгжиж байгаа болон хөгжил буурай орнуудын хувьд Глобал сэтгүүл зүй хөгжсөнөөр дэлхий, бүс нутаг, орон нутгийн хэрэглэгчдийн хоорондын уялдаа холбоог дээшлүүлж байна. Сэтгүүлчдийн хувьд зөвхөн тулга тойрсон асуудал биш глобал хэмжээнд бодож сэтгэж ойлгох бололцоотой болсон. Ялангуяа орон нутгийн бодит байдал, тухайн улсын соёл, нөхцөл байдлыг ойлгох боломжтой болсон юм.

Шинжлэх ухааны сэтгүүл зүй нь олон нийтэд аль ч төрлийн  шинжлэх ухааны тухай хамгийн энгийн байдлаар ойлгуулах боломжийг бүрдүүлсэн. Боловсрол, ардчилал, хөгжилд шинжлэх ухааны сэтгүүл зүй эерэгээр нөлөөлсөн юм. Шинжлэх Ухааны Сэтгүүлчдийн Дэлхийн Холбоо (WFSJ 2013), бусад судлаач эрдэмтэд мэргэжилтнүүдийн сүлжээ  шинжлэх ухааны сэтгүүл зүйг хөгжүүлэхэд маш их дэмжлэг үзүүлсэн. Шинжлэх ухааныг энгийн байдлаар хүргэснээр үзэгч, сонсогч, уншигчдын шинжлэх ухааны мэдлэг дээшлэх үндэс болсон билээ.  Энэ хөтөлбөрт багтсан биоэтик буюу биологийн ёс зүй эдгээрийн нэг жишээ юм.

Жендер ба сэтгүүлзүй нь сэтгүүлзүйн практикийн хүйсэнд тулгуурласан дүгнэлтийн чухлыг онцолдог.  ЮНЕСКО-гийн Жендерийн тэгш байдлын дэлхийн ач холбогдол тунхаг нь сэтгүүлчдийг хэрхэн яаж жендерийн асуудалд хандах, дүгнэх, түүнийг судалгаа болон мэдээ, өгүүлэлдээ  тусгахыг ойлгуулсан. Аливаа нэг мэдээ, өгүүлэлд эмэгтэйчүүдийн талаар бага өгүүлдэг. Эсвэл тэдний дуу хоолой гардаггүй. Олон улсын Эмэгтэйчүүдийн Хэвлэл Мэдээллийн Сан (IWMF)-гийн судалгаагаар нийт 59 орны 20 улсад эмэгтэйчүүдийн байр суурь хангалтгүй, ихэвчлэн дунд болон ахлах түвшний ажлын байранд байна гэсэн дүн гарчээ.  Жендерийн тэгш байдлын бодлогыг баримталдаг компаниудын талаас илүү хувийг түүвэрлэн авч үзэхэд Зүүн Европын орнуудынх 16 хувь, Барууны болон төв Сахарын Африкын орнуудынх 69 хувийг эзэлж байна. Эдгээр судалгаанаас эмэгтэйчүүд тоогоороо ч эзлэж байгаа байр суурьиараа ч эрчүүдээс доогуур байгааг сэтгүүлзүйн боловсрол олгогчид анхаарах ёстой. Сэтгүүлзүйн талбарт ч гэсэн эмэгтэйчүүдийн тоо, эрчүүдийнхээс бага байна.

Хүмүүнлэгийн сэтгүүлзүй нь гол төлөв хүний эрхийн асуудлыг хөнддөг.  Ялангуяа хямрал, дайн мөргөлдөөн эсвэл мөргөлдөөний дараах нөхцөл байдлын үед илүү тод харагддаг. Хөтөлбөрт оюутан болон сэтгүүлчдийг дайн мөргөлдөөн эсвэл энхийн цагт яг цагаа олж газар дээр нь сурвалжилж тухайн нөхцөл байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй болох талаар дурьдсан.

Хүний наймаа ба сэтгүүлзүй нь хүмүүнлэгийн сэтгүүлзүйг орчин үеийн боолчлол гэгдэх хүний наймааны асуудал руу өргөжүүлсэн юм. Үүнд эрэн сурвалжлах сэтгүүлзүй гол үүрэгтэй бөгөөд хүний наймаа нь гол төлөв эмэгтэйчүүд болон хүүхэд рүү чиглэж тэдний эрх ашиг хөндөгдөж байгаа асуудлыг сөхсөн байна.
Аюулгүй байдал ба сэтгүүлзүй нь сэтгүүлчдийг ажил үүргээ гүйцэтгэж явахдаа болгоомжтой аюулгүй байх шаардлагатайг анхааруулсан. Хөтөлбөр сэтгүүлчдийн хувьд улс үндэстэн, бүс нутаг, олон улсад тэдэнд туслах, аюулгүй байлгах, хамгаалагч, туслагчид байдаг гэдгийг ойлгуулах зорилготой. Мөн тэдэнд өөрсдийгөө аюулгүй байлгах хэд хэдэн боломж байгааг ойлгуулахыг хичээсэн. Үүнд хамаарах хэвлэл мэдээллийн институц, шийдвэр гаргагчид, хуулийн орчин, олон нийтийн талаар дурьдсан. ЮНЕСКО-гийн зохицуулдаг Сэтгүүлчдийн Аюулгүй Байдлын Үйл Ажиллагаа, НҮБ-ийн  Төлөвлөгөө нь сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хуулиар баталгаажуулах зорилготой. НҮБ болон ЮНЕСКО-гийн тэрхүү төлөвлөгөө нь энэ хөтөлбөрт багтсан юм.

# I – III хэсгийн ном зүй


Аслам, Рухсана. 2012. ЮНЕСКО Ж-Боловсролын Загвар: Ази Ном Далайд энэ нь ямархуу байна вэ? www.pmc.aut.ac.nz/ articles/unesco-j-education-model-how-has-it-fared-pacifc (2 сарын 20. 2013.)

Банд, Ф болон Шмиц Вайз, А. (eds). 2013. Хөгжиж байгаа орнууд болон шинэ тулгар ардчилсан орнуудад сэтгүүл зүйг заах нь: ЮНЕСКО-гийн Загвар Хөтөлбөр. Европын Харилцаа Холбооны Судалгаа ба Болосвролын Ассоциаци (ECREA)-ийн Европын Харилцаа Холбооны Дөрөвдүгээр Конференци, ЮНЕСКО ба Олон Улсын Харилцаа Холбоо (AEJMC)-ны зохион байгуулсан 2012 оны AEJMC хурлын тайлан. www.unesco.org/new/ fleadmin/MULTIMEDIA/HQ/CI/CI/pdf/news/unesco_model_curricu la_report.pdf (4 сарын 8. 2013.)

Бергер, Гай болон Фүүт, Жоү. 2013. Маргаашын сургалт: Сэтгүүл зүйн боловсролын өөрчлөлтийг хангах. (дараах бүлэг).

Бергер, Гай болон Матрас, Коринне. 2007. Чанартай сэтгүүл зүйн сургалтын институцийг таньж мэдэх болон Африкийн Сэтгүүл зүйн сургалтын чадварыг таньж мэдэх төв. Парис: ЮНЕСКО.

Клауссен , Дани. С. 2012. АНУ-ын J&MC –ийн боловсролын зоригтой санаа: Жинхэнээсээ нэг удаа өндөр чадвартай байхыг хичээх. Сэтгүүл зүй ба Харилцаа холбооны сурган хүмүүжүүлэх, Хэсэг. 67, №. 3, хуу. 211–17.

Клауссен , Дани С. 2007. Эрхлэгчийн тэмдэглэл: J&MC хөтөлбөрийн загвар нь хөгжиж байгаа орнуудын хувьд дэвшил, магадгүй хөгжсөн АНУ-ийн J&MC боловсролын сануулга. Сэтгүүл зүй ба Харилцаа холбооны сурган хүмүүжүүлэх, Хэсэг. 62, хуу. 237–40.

Дэвис, Н. Чо, М. О болон Хагенсон, Л. 2005. Олон улсын соёлын өрсөлдөөн ба боловсролын багш нарын технологийн үүрэг роль. Технологи болон Багшийн боловсролын өнөөгийн асуудал, Хэсэг. 4, №. 4, хуу. 384–94.

Финберг, Ховард. 2012. Боловсролын сэтгүүл зүйн ирээдүй: Хувий зүгээс. Европын сэтгүүл зүйн төвийн 20-р ээлжилт хуралдааны үеэр тавигдсан маш чухал илтгэл. 6 сарын 4 2012. Маастрихт, Нидерланд . www.newsu.org/future-journalism-education (1 сарын 31. 2013.)

Анхны хэвлэл. 2012. Нью-Йорк, Энэтхэгийн төлбөртэй хэвлэл мэдээллийн хэрэгслийг илрүүлсэн гэхдээ гол санааг нь ойлгоогүй. www.frstpost.com/business/ new-yorker-discovers-indias-paid-media-but-misses-the-point-476340.html (4 сарын 8. 2013.)

Фрийдмэн, Эрик болон Шафер, Ричард. 2010. Онолд амбиц ихтэй, гэхдээ амьдрал дээр үгүй: ЮНЕСКО-ийн шүүмжлэл, хөгжиж байгаа орнууд болон шинэ тулгар ардчилсан орнуудын сэтгүүл зүйн боловсрол ЮНЕСКО-гийн Загвар хөтөлбөр, 3-дагч ертөнцийн судалгаа, сэтгүүл. Хэсэг. 27, №. 1, хуу. 135–53.

Грэй, Ж. Воунегру, Л болон Чамберс, Л. 2013. Дата сэтгүүл зүйн гарын авлага: Сэтгүүлчид мэдээнийхээ ажлыг дээшлүүлэхийн тулд өгөгдлийг яаж ашиглах вэ? http://datajournal ismhandbook.org/1.0/en/introduction_0.html (4 сарын 8. 2013.)

Олон улсын Эмэгтэйчүүд хэвлэл мэдээллийн сан (IWMF). 2010. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эмэгтэйчүүдийн статус, дэлхийн сурвалжлага мэдээ. Вашингтон, ДС: IWMF.

Марк, Л. 2012. Экономист үзүүлэхдээ Долоо хоногийн мэдээ хэвлэлтэд амьдрал үлдсэн. www.thedrum.com/opinion/2012/10/25/reader-nomics-economist-shows-newsweek-there-life-left-print-0 (4 сарын 8. 2013.)

Mc Леллан, Мичиле болон Невтон, Эрик. 2012. Цахим сургалтын цаг үе ирлээ. Найт Сангийн сэтгүүл зүй тэдний анд ба Суралцагчдын ашигтай байдал- Тэд яагаад илүү зүйлийг хүсээд байна вэ? Миами, Флорида: Найт Сан. www.knightfoundation.org/media/uploads/publication_pdfs/KFTrainingFieldReportWEB.pdf (1 сарын 31 2013.)

Норденстран, Каарле. 2010. Дэлхийн Сэтгүүл зүйн Боловсролын Конгресс, Родесийн Их Сургууль, Өмнөд Африк:  7 сарын 5-7 2010.: Сэтгүүл зүйн хөтөлбөрийн ирээдүйг жолоодох нь. www.uta.f/cmt/en/contact/staff/kaarlenordenstreng/publications/WJEC2010_Curriculum_ per cent20Panel_ per cent20Proceedings1.pdf  (2 сарын 12 2013.)

Павлик, Ж_ В, Лауфер, П.Д, Бурнс, Д. П болон Атаяа P. T. 2012. Иракийн сэтгүүл зүйг шинэчлэх нь ба Масс Харилцаа холбооны өндөр боловсрол: Иракийн сэтгүүл зүйн өндөр боловсролд ЮНЕСКО-ийн загвар хөтөлбөрийг ашиглах нь. Сэтгүүл зүйн ба Масс Харилцаа Холбооны сурган хүмүүжүүлэгч. Хэсэг.67, №. 3, хуу. 268–85.

Пүүл, Майкел. 2007. Шинжлэх ухаан ба Илтгэл хэрэглэгчийн гарын авлага. 3 дахь хэвлэл. Оксфорд: Лион.

Сусан-Пина, Тара. 2012. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжлийг илүү их ашигтай болгох нь. Вашингтон ДС: Олон улсын Хэвлэл мэдээллийн туслалцаа (CIMA).

ЮНЕСКО. 2012. 11 Сэтгүүлчдийн сургалтад зориулсан ЮНЕСКО-гийн загвар хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн институцид илүүтэй ашиглах нь. ЮНЕСКО Абужа Сонин. Хэсэг 4, №. 2, хуу. 6.

Дэлхийн шинжлэх ухааны сэтгүүлчдийн холбоо  (WFSJ). 2013. Дэлхийн шинжлэх ухааны сэтгүүлчдийн чуулган. www.wfsj.org/news/news.php?id=304 (4 сарын 8 2013.)

Дэлхийн сэтгүүл зүйн боловсролын зөвлөл (WJEC). 2008. Сэтгүүл зүйн боловсролын WJEC'-ийн Зарчим  http://wjec. ou.edu/principles.php  (2 сарын 11.  2013.)

# IV. ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Тухайн орон нутгийн болон улс үндэстний соёл нөхцөл байдалд тохируулж ашиглах нь энэхүү загвар хөтөлбөрийн гол зорилго юм.  Хөтөлбөр бүр нь багш, сурган хүмүүжүүлэгч, төлөвлөгч нарт урам зориг төрүүлсэн шинэ санаа, арга барил, материалыг агуулсан болно.



# ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Роберт Г. Пикард

Хэвлэл  мэдээллийн тогтвортой байдал нь бие даасан хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөгжүүлснээр нийгэмдээ ач тустай. Хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын хамгийн гол хөшүүрэг бол ашиг орлого, сайн засаглал болон менежмент, мэргэжлийн сэтгүүл зүй мөн. Өөр нэг хөшүүрэг бол нийгэмдээ нөлөөлдөг, хүлээн зөвшөөрөгдсөн, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг хамгаалсан засгийн газрын ил тод байдал юм. Тогтвортой сэтгүүл зүйг хөгжүүлэх, сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлийн талаар бид доор судлах болно. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн тогтвортой байлгах орчин нөхцлийн талаар оюутнуудад заах болно.

**Курсийн төвшин:** Бакалаврын төгсөх курсийн оюутан / магистрын түвшин

**Төрөл:** Лекц, семинар ярилцлага, дадлага

**Сургалтын арга зүй:** Энэ курс нь оюутнуудад хэвлэл мэдээллийн тогтвортой байдалд тулгамддаг асуудал, бэрхшээл, сорилт, стратегийн талаар мэдээлэл өгнө. Лекц, ярилцлага, уншлага болон үйл ажиллагааг мэргэжлийн сэтгүүлчид ашиглаж болно. Яагаад гэвэл уг курс хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлчид хүндрэл бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар оюутнуудтай шууд тулж харьцана. Хэвлэл мэдээллийн салбарын тогтвортой байдалд  нөлөөлж байгаа  хүчин зүйлийг судлах долоо хоногийн даалгавар байж болно. Ялангуяа сэтгүүлчид болон менежерүүд хэвлэл мэдээллийн хэрэгслийг тогтвортой байлгахын тулд юу хийж байгаа талаар үзэх болно.

**Долоо хоногт орох цаг:** 3 цаг нь танхимын сургалт,  2 цаг нь уншлага болон судалгаа

**Курсийн тодорхойлолт:** Энэхүү 8 долоо хоногийн курсээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтвортой байдлыг хангах стратеги, дадал туршлага, орчныг бүрдүүлэх болоод хэвлэл мэдээллийн компани, сэтгүүлчдийн хариуцлагын талаар судална. Улс үндэстэн, засгийн газар, хэвлэл мэдээллийн үүрэг роль, хэвлэл мэдээллийн компаниудын үйл ажиллагааны цар хүрээ, сэтгүүл зүйн соёл болон дадал туршлагын ялгааг танин мэдүүлнэ. Мөн үйл ажиллагааны ижил төстэй талууд, тэдгээрийн хэрэгцээ зэрэгт анхаарлаа хандуулна.

**Дүгнэх болон үнэлгээний дүрэм, журам**

Семинар ярилцлага: нийт хичээлийн 20 хувь

Танхимын сургалт: 50 хувь

Төгсөлтийн шалгалт: 30 хувь

**Шаардлагатай материал:** Тогтвортой байдлын хүндрэл бэрхшээлийн талаар судалж уншихад интернеттэй компьютер ашиглах.

# Сургалтын хамрах хүрээ:

**Нэгдүгээр долоо хоног: Хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын танилцуулга**

*Сэдвүүд:* Хэвлэл мэдээллийн тогтвортой байдал гэж юу вэ? Яагаад чухал байдаг вэ? Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн бус байгууллагын үүрэг роль юу вэ? Тогтвортой байдлын суурь хэрэгцээ, шаардлага: Технологи, үзэгч уншигч, санхүүгийн хамааралгүй, засгийн газар болон нийгмийн хяналт. Тогтвортой байдал хэрхэн хэвлэл мэдээллийн хөгжилтэй холбогдох вэ?

*Семинар ярилцлага болон үйл ажиллагаа:* Тухайн орон нутагт хэвлэл мэдээллийг тогтвортой байлгах ямар хүчин зүйл байна вэ? Асуудлыг тодорхой болгосны дараа оюутнуудаа группээр хувааж, тогтвортой байдлын хүндрэл бэрхшээлийн талаар ярилцуулж, яагаад сорилт, хүндрэл бэрхшээл тогтвортой байдалд нөлөөлдөг талаар 2-3 нүүр мэдээ, нийтлэл бичүүлнэ.

*Даалгавар:* Сонгосон улсынхаа эдийн засаг, технологи, үзэгч уншигчдын тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлийн талаар (сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим хэвлэл мэдээлэл г.м) 2-3 нүүр мэдээ нийтлэл бичих

*Унших материал:* Олон Улсын Хэвлэл Мэдээллийн Туслалцааны Төв (2007), IREX (n.d.), Конрад Аденауэрын Сан (2006), Нелсэн болон Сусмэн-Пена (2009), ЮНЕСКО (2008).

**Хоёрдугаар долоо хоног: Тогтвортой байдалд нөлөөлөх засгийн газрын хүчин зүйл**

*Сэдэв:* Хараат бус хэвлэл мэдээллийн тогтвортой байдалд хуулийн зохицуулалт хэрхэн нөлөөлдөг вэ? Яагаад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон засгийн газрын ил тод байдал тогтвортой байдалд нөлөөлдөг вэ? Хэвлэл мэдээллийн зөвшөөрөл болон бүртгэл нь яаж тогтвортой байдалд нөлөөлдөг вэ? Засгийн газар сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл рүү дайрч давших нь тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөх вэ? Яагаад зарим гүжир гүтгэлэг хэвлэл мэдээллийг тогтворгүй болгодог вэ? Олон улсын стандарт хэвлэл мэдээлэлд нөлөөлж болох уу? Ямар хэвлэл мэдээлэл шууд болон шууд бусаар улсаас татаас авдаг вэ?

*Семинар ярилцлага ба үйл ажиллагаа:* Засгийн газрын ямар хүчин зүйл тухайн оюутны амьдардаг улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтвортой байдлыг сорьдог вэ? Үүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхой болгосны дараа оюутнуудаа группэд хувааж хүчин зүйлүүдээс нэгийг сонгож 2-3 нүүр мэдээ бэлтгүүлэх. Эдгээр хүчин зүйлүүд нь яаж тогтвортой байдалд нөлөөлөх вэ?

*Даалгавар:* Тухайн улсын засгийн газрын хэвлэл мэдээллийн тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйл сэдвээр 2 хуудас мэдээ бэлтгүүлэх.

*Унших материал:* Ковэн болон Вестфал (2010), Фрийдом Хаус (n.d.), Фридрих Эбертийн Сан (n.d.), Хил хязгааргүй хэвлэн нийтлэгчид (n.d.), НҮБ (1948), НҮБ Хүний Эрхийн Хороо (n.d.).

## Гуравдугаар долоо хоног: **Олон нийтийн хэвлэл мэдээллийн тогтвортой байдал**

*Сэдэв:* Олон нийтийн хэвлэл мэдээлэл гэж юу вэ? Тэд ямар үүрэг рольд тоглодог вэ? Ямар хүчин зүйл тэднийг тогтвортой байдлын арилжааны үйл ажиллагаанаас ялгадаг вэ? Ямар өвөрмөц тогтвортой байдалтай нүүр тулдаг вэ?

*Семинар ярилцлага болон үйл ажиллагаа:* Олон нийтийн хэвлэл мэдээллийн давуу болон сул тал юу вэ? Давуу болон сул талыг олж мэдсэний дараа оюутнуудаа группэд хувааж тогтвортой байдлын давуу болон сул талын талаар ярилцуулж 2-3 хуудас мэдээ бэлтгүүл.

*Даалгавар:* Тухайн оюутны амьдардаг нутгийн олон нийтийн хэвлэл мэдээллийн тогтвортой байдалд тулгарч буй асуудлын талаар 2-3 хуудас мэдээ бэлтгүүл:
Унших материал: Бюклей (2011), Фейрбэйн (2009), Фрэсер болон Рестрепо Эстрада (2001).

## Дөрөвдүгээр долоо хоног: **Шинээр бий болсон хэвлэл мэдээллийг тогтвортой болгох**

*Сэдэв:* Тогтвортой байдлын ямар асуудал шинээр үүссэн дижитал хэвлэл мэдээллийн компаниудын санааг зовоож байгаа вэ? Хэвлэл мэдээллийн хувийн компаниудын үндэс суурь юу вэ? Эдгээрийг үзэгч, уншигчидтай хэрхэн холбох вэ? Шинэ залуу компаниудыг алдаа гаргаж, ашиггүй ажиллахаас хэрхэн сэргийлэх вэ? Сэтгүүл зүйн хувийн компани гэж юу вэ?

*Семинар ярилцлага:* Шинээр дижитал хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулахдаа санхүүгийн асуудлаа хэрхэн шийдэх вэ? Үйл ажиллагааныхаа эхний 8-24 сарын хугацаанд компаниа хэрхэн санхүүжүүлэх вэ? Үнийн асуудлыг ярилцаж тохиролцсон бол оюутнуудаа групп болгон хувааж санхүүгийн асуудлаа хэрхэн шийдэх талаар даалгавар өгч 2-3 хуудас мэдээ бэлтгүүл. Сэдэв нь санхүүгийн асуудлаа хэрхэн шийдэх нь тогтвортой байдалд яаж нөлөөлөх тухай байна.

*Даалгавар:* Шинэ залуу хэвлэл мэдээллийн байгууллагын менежерээс ярилцлага авч тэд санхүүгийн асуудлаа хэрхэн шийдвэрлэж байна, тэдэнд ямар асуудал байгаа талаар мэдэж ав. Авсан ярилцлагаасаа сэдэвлэн 2 хуудас мэдээ бэлтгүүл.
Унших материал: Ж-Лаб (n.d.a, n.d.b), Пойнтер Институт (n.d.).

---

## Тавдугаар долоо хоног: **Тогтвортой байдлын менежмент болон засаглалын үүрэг, оролцоо**

*Сэдэв:* Хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд тасралтгүй үйл ажиллагаагаа хангана гэдэг хамгийн хэцүү. Менежер ямар тогтвортой байдлын асуудалд санаа зовох вэ? Тогтвортой байдлыг хангахын тулд захирлуудын үүрэг, оролцоо юу вэ? Тэд юунд санаа зовох ёстой вэ? Компанийнхаа нөөц (санхүүжилт, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт болон өр) - ийг яаж зөв зохицуулах вэ? Редакцийн хараат бус байдлыг хэрхэн яаж менежер, ТУЗ, эзэмшигч нар зохицуулах вэ? Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд тогтвортой байдлыг хангахын тулд ёс зүйн хувьд ямар байх ёстой вэ?

*Семинар ярилцлага:* Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах нь яагаад тийм чухал вэ? Тогтвортой байдлын засаглал, зохицуулалтын талаар ярилцсан бол оюутнуудаа групп болгон хуваагаад дээрх сэдвээр 3 хуудас мэдээ бичүүл.

*Даалгавар:* Хэвлэл мэдээллийн засаглалын бүтэц тэдгээрээс хамаарсан тогтвортой байдал, ТУЗ болон менежментийн багийн  ажлын хариуцлага үүргийг яаж тогтвортой байдалтай уялдуулах вэ? гэсэн сэдвээр 2 хуудас мэдээ бичүүл.

*Унших материал:* Африкийн Хэвлэл Мэдээллийн Санаачилга (n.d.), Бергер (n.d.), Глобал Нийтлэгчдийн Санаачилга (n.d.), Жарвис (2010), Энхтайвныг цогцлоох Африкийн Радио (n.d.), Томас (2009), Витолс (2011).

## Зургадугаар долоо хоног: **Санхүүгийн нөөц болон бизнес загварын чухал байдал**

*Сэдэв:* Бизнес загвар гэж юу вэ? Яагаад энэ нь мөнгөнөөс чухал байдаг вэ? Бизнес загварыг яаж үр ашигтай болгох вэ? Хэвлэл мэдээллийн менежерүүд болон сэтгүүлчид ашгийнхаа талаар юу гэж боддог вэ? Хүн бүрийн баримтлах ёстой бизнес загвар гэж байдаг уу?

*Семинар ярилцлага:* Яагаад өөр өөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нэгж хэсгүүдэд янз бүрийн бизнес загвар болон ашгийн эх үүсвэр байдаг вэ? Эдгээрийн талаар ярилцсан бол оюутнуудаа групп болгон хуваагаад бизнес загварын талаар 2-3 хуудас мэдээ бичүүл.

*Даалгавар:* Дурын сонгосон хэвлэл мэдээллийн компанийн бизнес загварын талаар 2 хуудас мэдээ бичүүл.

*Унших материал:* Африкийн Хэвлэл Мэдээллийн Санаачилга (2011), Фолкенфлик (2009), Фостер (2011), Жарвис (2011), Пикард (2010a, n.d.), www.opensocietyfoundations.org/reports/digitization- media-business-models, WAN/IFRA (2011).

## Долдугаар долоо хоног: **Тогтвортой байдлын санхүүгийн асуудал**

*Сэдэв:* Үр ашигтай зарцуулалт, хөрөнгийн үр дүнтэй хэрэглээ, өрийн тооцоотой менежмент, бэлэн мөнгөний урсгалын менежмент, тооцоолон бодох, үйл ажиллагааны хэмнэлт, нөөцийн байнгын шинэчлэлт тогтвортой байдалд яагаад чухал байдаг вэ? Ирээдүйн орлого болон тооцоолоогүй зарлагаа хэрхэн зохицуулна гэж төлөвлөж байна вэ?

*Семинар ярилцлага:* Нягтлан бодогч болохгүйгээр санхүүгийн асуудлаа хэрхэн зохицуулах талаар ярилц. Компанийнхаа үйл ажиллагаа болон санхүүгийн баланс, тэнцлийн тайланг аль нэг нягтлангүйгээр хэрхэн уншихыг сур. Санхүүгийн тайланг ойлгож уншихад хамгийн том хүндрэл бэрхшээл юу байдаг вэ? Эдгээрийг ярилцсаны дараа оюутнуудаа групп болгон хувааж компанийн эрүүл ашигтай үйл ажиллагааны талаар 2-3 хуудас мэдээ бичүүл. Сэдэв: Тогтвортой байдалд санхүү яагаад чухал вэ?

*Даалгавар:* Компанийн санхүүгийн тайлангийн талаар 2-3 хуудас мэдээ бичүүл.

*Унших материал:* Пикард (2010b, 2011a), Жижиг бизнесийн Тэмдэглэл (n.d.).

**Наймдугаар долоо хоног: Сэтгүүл зүйн болон мэргэжлийн хэвлэл мэдээлэл: найдвартай байдал:хамтын ажиллагаа болон салбарын хүч**

*Сэдэв:* Яагаад сэтгүүл зүйг  зохион байгуулах  болон дэмжих нь мэргэжлийн хэвлэл мэдээллийн  тогтвортой байдалд чухал вэ? Итгэл үнэмшилд агуулгын чанар хэр чухал вэ? Сэтгүүл зүйн ёс зүйн стандарт, шударга байдал, тэнцвэртэй байдал тогтвортой байдалд хэрхэн яаж нөлөөлдөг вэ?

*Семинар ярилцлага:* Орон нутгийнхаа хэвлэл мэдээллийн байгууллага болон хэвлэлийн эрх чөлөөний төлөө тууштай тэмцэгчийн талаар ярилц. Тэдний давуу болон сул тал нь юу вэ? Тэднийг дэмжсэнээр хэн юу хожих вэ? Өөр ямар байгууллага дутагдаж байна вэ?
Эдгээрийг ярилцсаны дараа оюутнуудаа групп болгон хувааж тогтвортой сэтгүүл зүйг дэмжиж ажилладаг байгууллагын талаар 2-3 хуудас мэдээ бичүүл.

*Даалгавар:* Олон улсын мэргэжлийн холбоод болон группийн албан ёсны тайланг ашиглан тухайн улсын сэтгүүлчдийн ажиллах орчин болон хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын талаар 2 хуудас мэдээ бичүүл:

*Унших материал:* Олон Улсын Хэвлэлийн Хүрээлэн (n.d.), Сэтгүүлзүйн мэргэжлийн ёс зүйн олон улсын зарчмууд (n.d.), Мэргэжлийн Сэтгүүлчдийн Нийгэмлэг (n.d.).

*Багшийн унших материалууд:*

Абботт эт ал. (2011), Койне болон Лийсон (2009), Хоулей (2009), Локслий (2009), Пикард (2011), Риидер болон Хатчер (2011), Сеневиртане (2012), USAID (2012).

*Онлайн нэмэлт унших материал:*

- Африкийн Хэвлэл Мэдээллийн Санаачилга (AMI), www.africanmediainitiative.org/
- Азийн Хэвлэл Мэдээлэл болон Мэдээлэл Харилцааны Төв (AMIC), www.amic.org.sg/
- Дижитал Ардчиллын Төлөөх Сан, www.democraticmedia.org
- Олон Улсын Хэвлэл Мэдээллийн Туслалцааны Төв, www.cima.ned.org/media-development/sustainability

- Тогтвортой Сэтгүүлзүйн Төв, Кеннесаугийн Их Сургууль, www. sustainablejournalism.org
- Кибер сэтгүүлзүй.Нэт, www.cyberjournalist.net
- Бие Даасан Хэвлэл Мэдээллийн Төв, www.indymedia.org
- Олон Улсын Сэтгүүлчдийн Төв, www.ijnet.org
- Олон Улсын Сэтгүүлчдийн Нийгэмлэг, www.ifj.org
- Олон Улсын Сэтгүүлчдийн Сүлжээ, www.ijnet.org
- Олон Улсын Хэвлэлийн Хүрээлэн, http://www.freemedia.at/
- Интерньюс Сүлжээ, www.internews.org
- IREX, www.irex.org
- Хэвлэл Мэдээллийн Зээлийн Сан, www.mdlf.org
- Өмнөд Африкийн Хэвлэл Мэдээллийн Институт (MISA) болон орон нутгийн салбарууд, http://new.misa.org/
- Хил хязгааргүй сэтгүүлчид www.rsf.org
- Дэлхийн Коммунити Өргөн Нэвтрүүлгийн Холбоо, www.amarc.org

*Санал тайлбар*

Энэхүү курсэд хэвлэл мэдээлэл ба нийгэм, хэвлэл мэдээллийн менежмэнтийн хичээлүүдийг агуулсан. Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагууд үүсэн бий болох, тогтвортой үйл ажиллагаа явуулах асуудал болон хэвлэл мэдээлэлд нөлөө үзүүлж буй орчны тухай илүү тодорхой, нарийвчлан харуулсан.

# Ном зүй


Абботт, Сусан, Прайс, Монрей Э болон Морган, Либби (eds), 2011. Хэвлэлийн эрх чөлөө болон хэвлэл мэдээллийн хэмжих нь – хөгжилд оруулж буй хувь нэмрүүд, Нью Уорк: Петер Ланг.

Африкийн Хэвлэл Мэдээллийн Санаачилга. 2011. Бизнесийн тодорхойгүй загварын үед Африкийн хэвлэл мэдээллийг санхүүжүүлэх нь. Найроби: AMI. www.amlf2010.org/upload/ENGLISH-AMLF-2010%20.pdf

Африкийн Хэвлэл Мэдээллийн Санаачилга. n.d. Африкийн хэвлэл мэдээллийн эзэд болон менежерүүдэд зориулсан манлайлал болон удирдлагын зарчмууд. www. africanmediainitiative.org/?q=con,135

Бергер, Гей. Редакцийн хараат бус байдал: зөвхөн редакторуудад зориулсан биш, хуудас. 126–32. www.kas.de/upload/auslandshomepages/subsahara/Extraordinary_Editor/Chapter_5.pdf

Бюклей, Стив. 2011. Хүйн хэвлэл мэдээлэл: Сайн туршлагын гарын авлага, Парис: ЮНЕСКО. www.unesco.org/ new/en/communication-and-information/re sources/publica tions-and-communication-materials/ publications/full-list/community-media-a-good-prac tice-handbook/

Олон улсын хэвлэл мэдээллийн туслалцааны төв. 2007. Хөгжиж буй орнууд дахь хэвлэл мэдээллийн эдийн засгийн тогтвортой байдлын чиг хандлага, ажлын хэсгийн тайлан. http://cima.ned.org/sites/default/fles/CIMA-Economic_ Sustainabili ty-Working_Group_Report.pdf

Кован, Жеоффрей болон Вэстфал, Дэвид. 2010. Олон нийтийн бодлого болон мэдээг санхүүжүүлэх нь. Өмнөдийн Их Сургууль, Анненберг Калифорниагийн Мэдээлэл харилцаа, сэтгүүлзүйн сургууль. www.niemanlab.org/pdfs/USC%20 Тайлан.pdf хувилбараар

Койне, Кристофер Ж болон Лийсон, Петер T. 2009. Хэвлэл мэдээлэл, Хөгжил болон Институцийн өөрчлөлт. Челтенхам, Их Британи: Эдвард Элгар.

Фейрбейн, Жейн. 2009. Хүйн хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын гарын авлага: Амьдралыг өөрчлөх бизнес. Вашингтон ДС: Интерньюс. www.internews.org/sites/default/fles/resources/InternewsCommunityMediaGuide2009. pdf

Фолкениик, Давид. 2009.  Жефф Жарвис:  Хэвлэл мэдээллийн бизнес загварыг боловсруулах нь (дахин). NPR. www.npr.org/templates/story/story.php?story Id=113512103

Фостер, Мишелле Ж. 2011. Зах зээл ба загварын уялдаа: Хараат бус мэдээний мэдээллийн хэрэгслийн бизнес. Вашингтон ДС: Олон Улсын Хэвлэл Мэдээллийн Туслалцааны Төв. http://cima.ned.org/publications/matching-market-and-model-business-inde pendent-news-media

Фрасер, Колин болон Рестрепо Естрада, Сония. 2001. Хүйн Радиогийн гарын авлага. Парис: ЮНЕСКО. www.unesco. org/new/en/communication-and-information/resources/publications-and-communication-materials/ publications/full-list/community-radio-hand book/

Фрийдом Хаус. n.d. Хэвлэлийн эрх чөлөө. www.freedomhouse.org/reports

Фридрих Эбертийн Сан. n.d. Африкийн хэвлэл мэдээллийн барометр. http://library.fes.de/pdf-fles/bueros/africa- media/08153.pdf

Глобал Бичлэгийн Санаачилга. n.d. Хэвлэл мэдээллийн хавсралт www.globalreport ing.org/reporting/sector-guidance/media/ Pages/default.aspx

Хоулей, Кэвин (ed.). 2009. Хүйн хэвлэл мэдээллийг ойлгохуй. Доузанд Оакс, Калиф.: Сайж.

Олон Улсын Хэвлэлийн Хүрээлэн. n.d. Хэвлэл мэдээлэл ба мөнө. www.freemedia.at/fleadmin/media/Documents/IPI_general/IPI_Report_2011_Media_Money.pdf

IREX. n.d. Хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын индекс. www.irex.org/resource/media-sus tainability-index-msi-methodology

Ж-Лаб. n.d.a. Шинэ Хэвлэл Мэдээллийг Бүтээгчид. www.j-lab.org/publications/new-media-mak ers-toolkit

Ж-Лаб. n.d.b. Шинэ дуу хоолой: Ямар ажлууд. www.j-lab.org/publications/new-voices-what-works

Жарвис, Жефф. 2010. Зохион байгуулалтын сэтгүүлзүйг заах нь. http://buzzmachine.com /2010/01/11/teaching- entrepreneurial-journalism/

Жарвис, Жефф. 2011. Эдийн засгийн хүнд мэдээний хичээл: бизнес загварын үүргүүд. http://buzzmachine. com/2011/04/25/hard-economic-lessons-for-news/

Конрад Аденауэрын Сан.  2006. Мөнгөний тухай: Хараат бус хэвлэл мэдээллийг оршин тогтнохуулахын тулд хэрхэн удирдах вэ. Бонн: Конрад Аденауэрын Сан. www.cameco.org/fles/money_matters_documentation_colour_1.pdf

Локслей, Гарейт. 2009. Хэвлэл мэдээлэл ба Хөгжил. Вашингтон ДС: Дэлхийн Банк.

Нилсон, Марк болон Сусмэн-Пена, Tara. 2009. Хэвлэл Мэдээллийн Хөгжлийн тухай эргэцүүлэхүй, Вашингтон ДС: Интерньюс. www.internews.org/sites/default/fles/resourc es/InternewsRethinking-Media-Dev.web_1.pdf

Пикард, Роберт Г. 2010a. Хэвлэл мэдээллийн бизнесийн сонгодог загварыг хайх. www.theme diabusiness.blogspot. com/2010/04/search-for-alternative-media-business.html

Пикард, Роберт Г. 2010b. Хэвлэл мэдээллийн олон талт зах зээлд бүтээгдэхүүний сонголт болон үнийг тогтооход тулгардаг бэрхшээлүүд www. themediabusiness.blog spot.com/2010/05/challenges-of-pricing-in-multi-ided.html

Пикард, Роберт Г. 2011a. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын санхүү болон эдийн засгийн эрүүл байдлыг хэмжих үзүүлэлтүүд The Economics and  Financing of Media Compa nies, 2nd edn. Нью-Уорк: Фордхам Их Сургуулийн хэвлэл. www.robertpicard.net/pdffles/indicators.pdf

Пикард, Роберт Г. 2011b. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын эдийн засаг болон санхүү, 2 дахь хэвлэлт. Нью-Уорк: Фордхам Их Сургуулийн хэвлэл.

Пикард, Роберт Г. n.d. Дижитал хэвлэл мэдээллийн зураглал: Дижитал болонХэвлэл мэдээллийн Бизнесийн загварууд. Нээлттэй Нийгэм Сан www.opensocietyfoundations.org/reports/digitization-media-business-models


TOTAL SALES BY REGION
REGION SALES
€ 1 236 345,0 Copper
€ 1 896 354,0 Steel
€ 2 569 345,0 Gold
€ 1 893 543,0 Silver
€ 7 595 587,0 Platinum
West
South
North
East
Total
TOTAL SALES

# ДАТА СЭТГҮҮЛ ЗҮЙ

Петер Үервейт

Дата сэтгүүл зүй нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нэг хэсэгт багтдаг. Гэхдээ ихэнх техник үйл ажиллагаа нь өдөр тутмын сэтгүүл зүйд хамаарна. Энэ курс нь оюутнуудад дата сэтгүүл зүйн арга хэрэгсэл, онолын талаар танилцуулах болно. Дата сэтгүүл зүйгээр ажиллахын тулд түүх болон сонгодог жишээ, парадигм шаардагддаг. Унших жагсаалтад дата сэтгүүл зүйн сонгодог жишээ болсон нийтлэлүүд багтсан.

**Курсийн түвшин:** 4 жилийн сургалттай бакалаврын түвшний 2-3 курсийн оюутан

**Курсийн тодорхойлолт:** Дата сэтгүүл зүй нь үүсээд 50 гаруй жил болжээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд нэр хүнд нь илүү өсөж байна. Энэ төрлийн сэтгүүл зүй нь дата буюу өгөгдлийн цуглуулгыг ашиглан бичсэн түүх, өгүүлэг, нийтлэлээс бүтдэг. Дата сэтгүүл зүйн гол төлөөлөл бол Их Британий алдартай сонин The Guardian юм. Мөн Скандинавын орнууд, Франц, Испани зэрэг улсуудын сонинуудад сонирхолтой өгөгдөл дээр тулгуурласан нийтлэл гардаг байна.
Дата сэтгүүл зүйн салбар хоёр хэсэгт хуваагдах бөгөөд тэдгээр нь сэтгүүлчээс мэдлэг болон ур чадвар шаарддаг.

Нэг дэх нь аргачлал нь статистик юм. Өгөгдөл нь ихэвчлэн судалгааны үр дүн байдаг. Хэдийгээр олон өгөгдөл болон мэдээлэл цуглуулж болох боловч утга ба хувьсах утга, хэмжигдэхүүн, алдааны орон зай зэрэг хэмжигдэхүүний талаар тусгай ойлголтгүй бол мэдээгээ боловсруулахад хүндрэлтэй. Эдгээр хэмжигдэхүүнийг ашиглан мэдээ боловсруулахдаа таамаглал дэвшүүлж болно. Унших жагсаалтад цуглуулсан өгөгдлийг ашиглан статистик болон аргачлалын дагуу боловсруулсан нийтлэлүүд байна.

Хоёр дахь хэсэг нь цуглуулсан өгөгдлөө уншаад ойлгох. Хамгийн сайн жишээ гэвэл Засгийн газрын болон олон улсын байгууллагын вэб хуудаснаас тодорхой статистикийн дата өгөгдлийг ашиглах. Нэгэнт эх сурвалжаа олсон бол түүнийгээ компьютер луу оруулна.  MS-Excel бол хамгийн их ашиглагддаг програм ба үүнээс гадна OpenOffice, LibreOffice зэрэг програмуудыг ашигладаг.

Нэгэнт ихэнх сэтгүүлч MS-Excel програмыг ашиглаж сурсан байдаг учраас өгөгдлөө MS-Excel –рүү оруулна. Мөн вэб хуудасны мэдээлэл болон pdf форматтай файлыг MS-Excel-рүү оруулдаг. Одоо мэдээгээ боловсруулах ажилдаа ороход бэлтгэнэ. Гэхдээ  өгөгдөл нь яг хүссэн форматтай орохгүй тул бага зэрэг өөрчлөх ажил хийнэ. Гэхдээ энэ бол механик ажил юм.

Статистик мэдээндээ тулгуурлан мэдээгээ боловсруулж таамаглалаа дэвшүүлнэ. Боловсруулсан статистик өгөгдөл чинь нийтлэлийн чинь гол цөм нь болж өгдөг. Үүнд дундажыг тооцоолох, хувийн ялгаа, корреляци зэргийг ашиглаж мэдээгээ боловсруулна. Гэхдээ их сургуулиудад илүү сайн статистикийн програмууд байдаг. Үүнд: SPSS (Statistical Package for Social Science) эсвэл Statistica гэх мэтийг ашиглаж болно.

Диаграмм болон схем нь ойлгоход хүндрэлтэй учир график ашиглах нь илүү дөхөмтэй байдаг. Үүнд:  Excel програмыг ашиглаж болно. Гэхдээ Tableau гэх мэт графикийн илүү сайн програмууд бас байдаг.

Ихэнх өгөгдөлд газарзүйн статистик орох магадлал өндөр байдаг. Ийм тохиолдолд GIS (geographical information systems) програмыг ашигладаг. Мөн Google ашиглаж болно.

Дата сэтгүүл зүйн бусад сэтгүүл зүйгээс ялгарах онцлог гэвэл цуглуулсан өгөгдлөө хүнд ойлгомжтой байдлаар хөрвүүлэх шаардлагатай болдог. Жишээ нь: Ямар нэгэн нийтлэл бичихдээ эхлээд өөрийнхөө туршлагаас гол баатраа сонгон түүний хэлсэн үгнээс ишлэл авна. Үүнд: ядуурлын түвшин, гэмт хэргийн гаралт, дэлхийн дулаарал, агаарын бохирдол зэргийг статистикаар үзүүлж болох юм. Шийдвэр гаргагчид, мэргэжилтнүүд сонирхолтой ишлэл болон статистик хэлж болох юм. Түүнийг нь ашиглаж болно. Хуучны аргаар бол хэн нэгнээс ярилцлага авч түүгээрээ өгөгдөл цуглуулдаг байсан. Харин одоо бол олон нийтийн сүлжээ буюу Facebook, Twitter ашиглах боломжтой.

Магадлалын онолоор бүлэг хүмүүсийг сонгоод судалгаа авах ба тухайн товч өгөгдлөөр магадлалыг олно. Нээлттэй асуултуудад анализ дүгнэлт хийхэд хаалттай асуултаас илүү хүнд байдаг тул өгөгдлөө боловсруулахдаа хаалттай асуултыг сонгосон нь дээр. Нөхцөл байдлаас хамаарч судалгаа хийхдээ уламжлалт хуучны аналог аргаар хийж болно. Гэхдээ орчин үед онлайн ашиглаад цахимаар судалгааг авч ч бас болох юм. Жишээ нь хэвлэл мэдээллийн вэб сайт дээр гарсан тоо баримтуудыг нэгтгээд боловсруулаад ашиглаж болно. Шаардлагатай үед сэтгүүлчдэд дата сэтгүүл зүй эсвэл статистик програм дээр ажиллах тусгай сургалт явуулж болно.

Дата сэтгүүл зүйн курс нь гол төлөв хувь хүн эсвэл бүлэг хүмүүс дээр тулгуурладаг. Оюутнууд өөрсдөө өгөгдлөө сонгоод түүнийгээ боловсруулна. Үүнд: багштайгаа хамтран сэдэв сонгох, өгөгдлөө цуглуулах, анализ дүгнэлт хийх, эцсийн байдлаар нийтлэлээ бичих гэсэн дараалаар явна. Төслийн жишээ нь тодорхой бүтэц, үр дүн, ашигласан эх сурвалжийн жагсаалт бүхий төлөвлөгөөг агуулсан байна.

**Тэмдэглэл: Энэхүү курс нь дата сэтгүүлзүйн суурь асуудлыг хамрах бөгөөд оюутнуудад хоёрдогч өгөгдлийг хэрхэн боловсруулах тухай заана. Анхдагч өгөгдөлтэй ажиллах нь онлайн судалгаа явуулах шиг хялбар. Сүүлийн үеийн ихэнх өгүүллүүд твиттер зэрэг нийгмийн мэдээллийн сүлжээнд суурилж байна. Эдгээр хоёр сэдэв нь мэдлэг, ур чадварт илүүтэй тулгуурлажээ. Энэ сэдвийн тусдаа загвар нь суурь курсийн үр дүнд гарч ирнэ.**

**Төрөл:** Дата сэтгүүл  зүй нь гол төлөв онлайн сургалттай хамт явдаг ба түүнд зориулсан тусгай програм хангамж, электрон икийн орчин шаардагддаг.
Дижитал сургалт нь танхимийн сургалттай хамт явагдах ёстой. Тиймээс багш болон оюутнууд бие биенийгээ сайн ойлгож онлайн сургалтын дэвшил болон сул талыг сайн ярилцах хэрэгтэй. Онлайн сургалтын дараа оюутнууд илтгэл тавьж сэтгүүл зүйг хэрхэн онлайнтай хослуулж эзэмшсэнээ харуулах ёстой.

**Сургалтын хандлага ба арга зүй:** Уг курс нь олон төрлийн сургалтын хандлагыг хослуулсан байдаг. Электрон орчин дахь онлайн сургалт танхимын сургалттай хосолсон байдалтай явагддаг. Мөн боломжтой бол онлайн төсөл, заах арга зүй хавсардаг. Хэрэв техникийн асуудлаас болж онлайн сургалт явуулах боломжгүй бол энгийн танхимын сургалт хийж болно. Жишээ нь нэг долоо хоногийн эрчимжүүлсэн сургалт байж болох юм.

Энэ сургалт нь оюутан төвтэй сургалт. Өөрөөр хэлбэл оюутнууд өөрсдийнхөө хийж байгаа ажилд хариуцлагаа хүлээж суралцдаг. Харин багш нар дасгалжуулагчийн үүрэг гүйцэтгэж оюутнуудын ажлыг эхлүүлж л өгдөг. Мөн оюутнуудын хийж чадахгүй байгаа зүйлд туслах үүрэгтэй.

Дата сэтгүүл зүйн багш нар электрон орчин болон онлайн мэдээлэл зүйн мэдлэгтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл, багш нар зөвхөн сэтгүүл зүйгээс гадна хоёр дахь буюу онлайн мэдлэгтэй байх ёстой. Багш нар өөрсдөө багштай байж болно. Үүнийг багшийн багш сургалт гэж нэрлэдэг.

Энэ курсийн гарын авлага нь бичвэрээр болон оюутан болон багш нарт зориулсан онлайн байх ёстой. Үүнд: Дата сэтгүүл зүйн жишээнүүд болон даалгаврууд багтсан байна. Түүнчлэн гарын авлагад курсийн тодорхойлолт, тайлбар, чиглэл багтсан.

**Дүгнэх:** 50 кредит/цаг

Энэ курсийн 70 хувь нь даалгавар болон тест байна. Онолын хувьд нээлттэй асуулт байх бөгөөд хариулттай байна. Мөн даалгаврууд бэлэн байна. Курсийн үлдсэн 30 хувь нь төсөл, илтгэлд зориулагдана. Дүгнэхийн хувьд оюутнууд өөрсдөө өгөгдлөө цуглуулж дата сэтгүүл зүйгээс юу сурснаараа илтгэл тавьж харуулна.

**Хугацаа:** Нийт 10 долоо хоногтой ба долоо хоногт 4 цаг (2 цаг уншлага, 2 цаг дадлага) эцсийн төсөлд 10 цаг зарцуулна.

**Тоног төхөөрөмж:** Тус курс нь цахим орчинд явагдах учраас Moodle сервер хэрэгтэй ба компьютерийн багтаамж, интернетийн хурд сайн байх хэрэгтэй. Бүх компьютер мэдээллээ нэг серверээс авсан эсвэл интернетээс авсан ч давхар мэдээллийн технологийн ажилтан шаардлагатай. Учир нь дата сэтгүүл зүйд зориулагдсан програм суулгах, татах мөн серверийн үйл ажиллагааг хянах шаардлага гардаг. Оюутан багш нарт бүгдэд нь Windows 7 болон түүнээс дээш үйлдлийн систем,  хүчин чадал бүхий интернеттэй компьютер шаардлагатай. Үүнд дараах програм хангамжууд суусан байх хэрэгтэй.

- И-мэйл хөтөлбөр
- Firefox вэб браузер
- Эксел эсвэл ижил төстэй хуудастай програм
- Outwit Hub, plug-in Firefox
- Гүүглийн сайжруулалт
- Хүснэгт эсвэл ижил төрөл.

# Сургалтын хэлбэр

## Нэгдүгээр хэсэг: Дата сэтгүүл зүй гэж юу вэ?

*Унших материал:* Дата сэтгүүл зүйн гарын авлага

*Даалгавар:* Дата сэтгүүл зүйтэй холбоотой сайн жишээ нийтлэл, мэдээ материал хайж олох

## Хоёрдугаар хэсэг: Судалгаа болон статистикийн зарчим

*Унших материал:* Сэтгүүл зүйн статистик мэдээ, асуултууд

*Даалгавар:* тодорхой өгөгдөл ашиглан дараах асуултад хариул:

- Аль нь хувьсах хувьсагч вэ? Юу хэмжсэн байна вэ? Ямар түвшний хэмжүүр вэ?
- Энэ өгөгдлөөс аль таамаглалыг шалгаж туршсан бэ?

Өөрийн сонгосон өгөгдөл дээр эдгээрийг ашигла.

## Гуравдугаар хэсэг: Spreadsheet буюу маягтын танилцуулга

*Унших материал:* (spreadsheets ба CAR техник) дараах даалгавруудыг гүйцэтгэ: Үүнд:

- Үндсэн тоо болон текстээ оруул, энгийн тооцоолол хий
- Энгийн томъёолол гарга, өгөгдөлд шүүлт хийж эмхэлж цэгцлэн энгийн график байгуул,
- Сайжруулсан гол хүснэгт

**Дөрөвдүгээр хэсэг: Маягт буюу Spreadsheet-тэй ажиллах**

*Даалгавар:*

- Дараах хоёр өгөгдлийг тат: 1) Онлайн өгөгдлийн сан 2) pdf-ийг Excel рүү
- CV-г оруул
- Google docs оруул
- Сонирхолтой гэсэн өгөгдлүүдийг ол, маягт буюу Spreadsheet –рүү буулгаад ямар техник ашигласнаа тайлбарла

**Тавдугаар хэсэг: Арилгах ба цэвэрлэх**

Унших материал: (on OutWit and Google Refine)

**Зургадугаар хэсэг: Дата анализ дүгнэлт: Шалгах ба төгсгөх**

**Долдугаар хэсэг: Вэб хэрэгсэл ашиглан график хийх**

Унших материал: (Maps ба Google fusion tables, ба Tableau)

**Наймдугаар хэсэг: Илүү сайн график болон газрын зураг хийхийн тулд Tableau and Google fusion-ийн хүснэгтүүд дээр ажилла.**

**Ес дүгээр хэсэг: Нийтлэл бич**

Унших материал: Бичиж байгаа нийтлэл

**Аравдугаар хэсэг: Төсөл, ганцаарчилсан ба бүлгээр**

# Унших материалууд

**Дата сэтгүүлзүйн түүх:**

Мэеэр, Филип. 2011. Нарийвчилсан болон дэлгэрэнгүй сэтгүүлзүй: нэгдсэн талбарын онолын чиг хандлага. www. nieman.harvard.edu/reports/article-online-exclusive/100044/Precision-Journalism-and-Narrative-Journalism-Toward-a-Unifed-Field-Theory.aspx

**Тодорхойлолтууд:**

Википедиа.  Компьютерийн тусламжтай мэдээлэх гэж юу вэ? http://en.wikipedia.org/wiki/Computer-assisted_reporting

Википедиа. Өгөгдлийг жолоодогч сэтгүүлзүй гэж юу вэ? http://en.wikipedia.org/wiki/Data_driven_journalism

Минди Мкадамсийн бэлтгэсэн өгөгдлийг жолоодогч сэтгүүлзүйн жишээнүүд: http://mindymcadams.com/tojou/2012/data- journalism-examples/

**Филип Мэеэрийн шагналт бүтээлүүд:**

www.ire.org/tag/philip-meyer-journalism-awards/

**Дата сэтгүүлзүйн гарын авлага:**

Дата сэтгүүлзүйн гарын авлага.орг. Дата сэтгүүлзүйн гарын авлага. http://datajournalismhandbook.org/1.0/en/

**Кодлогч болон сэтгүүлчдийн тухай:**

Вэрвейж, Петер. 2012. Дата сэтгүүлзүй: кодлогч болон сэтгүүлчидтэй хаана уулзах вэ. http://memeburn.com/2012/03/data- journalism-where-coders-and-journos-meet/

**Арван арга хэрэгсэл:**

Дибодеаукс, Трое. 2011. Илүү үр бүтээлтэй ажиллахын тулд дата сэтгүүлчдэд туслах арван арга хэрэгсэл www. poynter.org/how-tos/digital-strategies/147736/10-tools-for-the-data-journalists-tool-belt/

**Таван зөвлөмж:**

Дибодеаукс, Трое . 2011. Дата сэтгүүлзүйг эхлэн суралцагсдад зориулсан таван зөвлөмж. www.poynter. org/how-tos/digital- strategies/147734/5-tips-for-getting-started-in-data-journalism/

**Компьютерийн тусламжтай мэдээлэх арга техникууд болон дата сэтгүүлзүй:**

Issu.com. Дата сэтгүүлзүй. http://issuu.com/tcij/docs/data_journalism_book

**Хүснэгтэн тооцоолол:**

Жеймс, Б.В.Экселийн суурь гарын авлага. http://people.usd.edu/~bwjames/tut/excel/

**Сэтгүүлчдэд зориулсан арга зүй болон статистик:**

Explorable.com. 2011. Судалгааны арга зүй. www.experiment-resources.com/research-methodology.html

Explorable.com. 2011. Статистикийн гарын авлага болон давтлага. www.experiment-resources.com/statistics-tutorial.html

Issuu.com. 2011. Сэтгүүлчдэд зориулсан статистикууд. http://issuu.com/tcij/docs/cij_statistics_for_journalists_26_05_11

Нилес, Роберт. Сэтгүүлч бүрийн мэдэх ёстой статистикууд. www.robertniles.com/stats/

**OutWit:**

Гарын авлага hub: http://blog.outwit.com/

NICAR АутВит Хабыг хэрэглэх тухай: https://docs.google.com/a/d3-media.nl/document/d/16qj2_1EohABneH_h7Reh3ymL4_tf5VYYUxRl-ELycSs/edit?pli=1

**Гүүгл Рефне:**

Гарын авлага: http://code.google.com/p/google-refne/wiki/Screencasts

Гүүгл Рефнегийн тухай Пропаблика: http://www.propublica.org/nerds/item/using-google-refne-for-data-cleaning

Гүүгл дээр хайлт хийх хүснэгтийн мап: http://support.google.com/fusiontables/bin/answer. py?hl=en&answer=184641

**Хүснэгттэй ажиллах нь:**

Хүснэгт дээр хэрхэн ажиллах вэ. www.tableausoftware.com/public/how-it-works

**Өгүүлэл бичих нь:**

Эрэн сурвалжлах бүтээл бичих тухай гарын авлага: Хантер, Марк Ли. 2011. Таамагт суурилсан судалгаа: Эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага Парис: ЮНЕСКО. http://unesdoc.unesco.org/images/0019/001930/193078e.pdf



# ОЛОН ТАЛТ СОЁЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙ

Бэртрэнд Кабидоче

Энэ курс нь оюутнуудыг олон талт соёлын сэтгүүл зүйн мэдлэгтэй болоход зориулагдсан. Үүнд: контент хөгжүүлэлт, өөрийгөө таних, олон нийтийн домейн зуучлал, менежментийн бодлого, хэвлэл мэдээллийн байгууллагын хүний нөөцийн менежмент, эдийн засгийн гүйцэтгэл (бизнес), соёлын хөгжил, харилцаа холбоо ба мэдээлэл, олон нийтийн орон зай хөгжил ба нийгмийн асуудал, мэдлэг хөгжүүлэлт гэх мэт багтана.

**Курсийн түвшин:** Энэхүү курсийг их сургуулийн 3-р курсийн оюутнууд болон ямар ч мэргэжлийн магистрын сургалтын нэгдүгээр курст зориулсан болно.

**Курсийн тодорхойлолт:** 20-р дууны хоёрдугаар хагасаас мэдээлэл саадгүй хөвөрч, өргөн хэрэглээний бараа болон хүмүүсийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн эхэлсэн. Нийгмийн гол тоглогчид (олон нийт/ хувийн/ холбоо, хувь хүн/хэсэг бүлэг хүмүүс, институци)-ийг тооцохгүйгээр соёлын асуудлууд ээлж дараалан гарч ирэв. Үүнтэй зэрэгцэн phenomena буюу бүс нутаг, орон нутаг, геополитик, бэлэг тэмдгийн газар нутгийн хувиарлалт зэрэг үзэгдлүүд дэлхий дахинд шинээр тулгарсан. Өөрөөр хэлбэл, улс төр болон нийгмийн соёлын асуудал урган гарч ирсэн билээ.

Олон талт соёлын асуудлыг өнгөцхөн харвал, хэвлэл мэдээллийн агуулга, контент бүтцээс үйл явдалд, эрх чөлөөнөөс гишүүнчлэлд, нэг ертөнцөөс олон янзын соёл руу шилжих болсон юм (Braudel, 1958). Ингэснээр онол болон арга зүйн хандлага давхар өөрчлөгдсөн. Энэ өөрчлөлт нь яваандаа мэдлэгийг ур чадварын техник, хувийн ур чадвар, хуулан бичих ур чадвар болгон өөрчлөх болсон. Энэ нь улмаар сэтгүүл зүйд нөлөөлж, олон талт соёлын сэтгүүл зүйн салбар үүсэхэд хүргэсэн байна.

Өөрөөр хэлбэл сэтгүүлчид энэ салбар луу анхаарч олон талт соёлын мэдлэг мэдээлэлтэй болохыг шаардаж байна гэсэн үг. Уг курс нь сэтгүүлчид олон улсын соёлыг мэдэхгүйгээсээ болж  санаатай болон санаандгүй байдлаар олон талт соёлын мэдлэгийн алдаа гаргахаас сэргийлэх зорилготой. (Молес, 1967, мөн үүнээс хараарай Молес, 1979). Өнөөгийн мэдээллийн эрин зуунд олон талт соёлын талаарх ойлголтын зөрүү, төөрөгдөл гарах магадлалтай. Хүмүүсийн хувьд хэвлэл мэдээллийн хэрэгслээс шууд мэдээлэл авч, түүндээ итгэдэг учраас сэтгүүлчид олон талт соёлын талаарх мэдлэг, мэдээлэлтэй байхыг шаардаж байна. Тиймээс олон талт соёлын сэтгүүл зүйн салбар олон улсын соёлыг ойлгоход тус дөхөм болох юм.

**Төрөл:** Олон талт соёлын асуудлыг сурвалжлах, түгээх, мэдээлэх зорилгоор Олон талт соёлын сэтгүүл зүй гарч ирсэн. Олон талт соёлын сэтгүүл зүй болон Олон талт соёлын сахилга бат сэдвээр мэтгэлцээн зохион байгуулах.

**Сургалтын хандлага ба арга зүй:** Энэ курс нь бэлэн байгаа гарын авлага, хариулт, шийдэл гэхээсээ илүү сэтгүүл зүйтэй холбоотой юм.
Уг хөтөлбөрийн зорилго нь олон талт соёлын асуудлыг хөндөж нийтлэсэн хэвлэл мэдээллийн (хэвлэлийн мэдээ, телевизийн хөтөлбөр гэх мэт) талаар санаа зовсон хүмүүст зориулагдсан. Гол тоглогч нь олон талт соёлын салбар дахь асуудлыг хөнддөг хэвлэл мэдээлэл. Жишээ нь: Олон талт соёлын салбарт ярилцлага авах гэх мэт.
Курсийн төгсгөлд олон талт соёлын асуудлаар судалгаа хийсэн нэр дэвшигч өөр нэгэн нэр дэвшигчтэй Олон талт соёлын асуудлаар мэтгэлцэж болох юм.
Гэхдээ эхний нэр дэвшигч олон талт соёлын асуудлаар онолын туршлагатай байх бөгөөд асуулт нь дэлхийн, орон нутгийн, улс үндэстний гэх мэт олны анхаарал татсан асуулт байна. Мэдээж сэтгүүл зүйн туршлагатай байх ёстой.

**Кредит:** 60 кредит/цаг
Оролцогчийн идэвх нийт курсийн 30 хувь, үлдсэн 70 хувь нь тухайн оюутны Олон талт соёлын асуудалтай холбогдсон төсөл байх ба энэ нь магадгүй долоо хоног тутмын сонин байж болох.

**Хугацаа:** Нийт 12 долоо хоног байх бөгөөд долоо хоногт 4 цаг (нийт 24 цаг) эдгээрт 1 цаг нь уншлага, 1 цаг нь дадлага, 2 цаг нь аргазүй, онол.
Оролцогчдын хувьд Олон талт соёлын талаарх төслөө бичихийн тулд танхимаас гадуур цаг байх хэрэгтэй. Нэмэлт даалгаварт 30 минут илтгэл тавина. (20 минут илтгэнэ, 10 минут асуулт хариулт)
Товчоор хэлбэл, оролцогч 48 цагийг танхимийн сургалтад зориулна. 30 минутыг хийсэн ажлаа эрэгцүүлж дүгнэхэд зарцуулна.

**Тоног төхөөрөмж:** Энэ курст нарийн техникийн тоног төхөөрөмж хэрэггүй ч видео проектор, камер, фото аппарат зэрэг энгийн сэтгүүл зүйд хэрэглэгддэг тоног төхөөрөмж хэрэгтэй.
Нэмэлт хэрэгсэлд илтгэл тавихад зориулсан тах (Англиар U) хэлбэрийн ширээ байж болно.

## Сургалтын хэлбэр

Сургалтын дараалал (дөрвөн дараалалтай) бүрт оролцогчдын дадлага, онолын болон ойлголтын дасгал, оюуны дасгал багтсан байна.

**Нэгдүгээр хэсэг: Сэтгүүл зүй – Консепци агуулсан вектор (эзлэн түрэмгийлэл соёлыг өөрчилж чадах уу?)**

Европын колончлолын үед Франц стилээс универсализм буюу Их Британий космополитан загвар болж хоёр гүрний соёлын мөргөлдөөн бий болсон. Энэ нь анхны хоёр том иргэншсэн соёлын мөргөлдөөн байлаа.

Хэдийгээр колончлолын үед улс гүрнүүд өөрсдийнхөө соёлыг хамгаалж гадны соёлын эсрэг тэмцэж байсан (Жишээ нь: иргэншсэн ертөнц барбарууд буюу зэрлэг бүдүүлгүүдээс өөрсдийнхөө соёлыг хамгаалах гэж тэмцсэн). Гэвч мэдээлэл харилцааны технологи хөгжсөнөөр өөрсдийнхөө соёлыг хадгалан үлдэх ямар ч боломжгүй болсон.

Орчин үеийн онолоор улс үндэстэн хөгжихийн хэрээр аажмаар бүдгэрч эхэлсэн. Үүнийг “Иргэншил хоорондын мөргөлдөөн”  гэж томьёолдог.

Улс үндэстэн хөгжихийн хэрээр өөрсдийн соёлыг хамгаалж байсан үндэстнүүдэд хууль дүрэм үйлчлэхээ больж даяарчлалын (технологийн хувьсгал, мэдээллийн хурд, мэдээллийн нийгэм) соёлын өөрийн эрхгүй гарч ирэн улс хоорондын соёлыг нэгтгэж байна. Харилцаа холбооны зөөлөн хүч (АНУ, Хятад)

**Хоёрдугаар хэсэг: Сэтгүүл зүй – ¬Хүлээн зөвшөөрөгдсөн олон талт соёл**

Жакобины анализ дүгнэлтээрээ 18-р зууны сүүлчийг дэлхийн хоёрдугаар дайны пропагандаг хэвлэл мэдээллийн үүрэг рольтой  харьцуулсан юм. Арьс өнгөөр

ялгаварлан гадуурхах солиорол; Транс-соёлын тархац; Соёлын довтолгоон; Эволюцийн алдаатай онол; Антропологийн “Соёлын хамаарал” гэх мэт цагийн аясаар улс үндэстний соёл гэдэг ойлголт байхгүй болж байна. Өөрөөр хэлбэл, мэдээллийн технологи хөгжсөнөөр соёлын империализм буюу нэг соёлын давамгай байдал алдагдаж байна. Соёл болон улс үндэстний зааг ялгаа хэвлэл мэдээллийн нөлөөгөөр аажмаар багасч байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээлэл эдгээрийн зуучлагч гүүр нь болж байна гэсэн үг. Энэ нь эргээд нийгэмдээ нөлөөлж байна.

## Гуравдугаар хэсэг: Сэтгүүл зүй – холимог соёлын вектор

Соёлын интеграцчлал нь тухайн бүс нутгийн, улс үндэстний хөгжлөөс шууд хамаарч байна. Олон төрлийн соёл үүсэх гол хүчин зүйл нь масс буюу олонхоос шууд хамаардаг.

Тухайн улсын эрх мэдэлтнүүд хэвлэл мэдээллийг хянах гэж оролдож байна. Гэхдээ хил хязгаар сийрэг учраас энэ нь тэр болгон хэрэгжихгүй байна. Мэдээллийн орох гарах урсгал нь олон нийтийн орон зайг эзэлж байна. Мөн олон нийтийн сүлжээ ямар ч хил хязгааргүйгээр бусдын соёлд нэвтэрч байна. Мэдээллийн холимог байдалд харилцан ярианы хэвлэл мэдээлэл, уламжлалт хэвлэл мэдээлэл ба улс хоорондын хэвлэл мэдээлэл орж байна.

Олон талт соёлын үнэ цэнэ нь тухайн улсуудын соёл болгоноос хамаарч байдаг. Олон талт соёлыг хадгалахад шинэ хүмүүнлэг нийгэм болон ЮНЕСКО гол үүрэг гүйцэтгэж байна.

## Дөрөвдүгээр хэсэг: Олон талт соёл – хэвлэл мэдээллийн менежментийн шинэ урлаг, эсвэл хэрэглэгдэхгүй шүүмжлэлтэй бодол

Соёлын хөгжил, мэдээлэл болон харилцаа холбооны салбар нь сүлжээний (telecommunication - харилцаа холбоо)  болон мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийн салбартай нягт холбогддог. Аажим өөрчлөгдөж байгаа дэлхийн сэтгүүл зүйн соёлын байгууллагуудын хөгжилд Францын прагматик социологийн ойлголт чухал үүрэг гүйцэтгэсэн.

Хофтседе загвар бол менежментийн соёлын анхдагч юм. Соёлын олон талт байдлын неоинститут онол болон нөөцийн онолын анхны элемент нь бизнес юм. Олон талт соёлын практик болон арга техник хэвлэл мэдээлэлд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Соёл судлал, медиа судлал болон жендер судлал нь соёлын олон талт байдалд нөлөөлсөн юм.

Олон талт байдлын Ултра-Либерал үзэл нь соёлын националистууд юм. Олон талт байдал нь өөрөө эргээд нийгмийн чимэг болдог. Тэгэхээр хуучин Европын гео-эдийн засгийн, геополитикийн зөвхөн өөрсдийн соёлыг хамгаалах гэсэн үзэл цагийн эрхээр алга болж, олон үндэстнүүдийн соёл аль хэдий нь интеграцчлагджээ. Жишээ нь: АНУ-ын кино, спорт урлагийн соёл аль хэдий нь Атлантын далайг гатлаад хөгшин Европт хөл тавиад байна. АНУ-ын Холивүүдийн киног үзэж, спортын оддыг биширч, рок поп дууг нь сонсдоггүй Европ хүн байна уу? Үүнтэй адил сэтгүүл зүйд ч бас олон талт соёл нэвтэрчээ. Дэлхийн бүх л хэвлэл мэдээллийн хэрэгсэл АНУ, Английн CNN, BBC зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг даган дуурайж үлгэр жишээгээ болгож байна.

**Тавдугаар хэсэг: Олон талт соёл – дижитал соёл**

- Дижитал соёлын консепци
- Кибер – сэтгүүл зүй ба стандарт
- Дижитал сэтгүүл зүйн адилтгал
- Сургалт (хэвлэл мэдээллийн вэб сайтын анализ, соёлын асуудлуудыг олж мэдэх, харьцуулах)

# Унших материал, Ном зүй


**Хичээл 1:**

Маттеларт, Арманд. 1999. Histoire de l'utopie planétaire. De la Cité prophétique à la Société globale, Paris: La Découverte [trans. (2000) Historia de la utopía planetaria. De la cuidad prophética a la Sociedad Дэлхийн болон Ютопиа гарагийн түүх. Зөнчдийн хотоос дэлхийн нийгэм рүү, Барселона: Пайдос Иберика Эдисионес.]

**Хичээл 2:**

Шиллер, Хэрбэрт Ж. 1973. Харилцаа болон Соёлын давамгайлал. Вайт Плайнс, Нью Уорк: Олон Улсын Соёл Шинжлэх Ухааны Хэвлэл.

**Хичээл 3:**

Аппадюрай, Аржун. 1996. Modernity at Large: Даяарчлалын соёлын хэмжүүр. Минниаполис, Минн.: Миннесотагийн Их Сургуулийн хэвлэл.

Деморгон, Жакьюс. 2000. L'interculturation du monde. Парис: Антропос.

**Хичээл 4:**

Боюкюллион, Филиппе. 2008. La diversité culturelle. Une approche communicationnelle, Харилцааны асуултууд. http://questionsdecommunication.revues.org/1823

Гарнхэм, Николас. 1990. Олон нийтийн бодлого болон соёлын салбар. Капитализм ба Мэдээлэл харилцаа: Дэлхийн соёл ба Мэдээллийн эдийн засаг, Лондон: Сейж.

Гарнхэм, Николас. 2005. Соёлоос бүтээлч салбар руу: бүтээлч салбарын үр дүнгийн анализийг Их Британи дахь соёлын болон хэвлэл мэдээллийн шийдвэр гаргагчдад хүргэх. Соёлын бодлогын олон улсын сэтгүүл, Vol. 11, pp. 15–29.

Хопстеде, Гээрт. 1991. Соёл ба Байгууллага: Оюун ухааны програм хангамж, Олон талт соёлын хамтын ажиллагаа, түүний оршин тогтнох ач холбогдол. Нью Уорк: МкГрею-Хилл.

Меуер, Оливер. 2005. Олон талт соёлын менежмент: Стратеги, Байгууллага, Гүйцэтгэл. Парис: Дюнод.

**Хичээл 5:**

Киюүндою, Элайн (ed.). 2010. Cultures, technologies et mondialisation.  Парис: Л Харматтан

Бадилло, Патрик-Айвес. 2005. De la parfaite adéquation du journalisme à la 'société de l'information': les enjeux de l'information et de la communication [Сэтгүүлзүйн төгс байдлаас 'мэдээллийн нийгэм' рүү, мэдээлэл болон харилцааны учир холбогдол]. www.u-grenoble3.fr/les_enjeux/2005/Badillo/index.php

Браудел, Фернанд. 1958. Histoire et sciences sociales: la longue durée [Түүх ба нийгмийн шинжлэх ухаан: урт хугацааны]. Анналес, Ээзлхүүн. 13, №. 4, хуудас. 725–53.

Кристин, Жиин-Пирре (ed.). 2002. Рванда: Les médias du génocide, [Рванда: Устгалын хэвлэл мэдээлэл]. Парим, Картала (ЮНЕСКО-гийн хүсэлтээр).

Молес, Абрахам. 1967. Sociodynamique de la culture, Парис: La Haye, Mouton. (Орчуулга. (1974) Соёлын социодинамик. Бухарист: Эд. Шинжлэх ухаан.)

Молес, Абрахам. 1979. Англи хэлний давамгайлсан байдал нь Франц цэг. Хэлний Социологийн Олон Улсын Сэтгүүл, дугаар 22, хуудас. 51–6.

Žižek, Slavoj, 2004, Plaidoyer en faveur de l'intolérance [A Plea for Intolerance]. Castelnau-le-Lez, Франц: Climats.



# ХҮЙН РАДИОГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ

Калинга Сеневиратне

Тус курс нь оюутнуудад хүйн радиогийн практик дадлага, загвар, зарчим, ойлголт концепцийн талаар мэдлэг олгоно. Энэ сургалт нь гол төлөв Азийн хүйн радиогийн соёл, туршлагаас танилцуулах болно. Учир нь хөгжиж байгаа бусад орнуудад тулгарч буй хүндрэл бэрхшээлтэй ойр дөт юм. Тиймээс багш сурган хүмүүжүүлэгчдийг сургалтын хөтөлбөртөө илүү шинийг санаачлахыг уриалж зоригжуулж байна.

**Курсийн түвшин:** Радио техникийн сэтгүүл зүйгээр суралцаж байгаа бакалаврын төгсөх ангийн оюутнуудад

**Курсийн тодорхойлолт:** Арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөгжихийн хэрээр хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хотын оршин суугчдын хэрэглээнээс гарч зах зээлээс шахагдаж эхлээд байна. Ялангуяа радиогийн хувьд байдал тодорхой харагдана. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хотоос алслагдсан эсвэл амьжиргааны түвшин доогуур иргэдэд хамгийн хүртээмжтэй байдаг. Курсийн зорилго нь оюутнуудыг арилжааны бус радиогийн нэвтрүүлэг бэлтгэх чадварт сургах, тодорхой бүлэг хүмүүст хандсан мэдээ нэвтрүүлэг бэлтгэхэд нь тус дэм болох юм.

**Курсийн зорилго:**

- Оюутнуудын харилцааны ур чадварыг дээшлүүлэх, тодорхой ашиг сонирхлоор нэгдмэл бүлэг хүмүүсийн санаанд нийцсэн илүү ойр дотно мэдээ нэвтрүүлэг бэлтгэх.
- Хүйн радиогийн ерөнхий зарчим зорилгыг танилцуулах
- Оюутнуудад олон нийтэд хандсан радиогийн програм хөтөлбөрийг хийх, практик туршлага суулгах
- Оюутнуудыг хүйн радио редакцад ажиллах болон радиогийн мэдээ нэвтрүүлэг бэлтгэх, менежмент хийх ур чадвар, мэдлэг олгоход суралцах

**Курсийн хугацаа:** 15 долоо хоног, нэг семестр

Долоо хоногт заах цаг: 4 цаг (1 цаг лекц, 3 цаг заах/ангийн ажил) програм, хөтөлбөр судалгаа хийх зорилгоор радио редакц  болон бусад ажлын байранд

**Тэмдэглэл: Оюутнууд доод тал нь нэг радио продакшны бүтээлийн загвар гаргана. Учир нь уг курсээр радио продакшн эсвэл радио редакцийн үйл ажиллагаанаас заахгүй. Оюутнууд дуу бичлэг хураах, радио материалыг хамгийн энгийн байдлаар эвлүүлж монтажлах,  хамгийн энгийн дижитал технологи ашиглана. Оюутнууд сонголтоор арай дээд түвшний радио продакшны хөтөлбөр, ток шоу зэрэгт хамрагдаж болно.**

**Сургалтын төрөл:** Радиогийн менежмент, радио продакшны онол болон практикийн загвар. Мэдээлэл харилцаа холбооны бакалаврын ангийн оюутнуудад зориулсан. Мөн тухайн орон нутгийн радио редакцийн ажилтны удирдлага, зааврын дор онлайн сургалт байж болно.

Курсийн хувьд долоо хоног бүрийн лекц, ангийн ажил болон дасгал, ажлын байрны дадлага 8-10 долоо хоног эсвэл 2 долоо хоногийн эрчимжүүлсэн сургалт байна. Материалын эх сурвалж олж авах тэмдэглэл, нийтлэл, электрон хэвлэл, онлайн эх сурвалж, аудио бичлэг болон видео зэргийг ашиглахын тулд электрон номын сан ашиглаж болно.

Цахим сургалтыг энгийн ангийн сургалт/ангийн ажлын хурал семинартай хослуулан зохион байгуулна. Онлайнаар ажиллахын тулд оролцогчид буюу оюутан багш нар бие биенээ сайн таньж мэдсэн байх ёстой. Ангийн уулзалтыг үр дүнтэй болгож асуудлыг шийдэх гарц олохын тулд олон нийтийн тулгамдсан асуудлыг анхны сэдвээрээ сонгох хэрэгтэй. Үүнд энгийн анги ашиглан ангийн ажил хийх, мөн тулгамдсан асуудлаар радио дуу бичлэг, төсөл хийж үүнийхээ үр дүнтэй эсэх талаар ярилцана. Хамгийн сүүлийн ангийн уулзалт нь сурсан мэдсэнээ бие биедээ танилцуулах ЭШБХурал байна. Оюутан бүр илтгэл тавина.

**Сургалтын арга зүй, хандлага:** Энэ курсээр хэд хэдэн сургалтын хандлага, сургалтын арга зүйг ашигласан. Уг хичээл нь их сургуулийн төгсөх ангийн оюутнуудад семестрийн 13-15 долоо хоног заагдана. Эхний ээлжинд компьютер шаардлагагүй, энгийн анги танхим байхад болно. Харин нэг анги дундаа CD-ROM болон онлайн линк ашиглаж болно.

Тус курс нь хүйн радиогийн ажилтнуудад зориулж онлайнаар заагдана. Долоо хоног бүрийн хичээл нь дасгал сургуулилт, ажлын байрны дадлага зэрэгтэй 15-16 долоо хоног байна. Оюутны ажлын байран дахь дадлагын үнэлгээ хүйн радио редакцид хэрхэн ажилласнаас хамаарна. Хэдийгээр электрон орчинд онлайн хичээл заагдах боловч ангийн ажил, сургууль дээрх дадлага шаардагдах бөгөөд (хамгийн эхний ангийн уулзалт мөн курсийн дундуур хэд хэдэн удаа боломжтой бол долоо хоног бүр эсвэл хоёр долоо хоногт нэг удаа сургууль дээрх дадлагыг хийнэ) хэн нэгний удирдлага дор дадлага хийнэ.

Тус курс нь оюутан төвтэй буюу оюутанд тулгуурласан, оюутны бие дааж сурах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэ нь оюутнууд өөрсдийнхөө хийсэн ажил болон цагийн хуваарьт анхаарал тавьж хариуцлага хүлээж сурна.  Багш нар ерөнхийдөө дасгалжуулагчийн үүрэг гүйцэтгэж оюутнуудыг ажлын байранд очиход нь туслана. Мөн даалгавар өгч, хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь туслана.
Гэвч багш сурган хүмүүжүүлэгчид радиогийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй байх ёстой. Тэд урьд нь болон одоо хүйн радиод ажиллаж байвал бүр сайн. Ялангуяа хүйн радио, мөн электрон техникийн орчинд ажилласан туршлагатай байх шаардлагатай. Зарим хөгжиж буй орнуудад электрон радио техникийн тусгай сургалт явуулдаг. Үүнийг багш нарын багш гэж нэрлэх тохиолдол ч бий. Энэ сургалтын хөтөлбөр урьдчилан хийгдсэн байна. Сургалт хэд хэдэн техникийн их сургуулиудад эсвэл олон нийтийн радио редакц дээр явагдана.

Тэмдэглэл: Хүйн радио болон их сургуулиудын сургалтын материал өөр өөр улсуудад өөр өөр хэл дээр байдаг. Тиймээс  Англи хэл дээр байгаа энэхүү сургалтын хөтөлбөр болон материал хэд хэдэн хэл дээр орчуулагдан хэвлэгдэж болох юм.

**Дүгнэх:**

Их дээд сургуулийн хувьд: оюутнууд ганцаараа болон бүлгээрээ үнэлгээ авч, багшаар дүгнүүлнэ. Уг сургалтад улирлын сүүлийн дүн гэж байхгүй, оюутнуудын оролцоо идэвх чармайлт, төсөл хөтөлбөр, илтгэл зэргээр дүгнэнэ. Гэхдээ тухайн оюутан хүйн радиогийн мэдээлэл харилцааны онолын тухай эссэ бичиж дүгнүүлж болно.  Дүгнэлт хийх онооны хувь:

- Хүйн радиотой холбоотой эссэ (оюутан бүр): 20 хувь
- Радиогийн хөтөлбөрийн төсөл, төлөвлөгөө (группээр дасгал ажиллах): 10 хувь
- Мэдээ, мэдээллийг бүртгэж цуглуулсан байдал (группээр дасгал ажиллах): 10 хувь
- Мянганы Хөгжлийн Зорилтууд сэдвээр радио нийтлэл бичих: (группээр дасгал ажиллах): 10 хувь
- Сэтгүүлийн хөтөлбөр, төгсөлтийн ажил, төсөл (групп): 40 хувь
- Ирц болон идэвх: 10 хувь

Хүйн радиогийн редакцийн сургалтын хөтөлбөрт хамрагдагсдын хувьд: Тодорхой дүн байхгүй. Гэхдээ доор дурьдсан хөтөлбөрийг бүрэн эзэмшиж, тэнцсэн гэсэн сертификат авах болзол хангах ёстой.

Сертификат нь бүс нутгийн болон орон нутгийн их сургуулиудад хүйн радиогийн мэргэжлийн эрхтэйгээр олгогдоно. Сертификатыг авахын тулд дараах дасгалуудыг бүрэн хийж тэнцсэн байх шаардлагатай.

- Харилцаа холбоо мэдээллийн арга зүйн ерөнхий тест
- Радиогийн хөтөлбөрийн төсөл, төлөвлөгөө (группээр дасгал ажиллах)
- Мэдээ, мэдээллийг бүртгэж цуглуулсан байдал (группээр дасгал ажиллах
- Мянганы Хөгжлийн Зорилтууд сэдвээр радио нийтлэл бичих: (группээр дасгал ажиллах)
- Сэтгүүлийн хөтөлбөр, төгсөлтийн ажил, төсөл (групп)
- Ирц болон идэвх (суралцагч нийт хичээлийн доод тал нь 75 хувьд нь суусан байна.)

**Тоног төхөөрөмж:** Ямар ч их дээд сургууль болон хүйн радиогийн редакцид доод тал нь 3 дижитал дуу хураагуур, интернэтэд холбогдсон 3 компьютер, хураасан дуу бичлэг эвлүүлж, монтажлах Протүүлс програм хангамж суулгасан байна.

## Сургалтын хүрээ:

**Нэгдүгээр долоо хоног: Хөгжлийн онолууд болон оролцооны харилцааны тухай танилцуулга**

Лекцээр "Хөгжил гэж юу вэ?" гэсэн асуултад хариулна. Мэдээлэл харилцааны оролцоо болон хөгжлийн онолын талаар авч үзнэ. Өөр бусад улс орнуудын эволюци болон бусад дадлага туршлагаас судална.

*Видео:* AMIC, AIBD and Глобал Ай Медиа (2009), Махавелийн Хүйн Радио. Оюутнууд дараах холбоосоор орж үнэлгээний тайланг татаж авна уу http://unesdoc.unesco.org/images/0005/000559/055973eo.pdf.

*Сургалт:* Харилцаа холбоо, мэдээллийн үнэлгээний талаар ярилц. Мэдээлэл харилцааны хөгжил болон харилцаа холбооны талаар суралцана. Тухайн ангийг бүлэгт хуваан салбарын хөгжлийн арга зүйн асуудлаар судлуулна. Радиогийн бизнест шаардлагагүй арга зүйн талаар оюутнууд ярилцана.

*Унших материал ба ном зүй:*

*Тэмдэглэл:* Оюутнуудын хувьд дараах ном болон эх сурвалжаас өөрсдөө сонгоно. (2001, хуу. 7–32, 37–48, 121–32, 157–62, 169–74, 199–204, 211–16, 223–28, 253–8, 313–16). Мөн  Аскрофт et al. (2008, хуу. 1, 2, 4, 5,10, 17), Кумар (2001), Лукас (1997), Мефалопулос  (2003), Мелкоте (1993), Мелкоте болон  Муппиди (2002), Туфте болон Мефалопулос (2009), ван де Флиерт болон Хайн (2009).

**Хоёрдугаар долоо хоног: Коммунити болон мэдээлэл харилцааг ойлгох нь**

Лекцээр "Коммунити гэж хэн бэ" гэдэг асуултад хариулна. Үүнд: хэвлэл мэдээллийн хэрэгслийн цаад хязгаар, хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүлэг хүмүүст нөлөөлөх үүрэг роль. Хэвлэл мэдээл болон бүлэг хүмүүсийн харилцааны боловсролын хөгжил

болон хууль эрх зүйн талаар авч үзнэ. Тухайлбал, тухайн улсын соёл болон соёлын эрх зүйн асуудал хөндөгдөнө. Энэ нь коммунити болон хэвлэл мэдээллийн технологи ялангуяа хэвлэл мэдээлэлд тулгуурласан харилцаа, тэдний бие даасан байдал орно.

*Сургалт:* Оюутнууд тодорхой бүлэгт хуваагдан тухайн амьдарч байгаа орчин нөхцөлдөө хүйн ямар радио үйл ажиллагаа явуулж байгааг олж мэдэх шаардлагатай. Цаашлаад тэд хаана, ямар нөхцөлд хэрхэн үйл ажиллагаа явуулж байгааг судлан нийгэмд шаардлагатай асуудлыг тодорхойлно. Түүнчлэн тэдэнд ямар мэдээ материал байгаа талаар судлах хэрэгтэй. Оюутан болон суралцагчдын хувьд тэд олон нийттэй уулзаж, ярилцаж тэдний шаардлагатай, тулгамдсан асуудлын талаар ярилцлага авч яриа өрнүүлээд ангидаа товч илтгэл тавьж үйл ажиллагааг нь танилцуулах.

*Унших материал ба ном зүй*: Дагрон (2001), хуу. 217–22 (Хүйн Хэвлэл Мэдээллийн Сүлжээ, Кен улс), 259–64 (Чипас Хэвлэл Мэдээллийн Төсөл, Мексик), 271–6 (Грамийн Виллаж  Фоун, Бангладеш), 301–6 (Инфо Дес, Перу), 319–24 (Тосгоны Мэдлэгийн Төв, Энэтхэг). Мөн Андерсон (1991), Бартле (2010), Диксит (2010), Фуллер (2007), Хеншке (2002), Жаббар, (2005) Жаллов (2004), Кабилан (2009), Муппиди (2001), Пур (2003), Куебрал (2008), Рамираз (1990), Табин (2000), Таччи (2005), Ваттегама (2006).

## Гуравдугаар долоо хоног: **Алтернатив хэвлэл мэдээллийн зарчим болон туршлага**

Энэ хэсэг нь “Алтернатив хэвлэл мэдээлэл гэж юу вэ” гэдэг талаар судлах болно. Ялангуяа Азийн улс орнуудын бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээс юугаараа ялгагдах талаар мөн судлана.

*Сургалт:* Ангийн оюутнуудыг хэд хэдэн бүлэгт хуваана. Алфонсогийн Долгионыг Бий Болгох (2001) бүтээлийг судлан алтернатив хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн олон нийтэд хүрч байгаа талаар үзнэ. Жишээ нь Чөлөөт Хэвлэл Мэдээлэл, Чөлөөт Бодол (Кэйп Тоун хотын Хүйн ТВ) эдгээр видеог үзэж орон нутгийн нөхцөл байдлын талаарх асуудлын тухай ярилцана.

*Унших материал ба ном зүй:* Сеневиртне (2007), Бүлэг 3 (Индонез: Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн сонголт, 4 (Малайз: Интернет дээрх Хэвлэл Мэдээллийн Хэрэгсэл), 5 (Балба: Уурыг түүх) болон 6 (Филлипин: Чөлөөт орчинг дэмжих). Мөн Алберт (1997), Банержее (2008), Чандран (2006), Читти болон and Раттикалчалакорн (2007), Дин (2006), Найнг (2006), Сивараман (2006) болон Ян Юун Чеол (2004).

*Видео:* Чөлөөт Хэвлэл Мэдээлэл, (Чөлөөт Бодол, (Кэйп Тоун хотын Хүйн ТВ); Африкийн Хөдөө Орон Нутгийн Радио, Латин Америкийн Хүчтэй бүлэг бий болгох радио

*Азийн алтернатив вэб сайтуудаас үзээрэй: хуудас 000.*

## Дөрөвдүгээр долоо хоног: Хүйн радиогийн онцлог шинж чанар, эволюци, зарчмуудын танилцуулга

Энэ хэсэгт хүйн радиогийн хамгийн анхан шатны үйл ажиллагаанаас танилцуулна. Үүнд:

- Хүйн радиогийн хөгжлийн түвшний талаарх 3 төрлийн судалгаа
- Хүйн радиогийн тодорхойлолт
- Даяарчлал дахь хүйн радио
- Яагаад олон нийтийн радио биш хүйн радио гэж?
- Хүйн радиогийн эволюци
- Хүйн радиогийн онцлог шинж чанар
- Хүйн радиогийн үр ашиг
- Хүйн радиод тулгарах аюул, эрсдэлүүд

*Сургалт:* унших материал дээрх мэдээ мэдээллийг тухайн оюутан амьдарч байгаа орон нутгийнхаа хүйн радиотой харьцуулж дүгнэлт гаргана.

*Даалгаврыг дүгнэх (их, дээд сургуулийн хувьд):* Амьдарч байгаа орон нутаг болон бүс нутгаас хүйн радио редакциас судалгаа авч 2000-3000 үгтэй ЮНЕСКО,

AMARC болон Тамбули зэрэгтэй холбоотой эссэ бичиж дүгнүүлж ярилцана. Энэхүү даалгавар нь сургалтын 6 долоо хоногийг хамарна.

*Даалгавар (Хүйн радиогийн редакцийнханд):* Таван асуултаас хэтрэхгүйгээр хүйн радио, түүний орчин болон мэдээлэл харилцаа холбооны онол, зарчмын талаарх ойлголтыг тандах шалгалт авна.

*Унших материал ба ном зүй:* Фрэйзер ба Естрада (2001, бүлэг 1, 2) ба Табинг (2008, бүлэг 1, 3 ба 6). Бас Хавий-Картер (2009), Жаяавийра (2001), Жаяавийра ба Табинг (1997), Падхий, Прингл (2008), Сеневиранте (1993) ба Табинг (2008).

---

**Тавдугаар долоо хоног: Эхлэл: Хөтөлбөрийн бодлого, хууль эрх зүйн асуудал, ёс зүйн болон техникийн асуудлын код**

Хүйн радиог хэрхэн эхлүүлэх вэ? Дараах сэдвүүд лекц, сургалтын материалд багтана. Үүнд:

- Хүйн радиог үүсгэн байгуулах урьдчилсан нөхцөл юу вэ?
- Хүйн радио байгуулах бодлого болон үйл ажиллагаа
- Хүйн радио байгуулах үндсэн алхам, дараалал
- Тохиромжтой загвар
- Сургалт
- Сайн дурын ажилтан болон оролцогчдыг сонгох
- Редакцийн менежмент болон тогтвортой байдал

*Сургалт:* Ангийн оюутнуудыг 4 бүлэгт хуваана. Эхний нэг цагт 1-р групп бусад группийнхээ эсрэг мэтгэлцээн явуулна. Хоёр дахь хэсэгт 2 цаг 20 минут сургалтын шүүгч (багш)-тэй мэтгэлцэнэ.

- Мэтгэлцээн-1. Хүйн радио нь эдийн засгийн хувьд тогтворгүй
- Мэтгэлцээн-2. Хүйн радио нь олон нийтэд үзэл бодлын хувьд маргаан, мэтгэлцээн үүсгэнэ.

*Унших материал ба ном зүй:* Фрэйзер ба Естрада (2001, бүлэг 3, 4 ба 5), Рамакришнэн (2007, бүлэг 1–6) болон Табинг (2008, бүлэг 1 ба 2). Мөн Жанчифах (2011) ба Жаяавийра (2006).

## Зургадугаар долоо хоног: **Хүйн радиогийн загвар**

Энэ хэсэгт Ази, Африк, Латин Америк, Европын хүйн радиогийн загвараас танилцуулах болно.  Эдгээр загвараас:

- Хараат бус бие даасан хүйн радиогийн загвар
- Гуравдагч институцитэй хамтарсан хүйн радиогийн загвар
- Орон нутгийн засгийн газартай хамтарсан хүйн радиогийн загвар
- Шашны институцид хамаарах хүйн радиогийн загвар
- Төрийн бус байгууллагын явуулдаг хүйн радио
- Эвлэлийн-хүйн радиогийн загвар
- Үндэстэн ястаны хүйн загвар
- Арилжааны хүйн радиогийн загвар
- Олон нийтийн радио доторх загвар

Поверпойнт: “Хүйн радиогийн загварууд” (AMIC)

*Сургалт:* Доор дурьдсан радиогийн мэдээ нэвтрүүлгийг сонсоод ярилц:

- Тухайн орон нутгийн хүйн радиогийн эерэг болон сөрөг загваруудын талаар ярилц.
- Хүйн радиогийн зарим нэгэн суртал нэвтрүүлэг яагаад хүйн радиогийн стандартад нийцдэггүй вэ?

Оюутан бүр 2 минутаас ихгүй радио илтгэл тавихад бэлтгэн бичиж ангидаа тавьж хэлэлцүүл.

*Аудио:* Сеневиранте (2009) ‘Марагусиний DXLM Радио, Филиппин’ ярилцлага M. Мадхаван (1993).

*Унших  материал ба ном зүй:* Фрэйзер ба Эстрада (2001, бүлэг. 8), ба Табинг (2008, бүлэг. 3). Мөн Гош (2010), ИРИН (2008), Миглиоретто (2008), Сеневиранте (1989), Шанкар (2010), Дуу Хоолой  (n.d.).

## Долдугаар долоо хоног: **Хүйн радиогийн эдийн засгийн өрсөлдөх чадвар ба маркетинг**

Энэ хэсэгт хүйн радиогийн эдийн засгийн өрсөлдөх чадвар ба маркетингийн талаарх асуудлыг судлах бөгөөд голчлон Ази болон Африкийн орнуудын судалгааг хамруулна. Эдгээр судалгаанд тухайн улсын засгийн газар дэмжлэг үзүүлдэг эсэх талаар авч үзнэ. Судалгаанд Австрали, Өмнөд Африк, АНУ-ын хүйн радиогийн үйл ажиллагааг жишиг болгоно.

Сургалт: Ангийн оюутнуудыг 3 бүлэгт хуваагаад тухайн бүс нутаг дахь хүйн радиогийн санхүүжилтын загварын талаар хэлэлцэнэ. Дараах загваруудын нэгийг сонгож хэлэлцэнэ:

- Боловсролын байгууллагатай хамтран ажилладаг
- Төрийн бус байгууллагаас санхүүждэг
- Орон нутгийн захиргаатай хамтарсан
- Хүйн байгууллага эсвэл хамтралд суурилан бие даасан үйл ажиллагаа явуулдаг

*Унших материал ба ном зүй:* Арналдо (2008), ‘Маданпохара:, хуу. 36–54; Фрэйзер ба Естрада (2001), тусгай сургалт ‘Олутанга – ашигтай байрлал Тамбули Радио’ (ху. 76–9) ба Гана улсын Ада Радио(ху. 85–9); Табинг (2005, бүлэг.5, ‘Санхүүгийн менежмент’, хуу. 33–4). Мөн ABC Улзави (2004), CBF (2002), Корпорал (2008), Сеневиранте (2009), Субба ба Майнали (2008). CBF-ийн вэб сайтаас үз: (www.cbf.com.au) ба Хэвлэл Мэдээллийг Хөгжүүлэх агентлаг, Өмнөд Африк вебсайт (www.mdda.org.za).

## Наймдугаар долоо хоног: **Оролцоонд суурилсан хөтөлбөрийн загварууд, хөршийн програмууд болон хамтарсан хөтөлбөрүүд**

Энэ хэсэгт “Хүний төлөө хүн радио” хөтөлбөрийг бий болгоход хүйн радиод зориулсан хөтөлбөрийн загварыг боловсруулахдаа оролцооны мэдээлэл харилцааг хэрхэн хөгжүүлэх талаар судална. Сэдэвт: залуучууд, эмэгтэйчүүд, ажилчид болон бусад сонирхолын бүлгийг хамруулсан багц хөтөлбөрүүд байна. Түүнчлэн иргэдийг оролцуулсан ярилцлагын хөтөлбөрүүд хийх, олон нийтийн үйл явдлаас сурвалжлах, радиогоор дамжуулан орон нутгийн урлагийн үзэл санааг дэмжих зэрэг багтана.

Суралцагчдын хувьд Филиппин, Энэтхэг, Соломоны арлууд, Болив, Дани болон Шри Ланка улсуудыг судалгаанд хамруулна.

*Давтлага болон даалгаврыг дүгнэх:* Ангийн оюутнуудыг 3 бүлэгт хуваагаад тухайн орон нутгийн хүнй радиогийн оршин суугчдад хандсан хөтөлбөр байгаа эсэхийг тодруулах. Уг төсөл хөтөлбөр нь даалгаврыг дүгнэх болон оюутнууд дараагийн семестрийн сургалт болон лекцэд хамаарна.

*Унших материал ба ном зүй:* Бэнержий (2008), Бреснэхэн (2007), Эбрахим (2009a, 2009b), Изабел Сургалтын Сүлжээ (n.d.), Жираттикорн (2006), Роллс (2012), Сеневиранте (2012), Сингх (2010), Тибаян (1998).

**Есдүгээр долоо хоног: Мэдээ болон сүүлийн үеийн мэдээллийг хүйн радиод зориулж бичих:**

Энэ хэсэгт хүйн радиогоор мэдээ болон сүүлийн үеийн үйл явдлыг нэвтрүүлэхдээ баримтлах зарчим, бичлэгийн хэв загварын тухай авч үзнэ. Гол мэдээллийн хэрэгслүүдээс хэрхэн ялгарах вэ? Оюутнууд интернэт, орон нутгийн иргэд, үндэсний болон бусад эх үүсвэрүүдээс мэдээний боломжит алтернатив эх сурвалж болон бусад мэдээллийг интернэт, нутгийн ард иргэд болон бусад эх сурвалжийг хайна. Тэд ямар нэгэн аюул гамшгийн талаарх мэдээллийг дамжуулахад хүйн радио ямар үүрэгтэй болох талаар ярилцана. Мөн сэтгүүлчид тухайн гамшиг, хямралын талаар улс төр болон эдийн засгийн мэдээ, мэдээллийг дамжуулахад ямар чухал үүрэгтэй талаар суралцах болно.

*Багшид өгөх санал: Багш нар боломжтой бол тухайн болсон үйл явдлын талаарх мэдээллийг хурааж аваад ураги хойш нь гүйлгээд оюутнууддаа сонсгох, бүр олдохгүй бол тухайн орон нутгийн радиогийн редакци дээр очиж тухайн үйл явдлын видео болон аудио бичлэгийг авч оюутнууддаа үзүүлэх.*

*Дасгал:* Оюутнуудаа хоёр бүлэгт хуваа. Групп бүр нийт 15 минутыг текст мэдээнд, 3 минутыг улс үндэстний болон олон улсын аудио болон видео мэдээнд, 12 минутыг тухайн орон нутгийн олон нийтийн мэдээ, бизнес, улс төр, гэмт хэрэг, тээвэр, эрүүл мэнд зэрэг салбарын мэдээ бэлтгэхэд зарцуулна. Тухайн бичигдсэн дүрс болон аудио мэдээг ангийн оюутнуудад урьдчилан сонсгосон байна.

*Даалгаврыг дүгнэх:* Ангийн оюутнуудыг 3 групп болгон хуваана. Групп бүр орон нутгийн үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийн талаар 15 минутын бичлэг хийнэ. Тухайн бичлэгийг дараагийн долоо хоногт бусдад сургалт байдлаар ангид үзүүлж багшаар дүгнүүлнэ.

## Аравдугаар долоо хоног: Хүйн радио ба Мянганы Хөгжлийн Зорилтууд (MDGs)

Идэвхгүй сонсогчдыг агуулгын идэвхтэй бүтээгчид болгож, анхан шатны нэгжид байгаа хүмүүсийн дуу хоолойг дэмждэг өргөн боломж, хүчин чадал бүхий ашиглахад хялбар радио бол хүйн радио юм. Энэ хэсэгт хүйн радиогоор дамжуулан “Мянганы Хөгжлийн Зорилтууд”-ыг түгээн сурталчлахдаа мэдээлэл харилцааны стратегийн хөгжил болон оролцоог хэрхэн ашиглах тухай үзнэ. Мянганы Хөгжлийн Зорилтуудыг түгээн таниулах зорилго бүхий радио нэвтрүүлгийг бэлтгэхдээ орон нутгийн иргэд, албаны хүмүүс, хөгжлийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах тухай хүйн радиогийн загваруудыг хэлэлцэнэ. Хүйн радио нь орон нутгийн оршин суугчдын амьдралын хөгжил цэцэглэлтэд нөлөөлөөд зогсохгүй нийгмийн анхан шатны түвшинд сайн засаглал, ардчилсан оролцоог дэмжин дэлгэрүүлэхэд хоточ нохойн үүрэг гүйцэтгэдэг.

Дасгал:

- Мэдээ бэлтгэж ангид ярилцах
- Мянганы Хөгжлийн Зорилтуудын асуудлаар орон нутгийн радиод ямар хөтөлбөр байгааг ярилцах.

*Даалгаврыг дүгнэх:* Оюутнууд хоёр бүлэгт хуваагдаж Мянганы Хөгжлийн Зорилтуудын асуудлаар радиотой холбогдож  онцлог, шинж чанар, үйл ажиллагааны талаар 10 минутын турш ярилцана. Үүнд: орон нутгийн оршин суугчдын дуу хоолойг хүргэх шаардлагатай. Мөн засгийн газрын төрийн албан хаагчид, орон нутгийн албан тушаалтнууд болон судлаачид хамрагдах ёстой. Тухайн нийтлэл болон нэвтрүүлэг нь орон нутгийн оршин суугч, хэвлэл мэдээлэл, засгийн газар гэсэн гурван салбарыг хамруулна. Энд бичигдсэн хөтөлбөр болон бичлэгийг багш дүгнэнэ.

*Унших материал ба ном зүй:* АМАРК ВИН (2008), Ферия et al. (2006), Жевера (2007), Филппины Мэдээллийн Агентлаг  (2010), Шах ба Кокже (2009); Сан Стар (2011), ВИНЕТ (2008).

## Арваннэгдүгээр бүлэг: Агаарын сургалт

Хүйн радио нь амьжиргааны түвшин доогуур болон хот суурингаас алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд мэдээлэл болон албан бус боловсрол олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхий дээр нэлээд олон хүйн радио албан бус боловсрол болон мэдээлэл өгөх үйл ажиллагаагаараа хэдийнэ хүлээн зөвшөөрөгдсөн. Тэдгээрийн олонх нь 'School on the air' буюу агаарын сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлж сонсогчдод тодорхой хэмжээний мэдээлэл болон боловсрол олгодог. Энэ сургалтаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн албан бус агаарын сургалтын загварын талаар заах болно. Албан ёсны болон албан бус сургалтын ялгаа юу вэ? Орон нутгийн радио болон сонсогчдын хувьд тэрхүү зааг ялгаа юу байх вэ?

*Дасгал:* Албан болон албан бус сургалт, түүний мөн чанарын талаар ангид ярилцах.

*Унших материал ба ном зүй:* Хан (1004), Либреро (2009), Шарма (2002), Виас et al. (2002). Вебсайт: Австралийн Засгийн Газрын Агаарын Сургууль.

## Арванхоёрдугаар долоо хоног: Интернэт, шинэ мэдээллийн хэрэгсэл болон хүйн радио

Энэ хэсэгт интернэт болон бусад "шинэ мэдээллийн хэрэгсэл"-ийн технологи хүйн радиогийн мэдээллийн эх сурвалж болон түгээлтэд хэрхэн нөлөөлж, үйл ажиллагааг нь яаж баяжуулж байгаа талаар үзэх болно. 'Radio browsing the internet' буюу Радио хөтөчийг анх олонд таниулсан Шри Ланка улсын Котмэйл радиогийн төсөл болон түүнтэй ижил төстэй бусад төслүүдтэй танилцана. Түүнчлэн бүс нутгийн болон олон улсын интернэт болон утсанд суурилсан технологиор дамжуулан радио нэвтрүүлэг цацах технологи болох soundcloud, Hindenburg зэрэг харилцаа холбооны шинэ програм хангамжийн технологиос суралцана.

*Багшид өгөх санал: Энэ хэсэгт орчин үеийн мэдээллийн технологи, видео, олон нийтийн радиод зориулсан ICT буюу мэдээлэл, харилцаа холбооны технологийн PowerPoint илтгэлийн талаар танилцуулах хэрэгтэй.*

*Дасгал:* Оюутнууд гурван бүлэгт хуваагдаж “Интернэт радио хөтөч” гэсэн 30 минутын дасгал ажиллаж илтгэл тавина. Энэ нь дүгнэгдэхгүй болно.

*Унших материал ба ном зүй:* Арналдо (2008), ‘Котмэйл: Интернэт радио хөтөч’, ху. 24–30. Түүнчлэн Оп дэ Каул (2003), Милосевик (n.d.a) Милосевик (n.d.b), ЮНЕСКО (2004, 2005).

## Арван гуравдугаар долоо хоног: Хүйн радио болон гамшгийн тусламж

Хүйн радио нь аливаа гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл болон тусламж үзүүлэхэд мэдээллийн хувьд онцгой үүрэгтэй. Жишээ нь, Индонези болон Тайландад 2004 онд болсон Цунамигийн үеэр хүйн радио оновчтой зохион байгуулалтад орж үүргээ сайн биелүүлсэн. Одоогоор ихэнх улсад хүйн радио нь байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөтэй болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнийг даван туулахад мэдээллийн үүрэг гүйцэтгэж, ажилчид нь ч гэсэн энэ чиглэлээр ажиллаж байна. Хүйн радио нь гамшгийн өмнө урьдчилан сэргийлэх, гамшгийн үеэр болон дараа нь олон нийтэд мэдээлэл хүргэх чиглэлээр ажилладаг.

*Дасгал:* Багш 30 минутын хугацаатай сэтгүүлийн хөтөлбөр бэлтгэж, курсийн төгсгөлийн төслийг танилцуулна. Тухайн сэтгүүлийн хөтөлбөр хэвлэмэл болон аудио, видео зэрэг өөр өөр форматтай байж болно. Оюутнууд 3 бүлэгт хуваагдаж тухайн хөтөлбөр дээр ажиллана. Тэд хичээл дуусахаас өмнө тухайн сэдвийн дагуу ажлын төлөвлөгөө гаргаж батлуулна. Тэрхүү төлөвлөгөөндөө багийн гишүүн бүр ямар үүрэгтэй талаар тодорхой тусгаж өгнө. Багш тухайн бүлгийн төлөвлөгөөг батласны дараа тэд ажлын байран дээрээ очиж ажиллана.

*Унших материал ба ном зүй:* Пютра ба Пахлеми (2006), Вин (2009).

## Арван дөрөвдүгээр долоо хоног: **Хүйн радиогийн удирдлага, үнэлгээ болон дүгнэлт**

Энэ хэсэгт хүйн радиогийн удирдлага зохион байгуулалт,  үнэлгээ хийх үйл явцууд болон хүйн радиогийн амжилт, алдаа оноог хэрхэн үнэлж дүгнэх тухай авч үзнэ.

*Поверпойнт:* Хүйн радиогийн редакцийн менежмент – бэлтгэсэн Луий Табинг, Флилиппины Тамбули Хүйн Радио.

*Сургалт:* Долоо хоногийн сургалт гэж байхгүй, оюутнууд ажлын байран дээр эсвэл ангидаа аудио болон видео бичлэг хийх, тухайн хийсэн бүтээлээ эвлүүлж засварлах, багцлах болно. Энэ хөтөлбөр нь дараагийн сургалтаар хэрэгжинэ.

*Унших материал ба ном зүй:* Бюлло (2008), Мэйнэли эт ал. (2009), Холландер эт ал. (2008).

## Арван тавдугаар долоо хоног: **Хүйн радио ба идэвхтэй байдал**

Хүйн радио нь идэвхтэн гишүүд болон дэмжигчидтэйгийн хувьд засгийн газартаа дуу хоолойгоо хүргэх томоохон хэрэгсэл болдог тухай энэ хэсэгт үзнэ. Фижи болон Өмнөд Африкийн идэвхтнүүдийн тэмцлийн загвараас харж болно. Гэхдээ Филиппин болон Мексик улсад радиогоор эсэргүүцлээ илэрхийлж байсан тэмцэгч, эсэргүүцэгч, идэвхтнүүд бусдын гарт амиа алдсаныг бас дурьдах хэрэгтэй.

*Сургалтын холбоосууд:*
Фижи: фемЛИНКпасифик: www.femlinkpacific.org.fj/index.cfm?si=main.gen&cmd=communityradioactivism
Өмнөд Африк: Хүйн радиогийн идэвхтнүүдийг 16 өдөр дэмжсэн: www.bizcommunity.com/Article/196/59/86394.html

*Сургалт:* Дээр дурьдсан жишээнүүдээс нэгийг сонгож судал. Оюутнууд дараагийн долоо хоногт хийсэн бүтээлээ CD болон MP3 форматаар хуулаад дүгнүүлнэ.

# Бүлгийн унших материал болон ном зүй:


ABC Улвази. 2004. Хүйн Радиогийн секторыг тогтвортой болгох Сөүл Бийт Өмнөд Африк, South Africa. www.comminit.com/en/node/116295/376

Алберт, Майкл. 1997. Юу радиог алтернатив болгодог вэ? http://subsol.c3.hu/subsol_2/contributors3/alberttext.html

Аммунугама, Сара ба Жаявийра, Невилл. 1987. Дахин Бодох Хөгжлийн Харилцаа. Сингапур: AMIC.

Арналдо Карлос, (ed.). 2008. Азийн Хүйн Радио: Хүнийг хариуцлагата болгох. Манила: Тамбули Санi.

Андерсон, Бенедикт. 1991. Дүрсэлсэн Хүйн Радио: Национализмийн гарал үүсэл, тархалт. Лондон /Нью Йорк: Версо.

Арналдо, Карлос Carlos (ed.). 2008. Манила:Тамбули Сан.

Аскроыт, Жжозеф, Садандан Нэйр, К. ба Вйат, Ширлей А. 2008. Оролцооны Харилцаа Холбоо Харилцаа: Working for Өөрчлөлт ба Хөгжил Лондон. London: Сэйж.

Азийг тольдох нь. 2010. Пакистан: Орон нутгийн Хэвлэл мэдээллийн Сан Радио стратеги нэг сарын 27. Жакарта: Азийг тольдох нь.

Банерже,Чандаана. 2008a. Секс ажилчдын өгүүлэл, 10 Срын 26. Энэтхэг: Хүүт. www.thehoot.org/ web/home/story.php?storyid=3397&pg=1&mod=1&section Id=3&sectionname=COMMUNITY MEDIA&valid=true

Банержее, Чандана. 2008b. Агаарын Долгионы найдвар, 8 сарын 10, Энэтхэг: Хүүт.

Бартле, Фил. 2010. Хүйн гэж юу вэ? Социологийн хэтийн төлөв. АНУ: Коммунити нэгдлийг хүчирхэгжүүлэх нь www.scn.org/cmp/whatcom.htm

Бирово, Марио Mario Антониус. 2007. Индонезийн Хүйн Радиогийн Хөдөлгөөн: Коминитас Ёогикарта Жаринган Радиогийн кейс (Ёогикарта Хүйн Радиогийн Сүлжээ). http://mediaasiaconference. humanities.curtin.edu.au/pdf/Mario%20Antonius%20Birowo.pdf

Бонин, Мэри-Хелене ба Опоку-Менса, Эйда. 1998. Хүйн радио гэж юу вэ? А Нөөцийн гарын авлага, Southern Өмнөд Африк. AMAPK Африк/Панос.

Бүүнэ, M. 2007. Зүүн- чиглэл радиогийн идэвхтнүүд шуурхай мэдээг сорьсон нь, 10 сарын 19. Газетте (Монтрийл , Канад). www.canada.com/montrealgazette/ news/story.html?id=44ebeb44-c7da-4132-8cc4-2b800e0af727

Бреснахан, Росалинд. 2007. Боливийн хүйн радио: Уурхайчдын радиогийн редакц (үзүүлэн ). Америк хувилбар. 63, No. 4, pp. 672–3. http://muse.jhu.edu/ Булло, Порферио Г. 2008. Орон нутгийн радиогийн of DYMT хүйн радиогийн давамгайлал үнэлгээ. Филиппин: Акланы улсын Их сургууль.

Читти, Нарен ба Раттиалчалакорн , Срипан. 2007. Алтернатив Хэвлэл мэдээллийн Хэрэгсэл: Идиализм ба Прагнатикм. Малайз: Соутбонд.

Корпорал, Линетте. 2008. Хүйн радиогийн оролцоо,  1 сарын 11 . Банкок:ИПС.

Чандран, Премеш. 2006.  Малайсиакин: Улс болон зах зээл дээр хөлөө олох. Азийн хэвлэл мэдээллийн тайлан, хуу. 49–54. (Банкок: ИПС).

Драгон. Алфонсо Г. 2001. Долгион бий болгох: Нийгмийн өөрчлөлтийн харилцаа холбоо өгүүлэл. Нью-Йорк: Рокефеллер с ан.

Деане, Жамес. 2006. Балбад ардчиллыг бий болгоход хүйн радиогийн үүрэг роль юу байв? Рагху Майналийн ярилцлага, АМАРК-ВССД. www.amarc.org/ wccd/?p=wccd_Interview

Диксит Кунда. 2010. Мэссэжинд байгаа хэвлэл мэдээлэл: ардчиллыг хамгаалж, баталгаажуулж хөгжүүлэх. Азийн хэвлэл мэдээлэл, Хэсэг. 37, №.1, хуу. 10–12 (Сингапур: AMIC).

Эбрахим, З. 2009a. Хайбер радиод ажиллах нь, 9 сарын 25. Энэтхэг: Хүүт.

Эбрахим, З. 2009b. Пакистан эмэгтэйчүүдийн дуу хоолой агаарт,  9 сар. Пакистан: Эмэгтэйчүүдийн үйлчилгээний асуудал  хөндсөн.

Эллиот, Даун Моргон. 2011. Радиогийн идэвхтэн Ханна Сасаманы ярилцлага. АНУ: Радио: WMNF. www.wmnf.org/news_stories/international-womens-day-inter view-with-radio-activist-hannah- sassaman

Ферия, Моника, Манар, Малу Ц ба Лим, Мирна Б. 2006. Женпеасе: Алслагдсан бүс нутагт байгаа охид эмэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдсан байдал. Жакарта: ЮНЕСКО.

Фижи Таймс. 2011. Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн идэвх, хөдөлгөөн, 2 сарын 16. www. peacewomen.org/news_article. php?id=3085&type=news

Фрасер, Колин ба Эстрада, Сония  Р. 2001. Хүйн радиогийн гарын авлага. Парис: ЮНЕСКО.

Фуллер, Линда К. 2007. Хүйн мэдээллийн хэрэгсэл– Олон улсын өнцөгөөс. Нью-Йорк: Палгрэйв Макмиллан.

Гевера, Май. 2007. Комвал хотын Хүйн радио, 4 сарын 12. Филиппин: Давоа өнөөдөр. http:// davaotoday.com/2007/04/12/philippines-community-radio-empow ers-comval-town/

Жирард, Брүис. 1992. Радиогийн таашаал. Канад: Хар Сарнай ном.

Гош, Сома. 2010. СМС хүйн радиогийн PowerPoint илтгэл  @ 90.4 МГц. Лукнов, Энэтхэг: СМС.

Хамелинк, Сийс Ж ба Мехра, Ачал. 1990. Азийн Хүний эрх ба Харилцаа Холбооны Хөгжил. Сингапур: AMIC.

Хавеи-Картер, Лиз. 2009. Котмале Хүйн Радиогийн Интеоорг төсөл: Хүйн радиогийн тархи угаалт? Олон улсын судалгаа ба зайн сургалт., Хэсэг. 10, №.1. www. irrodl.org/ index.php/irrodl/article/viewArticle/555/1160

Хенске, Ребека. 2002. Хүмүүсийн хүч. Индонезд (Австрали), Асуудал 72.

Хинду. 2010. Хүйн радио активизмийг хүчттэй болгож чадна, 2 сарын 23. Хинду. www.hindu. com/2010/02/23/stories/2010022355630900.htm

Холландер, Эд, Хидаут, Дэди Нур ба Хаененс, Лийн. 2008. Индонезийн хүйн радио: a re-in

vention of democratic communication. Javnost – The Public, Хэсэг. 15, №.3, хуу. 59–74. www.javnost-thepublic. org/article/2008/3/4/

ИРИН. 2008. Лаос: Анхны хүйн радиогийн редакцийн хөгжил, 8 сарын 11. www.irinnews.org/ Report. aspx?ReportId=79748

Изабел Сүлжээний Сургалт. Соломон арлын хүйн радио. http://communitymediasolomons. wordpress.com/isabel-learning-network/

Жаллов, Биргитте. 2004. Хүйн радиогийн эрх мэдэл ба нөлөө. Харилцаа Холбооны Хөгжлийн Сэтгүүл, Хэсэг. 15, №. 2, хуу. 56–68.

Супара 2011. Хүйн радио аврал хүлээсээр, 1 сарын 23. Бангкок Шуудан.

Жавед, Жаббар. 2005. Иргэдийн Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн Хэлэлцүүлэг. Пакистан: Роял Бүүк Компани.

Жаяавийра, В. (2001). Котмале хүйн радио интернэт төслийн тайлан: Мэдлэгийн сангаа өргөжүүлсэн нь. http://go.worldbank.org/ 2BP49DV4B0

Жаяавийра Вижаяанада. 2006. Радио дамжуулалт: Азийн Радиогийн гол агуулгатай танилцах. 2006, Сингапур.

Жаяавийра, В. Ба Табинг, Л. 1997. Тосгоны дуу хоолой: Филиппины орон нутгийн радио эрх мэдлийг авах. ЮНЕСКО, 2 сар, хуу. 34–5.

Жиратикорн, Ампорн. 2006. Агаарын долгионыг ашигласан нь, 2 сарын 9. Банкок Шуудан.

Кабилан, К. 2009. Шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэдийн сэтгүүл зүй ба ардчилал: Малаясиакини Төсөл. Азийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл. Хэсэг. 36, №. 3, хуу. 156–8.

Хан, Шафуллах. 1994. Пакистаны Пешаварын фермерүүдийн дамжуулах хөтөлбөр. Какийла Пешавар радио: Шүүмжлэлтэй дүгнэлт хийж энэ нь фермд нөлөөлсөн нь. PhD, Синд Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, http://eprints.hec. gov.pk/103/

Кумар, Маниш. 2001. Хөдөө орон нутгийн харилцаа холбооны хөгжлийн мэссэж. Азийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Хэсэг. 28, №. 1.

Лукас, Францис. 1997. Хөдөө орон нутгийн фермийн аж ахуй эрхэлдэг хүмүүст зориулсан радио дамжуулалт: Филиппины зайн сургалт. Эмэгтэйчүүдтэй ажиллах зайн сургалтын боловсролын зөвлөгөө: НҮБ-ын Хоол хүнс болон Хөдөө аж ахуйн байгууллага сургалтын хөтөлбөрийг ивээн тэтгэсэн, Банкок, 3 сарын 25-28. www.fao. org/docrep/005/ac789e/ac789e00.HTM

Майнали, Рагу. 2008. Хүйн радио: Оролцоо ба Чадамж. Катманду: Хүйн Радиогийн дэмжлэгийн төв/ Балбын Экологийн Сэтгүүлчдийн форум.

Майнали, Рагу, Субба, Бикрам ба Чапагайн, Ядав. 2009a. Хүйн Радио: Хөгжлийн Гарын Авлага. Катманду: Хүйн Радиогийн дэмжлэгийн төв/ Балбын Экологийн Сэтгүүлчдийн форум.

Майнали, Рагу, Субба, Бикрам ба Чапагайн, Ядав. 2009b. Хүйн Радио: Үнэлгээний гүйцэтгэлийн систем. Катманду: Хүйн Радиогийн дэмжлэгийн төв/ Балбын Экологийн Сэтгүүлчдийн форум.

Мефалопулос, Паоло. 2003. Оролцогчдын харилцаа холбооны дадлагын онол. the case ФАО төсөл ‘Өмнөд Африкийн хөгжлийн харилцаа, холбоо‘. Вашингтон ДС: Дэлхийн банк. www.comminit. com/en/node/72266/38

Мелкоте, Сринивас Р.  1993. Гуравдагч ертөнцийн хөгжлийн харилцаа, холбоо: Онол ба дадлага. Канадын харилцаа, холбооны сэтгүүл, Хэсэг. 18, №. 1.

Мелкоте, С. Р ба Муппиди, С.Р. 2002. Анхдагч болон гуравдагч орнуудын хөгжлийн харилцаа холбооны агуулга нь өөрчлөгдөж байгаа. К. Махадеван, Киран Прасад, Ёойчи Ито ба Вижаяан Пиллай. Харилцаа Холбоо, Орчин үеийн ба Нийгмийн Хөгжил. Шинэ Дэли: Стерлинг.

Миглиоретто, Бианка. 2008. Лаосын Хүйн Радио: Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг бий болгох, 7 сарын 16. Манила. ИСИС. www.Isiswomen.org/

Милосевик, Бранислава. 2013. Мультимедиа сургалтын багц: Радио хөтөчийн гарын авлага. Нэг Дэлхий Радио. http://www. google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&frm=1& source=web&cd=4&ved=0CEEQFjAD&url=http%3 A%2F%2Fwww.itrainonline. org%2Fitrainonline%2Fmmtk%2Fmmtk_radio_browsing_handout.doc& ei=ZI6jUe HGJ7D04QTGjYCoAw&usg=AFQjCNGYH01I1iKcQYc9Z13eztEt0JxM MA&sig2=ICDdR3ElmAbElHJMgc_t7Q

С.Р. 2001. Хүмүүсийн Хөгжлийн Байгууллагыг ашиглах:  Эмэгтэйчүүдийн үүрэг роль ‘сангхамс’. Энэтхэг Захийрабад, С. Мелкоте ба С.Рао, Харилцаа холбоон дахь шүүмжлэлтэй асуудлууд: Дотоод асуудлуудыг хайж олох (K. E. Эапений Эссэ ). Шинэ Дэли: Сэги.

Маерс, Мэри. 2011. Тосгодын дуу хоолой: Хөгжиж байгаа орнуудын Хүйн Радио. Вашингтон ДС: Олон Улсын Хэвлэл Мэдээллийн Зөвлөгөөний Төв.

Нэйнг, Роналд Аюнг. 2006. Бирмийн хэвлэл мэдээллийн цөллөг: Хаалттай эрх чөлөө. Азийн Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн Тайлан, хуу. 24–6. Банкок: ИПС.

Оп дэ Коул, Мээртжэ. 2003. Шри Ланкийн Котмале Хүйн Радио- Сургалтын Тайлангийн Товч 11 сар. Тоон Сувгийн боломж. http://archive.digitalopportunity.org/article/view/72470

Падхей, Винод. Хүйн Радио: Радио шинээр төрөх.  www.caluniv.ac.in/Global%20mdia%20 journal/ Article-june2010/v%20pandey%20-g%20b.pdf (undated article)

Паварала, Винод ба Малик, Канчан. 2007. Бусад дуу хоолой: Энэтхэгийн  Хүйн Радиогийн Тэмцэл. Энэтхэг: Сэги.

Филиппин Мэдээллийн Агентлаг. 2010. Хүйн радиогийн компанит ажил, нийтлэгдсэн, 11 сарын 17.

Прингл, Ян. 2008. Анхдагч Хүйн Радио: Балбын ИПДС-ийн тусламжийн нөлөө. ЮНЕСКО-ИПДС.

Пур, Крипа Анант. 2003. Улс төрийн харилцаа холбооны оролцоо: Карнатака радиогоор дамжин Орон нутгийн засаглал ба Хөдөө орон нутгийн иргэдтэй холбогдсон. K. Прасад, Улс төрийн Харилцаа холбоо: Энэтхэгийн туршлага, хуу. 233–68. Дэли: Б Р Хэвлэх үйлдвэр.

Путра, Маккурага Афдал ба Рахмели, Венни. 2006. Индонез: Радио бол туслах агентлаг, К.Сеневиратне, Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүндрэл бэрхшээл: Азийн Цунами ба түүнийг давсан нь, хуу. 89–103. Сингапур: AMIC.

Кюбрал, Нора. 2008. Азийн утасгүй интернэт М4Д. Филиппиний Хөгжлийн харилцаа холбооны сэтгүүл,  Хэсэг. 1, №. 1. Рамакришнан, Н. 2007. СР: Технологийн Хэрэглэгчийн гарын авлага.   Парис: ЮНЕСКО.

Рамирез, Мина. 1990. Граунд-Аптай харилцах. Манила: Азийн Нийгмийн Институт.

Роллс, Шарон Багаван. 2012. Фиж: Костюмтэй радиогийн аялал. К. Сеневиратне, Хүмүүсийн Дуу хоолой, Хүмүүсийн эрх мэдэл: Азийн Хүйн радио ба түүний цаана, Сингапур: AMIC, хуу. 260–5.

Сеневиратне, Калинга. 1989. Олон нийтийн радиогийн дуу хоолой сонсогчдийн төлөө дуугарч байна, 4 сарын 24. Сидней Өглөөний Мэдээлэгч.

Сеневиратне, Калинга. 1993. Дуу хоолой гаргахгүй байгаа хүмүүсийн дуу хоолой болох: Австралийн Хүйн Радио. Азийн Хэвлэл Мэдээллийн Хэрэгсэл, Хэсэг. 20,№. 2.

Сеневиратне, Калинга. 2007. Азийн Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн Олон үзэл санаа: Алтернатив Мэдээллийн Хэрэгслийн үүрэг роль, нөлөө. Сингапур: AMIC. Сеневиратне, Калинга. 2009a. Филиппин Марагусаны ДХЛМ Радиогийн нийтлэл. ‘Азийн дуу хоолой’ дамжуулж байна. Сеневиратне, Калинга. 10 сар. AMIC.

Сеневиратне, Калинга. 2009b. Урам зоригийг хадгалах: Филиппиний Хүйн Радиогийн Эдийн засгийн өрсөлдөх чадварын үнэлгээ. Жакарта: ЮНЕСКО-AMIC.

Сеневиратне, Калинга. 2010. Азийн сүүдрээс Хүйн Радио ил гарч ирж байна. АзиаВиев, 4-5 сар, хуу. 18–19.

Сеневиратне, Калинга (ed.). 2012. Хүмүүсийн дуу хоолой, Хүмүүсийн эрх мэдэл: Азийн Хүйн Радио ба түүний цаана. Сингапур: AMIC

Жон, Жакобсон, Томас Л. ба Вайт, Ширлей. 1996. Нийгмийн Өөрчлөлтийн Оролцооны Харилцаа Холбоо.

Шах, Фатима ба Кокже, Милинд. 2009. MDG-г ойлгох нь : Мянганы Хөгжлийн Зорилтуудыг ойлгох энгийн гарын авлага. Сингапур: AMIC-ЮНЕСКО.

Шанхар, Малини. 2010. Хүйн Радио сул орон зайгаа хумиж чадлаа, 2 March., Бангелор, Энэтхэг: IPS. http://ipsnews.net/news.asp?idnews=50530

Шарма, P.C. 2002. Гиан Вани: Энэтхэгийн боловсролын FM радионы сүлжээ. Ажлын байрны тэмдэглэл, Хэсэг. 2, N. 2, Азийн Мэдээ. www.irrodl.org/content/v2.2/feld.html

Сингх, Анжали. 2010. Уттар Прадешийн Радиогийн Эмэгтэй хөтлөгчид шинэ эринд, 12 сарын 15. Энэтхэг: Хүүт.

Сивараман, Сатя. 2006. БНСУ: Ханкиорех, Иргэний Сонин. Азийн Хэвлэл Мэдээллийн Тайлан, хуу. 40–3. Банкок: IPS.

Субба, Бикрам, Чапагэин, Ядав and Майнали, Рагу. 2008. Хүйн Радио: Цуглуулсан Маркетингийн Стратеги. Катману: Хүйн Радиог Дэмжих Төв /Хүрээлэн буй орчны сэтгүүлчдийн Балба Форум. www.amarc.org/documents/manuals/CR_Collective_Marketing_Strategy1.pdf

Субба, Б. ба Майнали, Р. 2008. Хүйн Радио: Стратеги Төлөвлөгөөний Гарын авлага. Балба: Хүйн Радиог Дэмжих Төв. www.amarc.org/documents/manuals/CR_Strategic_Planning_Manual.pdf

Сан Стар. 2011. Хүйн Радиогийн редакци Н.Самарт суулгасан нь, 1 сарын 27. Сан Стар, Таклобан, Филиппин.

Табинг, Луи. 2000. Зүүн Өмнөд Азийн Хүйн Радиогийн хөгжил. С.Т. Кваме Боаыо, Африкт Хүйн Радиог хөгжүүлэх. Парис: ЮНЕСКО. www.unesco.org/webworld/publications/community_media/pdf/chap5.pdf.

Табинг, Л. 2005. Хүйн Радиог хэрхэн хөгжүүлэх вэ?. Шинэ Дели: ЮНЕСКО.

Табинг, Луи. 2008. Хүйн Радио болон Хүмүүсийн эрх мэдэл. Индражит Банерже ба Стефен Логан, Азийн Хүйн Радио Гарын авлага. Сингапур: AMIC, хуу. 93.Таччи, Жо. 2005. Хүйн Радио Төвөөр дамжуулан Өмнөд Азийн ардчиллыг дэмжих, 2 сар. Австраль:3Смедиа.

Тибаяан, Гемаррие, Б. 1998. Хүйн Радиогоор дамжуулан Хөдөө, алслагдсан орон нутагт хүмүүс эрх мэдэлтэй болох, Шалом, Дугаар 3, Израйль.

Туфл, Томас ба Мефалопулос, Паоло. 2009. Оролцооны Хүйн Радио: Дадлагын гарын авлага. Вашингтон ДС: Дэлхийн Банк.

ЮНЕСКО. 2003. Хүйн Радио дамжуулалтыг зохицуулах хууль: 15-р Зохицуулалтын Харьцуулсан судалгаа. Улсууд. Парис: ЮНЕСКО-гийн Үзэл Бодлоо Илэрхийлэх эрх чөлөө, Ардчилал Энх Тайвны салбар.

ЮНЕСКО. 2004. Хүйн Мультмедиа Төвийн Гарын авлага: Яаж эхэлж цаашид тогтмол ажиллах вэ? Парис:  ЮНЕСКО. www.unesco.org/new/en/communication-and-informa tion/resources/publications-and- communication-materials/publications/full-list/how-to-get-started-and-keep-going-a-guide-to- community-multimedia-centres/

ЮНЕСКО. 2005. Дэлхийн Хүйн Мультмедиа Төвүүд: Глобал лавлах, 11 сар. Парис: ЮНЕСКО.

Ван де Флиерт, Элске ба Хиен, Дү Ти Минх. 2009. Харилцаа Холбооны хөгжил: байнд ороогүйг олж онилох, Хэвлэл Мэдээллийн Хөгжил 2009/1, Лондон: WACC.

Энэтхэгийн Хүйн Радио, алхам алхамаар: Хүйн Радиогийн нөөц чадавх. Шинэ Дели: НҮБХХ.

Вьяас, Р.В, Шарма,  Р.С Кумар, А. 2002. Энэтхэгийн Боловсролын радио. Туркийн Онлайн Сэтгүүл Боловсрол, Хэсэг. 3, Номер. 3. http://tojde.anadolu.edu.tr/tojde7/articles/educationalradio.htm

Ваттегама, Чанука. 2006. Шри Ланка: Гамшгийн үеийн хэвлэл мэдээллийн үүрэг. К.Сеневиратне, Хэвлэл мэдээллийн сорилт, бэрхшээл: Азийн Цунами ба цаад тал. Сингапур: AMIC, хуу. 182–94.

Вин, Тин Лей. 2009, Индонезийн Хүйн Радиогийн редакцийн монитор ‘Уулын гал’, 3 сарын 25. Индонез: Алтернет. www.reliefweb.int  /rw/rwb.nsf/db900SID/SNAA-7QJ385?Open Document

ВИНЕТ. 2008. Эмэгтэйчүүд нөхөн үржихүйн талаарх мэдээллийг радиогоор хүлээн авсан Димитра мэдээний Сонин , Номер. 14, 3 сар.  Ром: FAO Димитра Төсөл. www.fao.org/docrep/016/ap520e/ap520e00.pdf

Хүйн Радио Эрхлэгчдийн Дэлхийн Холбоо (AMARC)/Эмэгтэйчүүдийн Олон Улсын Сүлжээ (WIN). 2008. Хүйн радиогийн Жендерийн бодлого. www.amarc.org/documents/Gender_Policy/GP4CR_English.pdf

Ян-Чеол, Чеон. 2004. Интернет мэдээ алтернатив хэвлэл мэдээлэл болох нь: Өмнөд Солонгосын OhmyNews. Хэвлэл мэдээллийн хөгжил Лондон: WACC.

## Видео, мултимедиа

AMIC. 2007. Дуу хоолойгоо гаргах боломжгүй хүмүүст дуу хоолойгоо хүргэх: Азийн Хүйн Радио, definition-тайлбар тодорхойлолтын талаарх ярилцлага, Азийн судлаачдын хамтарсан судалгаа, Хүйн Радионы бүтэц, ба харилцааны стратеги.

AMIC. 2008. Хүйн олон нийтэд харилцан ойлголцол бий болгох: Котмале Хүйн Радио

AMIC. 2009a. Радио DXUP-FM: Хүйн иргэдийг хооронд нь холбох, Өмнөд Филиппиний Юпи Минданаогийн Хүйн Радиогийн өөр өөр газар нутгийн хүйн иргэдийг уулзуулах баримтат бүтээл.

AMIC. 2009b. Радио Булуан: Лалын Шашинт Хүйн иргэдэд үйлчлэх нь. Булуаны Хүйн Радио редакци, Өмнөд Филиппины Минданаоигийн Лалын шашинт голдуу хүйн иргэд.

AMIC. n.d. Хүйн радиогийн тайлбар, тодорхойлолтын талаар Табинг Луитэй хийсэн ярилцлага.

AMIC Алтернатив хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба Оролцогч талуудын мэдээлэл харилцаа. Повепойнт илтгэл.

AMIC. Хүйн радиог танилцуулах Повепойнт илтгэл. Хүйн Радиогийн загвар нь

AMIC. Оролцогчдын програм, бүтээл Повепойнт илтгэл. AMIC. Хүйн Радиог эхлүүлэх нь

AMIC. Хүйн иргэдийг ойлгох. Повепойнт илтгэл AMIC. Мэдээ бичих. Повепойнт.

AMIC, AIBD ба Дэлхийн нүд хэвлэл мэдээлэл. 2009. Махавели Хүйн Радио: Хүйн иргэдэд тулгуурласан иргэдийн оролцоо.

Буш Радио, Кэйп Таун, Өмнөд Африк. www.youtube.com/watch?v=FkpwgWrh3Xo.

Кэйп Таун, Хүйн ТВ TV. Чөлөөт хэвлэл мэдээлэл, Чөлөөт бодол. www.youtube.com/watch?v=0FSfzfcP24w

CMS Хүйн Радио: Дуу хоолойгүй иргэдийн Дуу хоолой. Лукнов, Энэтхэг.

CTA. Африкийн алс хөдөө орон нутгийн радио. www.youtube.com/watch?v=qQfEsLVXQv0

Дагрон, Алфонсо Гумучио. 2006. Магдаленагийн дуу хоолой: Энх тайвны харилцаа, Колумбын Магдаленагийн Хүйн Радио сүлжээний баримтат бүтээл, иргэд Радио ашиглан өөрсдийнхөө дуу хоолойг бусдад хүргэдэг. Учир нь тухайн бүс нутагт засгийн газар болон босогчдын хооронд хүчирхийлэл, мөргөлдөөн газар аваад байгаа. Уг бүтээлийг Колумбийн CFSC Консорциум бүтээсэн

DXUP. Шууд болон агаараар цацдаг хөгжмийн програм. Филипины Упи, Минданао

ICF Сэтгүүлчид Латин Америкт хүчтэй хүйн радиог хөгжүүлж байна. www.youtube.com/watch?v=dv85gVabUp0.

Мадхаван, М. 1993. Энэтхэгийн Олл Индия Радиогийн менежер Нагеркойлтой хийсэн ярилцлага.

Шри-Ланкийн Махавели Хүйн Радио. Тухайн газар дэрээс нь авсан сурвалжлага.

Мэйнали, Рагу. Хүйн Радио болон МХЗ-ын поверпойнт илтгэл. Балба: Хүйн Радиог дэмжих төв

Нэг ертөнц. 2006. Хүйн Мултимедиа Төвүүд ба ЮНЕСКО-гийн Радио Сонсдог Интернет хөтөч www. communicationforsocialchange.org/index.php?pageid=10&itemid=6 YouTube trailer: www.youtube. com/watch?v=6ctvaQpN8cE

Радио Суара Варга. Программын стратеги. Повепойнт/видео. Зүүн Яава, Индонези

Табинг, Л. Хүйн редакци менежмент. Повепойнт илтгэл. Тамбули Хүйн Радио, Филиппин.

Тамбули Сан. 1998. Тамбули Хүйн Радио, Филиппин.

## Радио хөтөлбөрүүд:

AMIC. 2008. Азийн дуу хоолой, Дугаар 2, 8 сар. МХЗ-уудыг энгийнээр тайлбарласан ба Филиппиний дэд ерөнхийлөгч Ноли де Кастро Хүг хөгжүүлсэн нь.

AMIC. 2009. Азийн дуу хоолой, Дугаар 15, 10 сар. ‘Хүйн Радио Азид’. Сингапур. Энэ дугаарт (Бангладешийн Хүйн Радионы төлөөлөгч Шахжхан Сираж, Калинга Сеневиранте нар Өмнөд Азид хэрхэн Хүйн Радиог хөгжүүлсэн тухай гарна.)

AMIC. 2010. Азийн Дуу Хоолой, Дугаар 19, 3 сар. ‘Азийн Хүйн Радио’. Сингапур. (Энэ сэтгүүлд Калинга Сеневиранте, Рагу Мэйнали, Ласанта Де Силва Бово Усодо нарын томоохон төлөөлөгчдийн Олон Улсын хурал дээр хэлсэн үг, ярилцлага багтсан).

## Вэбсайтууд

**Азийн алтернатив хэвлэл мэдээлэл:**

Алиран (Малайз): www.aliran.com
Деккан Хөгжлийн нийгэмлэг (Энэтхэг): www.ddsindia.com
Дхан Сан (Энэтхэг): www.dhan.org
Фридае (Сингапур): www.fridae.com
Граундвьюс (Шри-Ланка): http://groundviews.org
Ирравадди (Мъянмар): www.irrawaddy.org
Malaysiakini.com  (Малайз): www.malaysiakini.com
Минда Ньюс (Филиппин): www.mindanews.com
Миниван (Малдив): minivannews.com/
Миззима (Бирм): www.mizzima.com/
Охмайньюс (БНСУ): http://international.ohmynews.com
Прачати (Тайланд): http://prachatai.com/english
Видео Сева (Энэтхэг) - http://www.videosewa.org
Залуу Азийн ТВ TV (Шри Ланка) - http://youngasia.tv

**Бусад:**

CBF: www.cbf.com.au
Соломанн Арлуудын Хүйн Радио : http://communitymediasolomons.wordpress.com/isa-bel-learning- network
Өмнөд Африкийн Хэвлэл мэдээллийн Хөгжил ба Олон Талын Агентлаг: www.mdda.org.za
Австралийн засгийн газрын вебсайт, Агаар болон Алслагдсан зайд Радио Дамжуулах Сургууль: www.cultureandrecreation.gov.au/articles/schoolofair



# ГЛОБАЛ СЭТГҮҮЛ ЗҮЙ

Сандиип Р. Мюппиди

Ахисан шатны энэхүү сургалт нь глобал сэтгүүл зүйд тохиолдож байгаа тулгамдсан асуудал, даяарчлагдаж буй дэлхий дахин дахь сэтгүүл зүйн практик зарчимуудтай өргөн хүрээнд танилцах, шүүмжлэлт чадварыг хөгжүүлнэ. Түүнчлэн оюутнуудад өөрсдийн амьдарч буй орон нутгийнхаа орчин нөхцлийг илүү таньж мэдэх, улмаар дэлхийн сэтгүүл зүйн хөгжилтэй харьцуулах дадлага болох зорилготой.

**Сургалтын түвшин:** Бакалаврын төгсөх анги

**Сургалтын тайлбар:** Энэ курсээр глобал сэтгүүл зүйн цэгцтэй, системтэй, шинжлэх ухааны ойлголттой болохоос гадна сэтгүүл зүйн чухал салбарын чухал асуудлууд болох даяарчлал, хэвлэл мэдээллийн хууль, хэвлэл мэдээллийн эзэмшил, төвлөрөл зэргийг хооронд нь холбоход чиглэгдсэн юм.

Глобал сэтгүүл зүйн талаарх тал бүрийн ойлголтыг тайлбарласан, задлан шинжилсэн материалуудыг уншсанаар танхимын лекц болон хэлэлцүүлгүүд (танхимын болон онлайн)-эд чухал хувь нэмэр оруулна. Мөн глобал сэтгүүл зүйг судалдаг эрдэмтэн судлаачид, дадлагажигчдын хамгийн чухал ойлголт, онолын талаарх суралцах болно. Бүх оюутнууд тухайн салбарт өрнөж буй үйл явдлын талаар шүүмжлэлтэй дүгнэлт хийж сурсан байх хэрэгтэй. Үүнд: лекц болон унших материалаас гадна глобал сэтгүүл зүйд өрнөж байгаа асуудлын талаар ярилцаж курсийн ажил эсвэл тодорхой даалгаврыг авч суралцана.

Мөн оюутнууд тус хичээлийг үзэхээсээ өмнө сэтгүүл зүйн хэрэгсэл, техникийн талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй. Оюутнууд дэлхийд өрнөж байгаа асуудлын талаарх онол, техникийн тодорхой ойлголттой болсон байх шаардлагатай.

**Уг хичээлийг судалсны үр ашиг:** Оюутнуудад дараах ашиг тусыг өгнө.
юун түрүүнд дүгнэлт хийх арга барилд суралцах, (a) глобал сэтгүүл зүйн асуултуудад шүүмжлэлтэй хариулт олоход суралцах, (b) үр ашигтай үнэн зөв мэдээлэл олж авах, (c) илтгэл тавих арга барилд суралцах , (d) оюутнуудад үндэсний болон ОУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслийн шүүмжлэгч, хэрэглэгч болохоос гадна энэ талын мэдлэгтэй болоход нь тусална.

**Заах арга барил, аргууд:** Үүнд: Семинар, лекц, уншсан зүйлээ ярилцах, дүгнэлт хийх зэрэг багтана.

**Заах хугацаа:** Нэг долоо хоногт хөтөлбөрөөс хамаарч олон цаг, жишээ нь 3-6 цаг. болно. Нийт 15 долоо хоног шаардлагатай.

**Дүгнэх:**

- Даалгавар: Нийт хичээлийн 30 хувиас доошгүй байна. Үүнд долоо хоногийн даалгавар багтана.
- Бие даалт: 20-25 хувь нь илтгэл байна.
- Интернет орчин ашиглах төсөл: 20 хувь. Сургалтын туршид хувь хүн болон блогчдын контентыг ашиглан хэвлэл мэдээллийн сайт үүсгэх. Үүнд: Өгсөн даалгавар сэдвийн дагуу мэдээний блог болон youtube ашиглан видео мэдээний вэб сайт үүсгэх. Хэрэв боломжгүй бол бусад уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл тухайлбал, сэтгүүл, радио нэвтрүүлэг, телевиз, сонин, сэтгүүл ашиглаж болно.
- Ирц оролцоо: 10 хувь.

# Курсийн тойм

(Эндээс сурсан хичээлийн хөтөлбөрийг цаашдаа өөрийн улс орондоо нэвтрүүлж өөрийн болгох, энд дурьдсан сэдвүүдийг тухайн орон нутагт нутагшуулан хэрэглэнэ).

---

## Нэгдүгээр долоо хоног: Даяаршил ба хэвлэл мэдээлэл

*Онолын хүрээ:*

- Даяаршлын хүрээ
- Хэвлэл мэдээлэл дэх даяаршлын үр нөлөө
- Даяаршлын харилцааны төлөв
- Даяаршлын ирээдүй

Тодорхой кейсүүд: хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчид болон эзэмшлээр нь бүсчлэн ялгаад орон нутгийн, бүсийн, үндэсний хэмжээний болон дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон сүлжээг тодорхойлж, жагсаалт гарга. Тэдгээрийн хичнээнийг үндэстэн дамнасан корпорациуд эзэмшиж, хэдийг нь хувь хүн эзэмшиж буй талаар үнэл.

*Унших материал:* Аппадурай (1996), Дэлхийн соёлын эдийн засгийн ялгаа ба уналт; Аппадурай (2003), Даяаршсан иргэд ба судалгааны санаа; Хротии болон Хоунэс (2003), бүлэг.10, Даяаршил ба ирээдүй; Л. Эко, Африк: Даяаршлаар холбогдсон амьдрал, Камалипүүр болон Артз (2007); Хэвэнс болон Лотз (2012), бүлэг. 11, Даярчлал; Томлинсон (1999), бүлэг. 1, Даярчлал ба соёл.

---

## Хоёрдугаар долоо хоног: Хэвлэл мэдээллийн системийн харьцуулалт (өөр өөр улс үндэстний систем)

*Онолын хүрээ:*

- Түүх ба нөхцөл байдал

- Хэвлэл мэдээллийг ашиглагч хүн ам зүй (Радио, телевиз, сонин, нэгдэж буй хэвлэл мэдээлэл гэх мэт)
- Хэвлэл мэдээллийн институтууд
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглэгч
- Глобал засаглал
- Олон улсын байгууллагууд
- Глобал хэвлэл мэдээллийн хэрэгсэл, орон нутгийн зах зээлд хэрхэн нэвтэрч байгаа

*Тодорхой кейс*: хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Бие даалт*:* Хэвлэл мэдээллийн институт эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгож, нарийвчлан кейс судалгаа хий. Бидний энэ семестрт судалсан хичээлүүдээс аль нь уг кейстэй хамааралтай байгааг олж мэд.

*Унших материал:* Мюппидигаас хамаарах улсууд (2012); ди Биирээс хамааралтай бүс, (2012). Плас Стиглиз (2003), Барнэтт болон Финнэмори (2004), Жэнниитс (2013), Карнс болон Мингст (2009), Риттбэргэр эт ал, (2011);

## Гуравдугаар долоо хоног: **Хэвлэл мэдээллийн хууль болон зохицуулалт**

*Онолын хүрээ:*

- Хэвлэлийн эрх чөлөө болон мэдээлэл олж авах эрх
- Үндсэн хуулийн заалт
- Төр, хэвлэлийн мэдээллийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагын үүрэг
- Хэвлэл мэдээллийн хуулийн ач холбогдол /тухай улсын түүхийн кейс
- Зохиогчийн эрх болон хууль бус үйл ажиллагаа; гүтгэх ба доромжлох

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Бүс нутгийнхаа хэвлэл мэдээллийн хуулийн талаар 2-3 жишээ ол. Ач холбогдол болон гарах үр дүнгийн талаар санал нийлж буй эсэх тухай хэлэлц. Яагаад санал нийлсэн эсвэл яагаад нийлээгүй вэ?

*Унших материал:* Лии Б.Бекер болон Тьюдор Влад, Дэлхий нийтийн хэвлэлийн

эрх чөлөө, Бээр (2012); Пакард (2013), бүлэг. 2, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө; бүлэг. 5, Хуулийн зөрчилдөөн; бүлэг. 6, Мэдээллийг цуглуулах; бүлэг. 7, Оюуны өмч: оюуны эрх. Улс орнуудын хууль. Түүнчлэн бүс нутагт хамаарах хоёр материалыг унших

## Дөрөвдүгээр долоо хоног: **Хэвлэл мэдээллийн ёс зүй**

*Онолын хүрээ:*

- Ёс зүйн асуудлууд – Нэрээ нууцлах, эх сурвалжаа нууцлах, зөвшөөрөл авах гэх мэт
- Нийгмийн удирдамж, заавар
- Эмэгтэйчүүд, гэмт хэргийн хохирогчид, байгалийн гамшигт өртөгсөд, шашны болон цөөнхийн хүчирхийлэл болон бусад эмзэг асуудлаар нийтлэхдээ хувийн нууцыг хамгаалах

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Тухайн орон нутгаасаа хэвлэл мэдээллийн ёс зүйн зөрчилтэй 1-2 жишээг ол. Ач холбогдол болон гарах үр дүнгийн талаар санал нийлж буй эсэх тухай хэлэлц. Яагаад санал нийлсэн эсвэл яагаад нийлээгүй вэ?

*Унших материал:* Хермэн Вассермэн, Олон улсын сэтгүүлзүйн ёс зүй, Бээр (2012); Вард ба Вассермэн (2010). Түүнчлэн бүс нутагт хамаарах 2 унших материал сонго.

## Тавдугаар долоо хоног: **Хэвлэл мэдээллийн асуудлууд**

*Онолын хүрээ:*

- Дэлхийн мэдээний урсгал
- Шинэ Дэлхийн Мэдээлэл ба Харилцааны (NWICO) журам ба үүний дараах хүрээ
- Соёлын империализм ба соёлын холимог байдал

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Тухайн улс орны хэвлэл мэдээллийн хэрэгслийн агуулгад гадны нөлөө байгаа эсэхийг тодорхойл. Хэрэглэгчдийн хувьд ийм төрлийн нөлөөлөл ач холбогдолтой эсэхийг хэлэлц. .

*Унших материал:* МкБридийн тайлан (ICSCP, 1980). О. Боед-Барретт, Дэлхийн мэдээлэл харилцааны захиалгууд, Мүүди (2003); Фрау-Миигс эт ал. (2012); Крайди (2005); Жонн С. Меррилл, Дэлхийн хэвлэлийн философи, дэ Биир (2012); Тэрхи Рантанэн болон Оливер Боед- Барретт, Дэлхийн болон үндэсний мэдээллийн агентлаг, ди Биир (2012); Томлинсон (1991); ЮНЕСКО (1991); Хермэн Вассэрмэн, Шүүмжлэлт болон барууны бус хэвлэлийн философи, ди Биир (2012).
Бүс нутагтаа хамаарах 2 унших материал сонгоно уу.

## Зургаадугаар долоо хоног: **Хэвлэл мэдээллийн хамрах хүрээ**

*Онолын хүрээ:*

- Даяаршил
- Дэлхийн болон орон нутгийн хамрах хүрээний анализ
- Мэргэшсэн хэвлэл мэдээллийн хамрах хүрээ, тойм (байгаль орчин, эмэгтэйчүүд, угсаатны бүлэг, шашин болон нийгмийн цөөнхүүд, санхүүгийн сэтгүүл зүй, спортын сэтгүүл зүй, эрүүл мэндийн нийтлэлээс дор хаяж 2 -ыг сонго)
- Шашин болон глобал бүс нутаг
- Хүний эрх болон иргэний нийгмийн байгууллагын эсэргүүцэл
- Дайн болон терроризм
- Дэлхийн нийтийн шилжилт хөдөлгөөн, түүнд хамаарах асуудлууд
- Иргэний нийгэм болон олон нийтийн идэвхтэй хөдөлгөөн
- Иргэний сэтгүүл зүй
- Байгалийн гамшиг, орон нутгийн хүрээлэн буй орчин, ядуурал, өлсгөлөн, хүнсний бүтээгдэхүүн тухай мэдээ сурвалжлагууд гэх мэт

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Дээр дурьдсан сэдвүүдтэй холбоотой мэдээллийн тархалт эсвэл 2 болон түүнээс дээш сонин, ТВ-ийн суваг, мэдээллийн хэрэгслийн агуулгыг харьцуул. Бүтээлүүдэд ямар ялгаа байгаад анализ хийж, шалтгааныг тайлбарла. Нэг үндэстний, нэг дэлхийн болон нэг орон нутгийн мэдээллийн хэрэгслийг сонго.

*Унших материал:* Бергер (2009); Дэс Фрийдмэн болон Даяа Кишан Цүссү, бүлэг.1, Хэвлэл мэдээлэл болон терроризмын хөгжил, Фрийдмэн болон Цүссүд(2012); Т. Л.Жакобсон болон В.Я.Жанг, Хэвлэл мэдээллийн дайн, энх тайван, дэлхийн иргэний нийгэм, Модид (2003); Дахр Жамайл, бүлэг. 17, Хэвлэл мэдээллийн түүх ба Иракаас сурвалжлах бодит байдал, Фрийдмэн болон Цүссүд (2012); Жастин Левис, бүлэг. 15: Терроризм ба нарийвчилсан мэдээ, Фрийдмэн болон Цүссүд (2012); Дэнни Шештер, бүлэг 18, Хэвлэл мэдээллийн дайны бэрхшээл Фрийдмэн болон Цүссүд(2012). Түүнчлэн бүс нутагт хамаарах хоёр унших материал сонгох.

## Долдугаар долоо хоног: **Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулж бичих нь**

*Онолын хүрээ:*

- Бичлэгийн зарчим
- Худалдааны арга хэрэгслүүд

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Олны танил сонин эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагаас түгээж буй мэдээ нийтлэлийн агуулгын талаар уншигчдын дунд бичил судалгаа хийж ярилц. Уншигч, үзэгчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээллийг хэрхэн хүлээн авч буй талаар тайлан бич. Тух: мэдээний сонголт, өрөөсгөл хандлага/үзэл бодол тулгах, найдвартай байдал, цаг үеэ олсон байдал гэх мэт.

*Унших материал:* Арнолд С. Де Бийр, Дэлхийн мэдээ, Бийр (2012); П. Эрик Лоуи, Сэтгүүлчид гадаад орнуудаас сурвалжлах нь, Бийр (2012); Паул Парсонс, Рич, Ландесбэрг болон Гленн Скотт, Хэвлэл мэдээллийн хөгжил дэх саад, Бийр (2012); Томсон болон Мэлойн (2004); Торнбург (2011).

## Наймдугаар долоо хоног: **Сэтгүүл зүйн боловсрол (орон нутаг болон багшаас хамаарч аль ч долоо хоногт зааж болно)**

*Онолын хүрээ:*

- Сэтгүүл зүйн боловсролын жишээ загварыг хөгжүүлэх
- Сэтгүүл зүйн боловсролын глобал байр суурь

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Янз бүрийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаа, сэтгүүл зүйн туршлагатай, сэтгүүл зүйн бичлэгийн төрлөөр хичээл заах сонирхолтой 2-4 сэтгүүлч, редактортай ярилцлага хий. Тэдний ур чадвар танд нийцэж буй эсэхийг бодолцоорой. Яагаад эсвэл яагаад болохгүй гэж?
*Унших материал:* Марк Дьюзе Дэлхийн сэтгүүлзүйн боловсрол, ди Биир (2012); Мюппиди (2008). Түүнчлэн бүс нутагтаа хамаарах хоёр унших материал сонгоно уу.

## Есдүгээр долоо хоног: **Хэвлэл мэдээллийн эзэмшил ба төвлөрөл**

*Онолын хүрээ:*

- Эрхлэгч-нийтлэлч нэгдэх
- Зах зээлийн эдийн засаг: маркетингийн мэдээ; төлбөртэй мэдээ
- Үндэстэн дамнасан корпорациуд
- Зар сурталчилгаа ба олон нийттэй харилцах
- Глобал сэтгүүлзүйн улс төрийн эдийн засаг – хэвлэл мэдээллийн эзэмшил ба төвлөрөл

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Дээрх сэдвүүдийн аль  нэгэнтэй хамааралтай жишээ сонгоод үүний талаарх санал бодлоо бичнэ. Хэвлэл мэдээлэл дэх улс төрийн эдийн засгийн ойлголтын талаарх шийдлээ санал болгоно уу. Энэ цаашид болох уу?  Яагаад, эсвэл яагаад үгүй гэж?

*Унших материал:*  Л.Артз, Үндэстнээс олон улс руу нэгдсэн загвар, Камалипоур болон Артз (2007); И.Комор, Даяаршлын үеийн хэвлэл мэдээллийн нэгдэл, Мүүди (2003); Хэсэг II, Продакшн: Хэвлэл мэдээллийн салбар ба нийгмийн ертөнц, Хоратаю болон Хойнес (2003); Ж. Лозано, Латин Америк: Хэвлэл мэдээллийн хольц, Камалипоур болон Артз (2007); Моско (2009); Дауг Ньюсом, Дэлхийн зар сурталчилгаа болон олон нийтийн харилцаа, дэ Биир (2012); К. Вишванат болон Л.Б.Зэнг, Олон улсын реклам сурталчилгаа, Мүди. Түүнчлэн бүс нутагтаа хамаарах хоёр унших материал сонгоно уу.

## Аравдугаар долоо хоног: **Хэвлэл мэдээлэл, эрх мэдэл ба нийгмийн өөрчлөлт**

*Онолын хүрээ:*

- Төрийн бус байгууллага ба иргэдийн байгууллага
- Нийгмийн өөрчлөлт дэх хэвлэл мэдээлэл ба эрх мэдэл
- Олон нийтийн өргөн нэвтрүүлэг үүрэг рольтой байна уу?

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Сайн дурын төрийн бус байгууллагад очоод тэдний зорилго, тэдний санхүүжилт, хэний төлөө ажилладаг, нийгэмдээ ямар өөрчлөлт авчрах талаар олж мэд.

*Унших материал:* С. Р. Милкоте болон П. Кришнатрей, Хөгжлийн мэдээллийн харилцааны салбарын бүтэц: хүндрэл бэрхшээл болон тэргүүлэх алхмууд, Мюппиди(2012); Мюппиди болон Мэнви (2012); Сэниврирант (2012). Түүнчлэн бүс нутагтаа хамаарах хоёр унших материал сонгоно уу.

## Арван нэгдүгээр долоо хоног: **Бүс нутаг дахь хэвлэл мэдээллийн хэл**

*Онолын хүрээ:*

- Англи хэл бол дэлхийн хэвлэл мэдээллийн хамгийн том  хэл
- Сэтгүүл зүйн орон нутгийн хэл, аялга

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Хамгийн хүртээмжтэй орон нутгийн сонины эхний нүүр болон телевизийн мэдээний агуулгыг Англи хэлээр гардаг түгээмэл сонин/ТВ-ийн мэдээтэй харьцуул. Оюутнуудын сонгосон өгүүлэл, мэдээний агуула, үзэл бодол, уншигчид зэрэгт ялгаа байна уу? Тийм бол ямар ялгаа байна вэ?

*Унших материал:* Бүс нутагтаа хамаарах хоёр материал олж унш.

## Арван хоёрдугаар долоо хоног: Шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл

*Онолын хүрээ:*

- Интернет зохицуулалт
- Блогууд, вики, файл түгээлт
- Хэрэглэгчдийн хандалт
- Нийгмийн сүлжээ

*Тодорхой кейсүүд:* хамаарах бүс нутгаасаа кейс сонгох

*Даалгавар:* Интернетийн орчинд үйл ажиллагаагаа тэлсэн уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагыг сонго. Цахим ертөнцөд зориулж мэдээ мэдээлэл бэлтгэх болон редакцийн үйл ажиллагаагаа цахим орчинд хэрхэн дасан зохицуулж байгаад үнэлгээ хий. Юуг хэрхэн яаж өөрчилсөн бэ? Мэдээний редакцаа нэгдүүлсэн үү эсвэл уламжлал болон цахим хэвлэлээ тус тусад нь авч явж байна уу? Оюутан судалсан зүйл дээрээ тулгуурлан хэвлэл мэдээллийн байгууллагууд ажилчдаа халахгүйгээр үйл ажиллагаагаа явуулах тухай зөвлөгөө өг.

*Унших материал:* Бриггс (2010); Вейкл ба Яанг (2012); Пакард (2013), бүлэг. 4, Интернэт зохицуулалт; Ван Дижк (2012). Бүс нутагтаа хамаарах хоёр материал олж унш.

**Тэмдэглэл: 13-15 дугаар долоо хоногт шалгалт, ангийн илтгэлүүд болон талбарын аялалыг хийнэ. Нэмэлт материал ашиглаж болно.**

# Ном зүй


Аппадюрэй, А. 1996. Том орчин: Даяаршлын үеийн соёлын хүрээ. Миннолис, Минн: Миннисотагийн Хэвлэл

Аппадюрэй, А. (ed.). 2003. Даяаршил, 2 дахь хэвлэлт. Дурхэм, Н.С.: Дюке Их Сургуулийн Хэвлэл.

Бэрэнжии, И болон Синиверанте, С. (eds). 2006. Даяарчлагдаж буй эрин зууны Олон нийтийн радио, телевиз. Сингапур: AMIC.

Барнэтт, М. болон Финнемори, М. 2004. Дэлхийн үүргүүд: Дэлхийн Улс төрчдийн Олон Улсын Байгууллагууд. Итака, Нью Уорк.: Корнеллийн Их Сургуулийн Хэвлэл.

Бэргэр, Г. 2009. Олон улсын мэдээнд интернэт хэрхэн нөлөөлж байна: Хуберлоксийн үеийн дэлхийн хамгийн дундаж парадоксийг судлах. Олон Улсын Харилцааны Сэтгүүл, Дугаар. 71, №. 5, хуудас. 355–71.

Бриггс, М. 2010. Сэтгүүлзүйн дараа: Дижитал орчинд хэвлэн нийтлэж, нэвтрүүлэх практик гарын авлага. Вашингтон ДС: SQ Хэвлэл.

Кротию, Д. болон Хойнес, Б. 2003. Хэвлэл мэдээлэл/Нийгэм: Салбарууд, Дүр төрх ба Хэрэглэгчид, 3 дахь хэвлэлт. Доузанд Оакс, Калиф.: Сейж/Пайн Форж.

Ди Биир, А. С. (ed.). 2012. Дэлхийн сэтгүүлзүй: Тулгамдсан асуудлууд ба Хэвлэл мэдээллийн систем, 5 дахь хэвлэлт. Пиирсон.

Даунинг, Ж. 1996. Олон Улсын Хэвлэл Мэдээллийн Онол: Шилжилт, Хүчирхэгжих, Соёл. Доузанд Оакс, Калиф: Сейж.

Фрау-Миигс, Д., Никей, Ж., Палмер, М., Похле, Ж. Болон Тюппер, П. 2012. NWICO-оос WSIS хүртэл: Харилцааны геополитикийн 30 жилд. Гол дүрүүд, Дагалдагчид, Бүтэц болон Хуваагдал. Оюун ухаан.

Фриидмэн, Д болон Цюссү, Д. К. (eds). 2012. Хэвлэл мэдээлэл ба терроризм: Дэлхийн чиг хандлага. Лондон: Сейж.

Женниитс, А. 2013. Дэлхийн мэдээнд тулгарч буй асуудал: Хөгжиж буй орнууд дахь Олон улсын өргөн нэвтрүүлгийн байгууллагуудын зах зээлийн стратеги. Нью Уорк: Ройтледж.

Хэвэнс, Т. болон Лотц, А. Д. 2012. Хэвлэл мэдээллийн салбарыг ойлгохуй. Нью Уорк: Оксфордын Их Сургуулийн Хэвлэл.

Мэдээлэл харилцааны асуудлыг судлах Олон улсын зөвлөл (ICSCP). 1980. Нэг дэлхий Олон дуу хоолой (Мак Брайдын Тайлан). Парис: ЮНЕСКО.

Камалипоур, Я. Р. Болон Артз, Л. (eds). 2007. Хэвлэл мэдээллийн ертөнц: Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн олон улсын чиг хандлага. Ланхам, Мд.: Роумэн ба Литтлэфилд.

Карнс, М. П. Болон Мингст, К. А. 2009. Олон Улсын Байгууллагууд: Улс төрчид ба Дэлхийн засаглалын үйл явц. Боулдер, Коло.: Лайнн Рейннер.

Крайди, М. 2005. Соёлын ялгаа эсвэл Даяаршлын үеийн соёлын уялдаа. Филаделфа, Пэнн.,

Тэмпл Их Сургуулийн Хэвлэл

МикФайл, Т. Л. 2002. Глобал мэдээлэл харилцаа: Онолууд, Оролцогч талууд болон чиг хандлагууд. Бостон, Масс.: Эллэн ба Бакон.

Миикл, Г болон Янг, С. 2012. Хэвлэл мэдээллийн нэгдэл нягтрал: Өдөр тутмын амьдрал дахь дижитал медиагийн нэгдэл. Нью Уорк: Палграве Макмилллиан.

Милкөүт, С. Р. 2012. Шууд нийгмийн өөрчлөлт дэх мэдээлэл харилцааны хөгжил: Онолын хэт хүлээлт ба хандлагууд. Сингапур: AMIC.

Мүүди, Б. 2003. Олон улсын болон Хөгжлийн мэдээллийн харилцаа: 21-р зууны хэтийн төлөв. Доузанд Оакс, Калиф.: Сейж.

Моско,  V. 2009. Мэдээлэл харилцааны улс төрийн эдийн засаг, 2 дахь хэвлэлт. Доузанд Оакс, Калиф.: Сейж.

Муппиди, С. Р. (ed). 2008. Ази Номхон далайн орнуудын Сэтгүүлзүйн боловсролын статус болон хамаарал:  Таван үндэстний судлал. AMIC/ЮНЕСКО Хэвлэл мэдээллийн Азид зориулсан дугаар, Дугаар. 35, №. 2.

Муппиди, С. Р (ed.). 2012. Азийн Мэдээлэл Харилцааны гарын авлага, 6 дахь хэвлэлт. Сингапур: AMIC.

Муппиди, С. Р. болон Манви, П. 2012. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ болон түүний талаарх өсөн нэмэгдэж буй иргэний ухамсарын өсөлт. Сингапур: AMIC.

Пакард, А. 2013. Дижитал Хэвлэл Мэдээллийн Хууль, 2 дахь хэвлэлт. Вилии-Блаквэлл.

Риттбэргэр, В, Зангл, Б. болон  Крюк, А. 2011. Олон Улсын Байгууллага. Нью Үорк: Палгрейв Макмиллан.

Сэнэвирэтн, К. 2012. Хүмүүсийн дуу хоолой, Хүмүүсийн хүчирхэгжилт: Ази болон хил залгаа орнуулын Хүйн радио.Сингапур: AMIC.

Стиклиз, Ж. Э. 2003. Даяарчлал ба түүний эсэргүүцэл.  Нью Уорк: В. В. Нортон.

Томпсон, Р болон Мейлойн, С. 2004. Өргөн нэвтрүүлгийн сэтгүүлчдийн гарын авлага: Телевизийн мэдээг аврах гарын авлага. Роумэн ба Литтлфилд.

Торнбург,  Р. М. 2011. Цахим мэдээг бэлтгэх нь: Дижитал ур чадвар, Хүчтэй өгүүллүүд. Доузанд Оакс, КА: Сейж//CQ Хэвлэл.

Томлинсон, Ж. 1991a. Соёлын түрэмгийлэл: Шүүмжлэлт танилцуулга. Балтимори, Мд.: Жонс Хопкинс Их Сургуулийн Хэвлэл.

Томлинсон, Ж. 1999b. Даяарчлал ба Соёл. Балтимори, Мд.: Чикагогийн Их Сургуулийн Хэвлэл.

ЮНЕСКО. 1991. Хараат бус, олон ургальч Африкийн хэвлэлийг түгээн дэлгэрүүлэх Виндхокийн тунхаглал.

Ван Дижк, Ж. 2012. Сүлжээний нийгэм, 3 дахь хэвлэлт. Доузанд Оакс, Калиф.: Сейж.

Вард, С. Ж болон Вассэрмэн, Х. (eds). 2010. Хил хязгааргүй Хэвлэл мэдээллийн ёс зүй: Дэлхийн чиг хандлага. Роутледж.



# ШИНЖЛЭХ УХААНЫ СЭТГҮҮЛ ЗҮЙ, БИОЭТИКИЙН НЭГДЭЛ

Жорж Глаассэн

Энэ курсээр шинжлэх ухаан ба технологийн сэтгүүл зүйг судална. Үүнд сүүлийн 30-аад жилд шинжлэх ухаан болон технологид гарсан биоэтикийн хөгжил, сонгодог био эрүүл мэндийн асуудал, хүрээлэн буй орчны асуудал болон бусад биоэтикийн жишээнүүдийг хөндөнө. Заах арга зүйн хэсэгт оюутнуудыг шинжлэх ухааны бодит ертөнцтэй танилцуулах зорилготой. Түүнчлэн шинжлэх ухааны талаарх хурал зөвлөлгөөн, лекцэд суух, олон нийтийн сонирхолыг татах шинжлэх ухааны сэдэв болон хөгжлийн асуудлаар эрдэмтэд урьж оюутнуудтай уулзуулна. Энэхүү хөтөлбөрийн нэг хэсэг болох оюутнуудыг үнэлэхдээ лекцүүдийн тухай мэдээлсэн, хурал зөвлөлгөөнд оролцсон байдлыг харгалзана.

**Сургалтын түвшин ба зорилтот бүлэг:** Энэхүү үндсэн хөтөлбөрийг сэтгүүл зүй, шинжлэх ухааны сэтгүүл зүйгээр мэргэшин суралцаж байгаа шинжлэх ухааны мэдээлэл харилцааны оюутнуудад, тэдний дипломын зэргийн хэсэгт зориулав.

**Сургалтын тодорхойлолт:**

Сэтгүүл зүйн оюутнуудад орчин үеийн шинжлэх ухааны онол болон шинжлэх ухааны мэдээлэл харилцааны талаарх ойлголт мэдлэгийг заана. Сургалтын зорилго нь байгалийн шинжлэх ухааны талаар тодорхой мэдлэгтэй болж яваандаа сэтгүүл зүйд ашиглах, цаашлаад нийгэмд байгалийн шинжлэх ухаан хэрхэн голлох үүрэг гүйцэтгэж байгааг мэдэхэд оршино. Шинжлэх ухааны сэтгүүл зүй нь байгалийн шинжлэх ухааны мэдлэг шаардах учраас сэтгүүлчид давхар байгалийн шинжлэх ухаантай холбогдолтой мэдээ материал нэмж унших, судлах шаардлагатай. Мөн байгалийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний ажилтантай ойр, нягт холбоотой ажиллах шаардлагатай болдог.

Шинжлэх ухааны сэтгүүлч нарын хувьд улс төр, санхүү болон спортын сэтгүүлч нараас ялгаатай, илүү төвөгтэй зүйл гэвэл байгалийн шинжлэх ухаан нь туршилтын шинжлэх ухаан учраас үр дүн гарсан хойно нь тухайн сэдвээр бичих болдог. Генетикч Ж. Б. С. Халдэнегийн хэлснээр шинжлэх ухаан бол эргэж буцаж байж батлагддаг. Байгалийн шинжлэх ухаан нь өндөр технологийн болон боломжгүй зүйлээс болох хүртэл явдаг ойлголтын гүүр нь болж өгдөг. Мөн байгалийн шинжлэх ухааны сэтгүүлч нь тухайн чиглэлээр судалгаа хийж байгаа хүмүүсийн хувьд маш их мэдээллийн уурхай болдог. Түүгээр барахгүй энгийн  иргэд уншигчдын хувьд байгалийн шинжлэх ухааны том мэдлэг болж өгдөг. Жишээ нь 17-р зууны Роуал Сошиати сэтгүүл нь тухайн үедээ философийн гол мэдлэг, мэдээлэл болж байсан. Тэр үед хөдөө орон нутгийн иргэд болон худалдаачид энэ сэтгүүлийн хэрэглэгч, уншигчид нь байжээ. Энэ сэтгүүл тухайн үедээ мэдлэгийн болон шинэ үгсийн сангийн гол гүүр нь болж байсан. Тиймээс шинжлэх ухааны сэтгүүлч, байгалийн сэтгүүл зүйн чиглэлээр сурч байгаа оюутнууд Нобелий шагналт Петер Медэвэрийн орчин үеийн шинжлэх ухааны шүүмжлэлтэй танилцаж, судалж болох ёстой юм.

> Орчин үед хойш тавигдаж байгаа уламжлалт (хуучны) шинжлэх ухааны өгүүллийг хамгийн түрүүнд ашиглах ёстой. Шинжлэх ухааны баримт материал, тэдгээртэй холбоотой үйл явдлын талаар ичиж зоволгүй, тодорхой баримтад тулгуурлан уншигчдад ойлгомжтой байдлаар олны хүртээл болгох хэрэгтэй. Ингэснээр байгалийн шинжлэх ухаантай холбогдолтой аливаа үйл

явдлын талаар уншигч, үзэгчид үнэнийг мэдээд зогсохгүй шинээр гарч ирж байгаа залуу сэтгүүлч, судлаачдад тухайн судлаачийн судалж хэвлүүлсэн, нийтэлсэн материал ихээхэн тус болох бөгөөд залуу сэтгүүлчийн цаг завыг хэмнэх болно. Мөн сэтгүүлч уншигчдад шинжлэх ухааны талаар зөв ойлголт өгөх болно.

(Медэвэр, 1963)

Шинжлэх ухааны сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж байгаа оюутнууд шинжлэх ухаан, технологи, байгаль орчин, биоэтик, шинжлэх ухааны болон шинжлэх ухааны бус зүйлүүдийн хоорондын харилцан уялдааны талаар судлах ёстой. Эдгээр оюутнуудын гол зорилго нь шинжлэх ухааныг дэлхийн түвшинд ойлгож мэдэх, ойлгосноо үзэгч, уншигчдад ойлгомжтой байдлаар хүргэх явдал юм. Нобелийн шагналт Роберт Парк “Олон нийтийн хувьд шинжлэх ухааныг гүнзгий дээд түвшинд мэдэх шаардлагагүй. Харин шинжлэх ухааны талаар тодорхой энгийн ойлголттой болсноороо амьдарч буй гараг ертөнц, захирагдаж байгаа өөрсдийн зохиосон материаллаг хууль зэргийн талаар тодорхой ойлголттой болох юм” гэжээ.
Шинжлэх ухааны сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж байгаа оюутнууд статистик өгөгдөл цуглуулж, боловсруулахдаа алдаа гаргах тохиолдол нийтлэг ажиглагддаг. Ялангуяа тэдэнд эрүүл мэндийн шинжлэх ухаан, биоэтик буюу биологийн судалгааны ёс зүй, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан зэрэгт цуглуулсан статистик мэдээ материалаа хөрвүүлэх, буулгах, тооцоолох, боловсруулахад тооцооллын болон математикийн арга барил дутагддаг. (Брэнд, 2008; Дэ Бийр болон Стэюн, 2002; Принслүү,   2006). Кохн (1993), Паулос (1995), Бластлэнд, Дилнот (2007).

Энэ салбараар суралцаж байгаа оютнуудын хувьд магадлалын онол болон тодорхойгүй зүйлийн талаар маш сайн ойлголттой байх хэрэгтэй. Жишээ нь: Шүүх хурал дээр forensic буюу сэжигтний шүүх эмнэлэгийн магадлагаа буруу хөрвүүлэгдэх тохиолдол гардаг. Ингэснээр хэн нэгэн хүн гэмт хэргийн золиос, хохирогч болж хэлмэгдэх нь ч бий. Нэмж жишээ татвал, Их Британий иргэн Сэлли Кларк бага насны хоёр хүүхдийнхээ амийг хороосон хэргээр буруутгагдсан. Харин Английн Royal Statistical Society буюу Эзэн Хааны Статистикийн Нийгэмлэг уг хэргийн мөрдөн байцаалтад анхаарал тавьж оролцсоноор хэрэг өөрөөр шийдэгдсэн аж.
Шинжлэх ухааны сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудад эрдэмтэн, судлаач, ЭША-нуудтай ойр хамтарч ажиллахыг зааж өгөх хэрэгтэй. Шинжлэх Ухааны Сэтгүүл Зүйн Сургалтын суурь хөтөлбөрт шинжлэх ухааны сэтгүүлчид эрдэмтэн судлаачидтай хамтран баталгаа, нотолгоотой өгөгдлийг боловсруулж мэдээлэх ёстой талаар заасан байдаг.

Эрдэмтэн судлаачидтай ойр ажиллахын өөр нэг давуу тал гэвэл сэтгүүлчдийн хувьд шинжлэх ухааны мэдээ материал, үг хэллэг, ялангуяа гадаад үг хэллэгийг энгийн хүнд ойлгомжтой байдлаар хөрвүүлэх, буулгах, боловсруулах, цаашлаад шинжлэх ухааны зөв мэдээ материалыг боловсруулах явдал юм. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны сэтгүүлч хэвлэл мэдээлэл болон шинжлэх ухааныг холбох гүүр нь болох учиртай.  Их Британий Эдийн Засаг болон Нийгэм Судалгааны Зөвлөлөөс (ESRC) гаргасан гарын авлагад:

> Эрдэмтэн судлаач болон сэтгүүлчдийн бэлтгэсэн, боловсруулсан бүтээл олон нийтэд ялангуяа хэвлэл мэдээллийнхэнд ил тод, ойлгомжтой, энгийн байх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэдгээр мэдээ, материалыг ашиглахдаа эргэлзэх шаардлагагүй байх учиртай. Засгийн газрын бодлогын хяналтан дор бизнесмэн болон олон нийтийн судалгааны материалын үр дүнд тулгуурласан техникийг нутагшуулж, олон нийтийн бүхэл бүтэн, иж бүрэн ойлголттой болж, академик шинжлэх ухааны үр дүнг ашиглан нийгэм болон эдийн засгийн асуудалд хандах шаардлагатай.
>
> (ESCR, 1993, хуу. 2)

Эрдэмтэн судлаач болон сэтгүүлчдийн хоорондын ажлын уялдаа ойлголт чухал болох талаар 1985 оны Их Британий Рояал Сошиати хэмээх Эзэн Хааны Нийгэмлэгээс гаргасан тайланд тодорхой дурьдсан. Үүний дараа Рояал Сошиати “Олон улсын шинжлэх ухаан ба олон нийтийн шалгуур” нэртэй семинар зохион байгуулсан. 1985 оны Рояал Сошиатиас гаргасан “шинжлэх ухааны талаарх олон нийтийн ойлголт” тайланд:

> Эрдэмтэн судлаачид олон нийтийн өмнө нээлттэй байж үүнийгээ өөрсдийнхөө үүрэг хэмээн ойлгох ёстой. Сэтгүүлчид шинжлэх ухааны ойлголттой байх ёстой гэсэн зарчимын нэгэн адил судлаачид хэвлэл мэдээллийн талаар тодорхой системтэй, ойлголттой байх нь гарцаагүй. Тэр тусмаа шинжлэх ухааныг олон нийтэд ойлгомжтой энгийн хэлбэрээр тайлбарлаж чаддаг байх шаардлагатай юм.
>
> (Рояал Сошиати, 1985, хуу. 5)

1996-1997 онд АНУ-д эрдэмтэн судлаач болон сэтгүүлчдийн хоорондын ажлын харилцан уялдаа, тэдгээрийн хоорондын ойлголтын талаарх анхны судалгаа

хийгдсэн. Мөн үүнтэй төстэй эрдэмтэн, судлаач болон хэвлэл мэдээллийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны талаар судалгаа гарсан байна. Эрдэмтэн судлаач болон сэтгүүлчдийн хамтын ажиллагаа, сайн харилцааны үр дүнд хэвлэл мэдээллийн байгууллагад дэвшил гарах болсон. Үүгээрээ дамжуулан олон нийт шинжлэх ухааны талаар энгийн ойлголттой болж уншигч, үзэгчид хожиж байна. (Бауер, 2000; Бюччи, 1998, 2004; Клаассен, 1991, 1995, 2001a, 2001b, 2011; Хес-мондалх, 2008; Шукла ба Бауер 2007; Вэбстер, 2006).

Хичээлийн номон дээрх байгалийн шинжлэх ухаан болон хил хязгаарын буюу дэлхийн шинжлэх ухааны ялгааг оюутнууддаа сайн тайлбарлаж өгөх хэрэгтэй. Эрдэмтдийн хувьд номон дээрх болон хилийн чанд дахь шинжлэх ухааны сул талыг Бауер ийнхүү тайлбарласан. “Номон дээрх шинжлэх ухаан нь хэн нэгний өөрийнх нь бүтээл харин frontier буюу хилийн чанад дахь шинжлэх ухаан нь сонирхолтой боловч тодорхойгүй, баталгаа нотолгоогүй” (1992, хуу. 37).

Номон дээрх болон фронтиер шинжлэх ухааны ялгааг танихгүйгээр шинэ нээлтийг таньж мэдэхэд хэцүү. Нелкин (1995, ху. 31–2) Ямар ч шинжлэх ухааны нээлт, хөгжил, сурталчилгаагүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл шинжлэх ухааныг бусдад таниулах хэрэгсэл болдог. Фронтиер шинжлэх ухаан нь бидний амьдралыг өөрчилдөг. Шинжлэх ухаан болон технологийн талаарх хэвлэл мэдээллийн мэдээ сурвалжлага нь компьютер болон биотехнологид суурилдаг.

Тодорхой судалгаа, мэдээ баримтад тулгуурласан шинжлэх ухааны холбогдолтой мэдээ, сурвалжлага олонд хүрсэнээр байгалийн шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн алдааг буруулдаг. Сэтгүүлч болон редактор, эрхлэгч нарын гаргадаг бас нэг алдаа нь тэдний бичсэн тодорхой шинжлэх ухааны мэдээ мэдээлэл дараагийн үед, хэдэн зуун дамжин уншигчдад хүрсээр байдаг. Цаг хугацааны эрхээр тухайн судалгааны мэдээ сурвалжлагын үр дүн үнэн зөв эсэх нь олон жилийн дараа ч гэсэн тодорхой болдог. Фронтиер шинжлэх ухаан нь туршигдаагүй, батлагдаагүй, тодорхойгүй байх тохиодол нийтлэг байдаг. Жишээ нь: Алимны Алар нэртэй шавьжны эсрэг хор хавдар үүсгэх нөхцөл болдог гэсэн мэдээлэл, сурвалжлага олны дунд шуугиан тарьж байв. Гэтэл Вашингтон Пост сонин энэхүү мэдээлэл нь шинжлэх ухааны судалгаанд тулгуурлаагүй, шинжлэх ухааны үндэслэлгүй, ташаа мэдээлэл болохыг хүлээн зөвшөөрсөн.  Тэгэхээр шинжлэх ухааны аливаа мэдээ баримт олон нийтэд таалагдах гэсэн, олон нийтийн эрх ашгийг хамгаалж байгаа дүр эсгэсэн хувь хүн, албан тушаалтан, бүлэглэлийн талд бус харин хэдийгээр нийгэмдээ эсэргүүцэлтэй

тулгарч байсан ч хамаагүй, олон нийтэд таалагдахгүй байсан ч хамаагүй, баталгаа нотолгоотой, судалгааны үр дүнд тулгуурласан, шинжлэх ухааны мэдээлэл, сурвалжлага байх ёстой. Энэ нь цагийн аясаар үнэн зөв мэдээлэл байсан эсэх нь мэдэгдэж, танигдах болно. (1977 оны 6 сарын 1).

Эрүүл мэндийн салбарынхан хэвлэл мэдээллийн байгууллагад дуулиантай, олны анхаарал татсан мэдээ мэдээллийг өгч сэтгүүлд нийтлүүлдэг. Жишээ нь: зүрх судасны өвчин, чихрийн өвчин, Alzheimer буюу санах ойгоо алдах өвчин, хорт хавдартай холбогдолтой өвчлөлүүд олны анхаарлын төвд байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр номон дээр хэвлэгдсэн шинжлэх ухааны бүтээл байдлаар цацагдаж байгаа фронтиер шинжлэх ухаан нь хэдэн сарын дараа няцаагдах магадлалтай байдаг. Энэ нь олон нийтийг төөрөгдүүлдэг. Учир нь хүмүүсийн олонх нь шинжлэх ухааны холбогдолтой судалгааны нийтлэл бус харин хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл хүлээн авдаг. Үүнд: эрдэмтэн судлаачид болон хэвлэл мэдээлэл хоёулаа буруутай болдог. Учир нь шинжлэх ухааны судалгааны үр дүн маш олон удаа туршигдаж, батлагдаж ихээхэн хугацаа зарцуулдаг. Сэтгүүлч болон эрдэмтэн судлаачдын хувьд хоорондын харилцаа уялдаагүйгээс болж хэвлэлийнхэн дөнгөж судалгааны түвшинд яваа судалгааны мэдээ баримтыг олонд ил болгох явдал гардаг. Үүнээс шалтгаалан ялангуяа эрүүл мэндтэй холбоотой, ерөнхий болон шинжлэх ухааны мэдээ мэдээллийн нэр хүнд унадаг. Давийс (2008) ба Голдакр (2008, 2012).

Аделмэнн-Грилл, Воксмэн, Креютзберг (1995, хуу. 2) нарынхаар бол эрдэмтдийн хувьд номон дээрх шинжлэх ухааныг мэргэжилтний хувьд таньж ойлгоход хялбар. Гэхдээ энгийн иргэдийн хувьд фронтиер шинжлэх ухааныг номон дээрх шинжлэх ухаанаас илүү сонирхож, илүү хялбараар ойлгодог.

Байгалийн шинжлэх ухааны сэтгүүл зүйгээр мэргэшиж байгаа оюутнуудын хувьд аль хэдийнэ хичээлийн номон дээр байгаа шинжлэх ухааны материал, сүүлд нь фронтиер шинжлэх ухааны бүтээл болж олонд хүрэх нь олонтаа. Ялангуяа хэвлэлээр “breakthrough” (Олны анхаарлыг татсан шуурхай мэдээ) буюу хорт хавдар болон аливаа өвчнийг эмчлэх эм бэлдмэл гарган авсан тухай олны анхаарлыг татсан мэдээ мэдээлэл ихээр цацагддаг. Гэхдээ энэ нь ихэнхдээ батлагддаггүй. Хүн төрөлхтөн одоо хүртэл хорт хавдрыг бүрэн эмчилдэг болж чадаагүй. Харин эмчлэх магадлалтай гэсэн бага сага туршилтын мэдээ мэдээлэл цацагдаж байдаг. Тиймээс шинжлэх ухааны сэтгүүл зүйн оюутнууд ‘breakthrough’ буюу хэдийгээр олны

анхаарлыг татсан, олны хүлээлт болсон сонин содон мэдээ мэдээлэл байлаа ч батлагдаагүй мэдээлээс татгалзах хэрэгтэй. Хичээлийн номон дээрх шинжлэх ухааны болон фронтиер шинжлэх ухааныг мэдрэлийн эмч, эрдэмтэн судлаач Симон Левая ялгаж салгахдаа:

> Бид шинжлэх ухааны талаар дандаа амжилт гаргасан, нээлт хийсэн, ялалт байгуулсан талаар, тухайлбал тухайн өвчний эсрэг эм бэлдмэл гарган авсан, саран дээр хүн хөл тавьсан, хамгийн хурдан компьютер зохион бүтээсэн зэргээр бахархдаг. Гэхдээ шинжлэх ухааны гайхамшигт амжилтын хажуугаар маш олон алдаа бүтэлгүйтэл дагалддаг. Шинжлэх ухааны амжилт болгон маш их алдаж, онож, бүтэлгүйтэж, асар их хөрөнгө зарж байж ирдэг. Гэвч энэ нь шинжлэх ухаан алдаа гаргаж байгаа биш харин тухайн эрдэмтэн дутуу дулимаг судалгаа хийснээс, туршлагагүйгээс, шинжлэх ухааны судалгаа хэт буруу тийшээ явснаас шалтгаалдаг.
> (LeVay, 2008, p. vii)

Эдгээр алдаануудын талаар болон шинжлэх ухааны судалгааны алдааны талаар оюутнууд ангидаа хэлэлцэх хэрэгтэй. Үүнд: 1997 онд Өмнөд Африкт ДОХ-ын эсрэг эм бэлдмэл гаргасан авсан тухай Вироденийн хэрэг (Биологийн судалгааны ёс зүйн талаарх хэсгээс үзээрэй). Мөн 1993 онд Вашингтон ДС-д гарсан Хүчирхийллийн гэмт хэргийг бууруулахын тулд анхаарал төвлөрүүлэх, бясалгал хийх хэрэгтэй гэсэн мэдээлэл цацагдаж байсан ч нотлогдоогүй. Бөөн дуулиан шуугиан болоод өнгөрсөн. Эдгээрийг жишээ болгож болох юм.

Бас нэгэн жишээ гэвэл (Эндрью Вейкфийлдийн дуулиан шуугиан) mumps–measles–rubella (MMR) буюу Гахайн хавдар- Салхин цэцэг- Улаан бурханы эсрэг вакцин, аутимз буюу жожгирох өвчний талаар 1998 оны 2-р сард Лансет сэтгүүл дээр хэвлэгдсэн нь судалгааны худлаа үр дүн болж таарсан. Гэхдээ судлаачид болон сэтгүүлчид 2010 оны 2-р сард буруугаа хүлээн зөвшөөрч залруулга гаргасан юм. Энэ мэт болсон үйл явдал нь шинжлэх ухааны сэтгүүлч болон судлаачдын нэр хүндэд маш муугаар нөлөөлж байна. Тиймээс шинжлэх ухааны сэтгүүлчид маш болгоомжтой, аливаа туршилт, шинжлэх ухаан дээр тулгуурласан баримт нотолгоотой, мэдээ мэдээллийг цацаж байх нь чухал юм.

> Эрүүл мэндийн шинжлэх ухаан нь маш нарийн судалгаа, баримт, мэдээ, туршилтад тулгуурладаг. Эрүүл мэндийн шинжлэх ухаан, хэвлэл мэдээлийн байгууллага болон сурах бичиг дээр хэвлэглэгдсэн хөдлөшгүй баримтаар

нотлогдож, батлагдаж, ижил төрлийн судалгаа хийж байгаа хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдөж, дэмжүүлсэн, хэн ч гэсэн очоод тухайн материалтай танилцах боломжтой, нээлттэй, ил тод байх ёстой.

(Кейзер байгууллагын Доктор, Гэри Фрийдмэн, Кохн, 1993, хуу 96)

Дипак Чопрагийн 1994 онд дэвшүүлсэн квантын аргаар хорт хавдрыг эмчлэх, Quantum Healing ба Ageless Body, Timeless Mind, The Quantum Alternative to Growing Old (1994) аргаар бол:

Квант физикийн аргаар хорт хавдарыг дарангуйлж эмчлэх нь эрүүл мэндийн шинжлэх ухааны хувьд дээд шатанд гарсан нэг том дэвшил. Квантум физик нь ультра туяаны хамгийн бага хуваагдахгүй хэсгийг ашиглан эмчлэх арга юм.

(Парк, 2000, хуу. 192)

Энэ нь фронтиер болон номон дээрх шинжлэх ухааныг хооронд нь ялгаж салгаж чадаагүйгээс үүссэн алдаа юм. Дипак Чопра нь эрүүл мэндийн шинжлэх ухааны ямар ч үндэслэлгүй, баримт нотолгоогүй, туршилтын үр дүнгүй, зүгээр л эдгэшгүй өвчнийг эмчилж болох талаар хариуцлагагүй ярилцлага хийж хэвлэлийн баатар болсон. Парк хэлэхдээ:

Дипак Чопрагийн энэ мэдэгдэл нь ухаантай, боловсролтой олон сая хүнийг манай дэлхий дээр болохгүй зүйл байхгүй, эмчлэгдэхгүй өвчин байхгүй гэдэгт итгэхэд хүргэсэн... Яагаад хүмүүс түүнд итгэв?... Яагаад гэвэл аливаа гаж этгээд санаа дэвшүүлэх нь шинжлэх ухааны нэг үйл явц юм. Гэхдээ ийм этгээд санаа хол явдаггүй, нэг бол урьд нь мэдэгдэж байсан санаа эсвэл нээгдээгүй, цаашид судалгаа яаж өрнөх нь тодорхойгүйгээс болж тухайн санаа мөхдөг. Шинжлэх ухааны нээлт нь тухайн эрдэмтний төсөөлөл дээр тулгуурладаг хэдий ч туршигдаагүй, турших боломжгүй, зүйлүүд хэвлэл мэдээлэлд шилжихээрээ мөхдөг, замын дундаас алга болдог.
(Парк, 2000, хуу. 193)

Сэтгүүлч, оюутнуудын хувьд судлаачидтай харилцах, шинжлэх ухааны хурал семинарт оролцох үеэрээ тэднээс ярилцлага авч, сурвалжлага бэлдэх нь зүйтэй. Эрдэмтэдтэй уулзаж жинхэнэ шинжлэх ухаан гэж ямар байдгийг мэдэж авах нь чухал. Боломжтой бол тухайн бүтээлээрээ олон жил судалгаа хийж байгаа эрдэмтнийг ангидаа урьж ярилцлага авч, ярилцах хэрэгтэй. Энэ сургалтын

хөтөлбөрийн нэг хэсэг болох даалгавар нь оюутнууд Олон улсын шинжлэх ухааны хурал, семинарт оролцсоноороо мөн судлаачидтай уулзаж ярилцсанаа дүгнүүлэх явдал юм. Энэ туршлага нь оюутнуудын хувьд шинжлэх ухааны сурвалжлага бэлдэх анхны суурь болж өгнө. Мөн хоёр хэлбэрээр үнэлүүлж дүгнүүлнэ.

Нэгдүгээрт, их дээд сургуулийн сэтгүүл зүйн оюутнуудын хувьд шинжлэх ухааны хурал, семинар болон зочдын лекцийг сурвалжилж мэдээ бэлтгэх. Үнэлгээний хувьд эдгээр мэдээ, сурвалжлагын гүйцэтгэх хугацаа богино байх ёстой. Хамгийн оройтлоо гэхэд тухайн шинжлэх ухааны хурал дууссаны маргаашаас хэтрэлгүй бэлтгэсэн сурвалжлагаараа мэдээ бэлтгэх. Оюутнуудын хувьд мөн тухайн судлаач эрдэмтэн судалгааныхаа бүтээлийн талаар сэтгүүлд нийтлүүлсэн бол түүгээр мэдээ, сурвалжлага бэлтгэх. Ярилцлагын өмнө тухайн эрдэмтний судалгааны нийтлэл болон материал сэтгүүл зүйн ангийн оюутнуудад урдаас тараагдсан байна. Оюутнууд дээд тал нь 400 үгтэй, сонины болон интернэт мэдээ бичих эсвэл тухайн эрдэмтний нийтлэлд тулгуурлан 3 минутаас хэтрэхгүй радио, телевизийн аудио, видео мэдээ сурвалжлага бэлтгэнэ.

Хоёрдугаарт, оюутныг үнэлэхдээ тухайн судалгааг хийж, бүтээлээ нийтлүүлсэн судлаач эрдэмтний ажлын явц, ажлын тухай, хувийн амьдрал зэргээр ярилцлага авч мэдээ сурвалжлага бэлтгэнэ. Хэрэв тухайн судалгаатай холбогдсон бол хүн төрөлхтний тулгамдаад байгаа асуудлууд болох дэлхийн дулаарал, цаг агаарын өөрчлөлт, эвалюци, вакцин тойрсон маргаан, амьтан дээр явуулсан туршилт болон судалгааны ажил, биоэтик буюу биологийн судалгааны ёс зүй зэрэг сэдэвтэй 2000–аас доошгүй үгтэй нийтлэл бичнэ. Энэ мөн радио болон телевизийн ярилцлага байж болно. Хэрэв тийм бол мэдээ, нэвтрүүлгийн нийт хугацаа 30-аас доошгүй минут байна.

Оюутнууд шинжлэх ухааны дараах салбаруудад тулгуурлан мэдээ бэлтгэнэ. Хичээлийн зорилго нь оюутнуудыг сэтгүүл, интернэт, сонинд зориулсан шинжлэх ухааны холбогдолтой мэдээ нийтлэл бичихэд сургах, радио телевизээр цацах мэдээ нэвтрүүлэг бэлтгэхэд сургаж дадлагажуулах явдал юм.

Шинжлэх ухааны салбаруудад:

## 1. Хүрээлэн буй орчин ба цаг уурын өөрчлөлт

Цаг уурын шинжлэх ухааны холбогдолтой мэдээ сурвалжлага бэлтгэхдээ дараах зүйлүүдийг анхаарна.

- Цаг уурын өөрчлөлт дэх улс төрийн нөлөө, оролцоо: Intergovernmental Panel on Climate Change (IPCC) буюу Олон Улсын Засгийн Газар хоорондын цаг уурын өөрчлөлтийн асуудал, эдгээрийн тайлан. Жишээ нь Японы Кёото болон Талуудын оролцоотой зөвлөлгөөн (COP) зэрэг бусад цаг уурын өөрчлөлтийн эсрэг хурал зөвлөлгөөний тайлан
- Цаг уурийн өөрчлөлт дэх нүүрс хүчлийн хийн ($CO_2$- хүлэмжийн хий ч гэдэг) нөлөө
- Эрс тэс уур амьсгал, үзэгдэл болон түүнийг танин мэдэх
- Хойд мөсөн туйлын мөс хайлах болон далайн түвшин нэмэгдэх
- Цаг уурын өөрчлөлт болон хүнсний үйлдвэрлэл
- Цаг уурын өөрчлөлтийн нөлөө болон тухайн зүйл амьтан мөхөх, ховордох
- Цаг уурын өөрчлөлт хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх
- 1987 онд батлагдсан World Commission on Environment and Development буюу Хүрээлэн Буй Орчин болон Хөгжлийн зөвлөлөөс гаргасан Johannes burg Declaration on Sustainable Development буюу Тогтвортой Хөгжлийн Йоханнесбургийн Тунхаг: Ирээдүй үеийн хэрэгцээг тооцолгүй одоо үеийнхний хэрэгцээнд нийцүүлсэн тогтвортой хөгжил, эдгээрт дараах сэдвүүд орно:
    - Дэлхийн цаг уурын өөрчлөлтийг хязгаарлах (Утааг багасгах)
    - Бүх төрлийн ойн санг хамгаалах, менежмент хийх
    - Цэвэр усны нөөцийг гамтай, зөв зохистой ашиглах
    - Байгалийн гамшиг болон хүний хүчин зүйлээс үүссэн гамшгийг бууруулах
    - Дэлхийн чинээлэг иргэдийн амьдралын хэв маягийн өөрчлөлт
    - Баялгийн тэгш хуваарилалт

*Унших материал:* Блүүм (2010), Хэнсен (2010), Орескес болон Конвей (2010).

## 2. Биоэтик

Агууламж: ЮНЕСКО –ийн Science Journalism Core Curriculum буюу Шинжлэх Ухааны Сэтгүүл Зүйн Гол Хөтөлбөр. UNESCO's Bioethics Core Curriculum буюу Биологийн судалгааны ёс зүйн гол хөтөлбөрөөс гаргасан Universal Declaration on Bioethics and Human Rights буюу Биологийн Судалгааны Ёс Зүй, Хүний Эрхийн Дэлхийн Тунхаг болон хүний эрхийн талаарх материалтай танилцаж түүнийг ашиглахад зориулсан. Зорилго нь био ёс зүйн талаар заах сургах бус харин энэ чиглэлээр сурч байгаа оюутнуудад ёс зүйтэй байх, цаашлаад био ёс зүйн асуудлаар мэдээ сурвалжлага бэлтгэх юм.

Universal Declaration on Bioethics and Human Rights буюу Биологийн Судалгааны Ёс Зүй болон Хүний Эрхийн Дэлхийн тунхаглалын нэгдүгээр бүлэгт эрүүл мэнд, амьдралын шинжлэх ухаан, технологи, нийгэм, хууль зүй, эдийн засаг, улс төрийн талаар мэдээлэл, нийтлэл бичих, цаашлаад ёс зүйтэй, үнэнч шударга тэр дундаа биологийн судалгааны ёс зүйтэй байх талаар дурьдсан байдаг.

ЮНЕСКО-гийн Био ёс зүйн хөтөлбөр нь эрүүл мэндийн чиглэлээр сурч байгаа оюутнуудад зориулагдсан ч сэтгүүл зүйн оюутнуудад мөн хамааралтай юм. ( UNESCO, 2008).
Шинжлэх ухааны сэтгүүл зүйг дэлхийн олон олон сэтгүүл зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлддэг их дээд сургуульд заадаггүй. ЮНЕСКО-ийн Шинжлэх Ухааны Сэтгүүл зүйн Хөтөлбөр нь:

> Өөр өөр соёлтой, түүх болон шашны өөр гарал үүсэлтэй олон улсын эрүүл мэндийн ажилтан, шийдвэр гаргагч, шинжлэх ухааны шинжээч, судлаач нарын мөрддөг ЮНЕСКО-гийн ёс зүйн зарчимд тулгуурласан зарчмуудыг агуулдаг юм.
>
> (UNESCO, 2008)

ЮНЕСКО-гийн Шинжлэх Ухааны Сэтгүүл зүйн Хөтөлбөрийн био ёс зүйн гарын авлага:

> Гол зорилго нь био ёс зүйн зөв зүйтэй ойлголт, сургалт, заах арга зүй. Энэ гарын авлага нь оюутан болон багш сурган хүмүүжүүлэгчдийг маш олон салбар төрөл чиглэлд мэдлэгээ өргөжүүлэхэд нь тус болох юм.
> (UNESCO, 2008, хуу. 5)

Дараагийн био ёс зүйн хэсэгт шинжлэх ухааны сэтгүүл зүйн оюутнуудад ёс зүйн чухал зарчмуудын талаар заана. Жишээ нь: Үүдэл эс, генетик туршилт, колоны аргаар эс үржүүлэх, хувийн, нууц болон эмзэг, хориглогдсон олон улсын судалгаа хийхгүй байх, хэн нэгнийг гутаан доромжлох, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахгүй байх, шударга ёс ба тэгш байдал зэрэг ЮНЕСКО-ийн био ёс зүйн тунхаглалын гурван бүлэгт байдаг дээрх зүйлүүдийн эсрэг ойлголт өгөх зорилготой юм.

Курсийн зорилго нь шинжлэх ухааны сэтгүүл зүйн оюутнуудыг нийгэмдээ хандсан мэдээ бэлтгэхдээ био ёс зүйн дээрх зарчмуудыг анхаарч, мөрдөж, дагаж ажиллахыг сургаж байгаа юм. Өөрөөр хэлбэл био ёс зүйн сэдвээр мэдээлэл бичихдээ сэтгүүлчид ЮНЕСКО-ийн дээрх зарчмуудыг анхаарч мэдээ бэлтгэх нь чухал юм.

Энэ хэсэгт ЮНЕСКО-ийн Universal Declaration on the Human Genome and Human Rights and UNESCO's Universal Declaration on Bioethics and Human Rights буюу Хүний Генийн Дэлхийн тунхаг болон Хүний эрх, Био ёс зүйн болон Хүний эрхийн тунхаг зэргээс суралцах болно. Энэхүү гарын авлагын сэтгүүл зүй болон шинжлэх ухааны сэтгүүл зүйн салбарт ЮНЕСКО-ийн био ёс зүйн хөтөлбөр тусгагдсан болно (2008). Шинжлэх ухааны сэтгүүл зүйн хөтөлбөрийн дэлгэрэнгүй нь дэлхийн ихэнх их дээд сургуулиудын сэтгүүл зүйн ангид заагддаг. Ялангуяа энэ хөтөлбөр нь эрүүл мэнд болон био ёс зүйн асуудлаар өдөр тутмын мэдээ бэлтгэдэг сэтгүүлчдийн чухал гарын авлага болоод байгаа юм.

Био ёс зүйн салбарт үзэх сэдэв:

- Сэтгүүл зүйн ёс зүй гэж юу вэ? Ихэнх хэвлэл мэдээллийн байгууллага, the International Organization of Newsombudsmen (Dvorkin, 2011) буюу Ньюсомбудсмений Олон Улсын байгууллагын гишүүдээр дамжуулж Олон  улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл зүйн ёс зүйн кодыг мөрддөг. Био ёс зүйн хувьд сэтгүүлчдэд маш их хүндрэл бэрхшээл тулгардаг. Сэтгүүлчид мэдээ бэлтгэхдээ био ёс зүйн зарчмуудыг мөрдөх шаардлагатай болдог. Жишээ нь, тэнцвэртэй үнэн зөв мэдээлэл, сонирхлын бүлгүүдийн дарамт шахалтнаас ангид, бие даасан, нийгмийн болон олон нийтийн эрх ашгийг хамгаалсан мэдээ нийтлэл бэлтгэхийг шаарддаг.
- Сэтгүүлчид эрдэмтэн судлаачдын хувьд мэдээ бэлтгэхэд био ёс зүй яагаад чухал вэ?
- Био ёс зүй дэх хүний эрх болон хүний эрхэм чанарын тухай тайлан (Бүлэг-3)

- Био ёс зүй дэх ашиг тус болон хор хөнөөлийн тухай мэдээлэх (Бүлэг-4)
- Био ёс зүй дэх бие даасан байдал болон хувийн хариуцлагын тухай мэдээлэх (Бүлэг-5)
- Био ёс зүй дэх хүлээн зөвшөөрөх (Бүлэг-6) болон хүлээн зөвшөөрөх чадваргүй хүний тухай мэдээлэх (Бүлэг-7)
- Хүний эмзэг байдал болон хувийн шударга байдлыг хүндлэх тухай мэдээлэх (Бүлэг-8). Сэтгүүлчид мэдээ бэлтгэхдээ яагаад эдгээр зүйлүүдэд анхаарах тухай дурьдсан.
- Био ёс зүй дэх хувийн нууц хадгалах байдлыг хүндлэх тайлан. Хувийн нууц хадгалах хил хязгаарыг хэвлэл мэдээллийн ёс зүй болон био ёс зүйн дэлхийн тунхагт заасан байгаа. (Бүлэг-9)
- Био ёс зүйн тэгш байдал шударга ёсны тайлан (Бүлэг-10)
- Био ёс зүй нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхахгүй байх болон хэн нэгнийг гутаан доромжлохгүй байх зарчмыг хүндэтгэх тухай тайлан (Бүлэг-11)
- Био ёс зүйн соёлын олон талт байдал, олонх цөөнхийг хүндлэх (Бүлэг-12)
- Био ёс зүйн эв санааны нэгдэл болон хамтын ажиллагаа (Бүлэг-13)
- Био ёс зүйн нийгмийн хариуцлага болон эрүүл мэнд (Бүлэг-14)
- Био ёс  зүйн ашиг тусыг хуваалцах (Бүлэг-15)
- Био ёс зүйн ирээдүй үеийг хамгаалах (Бүлэг-16)
- Био ёс зүйн хүрээлэн буй орчныг хамгаалах, амьтан ургамлын биологийн төрөл зүйл болон биосферийг хамгаалах асуудал (Бүлэг-17) Шинжлэх Ухааны Сэтгүүл Зүйн Хөтөлбөрийн Хүрээлэн Буй Орчин ба Цаг Уурын Өөрчлөлтийн тайланг үзэх.

Сургалтын материал: Био ёс зүйн үндсэн зарчим нь шинжлэх ухааны болон шинжлэх ухааны бус зүйлийн хоорондын харилцаан дээр тогтоно. Үүний талаар тодорхой ойлголтын дэлгэрэнгүйг хөтөлбөрийн 5-р бүлгээс харж болно. Дараагийн унших материал нь сэтгүүлчдийн био ёс зүйн сэтгүүл зүйн ойлголтын гарал үүсэл байдлаар ашиглагдаж болох юм. Мөн тухайн нийгэмдээ шинжлэх ухааны бус ойлголт болон үзэгдлийн жишээ болж болох юм. Гиббс (2008), МкЖий (2012), ЮНЕСКО (2011а), Ваухан (2012); ЮНЕСКО-гийн Био ёс зүй болон Хүний Эрхийн Олон улсын Тунхаглал, Хүний Геном болон Хүний Эрхийн Олон Улсын Тунхаглал, Хүний Генетик Мэдээлэл, Өгөгдлийн тухай Олон Улсын Тунхаглал (Universal Declaration on Bioethics and Human Rights, Universal Declaration on the Human Genome and Human Rights, and International Declaration on Human Genetic Data).

Кейс судалгаа: Био ёс зүйн энэ хэсэгт болон ёс зүйн хамгийн чухал хэсэг болох кейс судалгаануудыг дараах жишээнүүдэд хамруууллаа:
Яагаад өвчтэй хүний өвчний талаарх мэдээлэл сэтгүүлч болон сурвалжлагчдад хүндлэгдэж нууц байх ёстой вэ? Ялангуяа ДОХ болон сүрьеэ өвчнөөр өвчилсөн хүмүүсийн хувьд яагаад чухлаар тавигддаг вэ? Кейс судалгаагаар Өмнөд Африкийн шүүх өвчтэй хүний өвчний хувийн нууц нь хамгаалагдах эрхтэй болохыг баталгаажуулсан (Симпсон, 1996).

Тухайн шинжлэх ухааны холбогдолтой мэдээ нийтлэл “breakthrough” буюу хэдийгээр батлагдаж, туршигдаж, олны хүртээл болоогүй байхдаа нийгэмд олны итгэлийг авч шуугиан тарьсан үед сэтгүүлчид яаж тухайн сэдвийг сурвалжлах вэ? Тухайлбал:
1997 оны Өмнөд Африкийн Вироденегийн хэрэг буюу Преториягийн Их
- Сургуулийн эрдэмтэд туршигдаж, нотлогдож, батлагдаагүй үед ДОХ-ийн эсрэг эм бэлдмэл гарган авсан талаар олон нийтэд зарласныг хэвлэл мэдээллийн хэрэгсэл эцсийн үр дүнг сайн мэдээгүй, судлаагүй байж өлгөн авч зарласан. (Сидлей, 1997, хуудас. 450).
- Хүний stem cell буюу үүдэл эсийг клонийн аргаар үржүүлэн гарган авсан гэж өөрийгөө зарласан Хванг Вүү Сүкийн хэрэг. Түүний судалгааны материал Шинжлэх ухаан  сэтгүүл дээр хэвлэгдсэн. Гэсэн ч энэ нь худлаа мэдээлэл болох нь тогтоогдсон (Кенеди, 2006 онд уг нийтлэлийн дагуу эрэн сурвалжлага явуулж хүний үүдэл эсийг үржүүлсэн болох нь худлаа болохыг тогтоосон). Асуудлын гол нь шинжлэх ухааны сэтгүүлчид санаатай болон санаандгүй байдлаар судлаачдын маргааныг тэнцвэргүй мэдээлэх, мөн сэтгүүлч хаана ёс зүйгээ алдсаныг энэ жишээнээс харж болно.
- 1989 оны 3 сарын 23-нд Солт Лэйк Хотын Ютагийн Их Сургуульд болсон хэвлэлийн бага хурал дээр химич Стэнлий Понс болон Мартин Флейсшмэнн нар нь лабораторийн нөхцөлд, маш энгийн арга техникээр цөмийн нэгдэл (хайлш) гарган авснаа зарласан. (Палмер эт ал., 1989). Энэ мэдээг Их Британий Фанансил Таймс болон АНУ-ын Волл Стрийт Журнал сонины газар хамгийн түрүүн олонд мэдээлж шуугиан тарьж байсан.

> Волл Стрийт Журнал сонины газар дараагийн долоо хоногуудад хүйтэн цөмийн нэгдэл буюу хайлшны талаар цуврал мэдээ бэлтгэж, хамгийн сүүлийн үеийн технологийн хөгжлийн талаар тэргүүлэх нийтлэл бичиж, нийтэлж байсан. Ютагийн их сургууль хүйтэн цөмийн нэгдэл буюу хайлшийг худалдаж, борлуулахад Волл Стрийт Журнал сонинг ашигласан бол харин Волл Стрийт Журнал сонин борлуулалт болон захиалгаа нэмэгдүүлэхийн тулд хайлшийг ашигласан болж таарсан.
> (Парк, 2000, хуу. 15)

- 2012 онд профессор Тим Ноакес бага зэргийн устөрөгч нь чихрийн шижингийн эсрэг болон таргалуулахгүй байх үйлчилгээтэй болохыг баталсан гэж зарласан нь хэвлэл мэдээллийн байгууллага болон шинжлэх ухааны байгууллага өөрсдийнхөө нэр хүндийг хэрхэн амархан алдаж болохыг харуулсан юм. (Ноакес, 2012) Тухайн үед "Эрүүл мэнд 24" хэмээх спортын сэтгүүл хоёр хүн дээр туршилт явуулсан нь амжилттай болсон гэж зарлагдсан. Тим Ноакес олон шагнал хүртэж байсан нэр хүндтэй, спорт болон эрүүл мэндийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан байсан юм. Гэвч түүний хувьд харамсалтай зүйл болсон.

Тухайн хүн эд эрхтэнг хандивлах донор болсон эсвэл эд эрхтэн авах гэж байгаа тухай хувийн нууцын мэдээллийн хил хязгаар нь хаана байна вэ? Дэлхийн ихэнх улсуудын эрүүл мэндийн салбар эд эрхтэн хандивлагч болон хүлээн авагчийн талаарх тодорхой мэдээлэл, нэр усыг нууцлах хууль дүрэмтэй байдаг. Ийм хууль дүрэм байх нь зөв үү? Сэтгүүл зүйн оюутнуудын хувьд цаашид ийм төрлийн хэргийг хэрхэн яаж мэдээлэх, мэдээллийн эх сурвалжийг яаж олж авах талаар суралцах болно. Зүрх шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийсэн талаар 1967 оны 12 сард анх хэвлэл мэдээллээр цацагдаж шуугиан тарьж байжээ. Тухайн эд эрхтний донор болон хүлээн авагчийн хувийн нууцын тухай хил хязгаар, тэдгээрийн нэрсийг мэдэх гэсэн олон нийтийн сониуч байдлын хязгаар хаана дуусаж байна вэ? Өмнөд Африкийн эрүүл мэндийн сайд, доктор Манто Цхабалала-Мсимэнг 2007 онд элэг шилжүүлэн суулгах мэс засалд орсныг Сандэй Таймс сонин олонд ил болгосныг эсэргүүцэн эрүүл мэндийн сайд тухайн сониныг шүүхэд өгч байсан. Мөрдөн байцаалтын явцад түүний мэс заслын хувийн мэдээлэл эмнэлгээс хулгайлагдаж тухайн сонинд зарагдсан нь тогтоогдсон юм.

Яагаад сэтгүүлчдийн хувьд өвчтэй хүмүүстэй болгоомжтой харьцах, өндөр настай, залуу, хөгжлийн бэрхшээлтэй, өөр бусад өвчтэй хүмүүс тэдний эмзэг сэдэв болдог вэ? Сэтгүүлчид энэ талаар яаж сурвалжлах ёстой вэ?

Сэтгэл зүйн таагүй байдлаас болж нас барсан, амиа хорлосон, ялангуяа сэтгэцийн эрүүл мэндийн шалтгаанаас болж амиа хорлосон бол яаж мэдээ, сурвалжлага бэлтгэх вэ? Ийм тохиолдолд мөн хувийн нууцын хил хязгаар хаана байна вэ? Сэтгүүлчдэд зөвлөгөө өгөхөд:

> Дэлхийн 50 гаруй судалгаанд тухайн хүний эмзэг хувийн нууцыг бусдад ил болгосон мэдээлэл хэвлэл мэдээллээр цацагдсаны дараа амиа хорлох явдал нэмэгдсэн тухай үр дүн гарчээ. Тухайн хүний хувийн нууцын талаар гарч байгаа мэдээллийн үргэлжлэх хугацаа, давтамж, түүний нэр

төрд шууд халдсан зэргээс хамаарч амиа хорлох гэмт хэргийн тоо өссөн дүн байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр амиа хорлож буй хүний арга барил, график, сэтгэл хөдөлгөсөн дүрслэл олон давтамжтай, өргөн хүрээтэй цацалт, амиа хорлож буй байдлыг уран гоёор ойлгомжтой, сэтгэл хөдлөм байдлаар харуулах зэрэг нь амиа хорлох гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлдэг байна. Амиа хорлож байгаа байдлыг маш болгоомжтой, богинохон ч болов олон нийтэд үзүүлэх нь олон нийтийн сэтгэл санааг өөрчилж, хэн нэгэн сэтгэл санаагаар унасан, эмзэг, эрсдэлтэй байгаа, бусдаас тусламж хүссэн, ганцаардсан хүнийг амиа хорлоход уриалах, зоригжуулах алхам болдог байна.

Зовлон шаналал, өвчин зовлон, ядуу зүдүү байдал хүнийг эмзэг мэдрэмтгий болгодог. Энэ байдал нь ЮНЕСКО-гийн био ёс зүйн  хөтөлбөрийн гол анхаарах зүйл болоод байгаа. Сэтгүүлчдийн хувьд ажлаа хийж байхдаа зовлон шаналал, өвчин зовлон, ядуу зүдүү байдалтай байгаа хүмүүстэй хэрхэн ямар байдлаар харьцах вэ? Пулитцерын шагналт зурагчин Кевин Картер 1993 онд Өмнөд Суданд (иргэний дайнтай байгаа) шархаа дийлэхгүй нас барж байгаа нэгэн хүүгийн зургийг авахдаа арын фононд нь тас шувууны (сэг зэмээр хооллодог шувуу) зургийг оруулсан. Өөрөөр хэлбэл, энэ хүүхэд удахгүй нас бараад тэр тасын хоол болно гэдгийг зургаар өгүүлж чадсан. Ийм агууламжтай зураг хэзээ олон нийтийн анхааралд өртдөг вэ? Сэтгүүлчдийн хувьд хэн нэгний генетик мэдээллийн талаар мэдээ сурвалжлага бэлтгэж болох уу? Хэрэв тийм бол хил хязгаар нь хаана байна вэ? 2013 онд таван хүүхэдтэй, хар тамхины тариачин Хенрийтта Лэксийн хүүхдүүдийн ДНХ (гэнийн мэдээлэл)-г вакцин хийх зорилгоор хууль бусаар ашигласан нь олон улсад шуугиан тарьсан. Тухайн үед сэтгүүлч болон сэтгүүл зүйн ангийн оюутан Фулда болон Кайлен нар био ёс зүйн зөв алхам хийж, “Генетик туршилтын ирээдүйн ёс зүйн асуудал: олон нийтийн эрүүл мэндийн хэтийн төлөв” гэсэн нэртэй тухайн хууль бус, хүний эрхийг зөрчсөн вакцины асуудлыг хөндөж нийтлэл бичсэнээр дэлхийд шуугиан тарьж байлаа. (2006).

## Шинжлэх ухаан ба нийгэм: Шинжлэх ухааны дайн ба шинжлэх ухааны мэтгэлцээн

Шинжлэх ухааны сэтгүүлзүйн оюутнууд тухайн амьдарч байгаа орчин, нийгэмдээ байгалийн шинжлэх ухааны талаар мэтгэлцээн өрнүүлэх хэрэгтэй. Гэхдээ зорилго нь олон нийтийн шинжлэх ухааны талаарх мэдлэг, ойлголтын асуудлаар бус харин сурч мэдэж байгаа зүйлээ өргөжүүлэх, мөн сэтгүүлч болон сэтгүүл зүйн оюутнууд тухайн нийгэмд байгаа эрдэмтэд болон шинжлэх ухааны статус, шинжлэх ухааны нөлөөний талаар ойлголттой болох нь чухал юм. Жишээ нь:

- С.П. Снөүгийн хоёр өөр соёл иргэншлийн мэтгэлцээн (1959)
- Социбиологийн мэтгэлцээн (1975 оноос хойш). Дараах номуудаас үзээрэй. Вилсон (2000) болон Сегерстрэйл (2000).
- Постмодернизм ба нийгмийн шинжлэх ухаан болон байгалийн шинжлэх ухааны хоорондын дайн. Давкинс (2003), Сокал болон Брикмонт (1998a, 1998b).
- Шинжлэх ухааны дайн: Гросс болон Левиттс (1994), Сегерстрэйл (2000).

## 3. Эрдэмтэд болон хэвлэл мэдээллийн хоорондын харилцаа

Энэ курсээр шинжлэх ухааны асуудлаарх тодорхой ойлголт, ололт, мэдээллийг олон нийт хүлээн авахад эрдэмтэд ба хэвлэл мэдээллийн  хэрэгслийн үүрэг маш чухал талаар судална. Ялангуяа нийгэм дэх эрүүл мэндийн болон нийгмийн шинжлэх ухаанд гол үүрэгтэй талаар хөндсөн билээ.

- Эрдэмтэд яагаад бусадтай харилцах ур чадвараа нэмэгдүүлж, сайжруулах хэрэгтэй вэ?
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол үүрэг бол шинжлэх ухааны талаар баримт нотолгоотой үнэн зөв мэдээлэл өгөх.

Унших материал: Клаассен (2011), Хартз ба Чаппелл (1997), Нелкин (1995), Роуал Сошиати (1985, 2007).

## 4. Эрүүл мэндийн сурвалжлага

Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын дунд явуулсан судалгаагаар эрүүл мэндийн асуудал болон түүнтэй холбоотой түүх, нийтлэлүүд сонин интернэт уншигч, радио сонсогч, телевиз үзэгчдийн дунд хамгийн их анхаарал татаж, нийтэд дэмжигдэж, нэр хүнд амархан олдог гэсэн дүн гарчээ. Тиймээс эрүүл мэндийн сурвалжлага нь шинжлэх ухааны сэтгүүл зүйн хамгийн гол сэдэв бөгөөд сэтгүүлчид ач холбогдол өгөх ёстой юм. Энэ хөтөлбөрт дараах сэдвүүд багтана.

- Эрүүл мэндийн сурвалжлагын статистик өгөгдөл: Тайлбарыг энэ бүлгийн эхэнд дурьдсан байгаа (Эрүүл мэндийн сурвалжлагын статистик өгөгдлийг яаж ашиглаж сурвалжлага бэлтгэх вэ?) Унших материал: Кохн (1993), Бластланд болон Дилнот (2007), Паулос (1995)
- Эрүүл мэндийн сурвалжлагын ёс зүй: ДОХ, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, үүдэл эсийн судалгаа болон туршилт. Энэ бүлгийн хоёрдугаар хэсэгт био ёс зүйн сурвалжлага хэсгээс уншаарай.
- Амьдралын хэв маяг түүний нөлөө эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг сурвалжлах: Тамхи татах, дасгал сургуулилт, архины хэрэглээ, хар тамхины хэрэглээ, хоолны дэглэм, хэт таргалалт г.м.
- Эрүүл мэндийн үйлчилгээ болон эрүүл мэндийн шинжлэх ухааны чиг хандлага: Эрүүл мэндийн баталгааг хэрхэн яаж бүрдүүлэх вэ?
- Эрүүл мэнд дэх улс төрийн бодлого, шийдвэр: Улс төрийн бодлого, шийдвэр эрүүл мэндийн шинжлэх ухаанд хэрхэн нөлөөлж байна вэ?: ДОХ, үүдэл эсийн судалгаа, эрүүл мэндийн сан, тамхи, архи, амьдралын хэв маяг, хоол хүнсний хэрэглээний бодлого, хоолны дэглэм. Био ёс зүйн сурвалжлага гэсэн хэсгээс нэмж судлаарай.
- Эрүүл мэндийн дом: Шинжлэх ухааны бус болон шинжлэх ухаан гэсэн хэсгээс нэмж судлаарай.

## 5. Шинжлэх ухаан ба шинжлэх ухааны бус судалгаа

(Био ёс зүйн сурвалжлага хэсгээс нэмж судлаарай).

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд хамгийн их шүүмжлүүлдэг зүйл нь энэ салбарын ажилтнууд жинхэнэ шинжлэх ухааны баримт материал дээр тулгуурлаагүй, шинжлэх ухааны бус болон шинжлэх ухааны ололтыг хооронд нь ялгаж салгаагүйгээс алдаа гаргадаг. Оюутнуудын хувьд баталгаа, нотолгоотой шинжлэх ухааны баримт болон шинжлэх ухааны бус мэдээ мэдээллийг ялгаж сурах арга зүйд суралцах хэрэгтэй. Үүнд: шинжлэх ухааны нэрийг барьж олны анхаарлын төвд ордог Шинжлэх ухааны бус мэдээлэл багтана.

Энэ сургалтанд дараах жишээнүүд орно.

- Био ёс зүй болон шинжлэх ухааны бус (Био ёс зүй хэсгээс судал)
- Эвалюци, гарал үүсэл, ухаалаг дизайны мэтгэлцээн
- MMR буюу гахайн хавдар, салхин цэцэг, улаан бурхны вакцин болон жожгирох өвчний тухай мэтгэлцээн
- Өмнөд Африк болон бусад хөгжиж байгаа орнуудын ДОХ-ийн халдварын мэтгэлцээн
- Цаг уурын өөрчлөлтийг үгүйсгэх болон улс төрийн шийдвэр гаргах нөлөө, оролцоо

Унших материал: Форрест болон Гросс (2004), Голдакре (2008, 2012), Пигльючи (2010), Шапиро (2008), Сингх ба Эрнст (2008).

**Дүгнэх:** Шинжлэх ухааны сэтгүүл зүйн хөтөлбөрийн дүгнэх хэлбэрт дараах салбарууд орно.

- Шинжлэх ухааны бичлэг болон сурвалжлага-1 (хатуу мэдээ): 15 кредит/цаг.
- Шинжлэх ухааны бичлэг болон сурвалжлага-2 (асуудал хөндсөн өгүүлэл сурвалжлага): 15 кредит/цаг.
- Шинжлэх ухаан болон масс медиа: гүүр болох: 6 кредит/цаг
- Хүрээлэн буй орчин болон цаг уурын өөрчлөлтийн сурвалжлага: 6 кредит/цаг
- Сэтгүүлчдийн статистик: 6 кредит/цаг
- Шинжлэх ухаан ба нийгэм: Шинжлэх ухааны дайн ба мэтгэлцээн: 6 кредит/цаг
- Баримт нотолгоог дэнслэх: Шинжлэх ухаан ба шинжлэх ухааны бус болон шинжлэх ухааны арга зүй: 6 кредит/цаг
- Эм бэлдмэл ба эрүүл мэндийн салбар дахь био ёс зүйн сурвалжлага: 10 кредит/цаг

Бакалаврын болон бакалаврын дараах сургалтын хөтөлбөр нийт: 70 кредит/цаг
Хугацаа, давтамж: 28 долоо хоногийн давтамжтай. Нэг долоо хоногт 2.5 цаг.

Ном зүй болон нэмж уншиж судлах шаардлагатай материалын эх сурвалж (Үсгийн дараалаар) :

**Ном зүй болон нэмж уншиж судлах шаардлагатай материалын эх сурвалж (Үсгийн дараалллаар) :**

# Ном зүй:


Аделманн-Грилл, Б. С., Воксмэн, Б. Х. болон Крейцберг. Ж.В. 1995. EICOS: Тодорхой лабораторийн туршлага. Шинжлэх Ухааны Боловсролын Олон Улсын Холбооны үйл ажиллагааны танилцуулга, Барселона, 7-р сарын 21–23.

Бауэр, Х. Х. 1992. Шинжлэх ухааны боловсрол ба Шинжлэх ухааны аргын тухай. Урбана болон Чикаго, Ill.: Иллинойсын Их Сургуулийн Хэвлэл.

Бауэр, М. 2000. Соёлын үзүүлэлт ба хэвлэл мэдээллийн шинжлэх ухаан: хэвлэл мэдээлэлд анализ хийх контентын судалгаа. М. Дьюркэс болон С. вон Гроете (eds), Ойлголцол болон итгэлцлийн хооронд: Олон нийт, Шинжлэх ухаан болон Технологи, Амстердам: Харвүүд Академи, хуудас. 157–78.

Бластлэнд, Майкл болон Дилнот, Андрью. 2007. Тэр бол бар биш: Тоогоороо дэлхийд харагдаж байгаа. Лондон: Профл.

Блүүм, Арнолд Ж. 2010. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт: Чиглэлээрээ нэгдэх. Сандэрлэнд: Мд.: Синауэрын Холбоод.

Блам, Д., Кнадсон, М. болон Хэниг, Р. М. 2006. Шинжлэх ухааны бичигчдэд зориулсан гарын авлага. Оксфорд: Оксфордын Их Сургуулийн Хэвлэл.

Брэнд, Р. 2008. Тоон тоглоом: Өмнөд Африкын математикийн боловсолын кейс судалгааны сонин. Коммуникатой, Дугаар. 34, №. 2, хуудас. 210–21.

Бүччи, М. 1998. Шинжлэх Ухаан ба Хэвлэл Мэдээлэл: Шинжлэх Ухааны Харилцааны давуу чиглэл. Лондон: Рөүтлэдж.

Бүччи, М. 2004. Шинжлэх Ухаан ба Нийгэм: Шинжлэх ухааны нийгэм судлалын танилцуулга. Лондон: Рөүтлэдж.

Канадын Сэтгэцийн Холбоо. n.d. Амиа хорлолтын тухай бичихэд зориулсан хэвлэл мэдээллийн гарын авлага. www.cpa-apc.org/browse/documents/273.

Чопра, Дийпак. 1994. Квантюмын эдгэрэлт болон Агелесын бие, Мөнхийн оюун ухаан: Нью Уорк: Гурван Гол Хэвлэл.

Клаасэн, Г. Н. 1991. Шинжлэх ухааны бичлэгийн курсууд ба сэтгүүл зүй: сэтгүүлчдийн шинжлэх ухааны талаарх бичлэгийн ур чадварыг дээшлүүлэх арга болон замууд. Шинжлэх ухааны бичлэгийн өвөрмөц төрөл, Преториа: Шинжлэх Ухааны Хөгжлийн Төв, хуудас. 17–18.

Клаасен, Г. Н. 1995. Сэтгүүл зүй ба соёлын боловсрол – сэтггүүл зүйн оюутнуудын сургалтад зориулсан загварын чиг хандлага, Коммуникато, Дугаар 21, №. 1, хуудас. 12–20.

Клаасэн, Г. Н. 2001a. Шинжлэх ухааны мэдээлэл харилцаа: нийтийн боловсролын үйл явц. Африкийн Кардиоваскулар Сэтгүүл, Дугаар. 12, №. 4, хуудас. 249–50.

Клаасэн, Г. Н. 2001b. Сэтгүүлзүйн оюутнуудын сургалтын загварыг хайх нь. Экүюд Нови, Дугаар. 22, №. 1, хуудас. 3–24.

Клаасен, Жорж. 2011. Өмнөд Африкийн шинжлэх ухаан ба хэвлэл мэдээлэл: “бохир толь”-ны тусгал. Коммуникато, Дугаар. 37, №. 3, хуудас. 351–66.

Конн, Виктор. 1993. Мэдээ ба тоо: Эрүүл мэнд болон бусад салбар дахь статистикийн шаардлага ба маргалдааныг хэрхэн бичих гарын авлага. Эмэс, лова: лова Улсын Их Сургуулийн Хэвлэл.

Дэвиис, Ник. 2008. Хавтгай дэлхийн мэдээ. Лондон: Чатто ба Виндус.

Даукинс, Ричард. 2003. Постмодернизмыг илчилсэн нь. Латта Минон (ed.), Хорон санаатны санваартан: Ричард Даукинсын сонгосон эсээнүүд. Лондон: Виидэнфилд ба Николсон.

Ди Биир, А.С. болон Стиин, Э. 2002. Санифын ‘2002 Өмнөд Африкын үндэсний сэтгүүлзүйн ур чадварын аудит’. Экүюд Нови, Хуудас. 23, №. 1, хуудас. 11–86.

Дворкин, Жэффрии. 2011. Орчин үеийн мэдээний омбудсмэн – Хэрэглэгчийн гарын авлага. Toronto, Канад: Мэдээний Омбудсмэний Байгууллага.

Эдийн засаг ба нийгмийн судалгааны зөвлөл (ESRC). 1993. Таны дүгнэлтийн нүүр нуудас: ESRC-гийн судлаачдад зориулсан хэвлэл мэдээллийн удирдамж. Свиндон: ESRC.

Форрест, Барбара болон Гросс, Пол Р. 2004. Creationism’s Trojan Horse: Оюун ухааны загварын хэл. Оксфорд: Оксфордын Их Сургуулийн Хэвлэл.

Фулда, К. Г. болон Лайкэнс, К. 2006. Генетикийн урьдчилсан тест хийх ёс зүйн асуудлууд: олон нийтийн эрүүл мэндийн ирээдүйн төлөв. Эрүүл мэндийн сэтгүүл, Дугаар. 32, №. 3, хуудас. 143–7.

Гоббс, Нэнси (ed.). 2008. Клиникийн орон дээр төрөхөөс үхэх хүртэл: Сэтгүүлчдэд зориулсан Хастингийн биоэтикийн товч танилцуулга ном, Шийдвэр гаргагчид болон Компанит ажил зохион байгуулагчид. Нью Уорк: Хастингийн Төв.

Голдакр, Бэн. 2008. Муу шинжлэх ухаан. Лондон: Дөрөв дэх засаглал.

Голдакр, Бэн. 2012. Муу фарм: Мансуурлын компаниуд өвчтөн болон эмч нарыг хэрхэн төөрөгдүүлдэг вэ. Лондон: Дөрөв дэх засаглал.

Гросс, Пол болон Лэвиттс, Нормэн. 1994. Дээд зэргийн мухар сүсэгтнүүд: Шинжлэх ухаантай маргалдаж буй зүүний талынхан. Балтимори, Мд.: Жонн Хопкинсын Их Сургуулийн Хэвлэл.

Нэхсэн, Жэймс. 2010. Ач зээ нарын шуурга: Ирж буй уур амьсгалын хор хөнөөл ба хүмүүнлэг чанарыг хадгалж үлдэх сүүлчийн боломж. Нью Уорк: Блүүмсбари.

Хэртз, Ж. болон ЧаппэллІ, Р. 1997. Дэлхийгээс гадна: Америкын ирээдүйд Сэтгүүлзүй ба Шинжлэх ухааны хоорондын мөргөлдөөнийг хэрхэн тусгаж байна. Нашвилле, Тэнн.: Анхны Өөрчлөлтийн Төв.

Хэнстондхалф, D. 2008. Хэвлэл мэдээлэл ба нийгмийн онол. Лондон: Рөүтлэдж.

Кэннэдт, Доналд. 2006. Луйварыг хариулах нь. Шинжлэх ухаан, №. 314, 12-р сарын 1, хуудас. 1353 (түүнчлэн Хванг Воо Сүк эрэн сурвалжлах тайланг бүрэн эхээр нь

харна уу www.sciencemag. org/content/suppl/2006/11/28/314.5804.1353.DC1/Kennedy.12.1.06.SOM.pdf).

ЛиВэй, Саймон. 2008. Шинжлэх ухаан буруу явбал: Нээлтийн харанхуй булангаас ирсэн 12 мэдэгдэл. Лондон: Плам.

Маддокс, Жонн. 1983. ХДХВ-ийн айдас хэрэггүй. Байгаль, Дугаар. 302, №. 5911, хуудас. 749.

Мкжии, Глэнн. 2012. Биоэиткс: Эрүүл мэндийг хамгаалахын ёс суртахууны 60 кейс болон анхааруулга. Оксфорд: Жонн Вилей.

Мидавер,  П. 1963. ‘Шинжлэх ухааны бүтээлүүд хуурамч гэж үү?’ Сонсогч, Хуудас. 70 (9-р сарын 12), хуудас. 377–8.

Мюллер, М. А. 2012. Хуулийг шүүхээр тодорхой бусаар шүүн хэлэлцэх нь. Стэллэнбоч Хуулийн Сэтгүүл, Дугаар. 23, №. 3, хуудас. 599–609.

Нэлкин, Д. 1995. Шинжлэх ухааныг худалдах нь: Шинжлэх ухаан болон технологийг хэвлэлүүд хэрхэн нийтэлж байна. Нью Уорк: В. Х. Фриймэн.

Ноакэс, Тим. 2012. Зөв хоололтын санаанууд бүхий роман. Гүйгчдийн дэлхий, 3- сарын 20. www.runnersworld.co.za/nutrition/novel-dietary-ideas

Орэскэс, Наоми болон Конвэй, Эрик М. 2010. Даубтын Мэрчантс: Тамхи татахаас Дэлхийн дулааралын асуудал хүртэл үнэн болохыг шинжлэх ухаанчдын цөөн хэсэг нь хэрхэн бүрхэгдүүлж байна вэ. Нью Уорк: Блүүмсбюри.

Палмэнр, Ник, Кривит, Стэвэн болон Рюдижэр, Жонн. 1989. Ютагийн Их сургууль, Н-фишний хэвлэлийн бага хурлын тэмдэглэл. 3-р сарын 23. Шинэ эрчим хүчний цаг. Солт Лейк Хот, Ютай http://newenergytimes.com/v2/reports/ UUtahPressConference Transcript.shtml

Парк, Роберт. 2000. Вүүдүү Шинжлэх Ухаан: Худлаас үнэнд хүрэх зам. Оксфорд: Оксфордын Их Сургууль.

Паулос, Жонн Аллэн. 1995. Математикчид сонин уншдаг. Нью Уорк: Фэррэр, Страусс болон Гироукс.

Пигльюсси, Массимо. 2010. Стилтсийн тухай дэмий яриа: Банкаас шинжлэх ухаанд хэрхэн хэлэх вэ. Чикаго, Ill.: Чикагогийн Их Сургуулийн Хэвлэл.

Принслүү, Ж. А. 2006. Worstel Joernaliste om Syfers te Ontsyfer? ‘n Gevallestudie van ‘n Steekproef Suid- Afrikaanse Joernaliste se Syfervaardighede. Unpublished Master’s thesis. Стиллэнбосч: Стиллэнбосчийн Их Сургууль.

Амиа хорлолтын тухай мэдээлэх нь. Амиа хорлолтын тухай бичихэд зориулсан зөвлөмжүүд. http://reportingonsuicide.org/

Рояал Нийгэм. 1985. Шинжлэх ухааныг олон нийт ойлгох нь. Лондон: Рояал Нийгэм.

Рояал Нийгэм. 2007. Шинжлэх ухааны үзүүлэлтүүд ба олон нийт. Лондон: Рояал Нийгэм.

Сигэрстралэ, Уллика. 2000. Үнэнийг хамгаалагчид: Нийгмийн биологийн мэтгэлцээн. Оксфорд: Оксфордын Их Сургуулийн Хэвлэл.

Шапиро, Рөүз. 2008. Сакэрс: Алтернатив анагаах ухаан бид бүхнийг хэрхэн тэнэг болгодог вэ. Лондон: Хэрвилл Сэкэр.

Шукла, Р. болон М. Бауэр. 2007. Шинжлэх ухааны соёлын индекс (SCI): Бүтээн байгуулалт ба баталгаа. Европ болон Энэтхэгийн шинжлэх ухаан дахь амлалт, мэдлэг болон хандлагыг харьцуулан шинжлэх нь (зарчмын баримт бичиг). Лондон болон Дэли: Роял Нийгэм (Их Британи).

Сидлей, Пэт. 1997. Өмнөд Африкийн хэвлэлд ДОХ-ыг эмчлэх гайхамшгийн тухай. Их Британий Эмнэлэгийн сэтгүүл, Дугаар. 314, хуудас. 450.

Симпсон, М. А. 1996. HIV шинжлэх, ДОХ, болон голфийн курсыг нууцлах: ars muta, vita brevis. Хүнийг эмчлэх эрүүл мэндийн хамгаалал, Дугаар. 12, №. 1. www.humane healthcare.com/Article.asp?art_id=600

Сингх, Саймон болон Эрнст, Эдзард. 2008. Ур чадвар эсвэл Эмчилгээ: Шүүхийн тухай уламжлалт анагаах ухаан. Лондон: Бантам.

Сноу, С. П. 1959. Хоёр соёл. Кэмбридж: Кэмбриджийн Их Сургуулийн Хэвлэл. http://s-f-walk er.org.uk/pubsebooks/2cultures/Rede-lecture-2-cultures.pdf

Сокал, Элэн болон Брикмонт, Жиин. 1998. Оюун ухааны импортлогчид. Лондон: Танилцуулга номууд/Нью Уорк: Пидакор.

ЮНЕСКО. 1948. Биоэтик болон хүний эрхийн тухай олон улсын тунгаглал. http://unesdoc. unesco.org/images/0014/001461/146180E.pdf

ЮНЕСКО. 2008. ЮНЕСКО-гийн Биоэтикийн гол хөтөлбөр. Парис: ЮНЕСКО.

ЮНЕСКО. 2011a. Үр ашиг болон хор хөнөөлийн тухай кейс ном, Биоэтикийн гол хөтөлбөрийн кейс номын цуврал, №. 2. Парис: ЮНЕСКО.

ЮНЕСКО. 2011b. Хүний нэр хүнд болон Хүний эрхийн тухай кейс ном, Биоэтикийн гол хөтөлбөрийн кейс номын цуврал №. 1. Парис: ЮНЕСКО.

ЮНЕСКО. Хүний жином болон хүний эрхийн тухай түгээмэл тунхаглал. http://portal.unesco. org/en/ev.php- URL_ID=31058&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

ЮНЕСКО. Хүний генетикийн өгөгдлийн олон улсын тунхаглал. http://portal.unesco.org/en/ ev.php-URL_ ID=17720&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

Вайхан, Лэвис. 2012. Биоэтик: Зарчмууд, асуудлууд болон тохиолдлууд. Оксфорд: Оксфордын Их Сургуулийн Хэвлэл.

Вэйкфэлд, А .Ж. et al. 1998. Хүүхдүүдэд түгээмэл тохиолддог хөгжлийн эмгэг болох Ileal-lymphoid-nodular hyperplasia, non-specifc colitis. Лэнсэт, Дугаар. 351, 2-р сарын 28, хуудас. 637–41.

Вэбстэр, Ф. 2006. Мэдээллийн нийгмийн онолууд. Лондон: Рөүтлэдж.

Вилсон, Э. О. 2000. Социобиологи: Шинэ синтез, 20 дахь жилдээ зориулсан хэвлэлт. Кэмбридж, Масс.: Харвардын Их Сургуулийн Хэвлэл.

Байгаль орчин болон хөгжлийн дэлхийн хороо (1987) Бидний ирээдүй. Оксфорд: Оксфордын Их Сургуулийн Хэвлэл.



# ЖЕНДЕР БА СЭТГҮҮЛ ЗҮЙ

Доминик Рэйтт ба Эстелл Лебел

Энэ курс нь сэтгүүл зүйн салбар дахь жендер буюу хүйсийн харьцааны талаар авч үзнэ. Ялангуяа сэтгүүл зүйн салбарын оюутнуудад энэ салбарт хүйсийн тэгш бус хандлага байгааг нээн илрүүлж, өөрсдийн жендерийн талаарх хэвшмэл хандлагаа эрэгцүүлэн дүгнэх боломж олгох юм.

**Түвшин:** Энэ курс нь их дээд сургуулийн бакалаврын түвшинд мэдээ нийтлэл бичих зорилгоор хэрэглэгдэнэ.

**Курсийн тодорхойлолт:** Уг хичээлээр зөвхөн нийгэм болон эргэн тойронд бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа мэдээ нийтлэлд хүйсийн харилцаа ямар байгаа талаар үзэх болно. Ялангуяа удирдах түвшин, засаглалын асуудал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн менежмент хийхэд хүйсийн харьцаа ямар чухал гэдгийг судлах болно. Мөн бодлого тодорхойлох түвшинд ямар хүйс давамгай байгааг мэдэж авах болно.

**Төрөл:** Лекц, илтгэл, семинар

**Сургалтын хандлага:** Ихэнх улсын сэтгүүл зүйд хүйсийн харьцааны асуудлыг байнга хөнддөг. Тиймээс хэвлэл мэдээллийн салбарт жендерийн асуудлаар сургалт семинар болдог. Энэ курс оюутнуудад сэтгүүлчдийн дунд хүйсийн харьцаа ямар байгаа ялангуяа мэдээ баримт цуглуулах, хэн нэгэн эрх мэдэлтэнтэй уулзах, ер нь сэтгүүлчийн ажил хийхэд хүйс ямар чухал, яаж нөлөөлдөг зэргийг авч үзнэ.
Энэ курсийн гол зорилго нь тухайн нийтлэлд эрэгтэй болон эмэгтэй хүний дүр, тэдгээрийн дуу хоолой хэрхэн тусгагдаж байгаа, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн оролцоо, тэдгээрийн тэнцвэрт байдлын талаар судална.

# Сургалтын хүрээ:

**Сэдэв 1: Жендерийн ойлголт**

Жендерийн асуудал нь тухайн улсын соёл, хүмүүсийн нийгмийн үүрэг роль, боломж, олон нийтийн болон хувийн харилцаан дээр байнга гарч ирдэг. Хүйсийн тэгш байдал нь хүний амьдралын салшгүй нэг хэсэг, хүмүүс хоорондын итгэл, хүлээлт, найдварын ойлголт юм. Эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн хувьд жендер гэдэг нь тэс өөр ойлголт мөн өөр үүрэг рольтой.

**Сэдэв 2: Сэтгүүл зүйн нөлөө: Лейсбет Ван Зүүнэн (1994, ху. 48) сэтгүүл зүй бол жендер**

Хэвлэл мэдээллийн салбарын удирдах түвшний болон төлөөлөн удирдах зөвлөлийн түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага байдаг. Энд зөвхөн эмэгтэйчүүдийн тоог биш, харин тэдний хэвлэл мэдээллийн салбарт эзлэх үүрэг роль бага байгаа тухай ярьж байгаа юм. Барууны орнуудад сүүлийн хэдэн жил хэвлэл мэдээллийн салбарт ажиллах эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн. Гэхдээ продакшны түвшинд тэд цойлж гарах нь харагдахгүй байна. Глобал Медиа Мониторинг Төсөл (GMMP, 2010) судалгааны байгууллага 126 өөр өөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр Өмнөд Африкийн хэвлэл мэдээллийн байгууллага дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн талаар нэгэн сонирхолтой судалгаа хийсэн байна. Тэдгээрийн 15-ийн 14 нь Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэгийн орнуудад үйл ажиллагаа явуулж байна.

**Сэдэв 3: Жендерийн тухай хэвшмэл ойлголт ба хандлага**

Жендерийн тухай хэвшмэл ойлголт ба хандлага нь хэвлэл мэдээллийн салбар дахь эмэгтэйчүүдэд саад тотгор болдог. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаанаас хамаарч байгаа юм. Жендерийн хандлага нь хэн нэгнийг буруутгах эсвэл зан байдлыг засах гэсэн үндсэн хоёр хандлага нийтлэг ажиглагддаг. Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс ямагт мэдлэг доогуур юм шиг

харагддаг. Өөрөөр хэлбэл, дэлхийн аль ч хэвлэл мэдээлэлд эрчүүд, эмэгтэйчүүдээс анализ дүгнэлт хийж байгаа байдлаараа, нэр хүндээрээ илүү, мөн илүү олны танил болж харагддаг. Глобал Медиа Мониторинг Төслөөс хийсэн судалгаагаар дэлхийн хэмжээнд нийт эх сурвалжийн 24 хувь нь л эмэгтэйчүүд байдаг. Харин Африкийн бүс нутагт бол бүр 19 хувь нь эмэгтэй байдаг. (GMMP 2010)

Энэ статистик бол маш чухал юм. Учир нь сэтгүүл зүйн мэргэжил гэдэг бол өөрөө үнэнийг илэрхийлдэг институци юм.

**Сэдэв 4: Мэдээний сонголт ба захирах ёс**

Мэдээний бүтэц болон сонголтыг хийхдээ жендерт суурилсан өвөрмөц соёлтой улс орнууд байдаг. Энэ нь жендерийн асуудал юм. Эрчүүдийн хувьд мэдээний сонголт өөр байдаг. Эмэгтэйчүүдийн хувьд мөн өөр байдаг. Жишээ нь эрэгтэй хүн сонирхдог зүйлийнхээ талаар мэдээ бэлтгэж байдаг. Эмэгтэйчүүд ч мөн адил (Мэйд ба Лове-Морна, 2009).

Эмэгтэйчүүдийн сонгож авч  бэлтгэж байгаа мэдээ хүчирхийлэл, дайн, мөргөлдөөн багатай байдаг бол эрчүүдийнх эсрэгээрээ байдаг.  Мөн эмэгтэйчүүдийн сонгон авч бэлтгэж байгаа мэдээ илүү зөөлөн, аядуу, сэтгэлийн хөдлөлтэй, хүүхдийг гэсэн, илүү нийгэм рүүгээ хандсан байдаг. Эмэгтэй сэтгүүлчийн мэдээ хулгай дээрэм, авто машины осол, улс төр, нийгмийн асуудал гэхээсээ илүү эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг ялангуяа хүчингийн эсрэг,  гэр бүлийн хүчирхийллийн эсрэг давамгайлсан байдаг. Жишээ нь, эмэгтэй сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээнд бүсгүй хүн ямарваа нэг хүчирхийллээс эрүүл энх, амьд гарсан гэхээсээ илүүтэйгээр хохирогч байдлаар мэдээлэгддэг (Ромито, 2008). Өөрөөр хэлбэл, үзэгчдийн хувьд эмэгтэй хүнийг өрөвдүүлэх, тэднийг хүнд хүчир амьдрал туулж байгаа байдлаар харагдуулдаг.

**Сэдэв 5: Хэвлэл мэдээлэлд хэрэглэдэг хэл**

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ихэнх үг хэллэгийн утга эмэгтэйчүүдийг хүйсээр гадуурхах өнгө аястай буудаг. Европын ихэнх хэлэнд жендер гэдэг үг нь захирангуй утгатай байдаг. Люксенбург, Швейцарь, Франц, Бельги, Канад зэрэг орон эмэгтэй хүнийг хүйсээр нь гадуурхахын эсрэг тусгай толь буюу үгийн сантай. Гэхдээ хэвлэл

мэдээллийн төрлийн ихэнх хэлэнд эрэгтэйлэг буюу спорт, дайчин гэсэн метафор буюу зүйрлэл түгээмэл хэрэглэгддэг байна.

Хэвлэл мэдээллийн салбарын хэллэгт эмэгтэйчүүд болон эрчүүдийн ажил үүргийн талаар аль болох зөөлрүүлсэн байдлаар хэрэглэх нь олонтой. Жишээ нь, эмэгтэй сэтгүүлч элэнц хуланц гэхийн оронд өвөг дээдэс, галтай тэмцэгч гэхийн оронд гал сөнөөгч. Харин эрэгтэй сэтгүүлч зочид буудлын ажилтан гэхийн оронд зочид буудлын үйлчлэгч, цэвэрлэгч гэхийн оронд үйлчлэгч, гэр цэвэрлэгч гэхийн оронд гэрийн үйлчлэгч, секс ажилтан гэхийн оронд биеэ үнэлэгч гэх мэт.
(Интер Пресс Сервис, 2010)

**Сэдэв 6: Эмэгтэйчүүд болон өсвөр насны охидод зориулсан сэтгүүлүүд нийгэм дэх эмэгтэйчүүдийн дүр төрхийг харуулдаг**

Хэвлэл мэдээллийн редакцийн бүтээл болон реклам сурталчилгааны захиалгад жендер нөлөөлдөг. Жишээ нь: загварын ертөнц болон сайхан бүсгүйчүүдийг хэвлэсэн сэтгүүлийн борлуулалт сайн, худалдан авагчид нь голдуу эрчүүд (Карон, 2003).
Харин эмэгтэйчүүдийн сонирхол бол хоол унд, дотоод засал чимэглэл, косметик, хувцас загвар, үс арчлал, эрүүл мэнд байдаг. Тусгай студидэд будуулж, янзлуулж сэтгүүл дээр гарсан зураг ямар ч хүний нүдэнд хуурамч харагддаг ч эмэгтэй хүмүүс тийм болохыг хичээх эрмэлзэл төрдөг. Түүнчлэн уншигч, үзэгчдийн хувьд арьсны өнгө бас чухал. Жишээ нь, ихэнх уншигч Европ гаралтай цагаан арьстай эмэгтэй хүнийг харах сонирхолтой бол Африк гаралтай буюу өнгөт арьстай эмэгтэй хүнийг харах сонирхол арай бага байдаг ажээ. Өөрөөр хэлбэл ихэнх хүмүүс цагаан арьстай хүмүүсийг сайхан эмэгтэйд тооцдог.
"Өмнөд Африкийн жендер ба зар сурталчилгаа" (Лове Морна ба Ндлову, 2007) нэртэй сонирхолтой судалгааны үр дүнгээс танилцуулъя. Үүнд:

- Эмэгтэйчүүд мэдээний эх сурвалж болсноос зар сурталчилгаанд оролцохыг илүүд үздэг. (Эмэгтэйчүүдийг сонсохоор нэг хар)
- Настайвтар эмэгтэйчүүд зар сурталчилгаанд зохидоггүй.
- Эрчүүд бол эрч хүч, эрх мэдлийн дуу хоолой
- Худалдан авагч, хэрэглэгч үзэгчид сонголтоо хийхдээ зар сурталчилгаанаас бус харин хүйсээс хамаарч сонголтоо хийдэг.

**Сэдэв 7: Сэтгүүлчид улс төр дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй өөрөөр ханддаг**

Улс төр болон бизнест эмэгтэйчүүдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээ бэлтгэхдээ ялгаатай хандлага гаргадаг. Жишээ нь, улс төрч эмэгтэй байлаа гэхэд юу өмссөн байна, ямар харагдаж байна гэх мэтээр түүний улс төрийн үзэл бодол, туршлага, чадвар, зорилго гэхээсээ илүү хувийн байгаа байдал, гэр бүлийн байдалд илүү анхаарлаа хандуулдаг.

Дэлхийн аль ч улс оронд улс төр болон нийгмийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоо эрчүүдээс бага байдаг. Тэгэхээр аль ч салбарт юу ч хийдэг байсан хүйс маш чухал үүрэгтэй.

Макро эдийн засгийн бодлого, төсөв, худалдаа, бизнес зэрэг дэх хүйсийн харьцаа нь бодлого тодорхойлогчид, хэвлэл мэдээллийн шийдвэр гаргагчид болон оролцогчдын хувьд ойлгомжгүй байдаг  (Лове-Морна, 2006, хуудас. 6). Жишээ нь: Ихэнх салбар тэр дундаа хэвлэл мэдээллийн салбар нүүрэн дээрээ ажилтны хүйсийн харьцаа тэгш байна гэдэг боловч үнэн хэрэгтээ хүйсийн харьцаа байнга алдагдаж байдаг. Мөн хүйсээс хамаарч тэдний бизнес урагшилж байдаг.

**Сэдэв 8: ТВ сэтгүүл зүй нийгмийн бүтээн байгуулалтад хамгийн ихээр нөлөөлдөг**

Хөгжингүй орнуудад ихэнх үзэгч гол мэдээллээ телевизээр авдаг. Харамсалтай нь телевизээр цацагдаж байгаа мэдээ, нэвтрүүлэг болгон үнэн зөв, бодит хэрэгтэй мэдээлэл байдаггүй.

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байгаа ихэнх эмэгтэй нас явсан хойноо удирдах албан тушаалд очдог (Мейд ба Лове-Морна, 2009). Жишээ нь, Өмнөд Африкийн хэвлэлийн салбарын удирдах албан тушаалд ажиллаж байгаа хүмүүсийн дөнгөж 23 хувь нь эмэгтэй. Энэ нь эмэгтэй хүмүүс чадваргүйдээ биш мэргэжлийн тэгш бус байдал хэвлэл мэдээллийн салбарт байсаар байгаа бэлэн жишээ юм. Өмнөд Африкийн Сити Пресс сонины ерөнхий эрхлэгч Фериал Хаффежийн үзэж байгаагаар хэвлэл мэдээллийн салбарын удирдлага болон эздийн дараагийн давалгаа бол эмэгтэйчүүд. Монополь бага жижиг зах зээлтэй Баруун Африкт эмэгтэйчүүд өөрсдийн гэсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болсон. Хэрвээ эмэгтэй хүн хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшиж л байгаа бол нийгэмдээ маш том нөлөө үзүүлнэ.

## Сэдэв 9: Хөгжингүй орнуудад радио сэтгүүл зүй зах зээлээ алдаж эхлээд байна

Ихэнх радио хүмүүсийн үзэл бодол, сэтгэгдэл, дуу хөгжим, энтертэймэнт нэвтрүүлэг цацдаг. Харин өрсөлдөөнд тэр болгон хол явж чаддаггүй радионууд эмэгтэйчүүдийг доромжилсон нэвтрүүлэг, сэтгэгдэл цацдаг. Гэхдээ энэ нь газар авдаггүй.

Хөгжиж буй орнуудын хөдөө орон нутагт радио бол мэдээлэл авах хамгийн чухал эх сурвалж болдог. Радиогийн хувьд эмэгтэйчүүдтэй холбогдолтой мэдээ нэвтрүүлэг төдийлөн газар авдаггүй бол эрчүүдтэй холбоотой мэдээ нэвтрүүлэг хамгийн сайн нэвтрүүлэг нь юм. Тэгэхээр эмэгтэйчүүдийн хувьд  зарим тохиолдолд ялгаварлан гадуурхагдах тохиолдол бий. Учир нь байгалиасаа тэдний хоолойны өнгө эрчүүдийнхтэй харьцуулахад маш чанга байдаг.

Хүйн радио нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд өргөмөл хүүхдийг санагдуулдаг. Учир нь аль хэдийнэ зах зээлээс шахагдсан тул ажилчид нь голдуу сайн дурынхан эсвэл дадлагажигчид байдаг. Хот суурин газрын хүмүүс арилжааны буюу FM радиог илүүтэй хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, зөвхөн хөдөө орон нутгийнхан орон нутгийн радиог, хотын хүмүүс арилжааны радио сонсдог байна.

## Сэдэв 10: Ирээдүй

Техник технологи хөгжихийн хэрээр сэтгүүл зүйн хэлбэр маш хурдтай өөрчлөгдөж байна. Жишээ нь, нийгмийн мэдээллийн сүлжээ. Энэ нь их ашиг олдог гэхээсээ илүүтэйгээр инноваци буюу шинийг санаачилж өдөр ирэх тутам шинэ технологи нэвтрүүлэх болжээ. Мөн интернет хувьсгал мэдээлэл авах маш том хэрэгсэл болж байна. Мэдээлэл авахад хүндрэлтэй эсвэл мэдээлэл үнэгүй авахад төвөгтэй улс оронд ч гэсэн интернэтээр дамжин мэдээлэл авах боломжтой болсон.

Мэдээллийн технологи хөгжсөнөөр өвчин зовлонтой хүмүүс, жендерийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс бие биетэйгээ харьцан нэгдсэнээр эрх баригчдад дуу хоолойгоо хүргэж байна.

Гэхдээ энэ их мэдээлэл дундаас яг аль нь хэрэгтэй, эсвэл аль нь ПиАр мэдээлэл болохыг ялгаж салгахад хэцүү.

Зарим эмэгтэй сэтгүүлч тухайн улс орон, нийгэмдээ маш сайн ажилладаг. Гэвч зарим тохиолдолд тэд гэмт хэрэг, хүчирхийлэл, аллагын золиос болж байна. Жишээ нь, Иракт маш олон эмэгтэй сэтгүүлч хүчирхийллийн золиос болсон. Хил хязгааргүй нийтлэгчдийн мэдээлсэнээр; Иракт олон эмэгтэй сэтгүүлчид хүчирхийллийн золиос болж байгаа бөгөөд 2003-2011 оны хооронд 12 эмэгтэй сэтгүүлч амь насаа алджээ. Египетийн Тахрир талбай дээр барууны хоёр эмэгтэй сэтгүүлч хүчирхийлүүлсэн. Энэ явдал нь олон нийтийн, ялангуяа эмэгтэй сэтгүүлчдийн эсэргүүцэлтэй тулгарсан юм.

(Сторм ба Виллиамс, 2012 -оос харна уу)

# Ном зүй

Акер, Жоан.1990. Шатлал, ажлын байр, байгууллага: Жендерийн байгууллагын онол. Жендэр ба Нийгэм, Хэсэг. 4, № 2, хуу. 139–58.

Аргентиний Харилцаа холбоо болон Иргэний Холбоо. Жендер ба Сэтгүүл зүй, баримтат цуврал, Аргентин (www. artemisanoticias.com.ar) Аустин, Ж.Л. 1962.

Аустин, Ж. Л. 1962. Үгээр бид хэрхэн хийх вэ?: 1995 оны Харвард Их Сургууль дээр Уильям Жамесийн лекц. Оксфорд: Оксфорд Хэвлэлийн Их Сургууль.

Бэаувойр, Симоне Де. 1949/1986. Хоёрдахь бэлгийн харьцаа, 2 Хэсэг. Парис: Галлимард.

Бэаувойр, Симоне Де.. 2011. Хоёр дахь секс, транс. С. Борди болон С.Маловани-Чеваллиер. Нью-Йорк: Винтаж.

Берени, Лауре, Чаувин, Себастиан, Жаунайт, Александр болон Ревиллард, Анне. 2008. Аюукс жендерийн судалгааны танилцуулга: Жендерийн судалгааны гарын авлага. Брусселё: Де Боек.

Бисиллиат, Ж. 2000, 1997. Эмэгтэйчүүдийн асуудлын төлөөх тэмцэл ба хөгжил: үйл явдлын хэтийн төлөв. Ж. Бисиллиант ба С. Версчуур, Жендер: Зайлшгүй шаардлагатай арга хэрэгсэл. Асуудлын танилцуулга. Парис/Женев: Л. Харматтан, хуу. 19–29.

Батлер, Жудит. 1990. Жендерийн хүндрэл, бэрхшээл: Феминизм буюу Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалт ба мөн чанарыг үгүйсгэх. Нью-Йорк болон Лондон. Роутледж.

Батлер, Жудит. 2004. Жендерийг үгүйсгэх. Нью-Йорк болон Лондон: Роутледж.

Батлер, Жудит. 2005. Жендерийн хүндрэл бэрхшээл: Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалт ба мөн чанарыг үгүйсгэх, транс. С. Краус. Парис: Ла Десоуверт.

Батлер, Жудит. 2006. Жендер унахад транс. Максим Сервулле. Парис: Амстердамын хэвлэл

Канн, Дэвид Ж. болон Мохр, Пилип В. 2001. Австралийн Телевизийн мэдээнд жендерийн эх сурвалж ба сэтгүүлч. Радио, телевиз болон Цахим мэдээллийн хэрэгслийн сэтгүүл, хуу. 162–74.

Карон, Ж. 2003. Засгийн газрын Эрүүл Мэндийн Судалгааны бодлогын дэмжлэгээр жендер эсвэл хүйс нь ялгаатай ойлголт болохыг тодорхойлсон тайлан. Оттава, Онт.: Эрүүл мэнд ба Жендерийн Институт.

Чабаунд-Ричтерм, Данэйлле, Дескоутурес, Виржини, Дэврекс, Анне-Мэри болон Варика, Элени. 2010. Жендер нийгмийн шинжлэх ухааны хүрээнд. Дахин судлах: Де Макс Вебер а Бруно Латоур. Парис: Дисковери Хэвлэл

Коуломб-Гулли, М. 2011. Хэвлэл мэдээлэл. Энэ чиглэлийн салбар. Нийгмийн шинжлэх ухаан, №. 83.

Дамиан-Гайллард, Беатрис, Фрискю, Кеголене болон Сайтта, Эюгеней.2009. Жендерийн сэтгүүл зүй:Асуудлыг шийдвэрлэх. Харилцаа, холбооны асуудал №. 15, хуу. 175–201.

Давидс, Т. болон Ван Дриэл, Ф. 2005. Дэлхийн Жендерийн асуудал: Практик хэрэглээ болон Хэтийн төлөвийн өөрчлөлт. Алдершот: Ашгэти.

Джерф-Пэйрри, Моника. 2007. Сэтгүүл зүйн жендер: 20-р зууны үйл ажиллагааны цар хүрээ, түүний учир зүй, бүтэц: Нордиком хэлэлцүүлэг. Хэсэг.28, хуу.81–104.

Дорлин, Э. 2009. Хүйс, Арьс өнгө, Анги.Танин мэдэхүйн онол давамгайлсан. Парис: Францын Хэвлэлийн Их Сургууль.

Галлагхер, Маргарет. 1997. Хэвлэл мэдээллийн салбар дах эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт: Түүх нь дуусаагүй. Парис: ЮНЕСКО

Галлагхэр, Маргарет. 2001а. Жендерийн эргэн тойронд: Хэвлэл мэдээллийн хяналт, хамгааллын тухай шинээр хэлэлцэх асуудал. Лондон: Зэд

Галлагхэр, Маргарет. 2001б. Сэтгүүл зүй ба Жендерийн тухай нийтлэл. Яагаад маш цөөхөн эмэгтэй хүмүүс удирдах албан тушаалд очдог вэ? (Нэймэний тайлан). www.nieman.harvard.edu/reportsitem.aspx?id=101542

Галлагхэр, Маргарет. 2002. Хэвлэл мэдээллээр ардчилсан нийгэм дэх эмэгтэйчүүдийн эрх чөлөөний эрэлд . Хөгжил дэвшилд: "Хэвлэл мэдээллийн хэрэгслийг эмэгтэйчүүдийн эрх мэдлийг олж авах, тэдний оролцоог нэмэгдүүлэх нэг хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь" шинжээчдийн уулзалт. Бейрут, Лебанон. 11 сарын 12-15. НҮБ, Эмэгтэйчүүдийн эрх ашгийг сайжруулах хэлтэс (DAW).

Гарсия, Мэри-Кармен болон Меркадер, Патрисия. 2004. Жендерийн феминизм, эмчилгээний цагаачлалын хэвлэл мэдээллийн хөдөлгөөн. MEI №. 20, Бэлгийн харилцаа, холбоо: Л'Харматтан.

Гаунтлетт. Д. 2008. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба жендерийн мөн чанар: Танилцуулга. Лондон ба Нью-Йорк: Роутледж.

Гилл, Р. 2007. Жендер ба Хэвлэл мэдээлэл. Малден. Масс: Засгийн газрын хэвлэл.

Глобал Хэвлэл мэдээллийн Хяналтын Төсөл. (GMMP). 2010. "Африкийн Хэвлэл мэдээллийн Хяналтын Төсөл 2010" орон нутгийн тайлан. Торонто: Христийн харилцаа холбооны Дэлхийн Нийгэмлэг (WACC). http://whomakesthenews.org/images/stories/restricted/regional/Africa.pdf.

Хардин, Мэри болон Вайтсайд, Эрин. 2009. Хэвлэл мэдээллийн редакцийн жендерийн эргэн тойронд: Сэтгүүл зүй: Хэсэг. 10, №. 5,хуу. 627–46.

Интер Хэвлэлийн Үйлчилгээ. 2010. Жендер ба 3-р хэвлэлийн тайлбар толийн хөгжил. Банкок: ИПС. www.ips.org/mdg3/GenderandDevelopmentGlossary.pdf

Косут, М. 2012.Хэвлэл Мэдээллийн Жендерийн нэвтэрхий толь. Лондон: Сэги.

Лебел, Э. 2002. хэвлэл мэдээллийн хэрэгслээр Нийгмийн өөрчлөлтийн төлөө дэлхийн эмэгтэйчүүд. Насанд хүрэгчдийн боловсрол, эмэгтэйчүүдийн тухай бичиг баримтын төв. Феминист судалгаа, Хэсэг. 15, №. 1, хуу. 159–63.

Лебел, Э. 2005. Патриарх буюу эцгийн эрхт ёс, Феминист судалгаа. Хэсэг. 18, №. 2, хуу.1–8.

Линд, Р. А. 2012. Арьс өнгө/Жендер/Ангилал/Хэвлэл мэдээлэл, 3 дахь хэвлэл. Чикаго, Ill.: Илинойсын Хэвлэлийн Их Сургууль.

Лове-Морна, С. 2006. Ер бусын бизнес: Жендер ба Эдийн засгийн тайлан. Йоханесбург: Жендерийн Холбоо.

Лове Морна, С. болон Ндлову, С. 2007. Өмнөд Африкийн Зар сурталчилгаа ба Жендер. Йоханесбург: Жендерийн Холбоо.

Люнинборг, М. болон Майе, Т. 2013. Хэвлэл мэдээллийн Жендерийн судалгаа. Стютгарт, Герман: ЮТВ.

Мэйди, Р. болон Лове-Морна, С. 2009. Шилэн дээвэр буюу Эмэгтэйчүүдийг тэргүүнд гаргахгүй гэсэн үзэл: Өмнөд Африкийн Хэвлэл Мэдээллийн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд. Виндхоек: Жендерийн холбоо.

Медиас: Энэ чиглэлийн салбар. 2011. Нийгмийн шинжлэх ухаан. Мирайлын хэвлэлийн их сургууль.  Хэвлэл мэдээлэл болон жендерийн хяналт.  Хэвлэл мэдээлэл болон Хулуь зүйн хөтөлбөр. http://waccglobal.org/en/resources/media-and-gender-monitor.html

Мелин-Хайггинс, Маргарета. 2004. Сэтгүүл зүйн хавчигдал: Хэвлэл мэдээллийн редакцийн соёлын жендер. Жендер ба Хэвлэл мэдээллийн редакцийн соёл. Ажил дээр ялгах шинж тэмдэг.  Крисскил, Н.Ж.: Хамптон Хэвлэл, хуу. 197–222.

Менессон. 2005. Дэлхийн эмэгтэйчүүд. Жендерийн тэнцвэрийг бий болгоход спортын нөлөө. Парис: Л'Харматтан.

Мосисдоттир, Л. болон Эрлингдотттир, Р. 2004.  Европыг хөндлөн тархсан үг:  Улс төрийн болон бодлогын төсөлд жендерийн зонхилох хандлага. Олон улсын улс төрийн феминист сэтгүүл. Хэсэг. 7 №. 4

Оливеси, Аурелие. 2012. Дур булаам байхын нөлөө? Жендер ба улс төрийн сэтгүүл зүйн хэлэлцүүлэгээс. Тулуз: Мирайлын Хэвлэлийн Их Сургууль.

Судалгааны төв. 2005. Жендерийн үзэл баримтлал: Эмэгтэйчүүд сэтгүүлчид эх сурвалжийг хөндөхийг хүлээж байдаг. www.journalism.org/node/141

Робинсон, Г. 2005. Жендер, Сэтгүүл зүй ба Өөрийн хөрөнгө: Канад, АНУ болон Европын хэтийн төлөв. Кристкилл, Н.Ж.: Хамптон Хэвлэл.

Робинсон, Жертрүд. Ж.Сэтгүүл зүйн судалгаанд феминист хандлага: Канадын хэтийн төлөв. Глобал Хэвлэл мэдээлэл болон сэтгүүл-Канадын хэвлэл. Хэсэг . 1, №. 1, хуу. 123–36.

Ромито, Патризиа. 2008. Нам гүм байдлыг бий болгох: Хүүхэд, эмэгтэйчүүдийн нуугдмал хүчирхийллийн эсрэг: Бристол: Бодлогын хэвлэл.  www.feministes-radicales.org/wp-content/uploads/2010/11/Patrizia-Romito-A-Deafening-Silence.-Hidden-Violence-Against-Women-and-Children.pdf

Росс, К. 2010. Хэвлэл мэдээллийн жендер: Эмэгтэйчүүд, Эрчүүдийн хооронд улс төрийн ялгаатай бодлого. Ланхам, Мд: Ровман ба Жижиг талбар.

Сэрджениан, Эвэлине. 1997. Эмэгтэйчүүд ба хэвлэл мэдээлэл. Парис: Л.Харматтан.
Сторм, Х. болон Улъяам, Х. 2012.  Эмэгтэй хүнд газар үгүй:  Эмэгтэй илтгэгчдийн өмнө тулгарах асуудал. Лондон: Олон улсын Мэдээний Аюулгүй байдлын Институт (ИНСИ).

Хэвлэл мэдээллийн цаг. 2009. Эмэгтэйчүүдээс шалтгаалах нь, №. 12. Парис: Шинэ Дэлхийн хэвлэл.

Тусан, М. Э. 2005. Эмэгтэйчүүдийн талаар мэдээ бэлтгэх нь: Орчин үеийн Их Британы Жендер ба Сэтгүүл зүй. Урбана болон Чикаго, Ill.: Иллинойсын Хэвлэлийн Их Сургууль.

ЮНЕСКО. 2009. Тэнцвэрийг зөв хадгалах: Сэтгүүл зүй дэх жендерийн тэгш байдал. www.unesco.org/new/fr/communication-and-information/resources/publications-and-communication-materials/publications/full-list/getting-the-balance-right-gender-equality-in-journalism/

Ван Зоонин, Лиесбэт. 1994. Феминист Хэвлэл Мэдээллийн Судалгаа. Лондон/Мянган царс, Калиф.: Сэги.

Ван Зоонин, Лиесбэт. 1998. Мэдээ, Жендер ба Хүч. Лондон болон Нью-Йорк: Роутледж.

Ван Зоонин, Лиесбэт. 2002. Интернэт дэх жендер: мэдүүлэг, маргаан мэтгэлцээн болон соёл. Европын Харилцаа Холбооны Сэтгүүл, ХэсэгI. 17, №. 1, хуу. 5–23.



# ХҮМҮҮНЛЭГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ

Ибрахим Сеага Шав

Энэхүү курс нь оюутнуудад төр болон иргэний нийгмийн гол тоглогчдыг оролцуулан хэвлэл мэдээлэл ба хүмүүнлэг интервенцийн улс төр, эдийн засгийн талаар шүүмжлэлт хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг олгоно. Түүнчлэн хүмүүнлэг эсвэл хүний эрхийн сэтгүүл зүй ба хүний эрхийн асуудлыг хэрхэн сурвалжлах талаар заах юм. Үүний хажуугаар улс үндэстний болон олон улсын, улс төрийн, хууль ёсны, эдийн засгийн, соёлын бүтэц хүний эрхэд хэрхэн нөлөөлж байгаа, сэтгүүл зүйн туршлага эдгээр бүтцийн гол цөм нь болох талаар үзэх болно.

**Курсийн түвшин:** Сэтгүүл зүйн бакалаврын төгсөх курсийн оюутан

**Зорилго:** Энх тайван болон дайн мөргөлдөөний аль ч цаг үед хүний эрхийг хамгаалж сурвалжлах сэтгүүлчийн үндсэн үүргийн талаарх ойлголт мэдлэгийг оюутнуудад олгохыг зорьж байна. Хүн төрөлхтөний хувьд 1948 он буюу Дэлхийн Хүний Эрхийн Тунхаглал батлагдсанаас хойш 70-аад жил хүний эрх хуулиар хамгаалагдсан, хууль ёсны орчинд амьдарч байгаа. Энэ тунхаг батлагдсанаар улс үндэстнүүд иргэдийнхээ эрхийг ямарваа хүчирхийллээс хамгаалах үүрэг хүлээсээр ирсэн. Хэдийгээр улс орны засгийн газрууд хүний эрхийг хамгаалах сүржин үүрэг хүлээсэн мэт харагдавч хэрэг дээрээ засгийн газар болон эрх баригчид өөрсдийнхөө эрх ашгийг нэгдүгээрт тавьдаг. Тэд эрх мэдэл, байр суурь, өөрийн "Дэглэм"-ээ авч үлдэхийн тулд багахан хэмжээний тайван жагсаал, эрх баригчдын эсрэг эсэргүүцлийг нийгмийн аюулгүй, тогтвортой байдал нэрийн дор хүчээр тараах зэргээр иргэдийнхээ эрхийг зөрчиж, тэдний эсрэг хүч хэрэглэдэг. Зарим тохиолдолд эрх баригчид иргэдийнхээ улс төр, эдийн засаг, соёлын эсрэг хүчирхийлэл үйлдэгч бүлгүүдийг ивээн тэтгэж байна.

Сургалтын зорилго бол хүмүүнлэг сэтгүүл зүйн шүүмжлэлтэй болон онолын асуудлыг хэлэлцэхээс гадна иргэдийнхээ эрхийг хамгаалах засгийн газрын удирдагчид болон хүний эрхийг хамгаалагч төрийн бус байгууллагын үүргийн талаар судлах болно. Мөн сэтгүүлчдийн хувьд "Shortcoming" буюу алдаа дутагдал (хүний эрхийн эсрэг алдаатай сэтгүүл зүй) болон "Potential" (хүний эрхийн сэтгүүл зүй)-ийн сэтгүүл зүйн ялгааны талаар суралцах юм. Үүнд хүний эрхийн асуудал болох жендер, хүүхэд, боловсрол, эрүүл мэнд (ДОХ г.м.), цагдан хяналт, хүрээлэн буй орчин, тарчлаан зовоох, шоронгийн нөхцөл, хүний наймаа, цөөнхийг хоморголон устгах, геноцит устгал, ядуурал, өлсгөлөн, цагаачлал зэрэг энгийн сурвалжлага болон туршилтан дээр үндэслэсэн сурвалжлага, мэдээг яаж бэлтгэх талаар үзэх болно.

Оюутнуудын хувьд хүний эрхийн тулгуур зарчим болох стандарт, иргэдийн оролцоо, хариуцлага, тэдний гарал үүсэл, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, хууль зөрчих зэрэг хүний эрхийн хүчирхийллийн эсрэг зарчмуудаас суралцана. Тэд хүний болон байгалийн хүчин зүйлээс үүссэн хүмүүнлэгийн хямрал, тэднийг хамгаалах, тэдэнд туслах гэсэн хүмүүнлэгийн интервенцийн талаар үнэлэлт, дүгнэлт хийж сурна. Мөн оюутнуудад нийгмийн хариуцлагын хүрээнд

сэтгүүл зүйн ажлын үүргээ ухамсарлах, түүний дотор хүмүүнлэгийн сэтгүүл зүйн шүүмж, анализ хийх техникээс суралцана. Энэ сургалтаар сэтгүүлчийн хуулийн дагуу хүлээсэн үүрэг, мэргэжлийн болон ёс зүйн үүргээ ухамсарласнаар хүний эрхийн эсрэг хүчирхийлллийн гэрч болж ажил үүргээ хэрхэн нэр төртэй гүйцэтгэхийн чухлыг онцлох болно.

Мөн орчин үеийн шинэ мэдээллийн хэрэгслийн хэлбэр болох иргэн сэтгүүлч, Social Media буюу нийгмийн сүлжээ, хүмүүнлэгийн компанит ажил, хүний эрхийн сэтгүүл зүйн талаар ч хөндөнө.

Түүнчлэн хүмүүнлэгийн хямралыг сурвалжлах үеэр сэтгүүлчид тохиолдох ёс зүй, мэргэжил хийгээд хууль ёсны сорилт, хүндрэл бэрхшээлийн талаар судлах юм.

**Сургалтын хүрээ:** Хичээлийн төгсгөлд оюутнууд:

- Хүний эрхийн эсрэг хүчирхийлллийн талаар тодорхой хэмжээний практик болон онолын мэдлэгтэй болсон байна.
- Тэд хүний эрхийн зарчим болон хүчирхийллээс хүмүүсийг хэрхэн хамгаалах талаар сурвалжилж дүн шинжилгээ өгөх ойлголттой болно.
- Дэлхийн, улс үндэстний хэмжээний хүний эрхийн зарчмын асуудлаар судлах, үнэлэлт, дүгнэлт хийх арга техниктэй танилцана.
- Хүмүүнлэгийн хямралыг сурвалжлах үеэр иргэний нийгмийн хувьцаа эзэмшигчид болон улс төрийн бүлэглэлийн тал засах, арга саам илэрхийлэх, аливаа мэдээллийг мушгин гуйвуулахаас болгоомжилж мэдрэмжтэй байхад суралцана.

**Сургалтын төрөл:** Лекц, семинар/ангийн ажил, ажлын байр буюу газар дээрх сурвалжлага, мөн бүлгээр эрдэм шинжилгээний хурал

**Сургалтын арга зүй, хандлага:** Энэ хичээл нь багц лекц болон семинарыг агуулна. Долоо хоног бүрийн семинар болон лекцээр дурьдсан модулийн дагуу сургалт явуулна. Лекцэнд багц сургалт болон гүн гүнзгий онолын мэдлэгийн талаар заана. Харин семинарын хувьд лекцэнд багтсан агуулга болон асуудлыг задлаж системтэйгээр ярилцана. Лекц болон семинар энэ курсийн зорилго, сэдвийн дагуу болно.

Семинарт бүх оюутнуудыг бүрэн хамруулна. Үүнд зураг, дүрс, текст зэрэг материалыг ашиглаж, оюутнуудыг бүлэгт хувааж мэтгэлцүүлнэ. Сэдвийн хувьд тухайн лекц семинар дээр үзсэн онолын асуудлууд багтана. Лекцийн материал болон семинарын гарын авлага, модулийн мэдээллийг лекцийн өмнө электрон байдлаар оюутнуудад түгээсэн байна.

ЭШБХурлын хувьд  тухайн хүмүүнлэгийн хямрал болсон газар дээрээс сурвалжилсан сэдвээр оюутнууд илтгэл тавина. Хуваагдсан бүлэг бүр модульд багтсан (жендер, хүүхэд, боловсрол, эрүүл мэнд (ДОХ), цагдан хяналт, хүрээлэн буй орчин, тарчлаан зовоолт, шоронгийн нөхцөл, хүний наймаа, хоморголон устгах, генецит халдлага, ядуурал, өлсгөлөн, цагаачлал зэрэг) хүний эрхийн гол гол асуудлын чухал зарчмуудаас сэдвээ сонгож авна. Мөн улс үндэстэн, иргэний нийгэмд эдгээр асуудлыг хэрхэн эрэн сурвалжилж байгаа талаар оюутнууд илтгэл тавина.

Группийн хувьд ангийн нийт оюутны тооноос хамаарна. Жишээ нь, 50-60 оюутантай анги бол 10 бүлэгт хуваарилна. Таван долоо хоногийн хугацаанд хоёр бүлэг 1 долоо хоногт нь илтгэл тавина. Нийт үргэлжлэх хугацаа модулийн дагуу 11 долоо хоног. 80 хувь нь тухайн сэдэвтэй холбогдсон шүүмж, лекц, семинар байна. 20 хувь нь тухайн газар дээр  нь сурвалжилсан сурвалжлага, практик, илтгэл, үнэлгээ байна.

**Дүгнэх:**
Бүлгийн ажлын байр буюу газар дээрх сурвалжлага болон илтгэл: 20 хувь
Эссэ (2500 үг): 40 хувь
Шалгалт: 40 хувь. (Эссэ маягийн асуултууд байна. Хоёр хэсгээс бүрдсэн 10 асуулт, оюутнууд хэсэг тус бүрээс нэг асуултад буюу нийт 2 асуултад хариулна.)

**Семестр болон долоо хоногт заах цагууд:** Энэ модуль нь хоёрдугаар семестрт нийт 11 долоо хоногт 44 цагт багтана. Үүнд: 11 лекц болон 22 семинар/ангийн ажил. Өөрөөр хэлбэл нэг долоо хоногт 1 лекц болон 2 семинар/ангийн ажил. Лекц бүр 2 цаг, семинар/ангийн ажил бүр 2 цаг.

## Сургалтын хүрээ:

**Лекц-1: Хүний эрхийн асуудлаарх сурвалжлагын түүх болон ойлголт**

Лекцээр 19-р зууны Жеймс Крийлмэний үеийн хүний эрхийн сурвалжлагын түүх болон хөтөлбөрөөс танилцуулна. АНУ-д 1890-ээд онд гадаадын сурвалжлагч хүний эрхийн зөрчлийн талаар зоригтой сурвалжлага хийж баатар болж байсан үеэс эхлээд үзнэ. Мөн шар сэтгүүл зүйн тухай ч хамрах болно.

Лекц, семинараар дараах асуултад хариулт авна.

- Жеймс Крийлмэний хүмүүнлэгийн сурвалжлагын давуу болон сул тал юу вэ?
- Жеймс Крийлмэний хүний эрхийн сурвалжлага тухайн үед яагаад “бодит үнэн зөв” сэтгүүл зүйн хажууд “шударга” сэтгүүл зүй гэж үнэлэгдэх болсон бэ?

- Тэрээр хүний эрхийн сурвалжлагаараа ‘шар сэтгүүл зүй’ ба ‘нягт нямбай байх’, ‘үнэнийг мэдээлэх’-ийн хоорондын тэнцвэрийг хэрхэн хадгалсан бэ?

Унших материал: Бэхр (1992), Моритз (2006), Шав (2012b) Бүлэг.3, хэсэг 3

**Лекц-2: Хүний эрхийн сурвалжлагаас хүний эрхийн сэтгүүл зүй хүртэл**

Лекцээр 21-р зууны хүмүүнлэгийн сэтгүүл зүйн нарийвчлалын талаар авч үзэх болно.  Үүнд: уламжлалт хүний эрхийн сурвалжлагын зарчим, хүний эрхийн зөрчлийг нээн илрүүлэх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүний эрхийн сэтгүүл зүйтэй хэрхэн холбогдож байгаа талаар авч үзнэ. Мөн хүний эрхийн сурвалжлагыг сэтгүүл зүйн алтернатив загвартай харьцуулна.

Лекц болон семинараар дараах асуултад хариулна.

- Хүмүүнлэгийн сэтгүүл зүй гэж юу вэ? Энэ нь хүний эрхийн сурвалжлага болон дайн байлдааны сурвалжлагаас юугаараа ялгаатай вэ?

- Хүний эрхийн сэтгүүл зүй нь тайван цагийн сэтгүүл зүй болон дэлхийн сэтгүүл зүйгээс юугаараа ялгаатай вэ?
- Хүний эрхийн сэтгүүл зүй нь сэтгүүл зүйн сургалт болон дадлагад яагаад чухал үүрэгтэй вэ?

*Унших материал:* Ловасин (2008), Плайсэнси (2002), Шав (2012b) бүлэг 2 ба 3 (Өргөтгөсөн сэтгүүл зүй).

## Лекц-3: **Сэтгүүл зүй ба НҮБ-ын Хүний Эрхийн Тунхаглал**

Лекцээр НҮБ-ын хамгийн чухал баримт болох Хүний эрхийн конвенци, шийдвэр, тогтоол, чөлөөт үг хэллэг болон үзэн ядсан үг хэллэг, олон нийтийн аюулгүй байдал, мэдээллийн интервенци зэргийн талаар сурч мэднэ. Энэ нь хүмүүнлэгийн гамшиг хямралын үед сэтгүүлчид хэрхэн яаж сурвалжлага бэлдэх тал дээр туслах болно.

Лекц, семинараар дараах асуултуудад хариулт авна.

- НҮБ-ын хамгийн чухал хүний эрхийн конвенци, шийдвэр нь хүмүүнлэгийн сэтгүүлчдэд яагаад чухал вэ?
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хүний эрхийн сэтгүүлчийн ажилд яагаад чухал вэ?
- Чөлөөт үг хэллэг, мэдээллийн интервенци дутагдалтай байснаар хүмүүнлэгийн сэтгүүл зүйд хэрхэн сөргөөр нөлөөлдөг вэ?

Унших материал: Хамелинк (2004), Ласнер (2005), Пуддепхат (2005), Шав (2012b), Бүлэг-2, хэсэг-2.

## Лекц-4: **Сэтгүүлч бол хүний эрхийн зарчмуудын хоточ нохой бөгөөд асуудлууд**

Сэтгүүлч хүн хүний эрхийн стандарт, оролцоо, хариуцлага, ялгаварлан гадуурхахгүй байх, хууль эрх мэдэл зэрэг хүний эрхийн гол зарчмуудын “Watchdog” буюу хоточ нохойн үүрэг гүйцэтгэх ёстой талаар үзнэ. Мөн сэтгүүлчдийн ажил үүргийн нэгээхэн хэсэг болсон хүний эрхийн гол асуудлууд болох дэлхийн, улс үндэстний

жендер, хүүхэд, боловсрол, эрүүл мэнд (ДОХ), цагдан хяналт, хүрээлэн буй орчин, тамлан зовоолт, шоронгийн нөхцөл, хүний наймаа, геноцит аллага, цөөнхийг хомроглон устгах явдал, ядуурал, өлсгөлөн, гуйланчлал, цагаачлалын асуудлыг авч хэлэлцэнэ.

Лекц, семинараар дараах асуултуудад хариулна.

- Хүний эрхийн тулгуур гол таван зарчим хүний эрхийн асуудлаар сурвалжлахад яагаад чухал вэ? Жишээ гарга.
- Хүний эрхийн сэтгүүлч ялгаварлан гадуурхахгүй байх, эмэгтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ДОХ-той хүний эсрэг буюу хүний эрхийн хүчирхийлэлийн эсрэг зарчмуудаас юу хожих вэ? Тухайн сэтгүүлчдэд юу нь ашигтай вэ? Энэ талаар тайлбарла.
- Хүний эрхийн сэтгүүлч хариуцлага, хууль ёс, ядуу зүдүү болон сул талтай хүмүүсийн хүчирхийллийн эсрэг хүний эрхийн зарчмуудаас юу хожих вэ?

Унших материал: Биманaнд Калдербанк (2008) бүлэг 6 ба 7; Хамелинк (2004); Шав (2012b) бүлэг-12.

## Лекц-5: Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба хүмүүнлэгийн сэтгүүл зүй

Лекцээр эрэн сурвалжлах сэтгүүл зүйн арга ашиглан хүмүүнлэгийн хямрал, гамшигийн талаар мэдээ сурвалжлага бэлдэх зэрэг хүмүүнлэгийн сэтгүүл зүйн арга барилаас суралцана. Улс үндэстний болон олон улсын сэтгүүл зүй судлалд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хурдтай хөгжсөнөөр хүмүүнлэгийн сэтгүүл зүйд хэрхэн нөлөөлж цаашид хөгжилд нь ямар тус нэмэр болох талаар тодорхой ойлголттой болно.

Лекц, семинараар дараах асуултад хариулна.

- Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хүмүүнлэгийн сэтгүүл зүйд яаж нөлөөлөх, юу чухал вэ? Жишээ гарга.
- Хүмүүнлэгийн сэтгүүл зүйн сурвалжлагад evocative буюу сэргээн сануулах төрлийн давуу болон сул талын талаар яагаад мэдэх хэрэгтэй вэ?

- Хүмүүнлэгийн сэтгүүл зүйн сурвалжлагад diagnostic төрлийн давуу болон сул талын талаар яагаад мэдэх хэрэгтэй вэ?

Унших материал: Хавкинс(2002), Хойжер(2004), Шав(2012b)бүлэг.5.

**Лекц-6: Сэтгүүлчийн үүрэг нь төвийг сахих эсвэл ёс суртахууны гэрч**

Лекцээр хүний эрхийн хүчирхийллийн эсрэг ажиллаж байгаа сэтгүүлч бол дундыг баримталсан эсвэл ёс суртахууны гэрч болох талаар үзнэ.  Реалист улс төрийн онолын хүний эрхийн сэтгүүл зүйн cosmopolitan буюу олон талт соёлын талаар суралцах болно. Хүний эрх болон реалист парадигм, НҮБ-ын улс үндэстний бүрэн бүтэн байдал, 2005 онд шинэчилсэн 1648 оны  үл довтлох, хэлбэрийг хамгаалах хариуцлагын Вестфалиягийн гэрээний талаар ярилцана. Мөн сэтгүүлчдийн төвийг сахих болон ёс суртахууны парадоксын талаар үзнэ.

Лекц, семинараар дараах асуултуудад хариулна.

- Тухайн улс үндэстэн болон иргэний нийгэм дэх хүний эрхийн хүчирхийллээс үүссэн хүний зовлон шаналлын хажуугаар хүмүүнлэгийн сэтгүүлч төвийг сахисан байр суурьтай байж болох уу?
- Хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг зэрэг хүний эрхийн хүчирхийллийн өмнө сэтгүүлчдийн хувьд ямар сорилт, хүндрэл бэрхшээл тулгарч байгаа вэ?
- Хүмүүнлэг эсвэл хүний эрхийн сэтгүүлчийн ёс суртахууны үүргийн талаар хамгийн чухал, өөрт хамгийн сонирхолтой гэсэн 3 зарчмын талаар ярилц.

Унших материал: Лийтал (2006); Плайсанси (2002); Рантанин (2007); Шав (2012b) Бүлэг. 8, хэсэг-1 ,ху.144; Тестер (2001)..

**Лекц-7: Хүмүүнлэгийн сэтгүүл зүйн хууль ёсны, ёс зүйн болон бүтцийн сорилтууд**

Лекцээр хүмүүнлэгийн хямрал гамшгийн талаар сурвалжлах үед тохиолдох хүмүүнлэгийн сэтгүүл зүйн хууль ёсны, ёс зүйн болон бүтцийн сорилтуудын  талаар үзэх болно. Ялангуяа сүүлийн хэдэн жилд Африк, Ази, Хойд Америк, Ойрх Дорнодод тохиолдсон зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг зэрэг хүн төрөлхтөний хямрал, гамшиг, мөргөлдөөний талаар хөндөх юм. Мөн сэтгүүлчид хүмүүнлэгийн хямралыг газар дээр нь сурвалжлахад ямар хүндрэл бэрхшээл тохиолдож байгаа талаар болон тэдгээрийг хэрхэн даван туулж байгаатай танилцана.

Лекц, семинараар дараах асуултад хариулна.

- Хүмүүнлэгийн сэтгүүлч тухайн газар дээр ажил үүргээ гүйцэтгэж явахад хуулийн ямар зүйл заалтад баригдаж, хязгаарлагдаж хүндрэл үүсэж байгаа талаар ярилцаад жишээ гарга.
- Хүмүүнлэгийн сэтгүүлчийн хувьд хүний эрх зөрчигдсөнөөс болж тухайн хүмүүс зовж шаналж байгаа газар сурвалжлага хийхэд ёс зүйн ямар асуудал төвөгтэй байдал учирч байна вэ?
- Зарим тохиолдолд мэдээний өрөө болон тухайн улс үндэстний нийгмийн байгуулал зэргээс хамаарч хүний эрхийн сэтгүүл зүйг “Биелэгдэшгүй даалгавар” болгон хувиргадаг. Энэ талаар ярилц.

Унших материал: Денте Росс (2007), Хамелинк (2004), Кемпф (2007), Линч болон Мс Голдрик (2010), Симэнт (2001).

## Лекц-8: Хүмүүнлэгийн хямралын сурвалжлагын үе дэх хэвшмэл ойлголт, тархи угаалт болон гажуудал

Лекцээр байгалийн болон бусад гамшгаас болоод зовж шаналж байгаа хүмүүсийн талаар сурвалжлахад гардаг хүмүүнлэгийн хямралын хэвшмэл ойлголт, арга зам, гажуудлын талаар үзэх болно. Цаашлаад хүмүүнлэгийн сэтгүүл зүй болон дэлхийн шударга ёсны талаар сөхнө. Ингэхдээ АНУ-ын Вест Индийс, Зүүн Өмнөд Ази болон Африкт тохиолдсон явдлуудаас жишээ авах юм.

Лекц, семинараар  дараах асуултад хариулна.

- Хүмүүнлэгийн гамшиг, хямрал эсвэл зэвсэгт мөргөлдөөн зэргээр жишээ авч хэвшмэл ойлголт хүний зовлон шаналалд хэрхэн нөлөөлж байгааг ярилц.
- Тусламжийн ажилтнууд хүмүүнлэгийн сэтгүүл зүйд хэрхэн мэдээллийн эх сурвалж болж байгаа талаар ярилц.
- Аймшигтай хурц хэлбэрийн хүмүүнлэгийн хямралын үед сэтгүүлчид тусламжийн ажилтнуудтай хамтарч ажиллах үед гарах хүндрэл бэрхшээлийн талаар ярилц.

Унших материал: Алагиах (2001), Браумэн ба Бэкманн (1996), Чойлиараки (2006), Хойжер (2004), Шав (2012а).

## Лекц-9: **Сэтгүүл зүй ба хүмүүнлэгийн интервенцийн улс төрийн эдийн засаг**

Лекцээр сэтгүүл зүй хүмүүнлэгийн интервенцийн улс төрийн эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа талаар авч үзнэ. Хүмүүнлэгийн хямралыг зохицуулахын тулд цэргийн ажиллагаа болон туслах ажилтнууд, улс төр болон эдийн засгийн “Нууц” эрх ашгийг хамгаалахын тулд сэтгүүлчдийг ашиглах явдал гардаг. Сэтгүүлчид ийнхүү нууцаар холбогдох тохиолдол нь академик болон нийгмийн идэвхтнүүдийн дунд хэрхэн маргаан мэтгэлцээн дагуулдаг талаар үзнэ. Лекцийн зорилго нь ийм төрлийн мэтгэлцээнд оюутнуудыг бэлдэх, цаашдын дадлагад сургах юм.

Лекц, семинараар дараах асуултад хариулна.

- Хүмүүнлэгийн интервенцийн улс  төр, эдийн засгийн нөлөө гэж юу вэ? Энэ нь цаашлаад хүмүүнлэгийн сэтгүүл зүйд хэрхэн нөлөөлөх вэ?
- Хүмүүнлэгийн интервенцийн улс төр, эдийн засагт иргэний нийгэм болон улс төрийн төлөөлөл, элитүүдийн оролцоо, үүрэг роль юу байна вэ?
- Тодорхой хүмүүнлэгийн хямрал, эсвэл зэвсэгт мөргөлдөөн тэдгээрт нөлөөлөх үндэсний ашиг сонирхол, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хүмүүнлэгийн тусламж, хүмүүнлэгийн сэтгүүл зүйн чанарыг хэрхэн гажуудуулж байгаа талаар ярилц.

Унших материал: Алагиах (2001), Браумэн ба Бэкманн (1996), Чандлер (2002); Чойлиараки (2006), Хойжер (2004), Шав (2012б), бүлэг. 8.

## Лекц 10: **Шинэ хэвлэл мэдээлэл ба хүмүүнлэгийн олон нийтийн харилцаа: Кони 2012 видео сургалтын кейс**

Лекцээр хүмүүнлэгийн хямрал, зовж шаналж байгаа хүмүүст туслах зорилгоор хандив, сан бүрдүүлэх, хүмүүнлэгийн компанит ажилд шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн үүрэг гүйцэтгэх талаар үзнэ. 2012 онд АНУ-ын Хүний эрхийн байгууллагаас гаргасан Кони 2012 компанит ажлын алдартай видеоноос үзнэ. Тухайн үед хүний эрх ихээр зөрчигдөж байсан Уганда улсын босогч, сөрөг хүчний лидер Жосеф Кони нийгмийн сүлжээг ашиглан эсэргүүцлээ илэрхийлж, эрх нь зөрчигдөж байгаа иргэдэд зориулж мөнгө босгож чадсан нь нийгмийн сүлжээ хэр хүчтэй гэдгийг баталж чадсан юм.

Лекц, семинараар дараах асуултад хариулна.

- 2011 оноос эхэлсэн Арабын хавар хувьсгалд иргэний сэтгүүл зүй, хүмүүнлэгийн сэтгүүл зүй хэрхэн нөлөөлсөн талаар ярилц.
- Кони 2012 хүмүүнлэгийн видео компанит ажлын туршлагыг ашиглан хүмүүнлэгийн сэтгүүл зүйн нийгмийн сүлжээний давуу болон сул талын талаар ярилц.
- Хүний эрхийн талаарх сурвалжлагад онлайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглахад гарах хүндрэл бэрхшээлийн талаар ярилц.

Унших материал: Кони (2012), Мадианоу (2012), Шав (2012б) бүлэг.9, хэсэг-9:3, хуу. 174.

### Лекц-11: **Хүмүүнлэгийн сэтгүүл зүйн эрсдэл болон аюултай тал**

Лекцээр хүмүүнлэгийн сэтгүүл зүйн эрсдэл болон аюултай тал, амьд гарах стратеги, олон улсын хүмүүнлэгийн тухай хуулийн талаар үзнэ. Гамшиг, хямрал мөргөлдөөний талбар дээр ажил үүргээ гүйцэтгэж яваа сэтгүүлчийн амь насны эрсдлийн талаар хэлэлцэнэ. Хүмүүнлэгийн сэтгүүл зүйн эрсдэл, аюул заналыг ОУ-ын Улаан Загалмайн Нийгэмлэг болон бусад байгууллага давхар хамгаалж байдаг. Ангид хоёр видео клип үзүүлнэ.

Лекц, семинараар дараах асуултад хариулна.

- Зэвсэгт мөргөлдөөний талбар болон гамшиг болсон газрыг сонгоод ажил үүргээ гүйцэтгэж яваа хүмүүнлэгийн сэтгүүлчийн эрсдэл аюулгүй байдлын талаар ярилц.

- Хүмүүнлэгийн хямралын талаарх сурвалжлагад ‘embedded journalism’ –ийн оролцооны талаар ярилц.
- Хүмүүнлэгийн сэтгүүлчдийг хангалттай хамгаалсан олон улсын хууль эрх зүйн орчин байдаг уу?

Унших материал: Гейсс (2010), Олон улсын Мэдээний Аюулгүй байдлын Институт (2003).

### Тайлбар

Энэ курс нь сэтгүүл зүйн бакалаврийн төгсөх курсын оюутнуудад зориулсан. Харин магистрийн хөтөлбөрийн хувьд дэлхийн болон улс орны хүний эрхийн зарчмуудын талаар сэтгүүл зүйн үнэлэлт дүгнэлт, нарийн судалгаа хийж дэлгэрүүлэх шаардлагатай. Цаашлаад хүмүүнлэгийн интервенцийн улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн сэтгүүлч болон хүмүүнлэгийн ажилтан, чөлөөт ярилцлага болон хүмүүнлэгийн мэдээллийн интервенци, хүйтэн ба халуун мөргөлдөөн сэтгүүл зүйг хамгаалах хариуцлага, олон улсын гэмт хэргийн шүүхийн систем зэргийг UNICEF, WFP, UNDP, UNHCR, UNHRC, Oxfam болон MSF  зэрэг олон улсын хүмүүнлэгийн мэргэжлийн байгууллагуудтай холбогдож хамтарч нарийн судлах шаардлагатай.

# Унших материал ба ном зүй




Алагиах, Г.2001. Африк.Лондон: Жижиг, Броун.

Биэтти, Л, Миллер Д, Миллер,Э. ба Пило, Г.1999. Хэлэл Мэдээллийн Хэрэгсэл ба Африк: Гамшиг ба бослого эсэргүүцлийн дүр зураг. Г.Пило, Мэссэж хүлээн авсан. Харлов:Лонгман.

Бэхр, Э.1992. Хэн нэгэн хулгайлагдсан ба Энэ тухай хэлэх үү? Хармондсворт: Оцон шувуу.

Билл, М.1998. Үнэн бол бидний мөнгө. Хэвлэл/Улс төр, Хэсэг.3, №.1, хуу.102–9.

Биллами, А. Ж.2010. Төслийн хариуцлага: 5 жилд. Ёс зүй ба Олон улсын үйл хэрэг, Хэсэг. 24, №. 2, хуу.143–69.

Биман. Г. ба Калдербанк Д. 2008. Хүний эрх- Сэтгүүл зүйн арга зам: Вьетнамын сургалтын гарын авлага. Банкок: ЮНЕСКО.

Брауман, Р ба Бэкманн, Р. 1996. Хүмүүнлэгийн хэвлэл мэдээлэл. Мэдээллийн ёс зүй. Парис: CFPJ Хэвлэл.

Каррутерс, С. Л. 2000. Дайны талбар дах Хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл: Харилцаа холбоо ба 20-р зууны дайн. Лондон:Палгрэв Макмиллан.

Кассара, С.(1998). Латин Америкийн хүний эрхийн тухай АНУ-ийн сонинд, 1975–1982. Сэтгүүл зүй ба Улирал тутмын харилцаа холбооны хурал, Хэсэг. 75, №. 3, хуу. 478–486.

Чандлер, Д. 2002 Косовогоос Кабул руу. Лондон: Плуто Хэвлэл

Чоулиарки, Л. 2006.Зовлон зүдгүүрийн дарангуйлал. Лондон/Мянган царс, Калиф./ Шинэ Дэли: Сэги.

Цитрон, Д. К. ба Нортон Х. 2011. Зуучлал ба Үзэн ядсан яриа: Иргэний бүртгэлийг байхгүй болгосон нь. Бостон Хуулийн Их Сургууль, Хэсэг. 91, №. 4, хуу. 1435–84.

Коне, Ж. 2012. Нийгмийн сүлжээ буюу сошиел медиа нь хүмүүнлэгт хэрхэн нөлөөлж байна вэ? Кони 2012 ба Хаалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн үйл ажиллагаа. 5 сарын 10. Харвард Их Сургуулийн Хүмүүнлэгийн бодлогын хөтөлбөр ба Дайн, тулааны талаарх судалгаа. http:// hpcrresearch.org/blog/hpcr/2012-05-10/promise-social-media-humanitarian-action

Коттли, С. 2006. Зуучлалын зөрчилдөөн: Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжил ба Зөрчилдөөний судалгаа. Ариунбайдал: Нээлттэй Хэвлэлийн Их Сургууль

Дэнти Росс, С. 2007. Сэтгүүл зүйн энхтайван: Глобал хүйн загварын бүтэц.

Глобал хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэл: Газар дундын тэнгис хэвлэл, хэсэг. 2, №. 2. http://globalmedia.emu.edu.tr/fall2007/issues/9.%20Ross.pdf

Энтмэн Р. 1993. Бүтэц: Парадигмийн хугарлын тодоруулга. Харилцаа холбооны сэтгүүл, Хэсэг. 43 №. 4, хуу. 51–8.

Галтунг, Ж. 2004. Дайн тулаан ба хүчирхийлэл, түүний нөлөө: Хүчирхийлэлийн нөлөө ил ба далд. Хил давс ан: Зөрчил мөргөлдөөнийг энхийн замаар шийдвэрлэх энхтайван ба хөгжлийн сүлжээ.

Жейсс, Робин. 2010. 'Зэвсэглэсэн зөрчил мөргөлдөөний нөхцөл байдалд Олон улсын хүмүүнлэгийн хуулийн төслөөр сэтгүүлчид юу хийсэн бэ? Сурвалжлага. ИСРС. www.icrc.org/eng/resources/documents/interview/protection-journalistsinterview-270710.htm

Хамелинк С. Ж. 2004. Харилцаа холбоон дах хүний эрх. Мичиган: Хамптон хэвлэл.

Хаммонд, П. 2000. Хүмүүнлэгийн дайны тайлан: Суртал нэвтрүүлэг, ёс суртахуун ба НАТО-гийн Косовогийн дайн. Сэтгүүл зүйн сургалт, Хэсэг. 1, №. 3, хуу. 365–86.

Хаммонд, П. 2007. Хүйтэн дайны зөрчилдөөны хүрээ: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба Олон улс хөндлөнгөөс оролцох. Манчистер: Манчистерийн Хэвлэлийн Их Сургууль.

Хавкинс, В. CNN-ийн хүчин зүйлийн бусад тал: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба Зөрчил мөргөлдөөн: Сэтгүүл зүйн сургалт, Хэсэг 3, № 2 хуу. 225-40

Хойжер, Б. 2004. Глобал уучлалын хэлэлцүүлэг: үзэгч сонсогч ба хүний зовлон зүдүүрийн талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслийн тайлан. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Соёл ба Нийгэм 7 сарын 26. хуу 513–31.

Хакерби, М. 2005. Сэтгүүлчдин мөн чанар: Хөгжиж буй улсуудын сэтгүүлчидэд зориулсан интернэтэд холбогдох практик гарын авлага. Парис: ЮНЕСКО.

Олон улсын Мэдээний Аюулгүй байдлын Институт. 2003. Сөнөж байгаа түүхийн талаар ярь: Иракийн дайн ба Хэвлэл мэдээллийн хэрэгсэл: Трибют Брусселс 7 сарын 29.

Кемпф, В. 2007. Энхтайваны сэтгүүл зүй: Ухуулага сурталчилгааны сэтгүүл зүй ба зөрчил мөргөлдөөний хамрах хүрээн бүтэцийн хооронд дээсэн дээр явах. ЗӨрчил мөргөлдөөн ба Онлайн харилцаа холбоо, Хэсэг. 6, №. 2, 1 сарын 25. www.cco.regener-online.de

Лэснер, Т. 2005. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба Хүний эрх. Рода Смит ба Кристиен ван дэн Анкер, Хүний эрхийн гол зүйл: Хүний эрхийн тухай таны мэдэх хэрэгтэй зүйлүүд. Лондон: Ходдлер-Арнолд.

Лий, С.Т., Маслог, Ц. ба Ким, Х. С. . 2006. Азийн зөрчил мөргөлдөөн ба Иракийн дайн - өршөөл уучлалын хүрээ хязгаарын анализ. Олон улсын харилцаа холбооны сонин, Хэсэг. 68, №. 5–6, хуу. 499–518.

Ловасин, Л. 2008. Сэтгүүл зүй ба хүч: Хүний эрхийг бий болгох хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг роль ба Энхтайвны соёл. www.humanrightsdefence.org/journalism-and-power-the-role-of-media-in-build

Линч, Ж. ба Мс Голдрик, А. 2005. Энхтайвны сэтгүүл зүй. Строуд: Хавторн Хэвлэл.

Линч, Ж. ба Мс Голдрик, А. (2010). Зөрчил мөргөлдөөний тайлангийн Глобал стандарт ба энхтайван. Р. Л. Киибл, Ж. Туллоч ба Ф. Золлман, Энхтайвны сэтгүүл зүй, дайн тулаан, зөрчил мөргөлдөөний шийдэл. Нью-Йорк: Петер Ланг, хуу. 87–104.

Мадианоу, М. 2012. Нийгмийн сүлжээ буюу сошиал ертөнц дэх Хүмүүнлэгийн компанит ажил: Сүлжээний Архитектур ба Полимедиа үйл явдал. Лондон: Тайлор ба Францис.

Моритз, Фредерик. 2006. Америкийн хүний эрхийн тайлан шар хэвлэлд нийтлэгдсэн. http://worldlymind.org/creelover.htm;

Плиппе, Ж. 2001. Хууль ёсны хүмүүнлэгийн үйл, Өрсөлдөгч үгүй хэлэлцүүлэг. Моц, №. 3 сарын 6, хуу. 15.

Плайсэнс. П. Л. 2002. Сэтгүүлчид ёс суртахууны гэрч болох нь:р Мичиэл Игнатиэффийн "Глобал хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлд олонургалч үзэл баримтлал" Сэтгүүл зүй, Хэсэг. 3, №. 2, хуу. 205–222.

Пуддепатт, А. 2005. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө. Рона Смит ба Кристиэн Ван Дэн Анкер. Хүний эрхийн гол зүйл. Хүний эрхийн тухай таны мэдэх хэрэгтэй зүйлүүд. Лондон: Ходдлер-Арнолд.

Рантанин, Т. 2007. Олон улсын мэдээ: Сэтгүүл зүйн сургалт, Хэсэг. 8, №. 6, хуу. 843–61.

Робинсон, П. 2002. CNN -ийн нөлөө: Мэдээ, Гадаад Бодлого болон үйл ажиллагааны төөрөгдөл. Лондон: Роутлэдж.

Счирч, Л.  2002. Хүний эрх ба Энхтайванг бий болгох нь: Энхтайван руу чиглэсэн.  43 дах удаагийн Олон улс Судлалын Холбооны Конвенцид танилцуулсан баримт бичиг. Нью Орланс, Лоусиана, хуу. 24–7.

Шав, И. С. 2012а. Лондонд болсон 7/7 алан хядах халдлагын дараах Лалын болон Исламын стеротип мэдэгдэл: Соёлын харилцаа болон терроризмээс урьдчилан сэргийлэхийн утга учир. Олон улсын Харилцаа холбооны Сони, Хэсэг. 74, № 6, хуу. 509–24.

Шав, И. С. 2012б Хүний Эрхийн Сэтгүүл зүй: Зайн хүмүүнлэгийн үйл ажиллагааы тайлангийн ахиц дэвшил. Бэсингстоке: Пэлгрэв Макмиллан.

Симэнт, Ж. 2001.  Хүмүүнлэгийн хөгжил, Мэргэжил болон идэвх. Моц, №. 65, 3 сар, хуу. 28.

Тестер, К. 2001. Уучлал, нигүүслэл ба Хэвлэл Мэдээлэл. Букингхам:Хэвлэлийн Нээлттэй Их Сургууль.

Туссу, Д. К. 2000. ‘Хүмүүнлэгийн оролцоо'-г хуульчлан баталгаажуулах уу? CNN, НАТО болон Косовогийн хямрал. Харилцаа холбооны Европын сэтгүүл, Хэсэг. 15, №. 3, хуу. 345–61.



# ХҮНИЙ НАЙМААГ СУРВАЛЖЛАХ НЬ

ХатагтайС.Э.Деттмейжер- Вермеулен

Энэ курсээр орчин үед илрүүлэхэд хүндрэлтэй, далд хэлбэрт үйлддэг гэмт хэргийн нэг болох хүний наймааны талаар болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, болгоомжлох талаар үзнэ. Хүмүүст хүний наймааны талаар, мөн түүнээс урьдчилан сэргийлэх анхан шатны боловсрол олгоход сэтгүүлч ямар үүрэгтэй талаар хөндөх болно. Мөн хүн төрөлхтөний санааг зовоосон шинэ төрлийн гэмт хэрэг болох хүний наймааг таслан зогсоож, бууруулахад эрэн сурвалжлах сэтгүүл зүй ямар үүрэгтэйг судална. Энэ төрлийн гэмт хэрэг нь хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад байгууллагад тэр болгон мэдэгддэггүй, мэдээлэгддэггүй юм. Бид хүний наймаа гэж ямар төрлийн гэмт хэрэг болох, энэ талаар хэрхэн сурвалжлах, олонд хүргэх талаар үзнэ.

**Түвшин:** Сэтгүүл зүйн бакалаврийн төгсөх курсын оюутнуудад зориулсан:

**Сургалтын зорилго, зорилт:** Боолчлол гэдэг зүйл дэлхийн өнцөг булан бүрт байсаар ирсэн, одоо ч байгаа. Сүүлийн үед боолчлол илүү төгөлдөршиж, хүний наймаа буюу нийгмээс далд хэлбэрт хүнийг боол хэлбэрээр худалдах, мөлжих шинэ төрлийн гэмт хэрэг гарах болсон.  Энэ асуудлыг шийдэхийн тулд сэтгүүлчид хүний наймааны талаар бодитой, баримттай зүйлийг олонд ил болгох нь тэдний үүрэг юм. Хүний наймаа болон эрэн сурвалжлах сэтгүүл зүй энэ далд бүхнийг ил болгохын тулд хоёр аргаар тэмцэх хэрэгтэй.

Нэгдүгээрт: Сэтгүүлчдийн хувьд хүний наймаа хаана газар авч, цэцэглэж ялангуяа аль улс оронд илүү их дэлгэрч байгаа шинж тэмдэгийг мэдэх хэрэгтэй. Хүний наймаа гэж юу вэ? Хэрхэн хийдэг вэ? Хохирогчид нь хэн байдаг вэ? Хохирогчдыг яаж таних вэ? Энэ наймаа хаана олны анхааралд өртдөг вэ? Түүнээс хэрхэн сэргийлэх вэ? Хүний наймааны хохирогчдыг хэрхэн хамгаалах вэ?

Хоёрдугаарт: Сэтгүүлчдийн хувьд олон нийтийн баримт материал, мэдээ мэдээлэлд тулгуурлан хүний наймааны талаар бодит мэдээлэл авах боломжтой. Хүний наймааны эсрэг тэмцэхэд бодит баримттай, нарийн мэдээлэл чухал байдаг.

Хичээлийн бүтэц:

- *Долоо хоног 1:* Хүний наймааны танилцуулга
- *Долоо хоног 2:* Хүний наймааны хууль ёсны тайлбар, ойлголт
- *Долоо хоног 3:* Хүний наймааны талаарх судалгаа
- *Долоо хоног 4:* Хүний наймаа: Бэлгийн мөлжлөг
- *Долоо хоног 5:* Олон улсын хөдөлмөрийн цагаачлал ба хөдөлмөрийн мөлжлөг
- *Долоо хоног 6:* Хүний эд эрхтэнийг зарж борлуулах хүний наймаа
- *Долоо хоног 7:* Хүний наймааны эсрэг тэмцэх олон улсын ажиллагаа, чармайлт
- *Долоо хоног 8:* Хүний наймааны эсрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг болон ёс зүйн байдал

**Сургалтын хүрээ:** Энэ модулын төгсгөлд хүний наймаа болон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн харилцан уялдаа, тэдгээрийн мэдээ баримтыг ирээдүйн эрэн сурвалжлах сэтгүүл зүйд яаж ашиглах талаар үзнэ.

- Хүний наймааны талаарх тодорхой ойлголт, ерөнхий шалтгаан, эх үүсвэр, хүний наймаанд татан оруулах болон өөгшүүлэх хүчин зүйл, мөн бусад гэмт хэрэгтэй холбогдох байдал
- Хүний наймаа болон хууль бусаар хил давуулах наймааны ялгаа

- Олон улсын хүний наймаатай тэмцэх байгууллагын хувьцаа эзэмшигчдын талаарх ойлголт
- Олон улсын болон орон нутгийн хүний наймааны талаарх судалгаа, тэдгээрийг хэрхэн танин мэдэх
- Хүний наймааны талаарх судалгаа хийхэд учрах сорилт, хүндрэл, бэрхшээл
- Хүний наймааны эсрэг тэмцэхэд хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо. Үүнд сэтгүүлчийн ёс зүй, ёс суртахуун орно.

**Сургалтын төрөл, хэлбэр:** Лекц, семинар/ярилцлага, даалгавар

**Долоо хоногт орох цаг:** Долоо хоногт ангид 3 цаг, уншлага, судалгаа 2 цаг. Оюутнууд цагт тухайн сэдэвтэй холбогдолтой 15 хуудас материал унших (тухайн сурах бичгийн текстийн нягтралаас хамаарна). Хамгийн доод талын унших материал 120 хуудас (шаардагдах унших материалыг хар). Заавал унших ёстой материалын жагсаалтыг харна уу.

**Хэрэглэгдэх материал:** Холбогдох материалыг шүүж олж унших интернэтэд холбогдсон компьютер

# Сургалтын хүрээ:

## Долоо хоног 1: Хүний наймааны тухай

*Сэдэв:* Хүний наймаа гэж юу вэ? Хүний наймааны үйл ажиллагааны эсрэг хэтийн төлөв, хүний наймаатай холбоотой бусад гэмт хэргүүд, түүнд татагдан орох, хүчээр оруулах хүчин зүйлүүд, шинж тэмдэгүүд.

*Лекцийн зорилго:* Оролцогчдод:

- Олон улсын хүний наймаатай тэмцэхэд хэрэглэгддэг концепци болон нэр томъёоны талаарх ойлголт
- Хүний наймааны талаар шүүмжлэлтэй дүгнэлт хийх чадамж (жишээ нь: эдийн засгийн асуудал, хуулийн эрх зүйн асуудал, тархац, даяарчлал, гэмт хэргийн шүүн таслах ажиллагаа эсвэл хүний эрх зөрчигдөх ) болон энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд тэдний нөлөө хэр байгаа эсэх
- Хүний наймаанд хүчээр татан оролцуулах болон татагдан орох хүчин зүйлийн ойлголт, түүнтэй холбоотой зохион байгуулалттай гэмт хэрэг
- Хүний наймааны шинж тэмдгийн талаарх ойлголт

*Сэдвүүдийн танилцуулга:* Олон улсын энгийн ойлголтоор хүний наймааны тодорхойлолт нь НҮБ-ын тухайн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх, Нуун Дарагдуулахаас Урьдчилан Сэргийлэх, тухайн Хохирогчийг Шийтгэхийн эсрэг Протокол, нэмэлтээр Олон Улсын Зохион Байгуулалтай Гэмт Хэргийн эсрэг НҮБ-ын Конвенци буюу 3-р зүйлийн А-д тодорхой зүйлчилсэн байдаг:

> Энэ төрлийн бизнест хүн сургаж авах, зөөвөрлөх, тээвэрлэх, хоргодох байр олгох, хүн хүлээн авах, өөрөөр хэлбэл хүч хэрэглэх болон айлган сүрдүүлэх замаар, албадлагаар, хүүхэд эмэгтэйчүүдийг хүчээр байлгах, луйвар, залилан, хууран мэхлэх, эмзэг сул талыг нь ашиглан хүч хэрэглэх, хэн нэгнийг өөрийн сонирхолд нийцүүлэн ашиглах зорилгоор эрх мэдлээ ашиглаж хяналтандаа байлгах хамаардаг. Эрх мэдлээ ашиглах гэдэгт хүчээр биеийг нь үнэлүүлэх болон бусад төрлийн бэлгийн дарамт, хүнд хүчир хөдөлмөр хийлгэх, боолчлох, эд эрхтэнийг авч, зарж борлуулах зэргийг багтааж тэдгээрийг хориглосон байдаг.
> (НҮБ-ын 2000а нэмж тодруулах)

Хүүхдийн наймааны гэмт хэргийг хүний наймааны гэмт хэргээс бага зэрэг өөрөөр тодорхойлдог. Хүүхдийн наймаа гэмт хэрэг болох нь гол төлөв батлагддаггүй. Учир нь гэмт хэргийн золиос болж байгаа хүүхдүүд яг юу болж байгаа, юуны золиос болж, хаашаа хулгайлагдаж байгаагаа тэр болгон мэддэггүй. Тэгээд ч  хүүхдүүд харгалзах хүнгүйгээр бие даан явах боломжгүй. Хүүхдүүдийг голдуу хүнд хүчир хөдөлмөр хийлгэх, тэдний хөдөлмөрийг мөлжих зорилгоор хулгайлж, худалддаг учир хүний наймаанд тооцогддог.

Харин Human trafficking  буюу хүний наймаа нь  human smuggling  буюу  хууль бусаар хүнийг хил давуулахаас ялгаатай юм. Өөрөөр хэлбэл хэлбэл хууль бусаар хүнийг хил давуулах нь шууд болон шууд бус төлбөр, санхүү эсвэл материаллаг эд зүйлээр тухайн хил давуулсан хүнийг худалдан авдаг.  Хил давж зарагдсан хүмүүс нь голдуу тухайн улсын иргэн бус, байнгын оршин суугч биш байдаг. (НҮБ 2000). Хүнийг хил давуулан худалдаалж наймаалах нь Олон улсын хилийг хууль бусаар зөрчих үйлдэл. Харин хүний наймаа нь заавал хил давуулалгүй, тухайн нутаг оронд ч болдогоороо ялгаатай. НҮБ-ын хоёр тусдаа протоколыг нэгтгэж, нэмэлтээр 2000 онд Палермо Конвенцийг оруулснаар хүний наймаа болон хүн хил давуулж худалдаалах гэмт хэргийг ялгаж салгаж өгсөн. Хэдийгээр цаасан дээр хоёр гэмт хэрэг ялгаатай харагдавч зарим судлаачид тухайн хоёр гэмт хэргийг нэг нь нөгөөгөөсөө үүдэлтэй гэж маргадаг. Тэднийхээр бол хүний наймаа болон хил давуулж худалдаалах гэмт хэрэг grey zone буюу өөх ч биш, булчирхай ч биш бараг ялгаагүй гэж үздэг.  Өөрөөр хэлбэл энэ хоёр  гэмт хэрэг бие биенээсээ салшгүй холбоотой. Нэг гэмт хэрэг нь нөгөө гэмт хэргийнхээ үргэлжлэл болж өгдөг.

Хүний наймаа голдуу нууцлаг байдаг. Хууль зөрчигч этгээд үйл ажиллагаагаа нууц байдалд явуулдаг.  Хохирогчид нь ил гарч ирэхээс татгалздаг. Энэ бол хүний наймааны нууц дүр төрх. Тэгэхээр хүний наймаа гэж яг юу вэ? Үүнд доор дурьдсан маш олон төрлийн үйл ажиллагаа багтдаг. Сүүлийн үед surrogacy буюу “Тээгч эх” болох (хоёр тал мөнгө, санхүүгийн хувьд тохиролцсоны үндсэн дээр эмэгтэй хүн хүүхэд тээж гаргаж өгөх, зарах) шинэ төрлийн хүүхдийн наймааны гэмт хэрэг нэмэгдэх болсон:

- Хүний наймааны бэлгийн мөлжлөгийн зорилго нь гудамж, цонхоор биеийг нь үнэлүүлэх, хувийн эзэмшлийн байр саванд биеийг нь үнэлүүлэх, массаж, баар ресторoны тусгай өрөө, клуб, эмсийн хүрээлэн болон вэб камераар биеийг нь үнэлүүлэх, хүүхдийн порнограф, садар самуун, интернэтээр биеийг үнэлүүлэх, бусад дагалдах үйлчилгээнүүд багтана. (4-р долоо хоногийн хичээлээс нэмж судлах)

- Хүний наймаагаар хүний хөдөлмөрийг мөлжиж, шулахын зорилго нь олон цагаар ХАА ба цэцэрлэгжүүлэлтийн аж ахуй, цэвэрлэгээний үйлчилгээ ба хоол, хүнсний тээвэрлэлт, барилга, гэмт хэрэг, хар тамхи мансууруулах бодисын худалдаа, хөдөө орон нутгийн хүнд хүчир ажил, мал нядалгааны газар, нэхмэл сүлжмэлийн үйлдвэр, хоол хүнсний салбар зэрэгт хүнд хүчир ажил хүчээр хийлгэх орно. (5-р долоо хоногийн хичээлээс нэмж судлах)
- Хүний наймаагаар эрхтэн авч, зарж борлуулах хэсэгт хүний биеийн гол эрхтнүүд болох бөөр, зүрх, уушиг, элэг зэргийг авч өөр хүнд шилжүүлэн суулгах зорилгоор худалдаалж наймаалах. (6-р долоо хоногийн хичээлээс нэмж судлах)

Хүний наймаа нь хэдхэн улсаар хязгаарлагдахгүй, дэлхий нийтийн үзэгдэл болж хувираад байгаа юм. Энэ төрлийн гэмт хэрэг нь дэлхийн бүх бүс нутагт ямар нэг хэмжээгээр оршсоор байгаа юм. Хүний наймаанаас урьдчилан сэргийлэх явдал нь push-and-pull буюу санаатай болон санаандгүй байдлаар хүмүүс энэ хэрэгт татагдан орох эсвэл хэн нэгний нөлөөгөөр хүчээр орох, хохирогч болох хүчин зүйлүүдээс хамаардаг. Push буюу түлхэх эсвэл хэн нэгнээс хамаарч энэ хэрэгт татагдах орох явдал нь ядуурал, ардчилалгүй байдал, хүйсийн тэгш бус байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, дайн мөргөлдөөн, зэвсэгт мөргөлдөөн, эмх замбараагүй байдлын дараах нөхцөл байдал, нийгмийн интеграци сул, ажлын байр боломж бага, боловсрол эзэмших боломжгүй байдал, ялгаварлан гадуурхах үзэл гаарсан, нийгмийн сүлжээнд (Facebook г.м) хэт хяналтгүй донтсон зэрэг багтана. Pull буюу татах, эсвэл энэ төрлийн гэмт хэрэгт татагдан орох. Үүнд аялж зугаалахад хялбар болсон, эх нутгаас нь өөр улс оронд амьжиргааны түвшин өндөр байгаа явдал, тухайн улс эсвэл салбарын ажилчдын хүсэлт эрэлт, өөр газар амьдрах боломж элбэг тохиолдох зэрэг хамаарна.

Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэгчид нь ганцаарчилж болон сүлжээ байдлаар ажилладаг. Эдгээр хүмүүс ихэнх тохиолдолд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогддог. Тэд гэмт хэргийн бүлэглэлийн үйл ажиллагаатай эрх ашгийн хувьд нэгдэж ажилладаг.  Наймааны сүлжээ нь дэлхийн улс төр болон эдийн засгийн өөрчлөлт, аялж зугаалахад саадгүй хялбар болсон байдал, харилцаа холбоо, эдийн засгийн даяарчлал зэргээс хамаарч тодорхой институци наймаалагдсан хүмүүсийг өөрийн эрхэнд болон бусдад ашиглуулаад тодорхой хэмжээний ашиг олдог (голдуу санхүү, мөнгөн хэлбэрээр).

Хүний наймаа нь маш олон хэсгээс бүрдсэн цогц үзэгдэл юм. Энэ гэмт хэрэгт олон төрлийн, өөр өөр зорилго бүхий хувь хүн, гэмт хэргийн бүлэглэл оролцдог.

Төрийн болон төрийн бус байгууллагууд боломжийнхоо хэрээр хүний наймааны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэж байгаа боловч 100 хувь таслан зогсоож, урьдчилан сэргийлж чадахгүй байгаа. Эцэст нь хүмүүсийг энэ гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэхийн тулд салбар салбарын байгууллагын олон талт үйл ажиллагаа зайлшгүй чухал юм.

*Семинар, ярилцлага:*

- Хүний наймаа болон хүнийг хил давуулан худалдаалах гэмт хэргийн ялгаа юу вэ? Grey zone буюу энэ хоёр гэмт хэргийн ижил төстэй байдал болон нэг гэмт хэрэг нь нөгөөдөө хэрхэн нөлөөлж, шилждэг талаар ярилц.
- Хүний наймаа болон хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогч хэн бэ? Улс үндэстэн үү? Гэмт хэрэгт орооцолдсон хувь хүн үү?
- Хүний наймааны гэмт хэрэгт хэн нэгний нөлөөгөөр татагдан орсон, орооцолдсон, хүчээр орсон зэрэг хүчин зүйлийг хүний наймаа болон хил давуулан худалдаалах гэмт хэрэг хоёр дээр ялгааг нь тайлбарлана уу?
- Наймааны төрөл болох бэлгийн мөлжлөг, хүнд хүчир хөдөлмөрийн мөлжлөг, арилжааны мэс ажиллагааны болон эрхтэн шилжүүлүүлэн суулгах мэс заслын зорилгоор хүний эд эрхтэнийг хүчээр авч наймаалцахаас гадна өөр ямар төрлийн мөлжлөгийн гэмт хэрэг байж болох вэ?
  - Хүүхдийн наймаа гэж юу вэ?
  - Хүний наймаачид өөр бусад ямар төрлийн зохион байгуулалтай гэмт хэргийн бүлэглэлтэй холбогдох вэ?

*Даалгавар (сонголтоор):* Хүний наймаанд татан оруулах, татагдан орох хүчин зүйлийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээс холбоотой мэдээ баримт цуглуулж хоёр хуудас мэдээ сурвалжлага бич. UNODC –ээс хүний наймааны шинж тэмдэгийн талаар дэлгэрэнгүй уншиж судал.

*Унших материал (заавал унших):* Оппонг (2012),Тодрес (2011).

*Унших материал (санал болгосны дагуу):*
Академик утга зохиол: Ароновиц( 2009) бүлэг1, Хүний наймаа гэж юу вэ? Ба 3, Хүний наймааны хэтийн төлвийг тодотгох нь; Бруч (2004); Бакерт ба Парент (2002); Чандран (2011);Иордан (2002); Окубо ба Шелли (2011); Солт (2000); Шелли (2010); Смит ба Кангаспунта (2011); Турнер ба Келлю (2009).

Үндэсний болон Олон улсын байгууллагын тухай унших материал:
Хүний наймаа, хүүхэд болон эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг . (2010,2012). Олон улсын баримт:НҮБ (2000a, 2000b).
Нэмэлт: Хэргийг ил болгогч (2010) (кино);.

## Долоо хоног 2: **Хүний наймааны хууль ёсны тодорхойлолт**

*Сэдэв:* Хүний наймааны хууль ёсны консепци, энэ төрлийн гэмт хэрэг болон хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл, амьдрал дээр тохиолдсон үйл явдал, шинээр гарч ирэх асуудлуудтай холбоотой хүний наймааны тодорхойлолтыг хууль ёсны болгох.

*Лекцийн зорилго:* Оролцогч оюутнуудад туслах

- НҮБ-ын Палермо Протоколын хүний наймааны тухай тодорхойлолтын талаарх ойлголт авах
- Хүний наймааны тодорхойлолтын дагуу энэ гэмт хэргийн талаар өргөн цар хүрээтэй ойлголттой болох.
- Энэ концепттой холбоотой тухайн эмзэглэж, зовж, шаналсан хүнийг гутаан доромжлох, зүй бусаар ашиглах зэрэг хүний наймаатай холбоотой түлхүүр зарчмын тодорхой ойлголттой болох
- Хүний наймааг нүүдэл, шилжин суурьшихтай холбосон ойлголттой болох
- Хүний наймааны гэмт хэрэгтнүүд шүүхийн өмнө дуудагдсаны дараа гарах асуултуудын талаар ойлголттой болох.

*Сэдвийн танилцуулга:* Хүний наймааны боолчлол, хараат байдал, хөдөлмөрийн мөлжлөг зэрэг бүх төрлийн мөлжлөг нь аль ч олон улсын хууль ёсны засгийн газрын хувьд хүний эрхийг зөрчсөнд тооцогддог. Ийм төрлийн гэмт хэрэг нь ноцтой асуудал болж, улс төрчид, шийдвэр гаргачдын анхааралд өртөх хүртлээ удаан цаг хугацааг туулсан. Энэ гэмт хэрэг нь 20-р зууны сүүлийн 10 жилд л олон улсын анхааралд өртөж, санаа зовоож эхэлсэн байна. Одоо бол хүний наймааг орчин үеийн боолчлол, мөлжлөгийн гэмт хэрэг гэж бараг бүгд хүлээн зөвшөөрөөд байна.

Энэ санаа зовоосон байдал нь НҮБ-ын Палермо Протокол буюу НҮБ-ын гишүүн орнууд хүний наймаа гэж юу, ямар төрлийн гэм хэрэг болох талаар тайлбарлаж, тодорхойлоход хүргэсэн юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 3-р зүйлийн(а)- гаар бол хүний наймаа нь:

> Энэ төрлийн бизнест хүн сургаж авах, зөөвөрлөх, тээвэрлэх, хоргодох байр олгох, хүн хүлээн авах, өөрөөр хэлбэл хүч хэрэглэх болон айлган сүрдүүлэх замаар, албадлагаар, хүүхэд эмэгтэйчүүдийг хүчээр байлгах, луйвар, залилан, хууран мэхлэх, эмзэг сул талыг нь ашиглан хүч хэрэглэх, хэн нэгнийг өөрийн сонирхолд нийцүүлэн ашиглах зорилгоор эрх мэдлээ ашиглаж хяналтандаа байлгахыг хамааруулна. Эрх мэдлээ ашиглах гэдэгт хүчээр биеийг нь үнэлүүлэх болон бусад төрлийн бэлгийн дарамт, хүнд хүчир хөдөлмөр хүчээр хийлгэх, боолчлох, эд эрхтэнийг авч, нь зарж борлуулах зэргийг хамааруулж тэдгээрийг хориглосон байдаг.
>
> (НҮБ-ын 2000а нэмж тодруулах)

Хүний наймааны олон улсын ерөнхий тайлбар тодорхойлолт нь дэлхийн хүний наймааны эсрэг концепци, тэмцэлд маш том түлхэц үзүүлж, хувь нэмрээ оруулсан. Ерөнхий тайлбар тодорхойлолт нь зөвхөн бэлгийн мөлжлөгийг хүний наймаа гэж үзээд зогсоогүй, бусад хэлбэр, ХАА-н салбарт хүчээр хөдөлмөр эрхлэхийг хүртэл хүний наймааны тодорхойлолтонд оруулж өгсөн юм. Эдгээрээс гадна өөр бусад салбарт байж болзошгүй мөлжлөг, албадлагыг гэмт хэрэг гэж үзэн нэмж оруулж болохыг нээлттэй үлдээсэн юм.

Хүний наймааны тодорхойлолтонд үндсэн 3 элемент тусгадсаныг дээрх тайлбараас харж болно. Энэ Протоколд багтсан 3 элемент нь хүний наймааны хамгийн их санаа зовоосон гол хүчин зүйл юм. Гэхдээ шинэ шинэ асуултууд урган гарч ирсээр байна. Жишээ нь, хүний наймааны гэмт хэрэг үйлдэж байгаа боолчлогч гэгдээд байгаа этгээд болон мөлжүүлэгч, хохирогчийн хооронд ямар харилцаа байна вэ? Хэзээ хүмүүс өөрсдийгөө гэмт хэргийн хохирогч, хэн нэгний эрхшээлд орсон гэгдээ мэддэг вэ? Хохирогч хэзээ, хаана бэлгийн хариуцлага хүлээдэг г.м.

Хүний наймааны тодорхойлолтонд тухайн хохирогч өөрөө зориуд мөлжлөгт өртсөн эсвэл үнэхээр санаандгүй орооцолдсон талаар оруулсан байгаа. Хүний наймаа хил давж болон хилийн дотор ч болдог. Гэмт хэрэгтнүүд ганцаарчилж болон гэмт хэргийн сүлжээтэй хамтарч ажиллана. Тодорохойлолтонд хэн нэгэн өөр хүнийг мөлжих болон өөр хүнд бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг үйлдэх боломж олгосон зэрэг заалтууд байгаа. Гэхдээ энэ нь гэмт хэргийн ертөнцөд тохиолддог эсэх нь тодорхойгүй. Тайлбар толинд зөвхөн шууд “Харгис”-аар бус, хүчирхийлэл

болон хүчирхийлнэ гэж сүрдүүлсэн бол гэсэн заалт байгаа. Гэхдээ энэ нь арай хөнгөн мөлжлөг, хөнгөн хүчирхийлэл гэсэн утгатай заалт биш юм. Энэ дүгнэлт нь хүмүүст мөлжүүлж доромжлуулах болон хараат байдлын талаар тодорхой ойлголт өгөх юм.

Хүний наймааны талаарх хууль ёсны концепцийг зөв, сайн ойлгох нь гэмт хэрэг болон, асуудал дараа өндөр авч, гэмт хэрэгтэн мөрдөгдөж, шалгагдан шүүхэд дуудагдахад шүүхийн өмнө хэлэх үгтэй байхад тустай юм. НҮБ-ын Палермо Протокол нь НҮБ-ын гишүүн орнуудыг өөрсдийн орны хүний наймааны гэмт хэргийн хуультай нийцүүлж, өөриймшүүлж ашиглахыг шаарддаг. Гэхдээ зарим нэгэн оронд энэ тодорхойлолтыг арай өөр байдлаар ойлгож хэрэглэхийг үгүйсгэхгүй. Мөн зарим бүс нутгийн хэмжээнд хэд хэдэн хүний наймааны эсрэг гэрээ, хэлэлцээр НҮБ-ын Палермо Протоколын зарчим дээр тулгуурлан хийж байгаа. Эдгээр өөр өөр хэлэлцээрийн талаар энэ 7 хоногтоо багтаж ярилцана. Гэхдээ унших материалаас эдгээртэй холбоотой олон улсын баримт, материалыг олж уншиж болно.

*Семинар ярилцлага:*

- Хүний наймааны хохирогчийг зориуд санаатайгаар мөлжлөгт байлгасан талаар 3(а) Протоколын зүйлийн заалтын хаана нь тусгагдсан байна. Та заалтыг хүлээн зөвшөөрөх үү?
- Ядуурал, гуйланчлал хүний наймаанд хэрхэн нөлөөлж, ямар үүрэг рольтой байна вэ?
- Хүний наймааны концепци болон мөлжлөг хэрхэн бие биенээсээ хамаарч байна. НҮБ-ын хүний наймааны талаарх тайлбар хүний наймааны мөлжлөг болсон газрыг шаардаж байна уу?

*Даалгавар: (Сонголтоор):* НҮБ-ын Палермо Протоколын заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаа бол үүнтэй холбоотой 2 хуудас мэдээ сурвалжлага дурын сэдвээр бич. Эсвэл O'Connell Davidson–ы хүний наймааны эсрэг зүйл хууль хэрхэн нөлөө үзүүлсэн талаар, эсвэл Stoyanova (2013) -ийн  Олон Улсын Протокол тухайн улс орны хуульд хэрхэн бууж, тусгагдаж байгаа талаар болон Болгар улсын хуульд НҮБ-ын Палермо Протокол хэрхэн хэрэгжиж байгаа сэдвээр 2 хуудас мэдээ дүгнэлт сурвалжлага бич.

*Унших Материал (заавал унших):* O'Connell Davidson (2013), United Nations (2000a). Унших Материал (Сонголтоор унших):

Академик уран зохиол: Brusca (2011), Fredette (2009), Heinrich (2010), Stoyanova (2013).

Олон улсын байгууллагуудын унших материал: UNODC буюу United Nations Office of Drugs and Crime (UNODC), эсвэл НҮБ-ын Хар тамхи, Мансууруулах бодистой тэмцэх алба (2012a, 2012b).

Олон Улсын баримт материал: African Union (1981), Arab Council of Ministers of Justice (2012), ASEAN (2004), Council of Europe (2005), European Union (2011), League of Arab States (2004), Organization of American States (1969), United Nations (1948).

## Долоо хоног 3: **Судалгаа ба Мониторинг**

*Сэдэв:* Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн судалгааны дадлага, арга барил, өгөгдөл цуглуулах, анализ болон мониторинг хийх үүрэг роль

*Лекцийн зорилго:* Оролцогч оюутнуудад туслах

- Хүний наймааны асуудлыг хэрхэн эрэн сурвалжлах мэдлэг олгох, судалгааны өргөн хүрээтэй арга зүй судалгаанд хэрхэн нөлөөлөх (жишээ нь судалгааны үр дүн асуултаас хамаарч болох) талаар мэдлэг олгоно.
- Хүний наймааны асуудлаар яаж судалгаа хийх чадварыг эзэмшинэ.
- Хүний наймааны асуудлаар судалгаа хийхэд тохиолдох хүндрэл, саад бэрхшээл, сорилтын талаар ойлголттой болно
- Хүний наймааны асуудлаар шүүмжлэлэтэй судалгаа хийх (тоо болон чанар)

*Сэдвийн танилцуулга:* Анхаарал татах- хүний наймааны асуудал 21-р зууны эхний жилүүдэд хэрхэн өссөн талаар, хүний наймааны цар хүрээ, энэ гэмт хэргийн үнэн мөн чанарыг таних талаар хэвлэл мэдээллийн анхаарлыг татах. Эхний 7 хоногийн хичээлээр хүний наймаа хэрхэн далд хэлбэрт явагддаг болон энэ төрлийн гэмт хэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэр болгон мэдээлээд анхааруулаад байх боломж олгодоггүй талаар үзнэ. Хаана, хэзээ энэ гэмт хэрэг болсон нь тогтоогддоггүй, олддоггүй талаар үзсэн. Тиймээс сэтгүүлчид хүний наймааны феноменон болон энэ талын судалгааг хэрхэн хийх, мэдээ хэрхэн олж авах талаар суралцах хэрэгтэй юм. (Жишээ нь мэдээний олдоц, үнэн зөв мэдээлэл эсэх)

Хүний наймааны нууцлаг үйл ажиллагааг хэрхэн яаж сурвалжлах, цуглуулсан мэдээ, материалаа хэрхэн боловсруулах, хөрвүүлэх зэрэг нь маш чухал юм. Жишээ нь, хэн нэгэн хүний наймаанд өртөж, “Далд ертөнц”-д хүчээр орлоо гэхэд түүний болон гэмт этгээдүүдийн үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хил хязгаар хэр том байхыг мэдэхгүй. Гэмт хэрэгтний хувьд хэргээ нуун дарагдуулах боломж хэр байгааг мэдэхэд хэцүү. Эдгээр бэрхшээл мэдээ мэдээлэл, өгөгдөл авч цуглуулах боломжоос гадна мэдээ хэр баттай, үнэн зөв болон хүчинтэй болох нь бас чухал.

Өгөгдөл цуглуулах тоон болон чанарын үзүүлэлт нь аль болох сайн нарийн нямбай байвал үр дүн сайн гарна. Эдгээр өгөгдлийг цуглуулахад ямар мэдээлэл авах боломжтой байхаас бас хамаарна. Чанартай судалгаанд ямар ч тоон болон статистик судалгаа хамаарахгүй. Зөвхөн сэтгүүл зүй, найруулга зүй, уран зохиол, дүгнэлт, газар дээрх талбайн судалгаанаас бүрдэнэ. Харин тоон судалгаа нь статистик болон тоон үзүүлэлтийг боловсруулна.

Судалгааны тооцоог гаргахдаа эхлээд мэдээж хүний наймааны голомт байж болох нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтооно. Гэхдээ жирийн сурвалжлага биш учир маш анхаарал болгоомжтой ажиллана. Судалгаа хийхэд гарах хүндрэл бэрхшээл гэвэл тооцоо судалгаа бус харин тооцоо мэдээний дүн яг таг биш эсвэл нарийн мэдээ мэдээлэл байхгүй, мөн баттай эх сурвалж эсэхийг нотлоход бэрх. Бусдаас харж байхад судалгааны үр дүнд шууд хамаардаг зүйл гэвэл тухайн улсын хууль эрх зүйн орчин, хүний наймаатай хэрхэн тэмцэж байгаа эсэх, тэмцэх хүсэл байгаа эсэх, эрэн сурвалжлах байгууллагын чадавхи, бүртгэл мэдээлэл зэрэг ордог.

Ийм шалтгаанаар тухайн судалгаагаар олсон материалуудаа нэг дор байрлуулж, хэргийн багахан хэсэг ил болсон үед гэмт хэргийн талаар яарч дүрслэл гаргах, тоон үзүүлэлт хийлгүй, харин байгаа материалдаа тулгуурлан цаашдын судалгаандаа сэжүүр, чиг гаргаж, шаардлагатай гэвэл судалгааны бодлогоо өөрчлөх хэрэгтэй.

Дата өгөдлөө цуглуулахдаа хохирогч, сэжигтэн, хууль зөрчигчийн мэдээллийг бүгдийг цуглуулах хэрэгтэй. Эдгээр мэдээлэл бүгд байхгүй бол судалгааны үр дүн бага байж хүний наймаатай дорвитой тэмцэхэд хүндрэл учруулна. Асуудлыг дэвшүүлэхдээ бид дараах асуултуудыг өөртөө тавина. Яг хаана хүний наймаа цэцэглэж байна? Асуудал хэр том байна? Ямар төрлийн хүний наймаа газар авч байна? Дата, мэдээллээ цуглуулж байхдаа мониторинг судалгаа хийж, хүний наймааны эсрэг

ажилд ямар дэвшил гарч байна, ямар зорилго биелэгдэв зэргээр судалгаагаа ажиглаж болох юм. Ингэж өөрийнхөө ажилд шүүмжлэлтэй хандсанаар Медиа зэрэг нийгмийн бүх салбарын оролцоог нэмэгдүүлнэ. Дээр дурьдсанчлан сэтгүүлчид хүний наймаатай холбоотой нотолгоо баримт материал дээр тулгуурласан мэдээ сурвалжлага бэлдэж, олон нийтэд цацах хэрэгтэй. Хүний наймаатай тэмцэхэд баталгаа, нотолгоотой, ардаа буух эзэнтэй, үнэн зөв мэдээлэл цацах нь илүү үр дүнтэй.

Хангалттай дата цуглуулахын тулд бараг бүх газрын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сэтгүүлч, хохирогч, аюулгүй бол гэмт бүлэглэл, хувь хүмүүстэй мэдээлэл солилцох хэрэгтэй. Хүмүүсийн эмзэг хувийн сэдвээр эрэн сурвалжлага хийж байгаа учир Төрийн болон ТББ-ууд нэмэр болохоосоо нэрмээс болдог. Хувийн мэдээлэл гэдэг утгаараа хохирогч болон холбогдох хүмүүс төрийн болон ТББ-уудад мэдээлэл өгөхөөс татгалздаг. Харин чөлөөт эрэн сурвалжлагч болон хүний наймаатай тэмцэж байгаа сэтгүүлчдэд ярилцлага өгөхөөс татгалздаггүй. ЕХ-ны Хүний Наймааны Заавар, Удирдамж (2-р 7 хоногийн хичээлийг хар) гаргаж, ЕХ-ны гишүүн орнууд улсын тусгай сурвалжлагчийг танилцуулсан. НҮБ мөн тусгай сурвалжлагчаа томилж, Хүний Наймааны эсрэг мэдээ сурвалжлага авах эрх олгосон. Тусгай сурвалжлагчийг НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл томилдог.

Олон улсын цар хүрээтэй хүний наймааны эрэн сурвалжлагад дата цуглуулж байгаа бол улс үндэстний хэмжээнд өргөн цар хүрээтэй хийж болдоггүй. Учир нь хохирогч болон сэжигтэн улс орон даяар мэдээллээр хангагдчихдаг тул сурвалжлагчийн хувьд нууц задарсан хэрэг болдог. Олон улсын түвшинд эрэн сурвалжлах, өгөгдөл цуглуулах нь үндэсний хэмжээнд мэдээлэл цуглуулахаас хүндрэл бэрхшээлтэй, эрсдэлтэй байдаг. Учир нь үндэсний түвшин (Долоо хоног 1, 2-оос үзэж тодруулаарай)-ний дата цуглуулах, анализ хийх, судалгааны байгууллагад ашиглагдаж байгаа арга зүй болон улс төр, нийгмийн тайлбар тодорхойлолт ялгаатай зөрүүтэй байдаг.

*Семинар, ярилцлага:*

- Хүний наймааны гэмт хэргийн газар нутгийн хэмжээ, хязгаар болон шинж чанарыг яаж сайн судлах вэ?
- Хүний наймааны гэмт хэргийн газар нутгийн хэмжээ хязгаар болон шинж чанарыг сайн судлаж, энэ талаарх ойлголтыг сайжруулахын тулд эрэн сурвалжлах сэтгүүлчид ямар үүрэг гүйцэтгэх вэ?

*Даалгавар (сонголтоор):* Хүний наймааны үйл ажиллагааны судалгааны талаар 2 хуудас шүүмж, анализ бич. Холбогдох материалыг International Labour Organization (ILO) буюу Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага ба United Nations Office of Drugs and Crime (UNODC) буюу НҮБ-ын Хар тамхи, Мансууруулах бодис, Гэмт хэрэгтэй тэмцэх алба зэрэг Олон улсын байгууллагуудын судалгааны материал, үр дүн, жилийн тайлан зэргээс олж судалж болно. Судалгааны үр дүн хэрхэн яаж гарсныг ярилц (сонгосон арга зүйг ашиглан). Мөн улс үндэстний болон олон улсын түвшин дэх хүний наймааны судалгаа хийхэд тулгарсан хүндрэл, бэрхшээл, цуглуулсан мэдээ материал, хэр баталгаатай, зөв зүйтэй мэдээлэл болох талаар ярилц.

Унших материал (заавал унших): Гүүдий (2008), Тюлдам (2010), Яанг (2009).

*Унших материал(санал болгох):*
Академик унших материал: Брановскис ба Суртийс (2012), Дэвид ба Саттон (2004), Гоулд (2010), Гоздкиак ба Коллетт (2005), Грей эт ал. (2012), Лазко (2005), Лазко ба Грамегна (2003), Маттар (2008), ОБрейн (2010), Парасий Дагивал (2012), Ритчей ба Льюис (2009), Сюртийс ба Граггс (2010), Тайлдам ба Брановскис (2005), Вейтзер (2012).
Үндэсний болон Олон улсын байгууллагын тухай унших материал: Хүн худалдаалах ба Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглахын эсрэг үндэсний баримт (2012), АНУ-ын Төрийн Департмент (n.d.), UNODC (n.d.b).

Нэмэлт: Артур (2010).

## Долоо хоног 4: **Хүний наймаа: Бэлгийн мөлжлөг болон биеэ үнэлэлтийн тухай ярилцлага**

*Сэдэв:* Бэлгийн мөлжлөг, бэлгийн наймаа, анализ ярилцлага

*Лекцийн зорилго:* Оролцогчдод зориулав:

- Бэлгийн мөлжлөгийн шалтгаан, үндэс, суурийн талаар ойлголттой болох
- Дэлхий, бүс нутаг, орон нутгийн зах зээл дэх секс ба бэлгийн ажлын эрэлт хэрэгцээний тухай ойлголт
- Биеэ үнэлэлт болон бэлгийн ажлын талаар ярилцлага сурвалжлага бэлтгэхэд

гол үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийн байр суурь, тэдний шүүмж, анализын талаар мэдлэг, чадвартай болох

- Биеэ үнэлэлт болон бэлгийн ажлын талаар өөр өнцөг, байр сууринаас ойлгох, ярилцах чадвартай болох

*Сэдвийн танилцуулга:* Энэ долоо хоногийн хичээлээр хүний наймаа, тэр дундаа бэлгийн мөлжлөгийн зорилгын талаар илүү анхаарч үзэх болно. Бэлгийн мөлжлөг нь манай гарагийн өнцөг булан бүрт оршдог. Үүнд эрчүүд, эмэгтэйчүүд болон хүүхдүүд ч холбогдсон байдаг. Хүний наймаа гэдэг ойлголтонд бэлгийн мөлжлөг, гол анхаарлын төвд байсан сексийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэхэд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлдөг.

“Балба улсын бэлгийн наймаа”  (Хеннинк ба Симхада 2004) нийтлэлд бичсэнээр Балба эмэгтэйчүүд биеэ үнэлэхээр Энэтхэг улсыг зорьдог. Хохирогчид нь бага насны охид. Биеэ үнэлэх асуудалд тухайн улс орны, өөр өөр соёл иргэншилтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаа голчлон нөлөөлдөг. Жендерээс хамаарсан нийгэм болон эдийн засгийн тэнцвэргүй байдлаас хамаарч эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол бэлгийн мөлжлөгт өртөх нь их байдаг. Үүнээс жендерийн тэгш бус байдал бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдэж байгаа хүний наймааны гэмт хэргээс сэргийлэх арга байж болох юм гэж харж болно. Хүмүүсийг гутаан доромжилж эмзэг мэдрэмтгий байдалд оруулах явдал газар авч байгаа нь тухайн бүс нутгийн  нийгэм болон эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч байгаа юм. Өөр нэг хүчин зүйл гэвэл олон улсын хэмжээнд хөрөнгө чинээтэй холбоотой, интернэт зэрэг мэдээллийн технологи, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн түрэмгийлэл, цэргүүдийн бөөгнөрөл зэрэгт эрчүүд секс хүсэх эрэлт байгаа нь биеэ үнэлэхийг эдийн засгийн хувьд дэмжиж, хүмүүсийг бэлгийн мөлжлөгт татан оролцуулах том хүчин зүйл болж байна.

Бэлгийн мөлжлөг нь одоо дэлхий нийтийн санааг зовоосон “Шүдний өвчин” болоод байгаа. Ер нь энэ төрлийн гэмт хэрэг маш олон улс орны санааг зовоож байна.  Хүүхдийн биеийг үнэлүүлэх явдал нь манай дэлхийн хаана ч бэлгийн мөлжлөгт тооцогддог. Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд дэлхийн улсуудын соёл болон нийгмийн харилцаанаас хамаарч өөр өөр байдаг. Жишээ нь: ялангуяа барууны орнуудад насанд хүрсэн хүн биеэ үнэлэх  нь хүний наймаанд тооцогддоггүй. Биеэ үнэлж байгаа хүн хууль ёсны ажил хийж байна гэж хуулиар хамгаалагдаж энгийн ажил мэтээр хүлээн авч, тэд ч улсдаа татвар төлдөг. Бэлгийн мөлжлөгийн зорилготой

хүнийг наймаалж байгаа хүчин зүйл дэлхийн хаа нэгтэйгээс хамаарч хоорондоо өөр өөр байдаг. Мөн бэлгийн мөлжлөгийн төрөл нь ч янз бүр.

Тухайн улс үндэстний соёлын гарал үүслээс хамаарч бэлгийн мөлжлөгийн төрөл өөр өөр байдаг ч нэгэнт хүний эрх зөрчигдөж байна гэж үзэж байгаа бол тэмцэх л хэрэгтэй.

*Семинар, ярилцлага:*

- Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хийж байгаа хүний наймааны гэмт хэргийн талаар ойлгоход тухайн улсын соёл, гарал үүсэл ямар үүрэг рольтой вэ?
- Биеэ үнэлэх байдлыг либеральчилж чөлөөтэй болгох нь зарим хэсэгт нийгмийн ичгүүр сонжууртай байдал гэж үзэгддэг. Биеэ үнэлэх байдлыг зөвшөөрч байна уу?
- Биеэ үнэлэхэд хүргэдэг нөлөөлөл нь хүний наймаатай тэмцэх ойлголтоос ямар ялгаатай вэ?

*Даалгавар:* Бэлгийн мөлжлөгийн судалгааны талаар 1000 үгтэй бие даалт хийх. Сэдвийн хувьд бэлгийн мөлжлөг соёл болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлээс хэрхэн шалтгаалж байгаа болон бэлгийн мөлжлөгийн тархалтанд эдгээр хүчин зүйл яаж нөлөөлөх талаар. Мөн эдгээр хүчин зүйл нь бэлгийн мөлжлөгийн зорилготой хүний наймаатай тэмцэхэд яаж нөлөөлж байна вэ?
Унших материал (заавал унших):, Гомез эт ал. (2001), Хеннинк ба Симхада (2004, ялангуяа ху. 1–27).

*Унших материал (Санал болгосон):*
Академик уран зохиол: Агустин (2008), Брүүкс-Гордон (2006), Камерон (2008), Фэрлей (2003), Жеффрийс (2009), Маларек (2009), Салазар-Парренас (2011), Велтзер (2007).

Нэмэлт: Афганистаны бүжигчин хөвгүүд (2010), Энэхтхэгийн хүний наймаа (2011), Нарсий ба Черней (2013), Азийн чөлөөт радио (n.d.).

## Долоо хоног 5: Олон улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн ба хөдөлмөрийн мөлжлөг

*Лекцийн зорилго:* Оролцогчдод зориулав:

- Олон улсын ажиллах хүчний нүүдэл, шилжилт хөдөлгөөний суурь үндэс шалтгааны тухай ойлголт
- Глобалчлал, олон улсын ажиллах хүчний нүүдэл болон хүний наймаа зэргийн уялдаа холбооны ойлголт
- Бэлгийн мөлжлөгийн зорилготой хүний наймааны суурь механизмын анализ, үнэлэлт дүгнэлт.
- Бэлгийн мөлжлөгийн зорилготой хүний наймааны хууль дүрэм, шалтаг шалтгааныг дүгнэж цэгнэх

*Сэдвийн танилцуулга:* Өнөөгийн даяарчлагдсан ертөнцөд хүмүүс өөр өөр газар баян ядуу гээд янз бүрийн түвшинд амьдарч байна. Мөн техник технологи хөгжсөн, унаа зам тээвэр хөгжсөн зуунд хүмүүс амьдралын боломж хайн нүүдэллэж, шилжилт хөдөлгөөн ихэссэн. Нэгдүгээр долоо хоногийн хичээлээр бид хүний наймааг маш олон өнцөгөөс тайлбарлаж болохыг үзсэн.  Энэ долоо хоногт олон улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, түүнтэй холбоотой үйл ажиллагааны талаар ярилцах болно.

Олон улсын ажиллах хүчний нүүдлийг Олон Улсын Хөдөлгөөний байгууллагаас тухайн орны хүмүүс ажил олж амьдралаа дээшлүүлэх зорилгоор өөр улс руу нүүж шилждэг гэж тайлбарласан. Тэгэхдээ энэ төрлийн нүүдэл нь үргэлж хоёр болон түүнээс дээш улсын хилээр нэвтэрч ажил олох зорилгоор нүүж, шилжиж байгаа гэж үздэг. Энэ долоо хоногийн хичээлээр хүмүүс ажил олох зорилгоор нэг газраас нөгөө газар руу хэрхэн нүүдэллэдэг талаар ярилцах болно. Нэгдүгээр долоо хоногт бид тухайн хүн хүний наймаанд хэрхэн татагддаг эсвэл хүчээр ордог болохыг үзсэн. Үүнтэй адил хүмүүсийн ажиллах хүчний нүүдэл хөдөлгөөн нь ажил олох зорилгоор хил давж гадны улсыг зорьдог гэсэн онол бий.

Гэхдээ энэ нүүдлийн механизмын ‘dark side’ буюу “хар тал” эсвэл “хар сүүдэртэй тал” гэж хэлж болох олон улсын ажиллах хүчний нүүдэл нь ихэнхдээ хөдөлмөрийн мөлжлөгөөр төгсдөг. Сео-Янг Чо (2012)-ийн нийтлэлд хөдөлмөрийн мөлжлөгийн

зорилготой хэд хэдэн хүний наймааны хүчин зүйл үйлчилж байна. Түүнийхээр бол ихэнх хүний наймааны мөлжлөгийн хохирогч золиос нь ажил хайж нүүн шилжсэн хүмүүс байдаг. Гэхдээ түүний судалснаар бүх цагаачдыг хүний наймааны золиос гэж ойлгож болохгүй. Энэ долоо хоногийн семинараар хөдөлмөрийн мөлжлөг болон ажиллах хүчний нүүдлийн гол шалтгааны талаар  судалж үзнэ. Шведийн хойд хэсэгт шилжин суурьшсан Тайландын жимс түүгчид Олон улсын ажиллах хүч нэрээр очоод хүний наймаа болж хувирсан нь хөдөлмөрийн мөлжлөгийн тод жишээ юм.

*Семинар ярилцлага:*

- Чогийнхоор бол аль нь push-and-pull буюу түлхэх-ба-татах, эсвэл хөдөлмөрийн мөлжлөгт санаатай болон санаандгүй байдлаар татагдан орох үзэгдэл вэ? Та бүхэн өөрийнхөө улс оронд энэ үзэгдлийг олж харсан уу? Тийм бол нэрлэнэ үү.
- Нүүдэл шилжилт хөдөлгөөн болон хүний наймааны харилцан хамаарал нөлөөллийн талаар яаж ойлгох вэ?
- Шведийн хойд хэсгийн Тайланд жимс түүгчдийн хувьд “түлхэх-ба-татах” хүчний аль хүчин зүйл нь үйлчилсэн бэ? (Салтмарш, 2010; Вүүлфсон гм., 2012)?  Аль шийдвэрлэх хүчин зүйл жимс түүгч ажилчдыг хөдөлмөрийн боолчлолд оруулсан бэ?

*Даалгавар (Сонголтоор):* Хүний наймаанд уруу татах хүчин зүйлийн талаар бие даах ажил хийх Салтмарш (2010).

*Унших материал (Заавал унших):* Cho (2012, ялангуяа хуудас. 253–64), Салтмарш (2010), Вүүлфсон гм. (2012).

Унших материал (санал болгосон) Академик уран зохиол: Андерсон ба Андрийжасевик (2008), Балес 2007, 2012), Делгадо Вайс ба Маркюүз Коваррюбиас (2012), ILO (2013), IOM (n.d.), ОКоннелл Дэвидсон (2013), Пийке гм. (2004), Шамир (2012).

**Долоо хоног 6: Хүний эд эрхтэнг шилжүүлэн суулгах зорилго бүхий хүний наймаа**

Сэдэв: Хүний эд эрхтэнг шилжүүлэн суулгах зорилгоор авахад зориулсан хүний наймаа болон наймаа-эрхтэн шилжүүлэн суулгах, худалдаа арилжаа-эрхтэн шилжүүлэн суулгах аялал жуулчлал. Арилжааны зорилгоор эд эрхтэнээ хандивлах улс төрийн маргаан мэтгэлцээн

*Лекцийн зорилго:* Оролцогчдод:

- Хүний эд эрхтэнг шилжүүлэн суулгах зорилготой хүний наймаа болон наймаа-эрхтэн шилжүүлэн суулгах, худалдаа арилжаа-эрхтэн шилжүүлэн суулгах аялал жуулчлалын талаарх ойлголт.
- Хүний эд эрхтэнг хүчээр салгаж авах болон хүний наймааны харилцан уялдааны талаарх ойлголт.
- Арилжааны зорилгоор эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал болон эрхтэн шилжүүлэн суулгах аялал жуулчлалын суурь, нийгмийн асуудлын талаарх ойлголт.
- Дэлхий даяар ховордоод байгаа хүний эд эрхтэнг зарж борлуулах мэтгэлцээн, нөлөөлөл тэдгээрийн үүрэг ролийг таньж мэдэх.
- Дэлхий даяар ховордоод байгаа хүний эд эрхтэний асуудлыг хэрхэн зохицуулах талаар шүүмжлэлтэй дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэх.

*Сэдвийн танилцуулга:* 2008 онд Турк улсын Истанбул хотын тунхаглалаар хүний эд эрхтэнг шилжүүлэн суулгаж болох талаар тайлбарлаж дэлхий нийтэд зарласан. Тунхаглалаар эд эрхтэнийг шилжүүлэн суулгах нь хүн төрөлхтний 20-р зууны эрүүл мэндийн шинжлэх ухааны гайхамшигт ололт гэж зарласан. Уг тунхаглалын дараа амьдрах боломжгүй маш олон өвчтөн эрхтэн шилжүүлэн суулгаснаар амь аврагдсан.

Гэхдээ эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал нь аажимдаа өөрийн амжилтын хохирогч, золиос болж хувирсан. Амбагтшийр гм “Хүний эд эрхтэний төлөөх дайн: Эд эрхтэний наймаа болон эрхтэн шилжүүлэн суулгах аялал жуулчлал” товхимолыг хэвлүүлсэн (2013). (Энэ долоо хоногт унших шаардлагатай). Зохиогчийн судалснаар хүний эрхтэний хэрэгцээ хэрээс хэтэрч нийлүүлэлт яваандаа тасалдаж эхэлсэн. Амь тавьж байгаа өвчтөнүүд ямар ч үнээр хамаагүй, ямар ч замаар хамаагүй гадны улс орноос хүний эд эрхтэн худалдан авах “аян дайн”-д мордсон. Энэ их хүсэл тэмүүлэл нь эд эрхтэний зорилготой хүний наймааг гаарууулсан байх магадлалтай. Судалгаагаар бол энэ чиглэлийн хүний наймаанд өртөгсөд нь ядуу буурай орноос гаралтай, ядуу зүдүү амьдралтай хүмүүс юм байна.

Энэ долоо хоногт хүний эд эрхтэнийг шилжүүлэн суулгах зорилготой хүний наймааны суурь гарал үүслийн талаар судлана. Унших материалд дурьдсанчлан эд эрхтэний хомсдол, дутагдал болон эд эрхтэн шилжүүлэн суулгах, худалдаа арилжааны зорилготой эрхтэн шилжүүлэн суулгах аялал жуулчлал нь буурай орны хүмүүсийг эд эрхтэнээ зарах цаашлаад хүний наймаанд өртөх эрсдэлд оруулж

байгаа талаар, эд эрхтэний хомсдолын эсрэг яаж тэмцэх талаар үзнэ. Бодлого шийдвэрийн хувьд эдгээр асуудалд яаж хандах вэ? Үүний эргэн тойронд үүсээд байгаа асуудлын талаар ойлголт авах болно.

Энэ агуулгад “altruism” буюу өөрийгөө мартан бусдыг энэрэх үзэл гол байр суурийг эзлэнэ. Үүнд, хүний эд эрхтэний хомсдлыг шийдвэрлэхийн тулд арилжааны болон хандивын замаар эд эрхтэний нийлүүлэлтийг хангах гэсэн үзэл давамгайлж байгаа хэдий ч мэтгэлцэгч нөгөө тал энэ нь аюултай бөгөөд хүний наймааг дэвэргэнэ гэж үзэж байгаа. Мөн “altruism” буюу өөрийгөө мартан бусдыг энэрэх үзэл гол байр суурийг эзлэнэ гэсэн үзэл нь асуудлыг шийдэж чадахгүй. Амбагтшийр гм. (2013), Цаашлаад хүний наймааны гэмт хэргийг нэмэгдүүлэх магадлалтай юм байна.

Энэ 7 хоногийн хичээлээр сэдэвтэй холбогдуулан эрэн сурвалжлах сэтгүүлчид нийгмийн асуудлыг хэрхэн шийдэх. Ентмэн (1993)-ий эрхтэн хандивлах талаарх түүний үзэл бодол, асуудлыг арай өөр өнцгөөс харж байгаа талаар бид үзэх болно.

*Семинар ярилцлага:*

- Ямар нийгмийн асуудал эдийн засгийн, арилжааны эд эрхтний асуудлыг тайлбарлаж чадах вэ?
- Аль хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрхтэн хандивлах болон арилжаа, худалдааны зорилготой хандивын талаарх асуудалд таарч тохирох вэ?
- Даалгавар (Сонголтоор): Иран улс дахь арилжааны эд эрхтний хандивын боломжийн талаар судалж, дүгнэлт хийгээрэй. Учир нь Иран улс эд эрхтэн хандивласны хариуд, шагнал, урамшуулал, нөхөн олговор олгодог дэлхий дээрх цорын ганц улс юм.

*Унших материал (заавал унших):* Амбагтшийр гм. (2013), Ентмэн (1993), Хүний наймаа болон аялал жуучлалын олон улсын чуулган (2008).

Унших материал (Санал болгосон):
Академик унших материал: Бергланд ба Люндин (2011), Бюдиани-Сабери ба Карим (2009), Европын Зөвлөл (2009), Жансен гм. (2013), Люндин (2012), Моазам гм. (2009), Монирюззамэн (2012),9 Падилла гм. (2013), Рандолф Биард гм. (2013), Сандор гм. (2013), Счепер-Хагхес (2011), Счиктанз ба Хоейр (2013), Яиа (2010).
Улс үндэстэн болон Олон улсын байгууллагын талаар унших материал: ECCP (2012), WHO (2009).

**Долоо хоног 7: Хүний наймаатай тэмцэх олон улсын хамтын ажиллагаа**

Лекцийн зорилго: Оролцогчдод:

- Хүний наймаатай тэмцэх олон улсын хамтын ажиллагааны 5 P - урьдчилан сэргийлэх, хамгаалах, яллах ажиллагаа, шийтгэх, түншлэл гэсэн 5 зарчмын ойлголт
- Хүний наймаатай тэмцэх олон улсын хамтын ажиллагаа болон олон улсын үзэл бодлын тухай ойлголт
- Хүний наймаатай тэмцэх олон улсын хамтын ажиллагааны хүний наймаатай тэмцэх арга замуудын тухай ойлголт
- Хүний наймааны эсрэг тэмцэх Олон улсын үйл ажиллагааны ойлголт
- Олон улсын хамтын ажиллагааны талаарх шүүмжлэлтэй дүгнэлт гаргах чадвар.

*Сэдвийн танилцуулга:* Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хүний наймааны эсрэг тэмцэх гол түүчээ болдог. Тухайн улс орны хүний наймааны эсрэг тэмцэл болон олон улсын төвшин ямар байгаа вэ? Үр дүнтэй байгаа юу? Хүний наймааны талаар сэтгүүлчид ямар асуудалтай тулгарч байгаа вэ? Тухайн улс орны хүний наймааны эсрэг тэмцэл болон олон улсын түвшний бодлого ямар байгаа вэ? Олон улсад үйл ажиллагаа явуулдаг хүний наймааны гэмт хэргийн бүлэглэл байгаа юу? Тэдний эсрэг улсууд яаж хамтарч ажиллаж, тэмцэж байгаа вэ? Энэ тэмцэлд аливаа байгууллагын хувьцаа эзэмшигчид нэгдсэн байгаа тул улс үндэстэн болон олон улсын хэмжээнд маш олон төрлийн хамтрагч нар нэгдэж тэмцэж байгаа эсэх.

Олон улс болон бүс нутгийн хууль эрх зүйн хүрээнд улс орнууд тодорхой хариуцлага болон үүрэг хүлээж байгаа. Жишээ нь дараах байгууллагууд: (НҮБ-ын Протокол, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг болон хүний наймааг таслан сэргийлэх НҮБ-ын конвенцийн нэмэлт (2000); Хүний наймааны эсрэг үйл ажиллагааны Европын зөвлөлийн конвенц (2005); Хүний наймааны талаарх Европын Холбооны удирдамж (2011); Зүүн Өмнөд Азийн Үндэстнүүдийн Холбоо (ASEAN) Хүний наймааны эсрэг ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг хамгаалах тунхаг, (2004); Арабын хүний наймаанаас урьдчилан сэргийлэх цогц стратеги (2012) гэх мэт).

Зарим байгууллагуудыг 2-р долоо хоногт дурьдсан. Эдгээр олон улсын байгууллагууд бусад байгууллагуудтай хамтран хүний наймааны эсрэг тэмцэхэд гол чиглүүлэгч нь болдог. Мөн энэ байгууллагууд 5 P буюу тэмцлийн эсрэг олон улсын дуу хоолой болж өгдөг:

- Prevention – урьдчилан сэргийлэх. Хүний наймаанаас урьдчилан сэргийлэх олон улсын үүрэг: Хүний наймаа анх үүсэж цэцэглэсэн улс орон, транзит буюу дайран өнгөрөх улс орон багтдаг. Жишээ нь, хүний наймаанаас урьдчилан сэргийлэхийн тулд иргэдийг мэдээллээр хангах компанит ажил өрнүүлж, сургууль зэрэг хохирогч болж болзошгүй газруудад сургалт явуулдаг.
- Protection of victims – Хохирогчийг хамгаалах: хүний эрхийн түгээмэл тунхаглал, олон улсын болон бүс нутгийн байгууллагууд хамтран хохирогчдыг хамгаалах үүрэг хариуцлага хүлээдэг. Хохирогчдод бие эрхтэний, сэтгэл санааны болон нийгмийн дэмжлэг хэрэгтэй байдаг. Тэдэнд эрүүл мэнд, нийгмийн хангамж, хоргодох байр, цагаачлалын үйлчилгээ эсвэл түр амьдрах газар, хуульч зэргээр тусалдаг. Төрөлх эх орон руугаа буцахыг хүссэн хохирогчдод дахин гэмт хэргийн золиос хохирогч болгохгүйн тулд сургалт зөвлөгөө өгдөг. Тухайн хохирогчийн төрөлх эх оронд нь хүний наймаанд өртөх эрсдэл хэр байгаа талаар мониторингийн судалгаа явуулсан байдаг.
- Prosecution of offenders – Хууль зөрчигчийг яллах: Хуулиараа бол тухайн улс олон улсын өмнө хууль зөрчигчийг эрэн сурвалжилж, яллаж шийтгэх үүрэг хүлээдэг. Олон улсын хамтын ажиллагааны байгууллага нь бусад байгууллагуудыг чиглүүлж тагнуулын мэдээлэл солилцох зэргээр үйл ажиллагаанд нь оролцдог. Жишээ нь JIT – хамтарсан эрэн сурвалжлах баг олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцдэг. Энэ байгууллага нь Европын Холбооны гишүүн улсуудын хоёр ба түүнээс дээш гишүүнээс бүрдсэн байдаг. Criminal investigations – Гэмт хэргийн Эрэн сурвалжлах байгууллага нь ЕХ-ны гишүүн улсуудаас бүрдсэн. Европол байгууллага нь гишүүн улсуудтайгаа мэдээлэл солилцдог. Европол нь шинжээч, техник тоног төхөөрөмжөөр олон улсын эрэн сурвалжлах багийг хангадаг. Гэсэн ч хүний наймаа маш нууц далд хэлбэрт явагддаг тул тэдэнд бэрхшээл гардаг. Хохирогчид тэр болгон ил гарч ирж эдгээр байгууллагуудтай хамтарч ажилладаггүй. Учир нь хохирогчид тэр болгон өөрсдийгөө хохирсон гэж үздэггүй. Иймд эрэн сурвалжлах ажиллагаанд хойрго ханддаг.
- Punishment of offenders – Хууль зөрчигчийг шийтгэх: Улс орнууд олон улсын өмнө өөрсдийн газар нутаг дээр хууль зөрчсөн, хүний наймааны гэмт хэрэг үйлдсэн хууль зөрчигчийг шийтгэх үүрэг хүлээдэг. Гэхдээ хууль зөрчигчид заримдаа нэгээс дээш оронд үйл ажиллагаа явуулдаг учраас өөр улсын өөр шүүхэд очих магадлал бас байдаг. Тиймээс хүний наймаатай тэмцэж байгаа улс орнууд мэдээлэл болон мэдлэгээ солилцож байх шаардлага тулгардаг. Жишээ нь UNODC бусадтай датабэйсээ солилцдог.
- Partnership – Түншлэл: Маш олон мэргэжлийн агентлагууд хүний наймааны эсрэг тэмцэлд нэгдсэн байдаг. Гэхдээ тэд хамтарсан шийдэлд хүрэх шаардлагатай

байдаг. Учир нь хоёр ба түүнээс дээш улсын хамтын ажиллагаа маш чухал. Ялангуяа олон улсын Төрийн болон Төрийн Бус Байгууллагууд интеграцид орж бие биетэйгээ илүү нягт ажиллах шаардлага гардаг.

Олон улсын хүний наймааны эсрэг тэмцлийг зөвхөн дотоодын байгууллагууд ганцаараа шийдвэрлэж чадахгүй.
НҮБ-ийн Палермо Протоколын 2(с)-р зүйл (НҮБ 2000а)-д хүний наймаатай тэмцэхийн тулд олон улс орон хамтарч ажиллавал илүү үр дүнтэй гэж заасан байдаг.

*Семинар ярилцлага:*

- Хүний наймааны эсрэг олон улс хамтарч тэмцэхэд дээр дурьдсан 5 P гол үүрэгтэй. 5 P-ын талаар аль хэдийн дурьдсан ба эдгээртэй холбоотой өөр ямар жишээ байна вэ?
- Олон улс хүний наймааны эсрэг хамтарч ажиллахад ямар ямар хүндрэл бэрхшээл, сорилт шалгуур байна вэ?
- Өнгөрсөн 7 хоногийн хичээл дээр дурьдсан 5 P-тэй ижил төстэй хамааралтай ямар зүйл байна вэ?

*Даалгавар (сонголтоор):* Дараах сэдэв, чиг үүргийн дагуу 2 хуудас мэдээ сурвалжлага бич.

Улс үндэстэн болон олон улсын түвшинд хүний наймааны асуудалтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан тодорхой онцгой үйл явдлын талаар дараах хариултын дагуу бичээрэй.

- Хүний наймааны асуудал гэж юу вэ? (хохирогч, наймаачин, бүх төрлийн мөлжлөгүүд гэх мэт)
- Хаана, ямар улсад хүний наймааны асуудал хамгийн их гардаг вэ?
- Тухайн орны хувьд хүний наймааны эсрэг яаж тэмцэж юу хийсэн бэ? (Наймааны эсрэг тэмцэхэд хэн, ямар аргаар тэмцсэн бэ?)
- Хүний наймааны эсрэг тэмцэхэд улс үндэстний хэмжээний тэмцэл яаж олон улсын тэмцэлтэй нэгдэж хамтарч ажиллаж чадсан бэ?
- Хүний наймааны эсрэг тэмцэхэд өөр юу хийж болох вэ? Сэтгүүлч хүний хувьд юу хийх вэ? Онцлоно уу?

*Сонголт:* Зарим судлаачид тухайн хүн өөр улс оронд нүүж очоод хууль ёсны амьдрах статус, бичиг баримт, орон байргүйгээс хүний наймаанд өртдөг гэж маргадаг. Хууль бус цагаач иргэд гэмт хэргийн золиос болох гол шалтгаан юу вэ? Цагаач иргэдийн хяналт үндэсний аюулгүй байдлын ажиллагаа, амьдрал дээр хэрхэн зохицож амьдардаг вэ?
(Хариулт нь: Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа хүний наймааны тодорхой судалгаанд тулгуурласан байж болно. Хүний наймааны асуудал болон хүнийг хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг нь ямар нэгэн байдлаар холбоотой бөгөөд нэг нь нөгөөдөө шилжиж байдаг)

*Унших материал (Заавал): Гехт* (2008), Маттар (2005).

*Унших материал (санал болгосон):*
Академик унших материал: Бак (2007), Арабын Хууль Зүйн Сайдуудын Зөвлөл (2012), Грей гм. (2012), Грабб ба Беннетт (2012), Хелмберг (2007), Обокота (2010), Хамгаалах. (2012), Рейнолдс (2011), Рижкен (2006).

Олон улсын бичиг баримт: ASEAN (2004), Европын Зөвлөл (2005, 2011), Европын Зөвлөл болон Африкын Мужууд (2006), Нэгдсэн Үндэстний Байгууллага (1948, 2000а).

Нэмэлт: Эмэгтэйчүүдийн наймаа (2007), баримтат кино (25 минут): Зүүн Европын орнуудын эмэгтэйчүүдийн наймааны талаарх мэдээлэл, бүс нутгийн хүний наймааны эсрэг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, олон улсын байгууллагуудын оролцооны талаар гардаг.

## Долоо хоног 8: **Хэвлэл мэдээлэл ба ёс зүйн асуудлууд**

*Сэдэв:* Хүний наймааны эсрэг олон нийтийн оролцоо мэдээлэлтэй байх, ёс зүйн асуудал амьдрал дээр хэрэгжүүлэх эрэн сурвалжлах сэтгүүлчийн хариуцлагын тухай авч үзнэ.

*Лекцийн зорилго:*Оролцогчдод:

- Наймааны эсрэг тэмцэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг оролцооны талаарх ойлголт

- Хүний наймааны талбар голомт дээр ажиллаж байгаа эрэн сурвалжлах сэтгүүлчдийн ёс суртахууны дилеммын талаарх ойлголт
- Хэргийн газар ажиллаж байгаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн өнгөрсөн 7-н лекцээр сурсан хүний наймааны тухай хичээлээс ашиглан амьдрал дээр хэрэгжүүлэх

*Сэдвийн танилцуулга:* Хүний  наймааны эсрэг тэмцэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл маш их үүрэгтэй. Хүмүүсийг боловсруулаад зогсохгүй мэдээлэл өгч, болгоомжлуулж урьдчилан сэргийлэх ёстой. Мэдээлэлтэй байж урьдчилан сэргийлэх нь хүний наймаанд өртөхгүй байх эхний шат юм.  Хүмүүс тухайн гэмт хэргийн талаар мэдээлэлтэй байхад хэвлэл мэдээллийн хэрэгсэл маш их үүрэгтэй. Бас нийгэм олон нийтээс дэмжлэг оролцоо авахад нь тэдэнд мөн ихээхэн дэмжлэг болох юм.

Гэхдээ ямар нэгэн аюулгүйгээр эрэн сурвалжлах сэтгүүлчдийн хувьд жинхэнэ бодит мэдээлэл болсон түүхийн талаар мэдэж авахад маш их бэрхшээл тулгардаг. ( 3-р долоо хоногийн хичээлийг үзээрэй.) Маш сайн зохион байгуулалттай, тэнцвэрээ хадгалсан шийдвэртэйгээр хүний наймааны талаар ёс суртахууны дилеммтэй хандаж аль болох үнэн зөв мэдээлэлд ойртох боломж бий.

Мэдээлэл авах зорилгоор хохирогч болон сэжигтэнтэй ойр ажиллахад эдийн засгийн институцийн эсвэл сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндийн дарамт тэдэнд ирдэг. Тиймээс хэргийн газар ажиллаж байгаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хувьд тухайн судалгааны ажилд оролцохоос татгалзах эсвэл судалгаагаа үргэлжлүүлэх, зөв сонголт хийх хэрэгтэй. Эндээс сэтгүүлчдийн хувьд хохирогчтойгоо ажиллахдаа ямар цар хүрээтэй, хэр ойр зайнаас, харилцааны ямар хязгаартай ажиллах вэ гэдэг нь хамгийн гол зүйл юм. Дата цуглуулах зорилгоор хохирогчтой хийсэн ярилцлага нь хохирогчийг эрсдэлд оруулах магадлалтай байдаг.  Олон улсын ёс суртахууны стандартыг мөрдөөгүй өгөгдөл цуглуулах арга нь ёс суртахуунгүй ярилцлагын техник болж хувирдаг. Жишээ нь хүний наймааны талаар тухайн хохирогчийн аюулгүй байдал болон эрүүл мэндтэй холбоотой шууд асуултууд, түүний туулж өнгөрүүлсэн амьдралын талаарх асуултууд зэрэг нь хохирогчийг дахин энэ гэмт хэрэгт түлхэх, дахин золиос болгох эсвэл эрүүл мэнд болоод сэтгүүл зүйн хувьд дахин гэмтээх эрсдэлтэй байдаг.

Эрэн сурвалжлах сэтгүүлчид өөрийн сурвалжлагад зориулж аль болох их дата

материал цуглуулдаг. Тэдний хувьд цуглуулсан материал нь тэдний өөрсдийн болон бусдаас олж авсан мэдээлэл байдаг. Судалгааны материал нь нэг төрлийн интервенци, оролцоо байдаг тул сэтгүүлчид ёс суртахуунтай байж дата цуглуулах зөв техник эзэмшсэн байх ёстой. Ёс суртахууны сахилга батын тухай хэд хэдэн гарын авлага, код байдаг. (Санал болгосон унших материалаас харна уу) Сэтгүүлчид ярилцлага авч байгаа болон мэдээлэл авч байгаа эсвэл хохирогч сэжигтэн хэнтэй ч ойр ажилласан судалгааныхаа зорилгын талаар тэдэнд маш ойлгомжтой тайлбарлах,  судалгааны үйл явцтай холбоотой хэн нэгэнд ямар нэгэн эрсдэл гарч болох талаар мөн тайлбарлах, аль болох тэднийг ая тухтай сэтгэлд нийцсэн байдалд байлгах ёстой. Мөн мэдээлэл өгсөн хүний мэдээлэлд хэн нэвтэрч болох, ямар зорилгоор нэвтэрч болох талаар тэдэнд сайн талбарлаж өгөх хэрэгтэй. Дата цуглуулах цаад хил хязгаар, бусад ёс суртахууны асуудлууд, тухайн судлагдаж байгаа хүндээ мэдрэмжтэй, хүндэтгэлтэй хандах хэрэгтэй.

Жишээ нь тухайн уулзаж байгаа хохирогч аюулд орж магадгүй нөхцөлд тухайн сэтгүүлч хүний наймааны асуудлын талаар хэр цар хүрээтэй ярилцах вэ (тухайн яриа хохирогчтой холбоотой байвал)? Өөр нэг жишээ гэвэл тухайн хохирогч нь сайн сайхан амьдрал хайн хүний нутгийг зориод тэр нь яваандаа биеэ үнэлэгч болж төгссөн залуухан эмэгтэй байвал яах вэ?  Өмнөх лекцүүдэд үзсэн шиг хүний наймаа гэдэг бол маш өргөн цар хүрээтэй үйл ажиллагаатай, хохирогчтой,  наймаачидтай, хувьцаа эзэмшигч болон мэргэжлийн байгууллага агентлагууд, хувь хүмүүс энэ наймааг зогсооход маш нарийн төвөгтэй цогц асуудал юм.

Эрэн сурвалжлах сэтгүүлчийн хувьд тухайн цуглуулж боловсруулсан мэдээ мэдээллийг цацах, олонд ил болгох нь аюултай, эрсдэлтэй гэдгийг мэдэж байх хэрэгтэй. Ялангуяа баталгаа, нотолгоогүй худал, хуурмаг мэдээлэл байгаа эсэхийг анхаарах.  Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд олон нийтэд наймааны хор хохирлын талаар мэдээлэл өгч, энэ наймаанд өртөхгүй байх зэрэгт анхааруулга, сэрэмжлүүлэг өгч байх үүрэгтэй. Төгсгөлд нь алдаа мадаггүй, үнэн зөв, баталгаа нотолгоонд тулгуурласан мэдээлэл нь хүний наймааны эсрэг тэмцэхэд хамгийн гол үндэс суурь нь болдог.

*Семинар, ярилцлага:*

- Сэтгүүлчийн ёс суртахууны энэ дилеммын хариуцлагын тухай ярилцана уу. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хохирогчийг тэдгээрийн асуултанд хариулагчаар ашиглах нь зөв үү? Сэтгүүлч хариулагчаас мэдээлэл авахын тулд хэр хол явах,

ямар хил хязгаартай байх ёстой вэ? Сэтгүүлч хохирогчтой ярилцах боломжгүй тохиолдолд ямар сонголт хийх ёстой вэ?

- Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хүний наймаатай холбоотой сурвалжлагын үед ёс суртахууны ямар стандартыг мөрдөх ёстой вэ?

  Даалгавар (сонголтоор):

- Хүний наймааны талаар сурвалжлага бэлтгэж байгаа сэтгүүлчийн ёс суртахууны дилеммийн талаар дүгнэлт хий
- Хүний намааны асуудлаар сурвалжлахад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн мөрдөх ёстой хамгийн наад захын стандартыг гарга. Үүнд ёс суртахууны дилемм, тухайн мэдээллийг цуглуулах болон хэвлэн нийтлэх багтана.

*Унших материал (Санал болгосон):*

Академик унших материал: Бреннэн (2005), Ченг (2008), Чүү гм. (2010), Глассер ба Еттема (1989), Жонстон гм. (2012), Симмондс (2012), Тэйлор ба Сулливэн (2002), Тайлдам (2012), Вейнс (2012), Зиммермэн (2003).

Улс үндэстний болон олон улсын байгууллагын талаар унших материал: Эрэн Сурвалжлах Сэтгүүл зүйн Төв (n.d.), OSCE (2008), UNIAP (2008), UNODC (n.d.c).

Нэмэлт: Нидерландын Тусгай Сэтгүүлчийн Хүнийг наймаалах болон хүүхдийн эсрэг Бэлгийн Хүчирхийлэл, Хоёр  Жижиг Охин (TLG).

# Ном Зүй


Африкийн Холбоо.1981.Африкийн Хүн Төрөлхтний болон Хүний эрхийн тунхаг.

Агустин,Л.М.2008.Бэлгийн замбараагүй харьцаа.Сэксийн ашиг хонжоо:Нүүдэл,Хөдөлмөрийн зах зээл баавран хамгаалахСалбар.Лондон/Нью-Йорк:Зед.

Амбагтшээр,Ф.,Заитч,Д.Ба Вэймар,В.2013.Хүний эд эрхтний төлөөх тудайн: Эрхтний наймаа ба Эрхтэн Шилжүүлэн Суулгах Мэс Заслын Дэлхийн Аялал Жуулчлал, Глобал Гэмт Хэрэг,Хэсэг.14,#.1.http://dx.doi.org/10.1080/17440572.2012.753323

Андерсон,Б.баАндрижасевич,Р.2008.Бэлгийн боолчлол ба иргэд:Наймааны эсрэг Улс Төр.Хүний нүгэлт наймаа хүний нүүдлийг зогсоох эсэхийн улс төрийн маргаан болж байна,Дуудлага,#.40,хуу.135–45. www.statewatch.org/news/2009/feb/soundings.pdf

Ароновиц,А.А.2009.Хүний Наймаа, Хүний гуйланчлал: Хүний эд эрхтэний Дэлхийн худалдаа.Вестпорт,Конн.: Праегер.

Артур,С.2010.Өгөгдөлдөө дүгнэлт хийнэ гэдэг бол сэтгүүлч хүний ирээдүй гэж Тим Бернерс-Ли хэлсэн, 11 сарын 22. www.guardian.co.uk/media/2010/nov/22/data-analysis-timberners-lee

Зүүн Өмнөд Азийн Үндэстнүүдийн Холбоо (ASEAN).2004.Хүний Наймааны эсрэг Тунхаг, Ялангуяа Хүүхэд Эмэгтэйчүүд (2004).www.no-traffcking.org/resources_laws_regional.html

Бэйлс,К.2007.Хүний Наймааг юу гэж харж байна? Харьцуулсан болон Гэмт Хэргийн хууль эрх зүйн Сэтгүүл,Хэсэг.31,#.2,хуу.269–79.www.humansecuritygateway.com/documents/FTS_ WhatPredictsHumanTraffcking.pdf

Бэйлс,К.2012.Хаягдсан Хүмүүс: Дэлийн Эдийн Засгийн Шинэ Боолчлол. Беркели, Калифорния, Калифорниягийн Их Сургууль, Хэвлэл.

Бергланд,С.Ба Лундин,С.2011.‘Би явах боллоо’.Гадаадаас бөөр худалдаж авах нь ойлгомжтой. Мартин Ганнарсон ба Фредрик Свенаесус,Хүний бие бол Бэлэг,Баялаг,Бүтээгдэхүүн:Эд Эрхтэн, Зөөлөн Эд,Эсийг 21-р зуунд солилцож байна. Стокголм:Сөдертөрнс хөгскола хуу.321–42.http://edit.info. lu.se/upload/Kulturvetenskaper/dokument/TheBodyAsGift.pdf

Бреннан,Д.2005.Наймаанд өртсөн хүний талаарх судалгаанд тулгарах арга зүйн бэрхшээл: Лацко ба Гоздзиак,Dataба Хүний Наймааны Судалгаа: Дэлхийн Санал асуулга. Олон Улсын Нүүдлийн Тусгай Асуудал хөндсөн судалгаа, Хэсэг. 43,#. 1/2, хуу. 35–54. http://lastradainternational. org/lsidocs/282percent20IOMpercent20surveypercent20traffcking percent20(Global). pdf#page=37

Брүүкс-Гордон,Б.2006.Сексийн үнэ ханш: Биеэ үнэлэлт,Бодлого ба Нийгэм.Девон: Виллан. Бруч, Элизабет М.2004.Загвар:Хүний Наймаатай тэмцэх дорвитой арга хайж ол.Олон улсын Хуулийн Stanford сэтгүүл,Хэсэг.40,#.1,хуу.1–45.

Бруновскис, А.ба Суртийс, Р. 2012. Нүднээс далд? Наймаанд өртсөн хоххирогчийг таньж, олж илрүүлэхэд гарах Хандлага ба Сорилт бэрхшээл.Фафо/НЕКСУС Институтын төсөл: Наймааны хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах.

Бруска,С.2011. Палермогийн Протокол:Аборт хийлгэсний дараах эхний 10 жил,Дэлхийн Аюулгүй байдлын Судалгаа,Хэсэг.2,#.3,p.8–20.http://globalsecuritystudies.com/Bruscapercent20Palermopercent20Finalpercent20One.pdf

Б.де2007.Хамтарсан Эрэн Сурвалжлах баг: Европолын оролцоо.ЭРА Форум,Хэсэг.8,#.2,хуу. 253–64.http://link.springer.com/article/10.1007 percent2Fs12027-007-0014-7?LI=true

Бакерт,С.ба Parent,С.2002. Хүний эд эрхтний наймаа ба Зохин байгуулалттай гэмт хэрэг:Текстээс харахад. Салбар, Олон Нийт, Гэрээ ба Абориген Цагдаагийн Үйлчилгээ, Үнэлгээний Судалгаа. Рояал Канадын Цагдаагийн газар http://dspace.cigilibrary.org/jspui/bitstream/123456789/22297/1/ Traffckingpercent20Inpercent20Human percent20Beingspercent20andpercent20Organized percent20Crimepercent20Apercen t20Literaturepercent20Review.pdf?1

Будиани-Сабери,Д.А.ба Карим,К.А.2009.Эд эрхтэн наймаалах гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн алба:Олон нийтийн эм бэлдмэл,Хэсэг.4,#.1,хуу.48–51.

Камерон,С.2008.Биеийг нь үнэлэхүүлэх зорилгоор эмэгтэйчүүдийг наймааны гэмт хэрэгт татах С.Камеронба Э.Ньюмэн,Хүнийг наймаалах:Нийгмийн, Соёлын баУлс төрийн зорилгоор.Токио,Нью-Йорк, Парис:НҮБИх Сургуулийн хэвлэхPress.

Эрэн Сурвалжлах Сэтгүүл зүйн.Ярилцлага авах техник.http://tcij.org/sites/default/fles/u4/Interviewingpercent20Techniques.pdf

Чандрам, П.2011.Хүний наймааг ойлгох. П.Чандран,Хүний Наймаа танилцуулга ном: Их Британид Наймаа болон Орчин Үеийн Боолчлолыг таньж мэдэж хүлээн зөвшөөрөх. Лондон: Лексис Нексис.

Ченг,С.2008.Хүний ул шагайх баяригдаагүй өгүүлэляригдаагүй:Угсаатны зүй Наймаанд өртсөн эмэгтэйчүүд болон АНУ-ын зэвсэгт хүчний талаарх судалгаа сэтгүүл зүйтэй уялддаг. Бэлгийн амьдралын Судалгаа ба Нийгмийн Бодлого,Хэсэг. 5,#.4,хуу.6–18.

Чо,С.-Вай.2012.Загварын Ертөнц нь Хүний Наймааны эх үүсвэр, хүчин зүйл..http://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2117838.

Чүү,К.,Жанг,Ж.О.баЧой,К.2010.Хүний Наймаатай тэмцэхэд гарах Судалгааны Аргачлалын болон Ёс Суртахууны хүндрэл бэрхшээл:БНСУ-аас АНУ-руу бэлгийн мөлжлөгийн зорилгоор хил давуулах гэмт хэрэг.Эмэгтэйчүүд болон Гэмт Хэргийн Шүүх, эрх зүй. Хэсэг.20,#.1–2,хуу.167–85.

Арабын Хууль Зүйн Сайд нарын Зөвлөл.2012. Хүний Эд Эрхтэний Эсрэг Тэмцэх Бүхнийг Хамарсан Араб Стратеги. Арабын Хууль Зүйн Сайд нарын Зөвлөлийн Тоогтоол # 2012/2/15-27-879 Хуулийн Зүй болон Техникийн Ерөнхий Нарийн Бичгийн Департамент.

Европын зөвлөл.1950.Хүний Эрх болон Бусад Бүх Эрх Чөлөөг Хамгаалах Европын Конвенци.

Европын зөвлөл.2005.Хүний Эд Эрхтний Наймааны Эсрэг Конвенци.http://conven tions.coe. int/Treaty/en/Treaties/Html/197.htm(МөнАлбани, Армен,Азербайжан,Босни, Болгар,Голланд,Франц,Гүрж, Герман,Грек,Унгар,Итали,Латви,Македон, Норвеги, Польш,Португаль,Румын,Орос,Серби,Словак,Словен,Испани,Турк, Украйн хэлүүд дээр гарсан.)

Европын Зөвлөл.2009.Эрхтэн, Зөөлөн Эд, Эсийг эдгээрийг салган авч ашгийн зорилгоор салгах, удалдаалахыг хориглоно. Европын Зөвлөл, НҮБ-ын судалгаа.Страсбург: Европын Зөвлөл.

Европын Зөвлөл.2011.2011/36/Евро Парламентын ЕХбаЕвропын Зөвлөлийн 2011 оны 4 сарын 5 ны Удирдамжаар, Эрхтэн, Зөөлөн Эд, Эсийг эдгээрийг салган авч ашгийн зорилгоор салгах, удалдаалахыг хориглох болон Хохирогчийг хамгаалах талаар тусгасан. http://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2011:101:0001:0011:EN:PDF (Мөн Албани, Армен, Азербайжан, Босни, Болгар,Голланд,Франц,Гүрж, Герман,Грек,Унгар,Итали,Латви,Македон, Норвеги, Польш, Португаль, Румын, Орос, Серби, Словак, Словен, Испани, Турк, Украйн хэлүүд дээр гарсан.)

Афганистаны Хүүхдүүд,.2010.“Фронтын Тэргүүн эгнээнд”(Баримтат кино).

Дэивид,М.баСуттон,С.Д.2004.Нийгмийн Судалгаа:Анхан шатны.Лондон/Мянган царс мод,Калифорни/Шинэ Дели: Мэргэн хүн.

ДелгадоВайз,Р.баМарөуезКоваррубиас.Н.2012.Неолиберал даяарчлалын Стратеги: Ажиллах хүчнийг экспортлох ба тэнцвэргүй.Дээд төвшний Социологи,Хэсэг.2, #.2,хуу.127–34.

Энтман,Р.1993.Алдааны парадигмийн тодруулга.Харилцааны сэтгүүл,Хэсэг.43,#.4,хуу.51–8. http://sotomo-ve.geo.uzh.ch/sotomo/pps/lit/entman_93.pdf

Гэмт Хэргийн асуудал хариуцсан Европын Зөвлөл (ECCP).2012.Хүний эрхтнийг худаалахын эсрэг Европын Зөвлөлийн Конвенци. Страсбург: Европын Зөвлөл www.coe.int/t/dghl/standardsetting/cdpc/CDPCpercent20documents/CDPCpercent20(2012)percent 2021percent20-percent20epercent20- percent20Draftpercent20Conventionpercent 20againstpercent20Traffcking percent20inper cent20Humanpercent20Organs.pdf

Европын Холбоо.2011.2011/36/Евро Парламентын ЕХбаЕвропын Зөвлөлийн 2011 оны 4 сарын 5 ны Удирдамжаар, Эрхтэн, Зөөлөн Эд, Эсийг эдгээрийг салган авч ашгийн зорилгоор салгах, удалдаалахыг хориглох болон Хохирогчийг хамгаалах талаар тусгасан. http://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=O J:L:2011:101:0001:0011:EN:PDF (МөнАлбани, Армен,Азербайжан,Босни, Болгар, Голланд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Итали, Латви, Македон, Норвеги, Польш, Португаль, Румын, Орос, Серби, Словак, Словен, Испани, Турк, Украйн хэлүүд дээр гарсан.) http://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri= OJ:L:2011:101:0001:0011:EN:PDF

Европын Холбоо болон Африкийн Улсууд. 2006. Оуагадоугоугийн Үйл Ажиллагааны ТөлөвлөгөөгөөрХүний Наймааны эсрэг, ялангуяа Хүүхэд Эмэгтэйчүүд эсрэг хүчирхийллийг зогсоох талаар тунхагласан. http://ec.europa.eu/anti-traffcking/download.action;jsessionid=Z2J2RSrCVl8Nx1IJ5mJLxmqBTsjGJLW3vnmwJ4shrjTsrqz J184R!-656776111?nodePath=per cent2FEU+Policypercent2FOuagadougou+Action+Plan+to+combat+traffcking_en.pdf&fleName= Ouagadougou+Action+Plan+to+com bat+traffcking_en.pdf

Фарлей,М.2003.Биеэ үнэлэлт,Наймаа,ба Хүнд Стресс.Нью-Йорк:Хаворт Нүд үзүүрлэх болон Сэтгэлийн шарх бэртэл. Хэвлэл.

Фредетт, К. 2009. Хүний наймааны эсрэг НҮБ-ын протоколд: Наймааны гэмт хэргийн эсрэг илүү сайн хууль хэрэгтэй, Олон улсын Кардозо сэтгүүл болон Харьцуулсан хууль, №.101.http://heinonline.org/ HOL/LandingPage?collection=journals&handle=hein.journals/cjic17&div=6&id=&page

Галуска, Р. 2012.Боолын ангуучид, эмсийн хүрээлэнг ажилуулагч ба феминистүүд: Бэлгийн наймааны эсрэг эрэн сурвалжлах сэтгүүлчид, бэлгийн наймааны эсрэг үзэлтнүүд, феминист формаци,Хэсэг.24,№.2,pp.1–24.

Гект, А. 2008.Бүгд хуваасан хариуцлагатай гэхдээ өөр хариуцлага: Хүний наймааны эсрэг олон улс интеграцилагдах үүрэгтэй. Олон улсын хууль болон бодлогын Денвер Сэтгүүл,Хэсэг.37,хуу.29-62. http://djilp.org/wp-content/uploads/2011/08/Shared-But-Differentiated-Responsibility-Integration- International-Obligations-Fight-Against.pdf

Глассер, Т.Л. болон Эттэма, Ж.С. 1989.Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба Ёс зүй, Олонхийн харилцааны шүүмжлэлтэй судалгаа.Хэсэг.6,№.1,хуу.1–20.

Гомез, С.Ж., Раумонд, Ж.Г болон Хюгхэс, Д.М.2001. АНУ дах эмэгтэйчүүдийн бэлгийн наймаа: Олон улс ба дотоодод. 3 сар. www.uri.edu/artsci/wms/hughes/sex_traff_us.pdf

Гоодей, Ж. 2008.Хүний наймаа:товч өгөгдөл ба бодлогын хариу, Криминологи ба Гэмт хэргийн хууль зүй, Хэсэг.8,хуу.421–42. http://combattraffcking.eu/sites/default/fles/Human percent20TRaffckingper cent20-percent20Jopercent20Goodey.pdf

Гоулд, А.Ж, 2010.Хуурмаг шинжлэх ухаанаас жинхэнэ шинжлэх ухаан руу:Хүний наймааны тооцоолол ба Боолчлолын орчин үеийн форм. Хүний наймааны сэдвээр ээлжит хоёр дах удаагийн салбар хоорондын конференци, 2010.Линкольн, Небраска муж.: Небраскагийн Их Сургууль. http://digitalcommons.unl/edu/humtrafconf2/6

Э.М болон Коллет, Э. А.2005. Хойт Америкийн Хүний наймааны с удалгаа:Уран зохиолын шүүмж. Ф.Лазко болон Э. Гоздзиак,Хүний наймааны судалгаа ба өгөгдөл: Дэлхийн санал асуулга, судалгаа. Женев:IOM.

Грэй, Ж., Чамберс, Л. Болон Боунегру, Л. 2012. Дата сэтгүүл зүйн гарын авлага, Себастопол, Калифорни муж, О' Рейли хэвлэл мэдээллийн хэрэгсэл.

Грэй, Ж. Краувл, Х. Болон Снөв, К. 2012. Бидний үүрэг хариуцлага юу вэ? Хувь хүн болон байгууллагууд яаж хүний наймаанаас сэргийлэх вэ? Хүүхэд дээр хийгдсэн судалгааны сэтгүүл: Хүүхдүүдийн эрсдлийн талаар мэдээлэх бодлого, Хэсэг. 3, №.1.http://digitalcommons.library.tmc.edu/cgi/viewcontent.cgi?article=1073&context=childrenatrisk&sei-redir=1&referer=httppercent3Apercent2Fper cent2Fscholar.google.nlpercent2Fscholarpercent3Fas_ylopercent3D2012percent26qper cent3Dhumanper cent2Btraffcking percent2Bhumanpercent2Brightspercent2Bapproachper cent26hl percent3Denpercent26as_sdtpercent3D0percent2C5#search=percent22humanper cent20traffckingpercent20humanpercent20rightspercent20approachpercent22

Грэвкок, М. 2007.Зорчигчийг буудах: Австралийн хууль бус цагаачдын эсрэг дайн. М. Лий, Хүний наймаа. Девон: Виллан.

Грабб, Д. Болон Беннетт, К. 2012.АНУ-ын Хүний наймааны эсрэг хүчин чармайлтыг дэмжсэн орон нутгийн хуулийг хэрэгжүүлэх бэлэн байдал: Жоржия мужийн Хүний наймааны эсрэг сургалтын үнэлгээ ба хүний наймааны эсрэг орон нутгийн, дүүргийн болон улсын хуулийг хэрэгжүүлэхэд тэдэнд мэдээлэл өгч сургах. Цагдаагийн дадлага ба Судалгаа, Хэсэг.13,№.6,хуу.487–500.

Хэйнрич, К. 2010.Палермо протокол 10 жилийн дараа: Хүний наймааны хохирогчид хаана байна вэ? Хүний Эрхийн Товч Хэсэг.18,№.1,хуу.2–5.http://digitalcommons.wcl.american.edu/cgi/viewcontent.cgi?article=1145&context=hrbrief

Хэлмбэрг, М. 2007.Европын хуулийн байгууллагын хамтарсан эрэн сурвалжлагын баг:

Еврожаст JIT болонERA форумыг дэмжиж болох юм. Хэсэг.8, №.2,хуу.245–51. http://link.springer.com/article/10.1007percent2Fs12027-007-0012-9?LI=true

Хэннинк, М болон Симхада, П. 2004.Балбын бэлгийн наймаа: Агуулга болон үйл явц. Боломж болон Сонголт. Сонгийн нийтлэл №11.http://eprints.soton.ac.uk/34733/1/Sex percent20traffckingper cent20WP11.PDF

Энэтхэгийн хүний наймаа.2011.(богино видео бичлэг)www.youtube.com/watch?v=9yJWvphsa3A

Олон улсын Хөдөлмөрийн байгууллага (ILO).2013.Дэлхийн ажил олголтын чиг хандлага 2013: Хоёр дах ажлаасаа сайжирсан.Женев: ILO.

Цагаачлалын олон улсын байгууллага(IOM). Наймааны эсрэг. www.iom.int/cms/countertraffcking

Эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг ба Олон улсын Нефрологийн нийгэмлэгээс зохион байгуулсан эд эрхтэний наймаа, эрхтэн шилжүүлэн суулгах аялал жуулчлалын эсрэг Олон улсын хурал. 2008. Эрхтэний наймаа болон эрхтэн шилжүүлэн суулгах аялал жуулчлалын эсрэг Истанбулын тунхаглал. Хэсэг.88,№.8,хуу.1013–18. http://multivu.prnewswire.com/ mnr/transplantationsociety/33914/docs/33914-Declaration_of_Istanbul-Lancet.pdf (Араб, Боснин, Фарси, Франц, Герман, Еврей, Итали, Япон, Солонгос, Португали, Румин, Орос, Испани хэл дээр хэвлэгдсэн.)

Жэнсин, Н. Э. Хааси-Кромвижк, В. Ж. Ж. М. МсДоналд, М болон Скюй, М. 2013. Европын жигсов элемент: Нэгэн зоригтой гэр бүл эд эрхтэнээ шилжүүлэхийг дэмжиж зоригтойгоор коммпанит ажил зохион байгуулсан. Эрхтэн хандивлах болон эрхтэн шилжүүлэн суулгах олон нийтийн уулзалт, Ленгерих, Герман: Пабст Шинжлэх ухаан,хуу.161–9.

Жеффрейс, С. 2009. Үйлдвэрийн эм эрхтэн. Дэлхийн бэлгийн худалдааны улс төрийн эдийн засаг. Нью-Йорк: Роутледж.

А. Фрэйдмэн, Б ба Шафер, А. 2012.Бэлгийн наймааны асуудлын хүрээ: Хэний асуудал вэ? Яаж эмчлэх вэ? Феминист Хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа, 11December. www.tandfonline.com/doi/abs/10.1080/14680777. 2012.740492

Жордан, А.Д 2002.Хүний эрх эсвэл буруу?Хүний наймааны зөв эсвэл хүний эрх гэж хариулахын хүндрэлтэй тал, Жендер ба Хөгжил, Хэсэг.10,№.1,хуу.28–37.

Жосеп, Н. Болон Босковски, П.2012. Зарчмаас дадлага руу: Хэвлэл мэдээллийн ёс зүйн тэтгэлэгийн хүрээг тэлэх. Ёс зүйн орон зай, Хэсэг.9,№.4.http://journals.communicationethics.net/free_article. php?id=00033

Лазко, Ф.2005.Танилцуулга. Ф.Лазко ба Э.М.Гоздзиак, Хүний наймааны судалгаа ба өгөгдөл: Дэлхийн санал асуулга. Женев:IOM.

Лазко, Ф болон Грамэгна, М. А. 2003. Хүний наймааг илрүүлэх илүү сайн индикатор. Дэлхийн харилцааны Враун сэтгүүл. Хэсэг.10,№.1,хуу.179–94.

Арабын улсуудын лиг.2004.Арабын хүний эрхийн тунхаглал.

Ландин, С. 2012.Эд эрхтэний эдийн засаг: Молдов болон Изриал улсын эрхтэний наймаа. Шинжлэх ухааны талаарх олон нийтийн ойлголт. Хэсэг. 21,№.2,хуу.226–41.

Маларек, В. 2009. Жонс: Биеэ худалдах болон тэдгээрийн худалдан авч байгаа эрчүүд. Нью-Йорк: Аркади.

Маттар, М. У. 2005.Төв Азийн хүний наймааны эсрэг тэмцэх улсын хариуцлага. Олон улс болон Харьцуулсан хууль. Хэсэг27,№.2,хуу.101–84. www.protectionproject.org/wp-content/ uploads/2011/10/STATE-RESPONSIBILITIES-IN-COMBATING-TRAFFICK ING-IN-PERSONS-IN- CENTRAL-ASIA-Loyola.doc

